

МОНГО АЖААЧИЙН АНД



БЭЛЭГЭЙН АНД

ШИДЭТ  
ХҮҮРИЙН  
ҮЛГЭР

2

**ШИДЭТ ХҮҮРИЙН ҮЛГЭР**

**ХОЁРДУГААР ХЭСЭГ**

[www.kiebooks.com](http://www.kiebooks.com)

# БАГШ НАГАНЖУНАГИЙН ШАСТИР ӨЧҮҮХЭН ИНЭЭД АЛДАХ ХОРИН НЭГЭН БҮЛЭГТ ОРШИВ.

Номд мөргөмүү. Тэр ч Төвдөд хөрвүүлсэн Шагжамүний мэндэлсний үе тэргүүтэн ба түүнээс ангид Гадамбын төрлийн түүх, Динсан Жалүй-гийн шастир, Лянхуаны шастир Зүүдний охин тэнгэрийн шастир, Дүрсэн нарны шастир, Рамана хааны шастир, Лингийн их арслан хааны намтар, Бич (мич) Лхомоны үлгэр, Ардыг тэжээхүй дусал, Ерийи шувууны үлгэр, Гуйранчийн үлгэр тэргүүтэн хуучин үлгэр хэдий чинээ байснаас өдгөө авагдаж буй үлгэр нь хичээл зүтгэл ба зүрх зориггүй нөхдөд тус болж буй Сайн амгалан явдалт хааны намтар мөн. Үүнийг номлож үйлдэхүйд сонсохыг айлтгая.

Тэр ч хуучин үлгэрийг сонсоход гурван тангаргийг сахих хэрэгтэй. Мэдээд номлолгүй үл үйлдэх лүгээ нэг. Завсар дунд алгасалгүй сонсох лугаа хоёр. Эцэст цалгайруулж орхихгүй лүгээ гурвыг сахих хэрэгтэй Үүнийг таалалдаа хадгалахыг айлтгая.

Эрт урьд Энэтхэгийн өмнө зүгт төрөл төрлийн үед бандидагийн биеийг олсон багш Наганжуна зүрхэн хэмээгч Сараха-гаас насны шидийг олсон бурхны шажны дүвазыг сайтар байгуулсан эндүү үзэлтэй тэрсүүдийг үндсээр нь даран зохиогч Наганжуна зүрхэн танд магтан мөргөмүү.

Өмнө зүгийн Цогт ууланд бурхны зарлигуудыг хоцролгүй цуглуулж, бурхны ном ба ертөнцийн шастируудыг туурвиж байхдаа:

«Надад хав төгөлдөр нэгэн шавь хэрэгтэй байна» хэмээн таалан суув. Тэр цагт аглаг өмнө зүгт нэгэн хадны хажуу завсар хэрээний үүр байсан бөгөөд бас голын адагт ганц хөвгүүнтэй нэгэн хаан байсан бөлгөө. Түүний орчинд баяны хөвгүүн ба гуйранчийн ухаантай хөвгүүн байв. Хааны хөвгүүн, баяны хөвгүүн, гуйранчийн хөвгүүн хоёрыг дагуулаад голын эхэнд уйтгараа сэргээхээр очиж, өмнөх цогт уулын оройд авирч гараад хадны хажуу завсар хэрээний үүр байгааг үзэж чулуу түүж овоолоод тэр хадны дэргэд очиж хааны хөвгүүн тэр хоёрт өгүүлрүүн:

Бид энэ хадны завсрын хэрээний үүрийг цохиж гаргахаас нааш буцаж харихгүй гэж тангараглая гэснээр гурвуул тангараглан хэрээний үүрийг дэлдэв. Үд хэвийхэд хан хөвгүүн

– Миний энэ насанд хэрэглэх албат нөхөр зарц, төгс эдлэл өөрт бий. Хойд насанд хэрэгтэй номын зүгт урьд ч өгсөн, одоо ч өгч болно. Андгайг минь давааны буга аваг.

Би буцаж харилаа гээд хааны хөвгүүн буцаж йвлаа Гуйранчийн хөвгүүн

– Би тангараг эвдсэнээс буяны хүчин бага болжээ Одоо ч андгайг хагаруулваас хойдод үүнээс ч илүү хоосон болно гээд чулуу түүж овоолон хадны дэргэд ирээд дэлдэв. Баяны хөвгүүн өгүүлрүүн:

– Эрх ихтэй гээд тэр андгайг эвдэх хэрэггүй бөгөөтөл тэр өөрөө эвдэв. Явахын хэрэггүй буйтал тэр өөрөө урьдаар явлаа. Бид хоёр үүнийг гаргахыг хүртэл сууна гээд дэлдэв.

Наран давааны цаана орох шахлаа, хэрээний үүрийг энэ мэт буулгах хэрэггүй. Тангаргийг давааны буга аваг. Энэ насанд хэрэглэх эд надад бий. Эд байваас эрх зоргоор байж болно. Буцаж харилаа гээд баяны хөвгүүн харив. Гуйранчийн хөвгүүн

– Урьд насандаа өглөг эс өгснөөр өдгөө гуйранч болж төрөв. Энэ насанд хилэнцийг үйлдвээс хойдод Аюуш тамд одно. Гуйранчийн хүү Даваадагва би үхвээс ч үхсүгэй. Хэрээний үүрийг гаргаж л байж явна гээд чулуу түүж овоолоод дахин нүдсэн тул газар нь цөмрөөд хэрээний үүрээс үс нь мөрөн дээгүүрээ бүрхсэн бүтээлч нэгэн хүн гарч ирээд хөвгүүнийг гэдрэг нь харуулж унагаагаад үеийг мөлтөртөл дэвсэн түрүүлгэнэ харуулж газар шигдтэл дэвсээд

Гуйранчийн хөвгүүн ээ. Усанд алтны өнгө гарна. Хаданд сар шувууны дуун гарав. Үүртэй шувуунууд үүрэндээ очдог. Үүргүйчүүд нь үүр эрж бэдэрдэг. Оронтой хүмүүс орондоо очдог. Оронгүй хүмүүс суух газраа эрж бэдэрдэг. Энэ голд хааны хөвгүүнээс эрх ихтэй нь үгүй тул эрт явсан биз. Төгс эдлэлээр баяны хөвгүүнээс их нь үгүй тул сая явсан биз. Хөл хорьж суугчийн үүдийг дэлдээд чамд өргөл өгөх юм буй буюу хэмээн асуусанд гуйранч

Бүтээл бясалгалд оршин байгаа гэж огт санасангүй. Гуйранчийн хөвгүүн би хааны хөвгүүн, баяны хөвгүүн хоёроос хоцорч, хэрээний үүрийг гаргахгүйгээр үд буцах андгайгаа эвдэхээс эмээсэн билээ. Хааны хөвгүүн нөхөр, төгс эдлэл, цэргийн омог бүрдсэн тул тангаргийг бодсонгүй буцаж харьсан. Баяны хөвгүүн төгс эдлэл бүрдсэн тул тангаргийг тоосонгүй буцсан. Би урьд буян үл хурааснаар одоо хоосон хүний хөвгүүн болж төрөв. Надад төгс эдлэл үгүй тул өргөх юм хаанаас байх вэ? Одоо нүгэл хурааваас хойдод үүнээс ч ядуу бирдийн оронд төрөхөөс эмээгээд тангаргийг сахиж энэ хэрээний үүрийг дэлдсэн юм гэсэнд багш түр таалж

«Энэ нь төрөл дорой боловч оюун ихтэй. Урьд удаа чихэндээ номын зүйл сонсоогүй боловч буян хилэнцийн үйлийн үрийг энэ мэт ярьж байна. Үүний чин зориг маш сайн тул номын төлөө бэрх явдалд оруулбал бэрх явдлыг чадах бололтой гэж бодоод дагуулан

Чамд эх эцэг бий юу? хэмээн асуусанд тэр

Эцэг эх байвал хураасан юмтай байх буй за. Эд бэлэн байвал гуйранч хэмээгдэх ч үгүй билээ. Юм олохын аргыг одоо л айлтгая гэв. Тэр лам хөвгүүнийг бараа болгож дагуулаад өмнө зүгийн Цогт ууланд авчрав.

Тэр үед Энэдхэгийн өмнө зүгийн их хүүрийн газарт нэгэн том хүүрийн гадуур олон жижиг хүүр буй. Тэр том хүүрийг ардаа үүрээд хүүрт үг алдалгүй өмнө зүгийн Цогт ууланд авчирч чадвал уул алт болохын ерөөл бүтэх учиртай ажгуу. Энэтхэгт их алттай болгох хэрэгтэй хэмээн таалаад гуйранч Даваадагвад сайн өдөр, сайн Цагт хан хөвгүүний алдрыг олгож, тор ба хутга, тогшуурыг өгч хан хөвгүүнийг адислаад

Тэрсүүдийн цогцыг авч ирвэл бурхны шажин дэлгэрэх хийгээд энэ шажинд алтны үнэ өртөг их тул өмнө зүгийн Цогт ууланд алт буй болох болтугай хэмээн ерөөл тавив.

Хан хөвгүүн Сайн амгалан явдалтад багш нь,

Ууланд байдаг хийд маш олон бөгөөд лаврангийн дөрвөн зүгт хөл хураасан цээрийн тэмдэг нэжгээд буй. Хамгийн тэргүүнд авчирч чадвал цээрийн тэмдгийг даваад дотогш орсугай. Түүнээс хүүрт үг дуун алдах тэргүүтэн болбол долоон хоногт хүрэлцэх тостой гурил үүнийг идээрэй. Чингээд эс авчирвал дорнын цээрийн тэмдгийн дэргэд мөн долоон хоног хүрэх тостой гурил тавина. Харин хүүр нь өвдгөөс дээш алт үл болно. Чин зориг эс гаргавал алт үл олж ирэх болно. Би ч бясалгал ба бүтээлийг хичээж үйлдье. Чи ч чин зоригийг гаргатугай. Энэ шашинд тус болох алтыг авчрах хэрэгтэй. Чин зоригийг гаргагтун хэмээн зарлиг болов. Лам бас «Тэр долоо хоног хүртэл хүүрийг эс авчравч цээрийг давж орох магад» хэмээн сэжиглээд:

Долоо ба арван дөрвөн хоногийн дотор эс авчирвал гурилыг өмнөх цээрийн тэмдгийн дэргэд тавина. Бас цээрийн тэмдэг дээр тодорхой бичиг тавина. Ардаа хүүргүй болбоос цээрийг давж орох эсэхийг хэлэлцэх хэрэггүй. Чин зоригийг гаргагтун хэмээн айлдаад дотогшоо ажрав. Түүнээс хан хөвгүүн бээр тор ба тогшуур, хүлэг, хутга, тостой гурил, их оюутай хамт хумьж үүрээд хүүрийн газар өөд одов.

Гуйранч Даваадагвад хааны алдрыг соёрхсон анхдугаар бүлэг болой.

# ОХИН ДЭНИДБҮМИЙН ТӨРЛИЙГ ҮЗҮҮЛСЭН БҮЛЭГ ОРШВОЙ

Тэр хан хөвгүүн их модны дэргэд очсонд тэр модны оронд нэг их хүүр «намайг бүү ав» гэхэд гадуур нь жижиг хүүрүүд «намайг ав» гэлцэв. Чулууг огтлох иртэй хутгаа сугалж гаргаад

– Лам минь Наганжуна зүрхэн мөн. Би өөрөө хан хөвгүүн Сайн амгалант явдалт мөн. Иртэй хутга чулууг таслагч мөн. Тор минь есөн нүхт төмөр мөн. Тогшуур мод минь хүрэн сэндэн мөн. Цалам минь мэхт төмөр гинж мөн. Тост гурил минь барагдашгүй идээ мөн. Одоо буух буюу эс бөгөөс модыг чинь унагалаа гэсэнд тэр хүүр бууж ирэв Тогшуураар нэг сайн дэлдээд, хүүрийг торны дотор чихэж, хүлгээрээ хүлж, ардаа үүрээд явав. Долоон алхам төдий явахад хүүр өгүүлрүүн:

Хан хөвгүүн, хан хөвгүүн. Эс бөгөөс хан хөвгүүн нэгэн түүхийг ярьтугай. Эс бөгөөс би ярья гэв. Хан хөвгүүний санаанд ламын захиа «тэр хүүр юу яривч үг бүү хэл» гэснийг бодоод дув дуугүй байсан тул хүүр

Үйлээ барсан хан хөвгүүн чиний амнаас үг гарахгүй буюу. Би нэгэн түүхийг ярья. Сонсогтун гээд өгүүлэв

Нэгэн голд нэгэн хаан байв. Хааны харъяат нэгэн баян байсан бөлгөө. Түүний орчинд гуйранчийн хөвгүүн байв. Хааны хөвгүүн, баяны хөвгүүн, гуйранчийн хөвгүүн гурвуул

– Голын эхэнд Дэнидбүм нэрт нэгэн охин бий. Урьд урьдын цаглашгүй олон төрлөө мартаагүй тов тодорхой мэдэх бөгөөд эр хүнд үг ярьдаггүй гэлцэв. Голын адгийн тэр хаан,

– Хан хөвгүүн тэр охиноор үг хэлүүлж чадвал баяны хөвгүүний эд таваарыг мөрийд аваад гуйранчийн хөвгүүнийг боол болгох буюу. Баяны хөвгүүн үг яриулж чадвал хаан төрийн тэн хагасыг эзэлнэ. Гуйранчийн хөвгүүн тэр охиноор ганцхан. үг хэлүүлж чадвал хаан төрийн тэн хагасыг эзлэх ба баяны хөвгүүний эд таваарыг мөрийд авна гэв.

Нэгэн өдөр хааны хөвгүүн голын эхэнд очоод, түшмэл ба их зааныг чимгээр чимж, дуу бүжиг тэргүүтнийг чадах чинээгээр наадавч охин үгийн хариу эс гаргав. Бас баяны хөвгүүн чимэг хэрэгсэл, хотол чуулганыг авч очоод охиноос үгийн хариу горилсон боловч үгийн хариу авч чадсангүй буцаж ирэв. Гуйранчийн хөвгүүн маргааш нь цоорхой уранхай дээлээ эвлүүлж мухар ханцуйтай дээл өмсөөд голын эхэнд очих замд голын эхнээс ирж яваа хөгшин эмгэнтэй учрав Эмгэн

Гуйранч хаана очиж явна гэвээс

– Эмгэн ээ, голын эхний охиныг үг дуугаргахаар явж байна гэсэнд эмгэн үл ойшоон инээгээд

Төөлдөр их хаан очиж заанаа чимгээр чимж, дуу бүжиг өдий төдий наадам тохууныг үйлдэвч охиныг дуугаргаж чадалгүй буцсан. Өчигдөр голын хаяаны хөвгүүн ирээд чимэг хувцас, төгс эдлэлийг авчравч мөн охиныг дуугаргаж чадалгүй буцсан билээ. Гуйранчийн хөвгүүн чи түүгээр үг яриулж чадах гэж үү гэсэнд гуйранч

– Тэр охин нь их хаан ирсэн ч дуу гардаггүй бөгөөд баян эд идээ, төгс эдлэл хотол чуулганыг авчравч үг хэлдэггүй ажгуу. Тийм бөгөөс тэр охин лав хэлгүй буюу гэсэнд эмгэн

Тэр охин хаанаас хэлгүй байх вэ. Олон төрөлдөө Аюуш бурхны бие зарлиг тааллын шүтээнийг босгосны эрдмээр өгүүлэхдээ мэргэн бөгөөд бие өнгө ариухан, олон төрлөө мэддэг эрдэмтэн мөн гэсэнд гуйранчийн хөвгүүн өгүүлрүүн:

– Энэ голд хааны хөвгүүнээс үлэмж нь үгүй. Түүнд эс дуун гарваас хэлгүйгээс ч цааш хэлгүй мөн буюу гэсэнд эмгэн ондуцаад

– Гуйранч чи сайтар сонс. Тэр охин бол цаглашгүй төрлөөн дуртгасан нь энэ мэт буй.

Урьд төрлийн үед өлөгчин барс болохын цагт гөрөөчин эрийг нь алав. Өлөгчин барс таван зулзага төрүүлээд эцэггүй зулзагаа бойжуулж өөрөө хоол эрж явахын цагт гөрөөчин, зулзагануудыг алав. Өлөгчин барс өөрөө сандран дутаасан (зугтаасан) боловч мөн алагдав. Орчлонгоос тэр үед гансрах сэтгэл төрөв.

Бас түүний хойд төрөлд жигүүртэн сойрын биеийг авах цагт давилгана модны завсар үүрлэж байгаад одоо жигүүр ургаагүй ангаахайнуудаа мал хариулагчдын алдсан түймрээс арчилсаар өөрөө ч түлэгдэв. Эр нь ирээд далавчаа усанд дүрээд галыг унтраах гээд түлэгдэж эр эм бүгдээрээ үхэв. Тэр үед ертөнцөөс уйдах сэтгэл төржээ.

Түүний хойд төрөлд болжморын биеийг олоод нэгэн их баяны тарианы дунд үүрлэн жаргаж байсанд гурван өндөг гаргаад тэр нь дэгдээхэй болон өсөв. Тариа услах үеэр ус өөдөө оргилж гарсан ба суваг урвуулахад дайралдаж, дэгдээхэйнүүд нь автагдаж балчгийн дотор цохигдон алагдав. Эх нь хүүхдээ эргээд бас балчигт орж үхэв. Цаглашгүй төрлөөс нааш эр хүмүүст үг ярьдаггүй нь түүний учир мөн болой гэв.

Тэндээс гуйранч голын эхэнд хүрч, тэр охины юм нэхдэг газрын дэргэд очоод «ий ий» хэмээн уйлсанд охин түүнийг нэг нүдээр ч харалгүй хэжмээ (утсаа) уяад суудаг газраа сольсон тул бас хойноос нь очиж «ий ий» хэмээн уйлж суув. Охин үгийн хариугүй өөрөө гэртээ харьж одов. Бас хойноос нь дагаж очсонд охин үүдээ чанга хаав. Тэр хөвгүүн босгыг нь дэрлээд уйлав. «Ий ий» гээд

– Анх урьд төрөлд чамайг өлөгчин барс болж явах цагт би хоол эрж явтал гөрөөчин намайг харваж алав. Чи ч хүүхдээ орхиж чадалгүй байж гөрөөчинд алагдав. Жигүүртэн сойрын биеийг авч явахдаа, ангаахайнуудаа далавч бүрдэж чадаагүй үед галд алдаж чи тэднийг эргэснээс өөрөө ч осолдож бүгдээрээ галд амь үрэгдсэн ажгуу. Түүний сүүлд болжморын бие авахын цагт намайг хоол эрж явахын хойгуур тарианд ус тавьж сувгийг урвуулсанд чи хүүхдүүдээ балчигт алдсан ба би ч балчигт орж алагдсан билээ. Төрөл төрөлд эм минь болсон чи чингэж байсан бөлгөө хэмээн уйлсанд охин урьд төрлөө дурдаад, сэтгэл нь уяран элмэрч нулимс гаргаад тэр охин үүдээ нээж дэргэд нь суув. Гуйранч урьдын үгээ дахин ярьсанд охин

Төрөл төрлөө дурдахад гашуудал төрөв. Чи төрөл; төрлийн нөхөр мөний тул дотогшоо ор. Өр төлөөсийг хариулах хэрэгтэй буй за гээд дотогшоо оруулав. Түүний муу гутал хувцсыг хол

хаяж, охин сайн гутал хувцас чимэг хэрэглэлүүдийг өгөөд угаан цэвэрлэж үнэртэн уугиулав.

Тэр шөнө тэндээ хоноод маргааш нь тэр эр эм хоёр хааны харшид очив. Тэр хан хөвгүүн гуйранчийн хөвгүүнд хаан төрийн тэн хагасыг эзлүүлэв. Баяны хөвгүүн эд тавааруудыг мөрий болгон өгөв. Хэдэн жил өнгөрөв. Охин урьд төрөлд Аюушийн бие зарлиг тааллын шүтээнийг босгосноор тэр голд хаан сууж, хаан төрийг номын ёсоор дэлгэрүүлсэн болой хэмээн өгүүлсэнд хаан

– Тэр хүн буян ихтэйеэ хэмээн үг алдсан тул хүүр

Хүүрт үг хэлэв гээд төмөр торыг гал бадартал гурав дэлдээд, харцага хүр хэмээх адил араас алдагдав.

Охин Дэнидбүм төрлөө дурдсан хоёрдугаар бүлэг болой.



# ОХИН, ХААНЫГ ҮХЛИЙН ОРНООС АВЧИРСАН БҮЛЭГ ОРШВОЙ

Тэндээс хаан, төлдрийн хүүрийн дотор буцаж очсонд тэр хүүр нь модны орой дээр суусан байв.

Лам минь Наганжуна Зүрхэн мөн. Би өөрөө Сайн амгалан явдалт хаан мөн. Хутга минь ирээр чулууг таслагч мөн. Тор минь есөн нүхт төмөр мөн. Тогшуур минь хүрэн сэндэн мод мөн. Хүлэг минь мэхт гинж мөн. Хүүр чи буухгүй буюу. Модыг чинь унагалаа гэсэнд тэр хүүр бууж ирсэнд тогшуураар нэг дэлдэж, торын дотор чихэж хүлгээр боогоод ардаа үүрч явав.

Бас хүүр:

– Хан хөвгүүн, хан хөвгүүн. Зам хол уйтгартай тул эс бөгөөс хаан нэг түүхийг яригтун. Эс бөгөөс хүүр би хулганын хумсын төдий нэгэн түүхийг ярьсугай гэхэд хан хөвгүүн

– Чиний учрыг мэдэж байна хэмээн санаж огт дуугүй байсан тул үйлээ барсан хан чиний мэтийн амнаас үг гарахгүй буюу. Чи сонсогтун.

Нэгэн голд нэг хаан байжээ. Хааны албатад эцэг эх нь урьд үхсэн, зүс сайтай ганц охин байжээ. Тэр хааны хөвгүүн охины дэргэд ирж түүнтэй танилцан дасалцав. Бас нэгэн үе болсонд охины дэргэд хан хөвгүүн ирээд

Одоо надад эхнэр авч өгөх нь байна. Эхнэр авбал би үхэх болно гэсэнд охин

– Хатан авбаас сайн гэдэг. Хатныг эртхэн авбаас эцгийг хөгшрөхийн өмнө хөвгүүнтэй болох тул яавч хатан авбаас сайн хэмээн айлдав. Хан хөвгүүн

– Хатан авбаас авсан даруй би үхэх болно гэв. Охин

– Одоо эцэг чинь урьд бие бараад үгүй болсон, хөвгүүн; болбоос үл болох тул одоо эх чинь юун хэлэх болбоос түүнийг дагаваас сайн гэв. Тэр хан хөвгүүнд эх ба түшмэл

– Хаан төрийг барихад хатан хэрэгтэй. Таарамжгүй хатан авбаас хааны язгуур саарахад хүрнэ гээд хан хөвгүүнтэй чацуу нэгэн хатныг аваад нэг сар болоход хаан нь хүнд өвчин хүрээд наснаас нөгчив. Урьдын хааны сүнс тэнэж ирээд үсээ өрвийлгөж сэгсийлгээд, хувцасны хормойг чирээд ядарсан байдалтай, царай зүс нь дорой болж охины дэргэд үзэгдсэнд тэр охин

Хан хөвгүүн нь хатан аваад хүчир өвчин туссан бололтой хэмээн бодоод хаанд

Төлдөр хатан авснаас хойш ирдэг чинь цөөрсөн ба зүс царай чинь алдагдсан байна гэсэн хаан өгүүллрүүн

– Аль хэдийний эхнэр авбаас би үхнэ гэж чамд хэлж байсан биш үү. Одоо өвчин тусаад байна гэв. Охин

Чилээрхсэн боловч эдгэрүүлж болох буй за. Авсан хатныг таалалдаа таалах буюу гэв. Хаан:

– Энэ шөнө насны авшгийг үйлдэх ба үлдэц биеэ үзэх учиртай тул чи очвоос сайн гэв. Тэр охин

«Урьд бол хаан сүр жавхлантай, чимэг хэрэглэл сайтай ирдэг сэн. Одоо хувцас хунар муутай, дорой байдалтай ирсэн нь юу болов» хэмээн сэжиг төрөв. Тэр хааныг охин наран шингэж орой болтол дагаж явав. Бүрий барай болох үеэр хааны харшид очмогц хэнгэргийн дуун дүн дүн хэмээн сонстов. Хаанаас охин:

– Энэ хэнгэрэгний их дуун гарч буй нь насны авшиг болж буй юу гэхэд хаан:

– Охин чамд миний үлдэц бие байгаа тул миний сэтгэл чамд эргэцсэн ажгуу. Би үхээд долоо хоног өнгөрч буй учир энэ шөнө миний долоо дахь хоногийн буяныг үйлдэж байгаа юм. Охин

– Хааныг хальсан гэж сэтгэл санаанд огт орсонгүй. Төрсөн ээжээ надтай танилцуулна уу гэсэнд хаан

Охин чи манай үхрийн хашаанд оч гээд, тэр үдэш хоёул үхрийн хашаанд очив. Тэнд хэвтэж байтал хааны хатан, ээж хоёр нь хсорондоо тар түр хийн хэрэлдэж байгаад эх нь

– Хөвгүүн үхмэгц сайн сүлдний оюуг минь нууж болохгүй. Бусад оюунуудыг чи авбаас ав. Харин миний сүлдний оюуг өгвөл зохино гэв. Хатан:

– Сайн оюу тэргүүтэй алтан оюу зэргийг нас барахын өмнө хан хөвгүүн өөрөө аваад явсан гэх зэргээр үхсэн амьд хоёрыг тулгاماар хэрүүл тэмцэл болж байв. Хаан, охинд:

– Би үхнэ гэж бодоод, миний үлдэц бие чамд буй учир алтан оюунуудыг хатны гараас аваад манай их тарианы дунд булж дээр нь том цагаан чулуу тавьсан билээ. Охин чи ээжийн буй газар очиж урьдын учрыг тодорхой ярьж эх эхнэр хоёрын хэрүүл тэмцлийг болиул гэв.

Тэр үед идээ зориулах уншлагын дуун дэн дэн гарсанд хаан хөвгүүн сантран

– Надад хоол өгч байна. Охин минь би одоо явья гээд босоод одов. Хааныг одсоны дараа охиноос нэгэн хүүхэд төрөв. Хаан дээрээс өгсөн хэсэг бусаг идээг хормой дүүрэн авчрав. Түүнээс хаан охинд өгөөд өөрөө ч идэлцэв. Тэнд хэнгэргийн дүн дүн дуугарсанд хаан

– Надад зам зааж өглөө. Би явья гээд босоход охин хааны хормойноос зуурав. Хаан:

Надаас зуураад тусгүй. Урьд ярьсанчлан ээжид хэлээд чи ээжтэй нэгэн дор сууваас зохино гэсэнд охин зууралгүй

– Ээжтэй уулзахыг хүртэл байзнагугай хэмээн айлдсанд хаан

– Би өөрөө ээжтэй уулзахын нөхцөлгүй. Буяны сайн цагт би ирнэ гээд одов. Тэр охин хөвгүүн төрсөн ба хаанд сэтгэл гансарснаар маргааш өглөөний наран гарах хүртэл ухаангүй байв. Үхэрчид үхрээ өдөр бэлчээхээр ирэв. Тэр охины ухаангүй унасан байхыг үзээд үхэрчин айж өөдөө гүйж хатан ээжид

– Манай үхрийн хашаанд үхэр хаших үеэр юу ч байгаагүй. Гэтэл, хаантай дасалцсан хэмээдэг тэр охин үхрийн хашаанд нэгэн хүүхэд төрүүлээд өөрөө цус алдаад үхсэн байна гэхэд, хатан ээж түргэн гүйж ирэхэд тэр охин хялайгаад унасан байх бөгөөд ээж

– Нялх хүүхэд нь хөвгүүн буюу охин буюу хэмээн үзсэнд хөвгүүн байсан тул зарлагыг дуудаад хэлсэн нь

– Түшмэдэд хэлж бурам самарсан үрийн архи, зандны шүүстэй ус, утах гурилыг түргэн авч ирэгтүн. Түшмэд ирэхгүй байж үл болно. Ийм шинж тэмдэг ноднингоос үзэгдэж байсан билээ. Хаан хальсан ч түүний өдлөг байна. Хөвгүүн үхэвч үр нь үлдэв. Утах гурилыг түргэн авч ир гэсэнд хатан ээжийн зарлигийг зөрчилгүй их түшмэд ирэв. Тэнд ирээд утах гурилаар утаж сүрчилгэ үйлдэж, бурам самарсан үрийн архийг өгсөнд, охин босоод нүдээ бүлтийтэл ширтэж, хатан ээжийг хараад гараас нь зууран уйлав. Хатан эх

– Чи уйлах хэрэггүй. Чамд хэлэх үг байвал хэлэгтүн гэсэнд охин

– Их ээж хатан аа. Надад номын их хаанаас зарлиг буулгахдаа хатан авбаас би үхэх буй за гэдэг байлаа. Заавал хатан таалтугай хэмээн тулгаж айлдсанд хатан авбаас одоо би үхнэ хэмээн айлдсаар байсан билээ. Бас миний авааль хатныг буцаатугай хэмээн айлдсан. Манай тэр их тарианы дунд нэгэн хонхор газарт байгаа бөөн цагаан чулууны доор сүлдний оюу тэргүүтэй алтан оюунууд буй хэмээн айлдсан болой. Хааны айлдсан үнэн бол тогтсон сайн цагт ирж байна хэмээн ам авсан билээ гэсэнд хатан эх

– Охин чи өөдөө оч гээд харшид дагуулан оров. Хааны хөвгүүнийг гадна тал нь цагаан шилүүсээр өнгөлсөн, дотрыг хятад торгоор хийсэн зөөлөн дэвсгэр дээр суулгаад түшмэл албат нар:

Хөвгүүн гарснаар хааны үндэс тасрахгүй болов хэмээн баясалцав.

Түүнээс арван тавны үүр шахахад хангир жингэр гэсэн дуун гарсанд охин

Төлдөр энэ мэтийн дуун гараагүй сэн. Хаан ирнэ хэмээн айлдсан нь үнэн болов уу. Эс бөгөөс энэ хүүхдийг аваачих чөтгөр ирэв үү хэмээн харсанд хаан хүрч ирээд:

– Охин бүү босогтун. Суутугай гэв. Чингээд булж нуусан зүйлүүдийг авчирч өгөв. Охины дэргэд түр суугаад унтахын завсар тэр охин хааны бүсийг аяархан татаж, хөвгүүний дэрэн доор ивсэн тул тэр хаан гэнэт сандарч

– Би явах хэрэгтэй болов. Зэмлэл ирнэ гээд боссонд охин

– Бүс чинь хүүгийн доор орсон буй гэсэнд

– Одоо хүү уйлах буй за гээд орхиж явлаа. Түүний маргааш наран ургахад хүүхэн хааны бүсийг эх хатанд авч очоод

Урьд шөнө хаан ирсэн хэмээн айлдсанд

– Ирсэн бол надад яагаад хэл өгдөггүй юм. Чиний үг худал биз. Үхсэн хойноо уулзана гэдэг ч огт байдаггүй хэрэг гэсэнд хүүхэн

– Ирсэн нь лавтай үнэн Бүс нь энэ мөн буй за гээд бүсийг үзүүлсэнд бүсийг таниад эх хатан муужран унав. Хүүхэн их л бодол бодож байв. Эх хатан сэргэж босоод:

– Одоо дахин ирвэл чи эх хүү бид хоёрыг уулзуулахыг хичээ гэв.

Бас нэгэн сар болсны хойно арван тавны үүр шахахад хангир жингэр дуун гарчээ. Хүүхэн хаан ирж байгаа буюу гээд сандран боссонд хаан

– Хүүхэн хаашаа явах нь вэ. Суутугай гэсэнд

Би эх хатныг урьж авчрахаар одъё гэв. Хаан

– Чи энэ хүү бид хоёрыг хааяа ч уулзах аргагүй болгож байна. Би эхтэйгээ уулзахын нөхцөлгүй гэсэнд

– Эх хатан хэл өгөөрэй гэж захисан билээ хэмээн хэлэв. Хаан хөвгүүн

– Би ээжтэй уулзахын арга байж болох боловч чи яагаад ч гүйцэтгэж үл чадна гэсэнд хүүхэн

– Учрахын арга байваас аминд тулавч чадахыг бодно гэхэд

Чи дуугүй суу. Чадахгүй гэв. Хүүхэн өгүүлрүүн

Их хаан аа. Эхийн магнайн нүд болсон ганц хөвгүүн нь эхтэйгээ учрахын арга байдаг болбоос би үхэвч үхсүгэй. Хааны үндсийг залгамжлах ганц хүү ч буй тул би ямар бэрхтэй боловч бүтээж чадна хэмээн айлдсан тул хаан

– Чи бэрх үйлийг бүтээвээс одоо би буцаж ирэхийн арга бий гэв.

– Тийм арга байваас намайг сэтгэлдээ таална уу хэмээн айлдсанд:

Чи ерийн төрөл дорой тул зориг мөхөс, ялангуяа чамд нялх хөвгүүн байгаа учир үл чадна. Санаа амар сууваас зохих буй за. Үл чадах нь лавтай. Гэвч чадваас чи сэтгэлдээ сайн хадгалагтун. Би өгүүлбэ. Манай эндээс цааш одох аваас шулмасын хар голын дотор багтсан сайхан амтат үлэмжийн нэгэн булаг бий. Түүнийг олж очоод «урьд үзсэн булгуудын дотор чамаас муухай булаг үгүй ажгуу» гээд жишүү хараад хөвөөн дээгүүр нь яваад өнгөртүгэй. Түүнээс цааш явбаас өөр цус болсон нэгэн булаг бий. Түүнд «урьд үзсэн булгуудад чамаас сайхан амттай ариухан нь үгүй» гээд нэг сайн уучхаад угаалыг үйлдээд яваарай. Түүнээс цааш явтал үлэмж сайхан нэгэн суварга бий. Түүнд «урьд үзэгдсэн суварганд чамаас өөр бөөлжис хутгамаар суварга үзээгүй. Чамд адистид байхын нөхцөлгүй» гээд буруу эргээд яваарай. Түүнээс цааш очтол хар нохойн сангарцгаар үйлдсэн нэгэн суварга буй. Түүнд «урьд үзсэн суваргад чамаас адистидтай ариухан сайхан суварга үзээгүй» гээд адистид айлтгаж эргээд яваарай. Түүнээс цааш одвоос шөвөггүй зөвхөн хуруугаараа гутал сэлбэж байгаа нэгэн өвгөн бий. Түүнд нэг шөвгийг өгтүгэй. Түүнээс цааш одвоос нэгэн эмгэн хуурга хуурахдаа

галын хайчгүй хөхөөрөө арчиж хуурга хуурч буй. Түүнд галын хайч нэгийг өгтүгэй. Түүнээс цааш одвоос хоёр хөвгүүн ганц хувцас булаалдаж байна. Тэдэнд нэжгээд дээлийг өгтүгэй. Түүнээс цааш одвоос ганц баглаа өвсийг хоёр ишиг булаалдаж байна. Тэдэнд баглаа өвс нэжгээдийг өгтүгэй. Түүнээс цааш одвоос хоёр хөгшин нохой нэгэн яс булаалдаж байна. Тэдэнд нэжгээд ясыг өгтүгэй. Түүнээс цааш одвоос дөрвөн үүдтэй төмөр хот бий. Түүний дотор тарничны байдалтай эр эм шулмас их хот мандал бэлтгээд байна. Хот мандлын захад нь хар зүрх «намайг ав, намайг ав» гэж буй. Хот мандлын голд бусад зүрхнээс жижигхэн булбалзсан улаан зүрх «намайг бүү ав, намайг бүү ав» гэж буй. Гол хэрэгтэй авах юм нь энэ болно. Тэр замаар зорчиход бэрх бөгөөд тэдгээр тарничин чадал хүчин ихтэй сүрхий аймшигтай тул чи авч үл чадна гэсэнд хүүхэн

– Хаан чамтай л ханилах учир буй бол хэдий их бэрх боловч бүтээхийг чармайна гэсэнд хаан

– Хүүхэн яавч одох болбоос тэр зүрхийг аваад ер дуун гаралгүй, огт эргэж харалгүй явж манай энэ харшид ирвэл бид нар учирч болно. Чингэж хүүхэн чи чадах уу гэсэнд хүүхэн

– Амин дээр тулсан ч авч ирье. Эх хөвгүүн хоёрыг уулзуулахын ерөөлийг тавья. Би энэ бэрх үйлийг бүтээнэ хэмээн айлдсанд хаан

– Буцаж харихгүй, үг дуун гарахгүйг сэтгэлдээ баг бодох хэрэгтэй гээд залрав.

Тэр охин хааны айлдсан бүхнийг эх хатанд айлдсанд эх хатан баясаад

– Хэдийд явах вэ гэв.

Хорин есний үдэш явья гэв. Чингээд хорин есний шөнө болоход охин урьд юу гэж өгүүлсэн ёсоор хэрэглэл бүгдийг аваад одов.

Тэр голд хүрэхэд үлэмж сайхан амттай булаг дайралдав, Түүнд

Урьд үзэгдсэн усанд чамаас бөөлжис хутгамаар булингартай булаг үзээгүй. Одоо байгаа булагт чамаас бузар булаг үгүй гээд шороо цацаад нүдээ буруулж цааш явтал цус бээр болсон нэгэн булаг тааралдав. Тэр булагт «урьд үзсэн булгийн дотор чамаас сайхан амттай нь үгүй билээ» гээд амандаа нэг балгаад угаалыг үйлдэж явав. Цааш яваад гайхамшигт суваргын дэргэд хүрэв. «Урьд үзсэн суваргад чамаас муухай бөөлжис хутгамаар нь үгүй байна» гээд буруу эргэж алхаж гишгээд явсанд хар суварга тааралдав.

«Урьд үзсэн суваргад чамаас сайхан нь байсангүй» гээд адистидийг айлдаж эргээд одов. Түүнээс цааш одвоос шөвгөгүй өвгөн тааралдсанд шөвгө өгөв. Түүнээс цааш одвоос галын хайчгүй эмгэн тааралдсанд галын хайч өгөв. Түүнээс цааш хувцасгүй хөвгүүдэд хувцас нэжгээдийг өгөв. Түүнээс цааш одвоос хоёр ишигт баглаа өвс нэжгээдийг өгөв. Мөн цааш одвоос яс булаалдсан нохой байсанд яс нэжгээдийг өгөв. Түүнээс цааш явж төмөр хотын дорно зүгийн үүдэнд хүрэв. Үүдээр дотогш орж очсонд тарничид. зарим нь хэнгэрэг дэлдэхийн завсар унтсан байх ба зарим нь хум хум пад пад гэхийн завсар унтсан байхын дундуур сэмээрхэн гэтэж очсонд булбалзан чичирсэн, нэг зүрх «намайг бүү ав, намайг бүү ав» гэж байсныг шүүрэн авч өврийнхөө мухарт хийгээд дутаав. Түүнийг хоёр нохойн дэргэд

хүрэхэд тарничид мэдээд үсээ сэгсийлгээд соёогоо ярзайлгаад эр шулмас баруун талаар нь цувалдаад эм шулмас зүүн талаар нь дувалдаж «хоёр нохой түүнийг барьтугай» гээд хөөсөнд хоёр нохой

Бид хоёр энэ ясыг булаалдаж өдөр бүр хэрэлддэг байсан билээ. Яс нэжгээдийг бидэнд өгсөн тул хүүхнээс илүү ачтай этгээд үгүй. Иймд чи чадах чинээгээрээ дутаагтун. Бид чадах чинээгээрээ саатуулья гэв. Чингээд хоёр ишигний дэргэд очиход

Ишиг чи түүнийг барь гэсэнд хоёр ишиг өгүүлсэн нь:

– Бид хоёрт өвс өгсөн тул хүүхнээс их ачтай нь үгүй. Чи чинээгээрээ дутаагтай гээд өнгөрүүлэв. Бас ах дүү хоёрын дэргэд хүрэхэд «түүнийг барь» хэмээн өгүүлсэнд, ах дүү хоёр

– Хүүхнээс ачтай этгээд үгүй. Чинээгээрээ дутаагтай гэв. Бас эмгэний дэргэд хүрэхэд «эмгэн чи түүнийг барь» гэв. Эмгэн

– Надад чамаас илүү ачтай нь үгүй учир чадах чинээгээрээ дутаагтай. Би ч чадах чинээгээрээ түдгэлзүүлье гэв. Бас өвгөний дэргэд хүрэхэд «өвгөн чи түүнийг барь» гэхэд

– Надад чамаас их ачтай нь үгүй тул чи чадах чинээгээрээ дутаагтай. Би ч чадах чинээгээрээ түдгэлзүүлье гэв. Бөөлжис хутгамаар суваргын дэргэд хүрэхийн сацуу «түүнийг барь» гэсэнд

– Надад мөргөж адистидийг айлдсан нь чамаас өөр үгүй тул чадах чинээгээрээ дутаагтай гэв. Бас сайхан суваргын дэргэд хүрэхэд «түүнийг барь» гэв.

– Энэ мэтэд ам мурийж ч болохгүй. Охинд юу ч хийгээгүй байхад тоолгүй алхаж буруу эргээд явчихсан тул үүнийг барих ахул яндрьг нураах ч мэдэшгүй гээд барилгүй өнгөрүүлэв. Үүнээс нааш дутааваас идээ бээр цустай булагт хүрэхэд «түүнийг барь» гэсэнд

– Надаас илүү бөөлжис хутгамаар булаг энэ голд үл байхад намайг магтсан нь охиноос бус үгүй тул чи чинээгээрээ дутаагтай. Би ч чадах чинээгээр түдгэлзүүлье гээд өнгөрүүлэв. Бас анхны тунгалаг сайхан булагт хүрсэнд «булаг чи түүнийг барь» гэсэнд

– Энэ мэтэд хааш яаш үл болох буюу. Энэ эм огт тоохгүй доромжлоод шороо цацсан тул өдгөө барих аваас бүр ч баллах буй гээд хүүхнийг барилгүй өнгөрүүлэв. Тэр хүүхэн харшийн үүдээр дотогшоо орохдоо гэдрэг харсанд «нааш ир, нааш ир» гээд хаан харшин дотор хэдийн ирж нүдээр ширвэн харж байв.

– Хан хөвгүүн ирсэн хэмээн хөгшин ээж хан хөвгүүнээс зуураад «үхсэн амьд учрав» гээд түр муужран унав. Түшмэл албат бүгд хамтаар баярлав. Тэр хүүхэн лавтай буян ихтэй тул хөвгүүнийг үүрд гэтэлгэв. Тэр хүүхэн хатан болж дөрөв таван хөвгүүд охидыг төрүүлж, хаан төрийг ч урьдаас улмаар дэлгэрүүлж, өдөр шөнийг номоор өнгөрүүлэх болов хэмээн хүүр ярьсанд Сайн амгалан явдалт хаан

– Тэр охин жирийн байдалтай буян ихтэй байжээ хэмээн хэлсэнд хүүр .

– Хүүрт үг хэлэв хэмээн төмөр торыг гал бадартал гурав дэлдээд харцага мэт хүр гээд

алдуурч одов.

Охин, хааныг үхлийн орноос аварсны гуравдугаар бүлэг болой.

# ХААН НОХОЙД ХУВИЛЖ ЭХНЭРЭЭ ЭРСЭН БҮЛЭГ ОРШВОЙ

Бас хаан төлдрийн хүүрийн тэнд очоод

– Лам минь Наганжуна зүрхэн мөн. Би өөрөө Сайн амгалан явдалт хаан мөн. Хутга чулуу таслагч мөн. Тор есөн нүхт төмөр мөн. Тогшуур мод хүрэн сэндэн мөн. Хүлэг мэхт гинж мөн. Хүүр буухгүй буюу. Эс бөгөөс модыг унагана гэсэнд хүүр бууж ирэхэд тогшуураар дэлдэж торын дотор чихээд хүлгээр чанга хүлж үүрээд арван алхам төдий явахын үед хүүр: «Хан хөвгүүн, Хан хөвгүүн» гээд

– Зам хол уйтгартай тул нэгэн түүхийг хэлтүгэй, Эс бөгөөс би хулганын хумсын төдий юм ярья гэв. Хаан ч «чамайг мэдэж байна» хэмээн бодоод дуун эс гаргасанд

– Үйлээ барсан хаан чиний мэтийн амнаас үг үл гарах буюу.

Чи өөрөө сонстугай гээд өгүүлрүүн:

Нэгэн их голд нэг их хаан байсан бөлгөө. Тэр хаан нөхөр, төгс эдлэл, хотол чуулган бүрдсэн төрөл язгуур үндэс төгөлдөр тул хатан болох охин олон буй боловч тэр хаан хэрсүү ухаантай тул «бус нэгэн орны эмгэн өвгөн хоёрт буянтай, гурван охин байгааг авья гэвэл өгөх буй за» гээд буян нь их багыг дэнсүүлэх ба хэрсүү цэцнийг шинжлэх хэрэгтэй хэмээн таалж хаан нэгэн хөгшин нохойд хувилаад нарийвчлан шинжлэхээр явж тэр оронд хүрээд нэгэн ачмаг арвай үүрч өвгөн эмгэний үүдэнд очив. Эмгэн ус авахаар гарч ирсэнд хөгшин нохой

– Ээ, хөгшин эмгэн. Миний энэ ачмаг арвайг хадгалж өгнө үү? гэсэнд эмгэн

– Арвайг хадгалж болно гэхэд хөгшин нохой:

– Намайг арвайгаа авахаар ирэхэд энэ арвай бэлэн байх хэрэгтэй.

– Хэзээ ирж авах вэ? гэсэнд хөгшин нохой

– Хэзээ ч магадгүй гээд буцаж явав. Түүнээс хойш хэдэн жил өнгөрсөн боловч тэр нохой арвайгаа авахаар эс ирсэнд эмгэн нь өвгөндөө

– Эртний ирж захисан тэр хөгшин нохойн яс үс нь ч үрэгдсэн буй за. Нохойн нас есөн жилээс давахгүй тул тэр одоо үхсэн байх. Ер алга болжээ. Тэр арвайг биеэр нь байлгах гээд сольж болохгүй сав эзлээд байна. Үүгээр архи нэрье гэхэд өвгөн

– Тэр хэвээр байлгах хэрэгтэй гэсэн тул хадгалваас сайн гэхэд

– Сайн арвай юм. Зээлж хэрэглээд нугалж төлвөл болох ажгуу хэмээн хэлж архи нэрэв. Түүнээс хэд хоногийн дараа тэр нохой булгийн дэргэд ирсэнд хамгийн их хүүхэн ус авч яваад тааралдав. Нохой хүүхэнд:

– Хүүхэн ээ. Эхэд чинь эрт захиж хадгалуулсан арвайгаа хэрэглэе гэсэнд хүүхэн ээждээ ирж



- Тэр нохой арвайгаа хэрэглэе хэмээн ирсэн байна гэв.
- Чингэвэл дотогш оруулахгүй яав гээд, ээж нь өөрөө гараад дотогш дуудав.
- Ээ, чамайг эртнээс хойш хүлээгээд ирэхгүй болохоор чинь бид арвайгаа нийлүүлсэн билээ гэсэнд нохой
- Чингэж бүү ярь. Би урьд тэр арвайг биеэр хэрэглэнэ гэсэн шүү дээ. Одоо тэр арвай л хэрэгтэй гэсэнд
- Чиний тэр бүтэхгүй болсон. Нийлүүлээд үгүй болгосон гэв.
- Нийлүүлж дууслаа гэвч миний л арвайг өгвөөс болох буй за гэсэнд, эмгэн
- Эртээс хүлээгээд ирээгүй учир, гурав буюу дөрвөн хувь болгож өгье гэхэд, нохой
- Зуун хувь болгож өгсөн ч миний өөрийн арвай биеэр бус болбоос авахгүй гэв.
- Чи өөрөө түргэн ирэхгүй байгаад иймд хүргэв гэсэнд,
- Би хэзээ ч ирэх магадгүй. Ирэхийг хүртэл хадгалтугай гэсэн шүү дээ. Одоо чи миний арвайг үгүй болгосон болбоос охины чинь нэгийг авья гэсэнд
- Өөр арвай эс авбаас охиноо өгөх хэрэгтэй буй за гээд их охиноо түүнд өгөв. Нохой тэр охиныг дагуулаад тэртээ газар хүрсэнд нэг их ус байв. Нохой
- Охин оо. Чамайг би үүрье гэсэнд охин нохойд үүрүүлээд ус руу орсонд «Чи цэцэн бус байна» хэмээн бодоод нэгэн эргийг өгсөж явав. Тэр эргэн дотор аятай ор дэвсгэр ба гал голомт, хоол ундны хэрэглэл ч байв. Нохой
- Мах тосыг охин цадталаа ид. Надад ч өг. Сайхан ор дэвсгэрийн дээр жаргая гэсэнд тэр охин: «Энэ хөгшин нохой энэ эргэний дотор суудаг байна гээд өөрөө цадтал идээд нохойд нохойн хоолыг өгөөд, охин өөрөө гурван давхар дэвсгэр дэвсээд нохойд гол нь цоорсон нэгэн дэвсгэрийг дэвсэж өгчээ. Нохой «Энэ охин тэнэг байна. Буян асар ихтэй боловч буянтайгаас цэцэн нь дээр» хэмээн бодож хүүхнийг
- Эхдээ очихыг бэлтгэгтүн гээд хэсэг бөөн мах үүрүүлэн хоёул хөгшин ээжтэйгээ уулзахаар явав. Тэднийд хүрч ирэхэд эх нь:
- Охин минь ирэв үү? Сайн байв уу? гэсэнд охин
- Би сайн байлаа гэв. Ээж
- Аяа, хөгшин нохой хаана байна? гэхэд, тэр гадна байна гэв. Эх нь хүүхнээ
- Чи яасан тэнэг юм бэ? Түүнийг гэртээ оруулахгүй, Мунхаг байна гээд гарч «хөгшин нохой сайн явж ирэв үү? гээд урьсан тул

– Хөгшин эхийн бие сайн буюу гэв. Чингээд нохойг дотогш оруулав. Нохой, өвгөн эмгэн хоёрт

– Би танай дунд охиныг авья гэсэнд

За хүргэн нохой минь авья хэмээвээс өгөх хэрэгтэй гээд өгөв.

Тэр хоёр ханилаад явлаа. Усны дэргэд хүрсэнд

Охин оо, чамайг би үүрье гэсэнд

– Эр минь мөн тул би үүрүүлж болохгүй. Харин хувцас сав хоёрыг үүрч тусал гээд толгойгоо нийлүүлээд гатлав.

– Чи эгчээсээ арай дээр юм гэж бодож эргэн дотуур өгсөн нөгөө газарт ирээд

– Чи мах тосыг өөрөө ч ид, надад ч өгтүгэй. Дэвсгэр дэвсэгтүн гэсэнд охин махны үлдэгдэл ба яснуудыг нохойд өгөв. Охин өөрөө аль сайныг нь идсэн тул «тэр охин эгчээсээ арай сайн буюу. Одоо сонгож авахад бага охины хэрсүү цэцнийг шинжлэх хэрэгтэй» хэмээн сэтгээд, бас тэр охинд нохой хэлэв

– Нэг хэсэг бөөн мах үүрээд явж эхтэйгээ уулзваас сайн гээд хөгшин нохой ханилаад очив. Үүдний дэргэд хүрэхэд охин дотогшоо оров. Өвгөн эмгэн хоёр

– Охин ирэв үү? Гэр хотлоор мэнд сайн уу? Нөхөр хөгшин нохой хаана одсон бэ? гэв.

– Би сайн байна. Хөгшин нохой гадаа байна гэв.

– Манай энэ хоёр охин тэнэгээс тэнэг байна. Дотогш оруулахгүй яасан юм бэ гээд эх нь дуудахаар гарч

– Хөгшин нохой сайн ирэв үү? гэхэд

– Хөгшин ээж бие сайн уу? гэв. Түүнийг дотогш нь оруулсанд нохой

– Таны бага охиныг би авья гэсэнд өвгөн эмгэн хоёр

– Чи жаргалтай сайхан байлгадаг учир өгөх хэрэгтэй гээд түүнийг өгсөнд нохой түүнтэй ханилж их усны дэргэд очив. Нохой

– Охин, би чамайг үүрье гэсэнд охин хэлэв.

– Намайг та үүрч болохгүй. Та нохой боловч эцэг эх минь танд өгсөн тул, эр та ахлагч эзэн мөн тул би үүрэх учиртай буй за. Гэвч би даахгүй билээ хэмээн өгүүлсэнд нохой сэтгэлийн угаас баясаад

– За чингэвэл сав гутлыг би үүрье гэхэд

– Танд гутал ачих хэрэггүй гээд ачсангүй ус гатлав. Эргэн дотор хүрэхэд дэвсгэр ба гал голомт бэлэн байсанд нохой

– Охин өөрөө ч мах тосыг ид. Надад ч өгтүгэй гэсэнд охин тэр махыг чанаж тосыг хайлж нохойд өгөөд өөрөө ч идэв. Нохой баясаад охинд:

– Хоёр эгч чинь надад өгөөгүй. Харин чи аль сайныг надад өглөө гэсэнд охин

– Өгөх учиртай. Өөрийн чинь эд юм мөн шүү дээ гэсэнд нохой болж хувилсан хаан «Энэ охины буян нөгөөдөх хоёр эгчтэйгээ сацуу боловч энэ цэцэн оюунтай байна. Одоо үүгээр үүрдийн нөхөр болговоос сайн буюу» гэж бодоод түүнд бишрэв.

Тэр шөнө зузаан дэвсгэрийг нохойд дэвсэж өгөв. Нимгэн дэвсгэрийг өөрөө дэвсээд хэвтэв. Маргааш өглөө эрт босоод нохойн сангарцаг ба хоёр эгчийн ариун буснуудыг арчин цэвэрлээд сууцыг аятай сайхан болгов. Тэнд өнө удаан суусаар байтал, тэр охиноос гурван гөлөг гарав. Тэр нохойд хувилсан хаан охинд

– Энэ эрэг бол бидний үүрд суухын орон бус, суух газрыг соливоос сайн гэхэд охин

– Гөлөгнүүд нь идээшсэн газар байхгүй. Бусад газар очоод жаргах болов уу даа. Мэдэхгүй тул эндээ сууя гэсэнд нохой

– Хурдхан явбаас яасан ч дээр. Энэ уснаас гарч явъя гээд яван завдсанд охин:

– Гал голомт, дэвсгэр бүхнийг яавал дээр вэ? гэсэнд

Эргэнд хадгалтугай гээд явав. Тэр хоёр өөдөө очсонд тэр голын эхэнд айл олон байсан тул тэр нохой хэлсэн нь

– Ясны дотроос хэсэг бусаг юм олдож болох учир олж идье гээд яван завдсанд охин

– Ханилаад явбаас сайн. Ясан дээрх олон нохой чамайг хөөж барьж идвэл энэ зулзага бага учир буцаж харихад ичгүүртэй, Эх хүүхэд бид ямар байдалд орох вэ?

– Ээ, гэмгүй. Зүгээр зүгээр. Чи өөрийн зулзагануудаа үүрээд алгуурхан явж очоорой гээд одов. Тэр охин мөрөөр нь явсанд эр нь нэг хонхорт ороод нүдэнд үл үзэгдэх болов. Охин тэр өөд очихын цагт мөр нь тодорхой байв. Даваанаас уруугаа бууж нэгэн хонхор дотор орсонд нохойн арьс бутраад цус нь нэлийж улайгаад байгааг охин хараад «Ийм болсон ажгуу. Өнөөх эргэндээ суухыг бодохгүй, хаашаа ямар чөтгөр хөтлөв? Одоо орондоо буцаж харъя хэмээвээс хүнээс гөлөг төрсөн тул ичгүүртэй. Гуйранчилья гэвч яахыг мэдэхгүй» гэж сэтгээд тэр нохойн арьсыг өвчүүндээ дарж хэвтээд уйлж байв. Гэтэл морьтой хүмүүс хүрч ирээд

– Хатан сайн буюу гэхэд, «Энд надаас өөр хүн үгүй» хэмээн сэтгэж уйлахаа болив. Морьтой хүмүүс дэргэд нь ирээд

– Хатан авгай босогтун гэсэнд охин

– Хэнийг гэж эндүүрч энд ирээд байна. Миний эр хөгшин нохой буй. Тэр ясан дээр цугларсан ноходод баригдаад үхсэн гэсэнд

– Бид эндүүрээгүй. Одоо босохыг айлтгая хэмээн гараас нь татав. Охин «Эдгээр нь хэнийг хэмээн эндүүрээд байгаа юм бол? Миний эр хөгшин нохой энд баригдаж үхсэн» хэмээн бодож байтал

– Хатан босогтун гэж босгоод охинд чимэг хувцсыг сайтар өгч «Эгч дүү нар чинь одоо хаана буй» гэв.

– Надад гурван гөлөгнөөс өөр юм үгүй билээ. Хэнтэй эндүүрээд байгаа юм бэ? гэсэнд

– Энэ чинь их хэрэгтэй гээд морьтой хүмүүс түүнийг өвөр дээрээ дүүрэв. Тэнд ирсэн бүгдээр мориндоо мордоод хааны харшид хүрч очив. Тэр хаан алтан ширээний дээр сууж, түшмэд нь эргэн тойрон хүрээлж чимэг хэрэглэлийг сайтар зүүгээд тэр охиныг оюу ширээн дээр суулгасанд тэр охины сэтгэлд «надад эр хөгшин нохойноос өөр нөхөр үгүй. Энэ нь гайхамшиг тавилантай тунгалаг царайтай хаан байна» гээд юу ч хэлэхээ мэдэхгүй чиг зогссонд хаан

– Охид хүүхэд хаана байна? гэв. Тэднийг авчирсан хүмүүс гөлөгнүүдийг хааны мутарт өргөсөнд гурван гөлөгний оройгоос нь илбэн зулбасаар гөлөгний арьсыг хуйлруулан гайхамшигт сайхан хоёр хөвгүүн, нэг охинтой гарч ирэв. Хаан:

– Эднийг би өөрийн адилаар хувилгасан юм. Охин оюу ширээн дээр суутугай гэсэнд охин маш баясаж гайхаад мөргөж оюу ширээн дээр суув. Тэр орны хааны хатан болов.

Хаан, хөгшин эцэг эх хоёрыг нь дуудаж авчраад улс гүрнээ урьдаасаа нэн улам дэлгэрүүлэн мандуулж, хаан төрийг номтой зохицуулан барив. Ийм буян ихтэй нэгэн охин байв гэсэнд Сайн амгалан явдалт хаан

– Тэр охин нь хоёр эгчээс илүү хэрсүү цэцэн буян ихтэй буюу гэсэнд

– Хүүрт үг алдав гээд төмөр торыг гал бадартал гурав дэлдээд харцага адил хүр хэмээн араас алдагдав.

Хаан нохойд хувилж эхнэр эрсний дөрөвдүгээр бүлэг болой.

# ХУДАЛДААЧНЫ НОЁН БРАНМА СЭРЧҮН ХЭМЭЭГЧ БУЯНТАН ХААН ТӨРИЙГ БАРЬСАН БҮЛЭГ ОРШВОЙ

Бас хаан тэр модны дэргэд очоод

– Лам минь Наганжуна Зүрхэн мөн. Би өөрөө Сайн амгалан явдалт мөн. Тор минь есөн нүхт төмөр мөн. Тогшуур минь хүрэн сэндэн мөн. Хүлэг минь мэхт гинж мөн. Хутга минь чулууг таслагч мөн. Хүүр чи буухгүй буюу Модыг чинь унагана гэхэд тэр бууж ирсэнд тогшуураар дэлдээд торын дотор чихээд хүлгээр сайн хүлээд зорих газар өөдөө үүрээд одов.

Хаан аа, зам хол уйтгартай тул түүх ярьтугай. Эс бөгөөс би ярья гэхэд хаан үг алдуулах буй хэмээн бодоод дуун эс гарав. Тэр хүүр өгүүлрүүн:

– Үйлээ барсан хаан чиний амнаас үг гарахгүй буюу? Би хулганын хумсын төдий нэг түүхийг өгүүлье. Сонстугай

Нэгэн голд нэг хаан байсан бөлгөө. Бус нэгэн орноос худалдааны хэргээр ирсэн нэгэн хүц тэр оронд тохинин суурьшиж байв. Нэгэн үе болоход тэр хааных шинэ жил болохын учир боов хийж байв. Худалдаачин үүдний завсраар харахад боовоо эргүүлж байх нь харагдав. Боовоо гарган тоолж гүйцээд үүдээ нээв.

– Надад нэгэн боов хайрлана уу гэхэд

Боовны тоог таах болбоос өгч болно гэсэнд «Болно» гээд одоогийн байгаа боовны тоог хэлсэнд аргагүй үнэн байсныг хаанд айлтгасанд хаан

– Энэ мэргэн хүн байна гээд тэр худалдаачныг мэргэн худалдаачин ноён хэмээн алдаршуулав.

Бас нэгэн үе болоход хаан морио алдсан тул худалдаачны ноёныг дуудаж ирүүлээд:

– Бид нар морио алдсан учир чи мэргэлж өгөгтүн гэв. Тэр ноён гэртээ хариад сэтгэл нь зовж, байшин дээрээ гараад сууж байв. Морь хулгайлсан гурван хүн ирээд

– Худалдаачны ноён мэргэн гэдэг бил үү? гэлцэж байв. Тэднийг юу ярьдаг бол гээд худалдаачны ноён далдаас чагнаж байв. Худалдаачны ноён тэднийг харсан боловч тэд ноёныг үзсэнгүй хоорондоо ярилцав. Нэг нь:

– Ноён хэрвээ мэргэн бол бид баригдах болно гэсэнд нэг нь

– Түүнийг үнэн хэмээн үл итгэнэ гэв. Худалдаачны ноён тэр гуравт үзэгдэлгүй арьсан дэвсгэрийн үсийг гадагш харуулаад тэр гурвын толгой дээр дахин дахин сэгсэрсэнд тэдний толгойд дэвсгэрийн үс тоос тогтов. Тэр гурав нь

– Одоо сонстохооргүй далд газарт очье. Мэдэгдэх буй за гээд явцгаав.

Худалдаачны ноён баясаад маргааш нь хааны дэргэд очиж

– Голын хүмүүсийг цугларуулах хэрэгтэй гэв. Тэр мэт мянганы ноён зуутын ноёныг, зуутын ноён аравны ноёныг удирдаж албат хүмүүсийг цугларуулав. Худалдаачны ноён хэсэж явтал нөгөө гурвын толгой дээр дэвсгэрийн үс илхэн харагдав. Тэр гурвуул нэгэн хамт сууж байв.

Энэ гурав мөн гэсэнд, тэр гурав хааны морийг алалгүй гаргаж өгөв. Тэдгээрийн амь өршөөхийг гуйж худалдаачны ноён айлтгал хийв. Тэр хааны таалалд

– Энэ хүн миний албат бус, өөр газар одвоос хайран гээд охиноо өгөв.

Бас нэгэн үе болоход хааны албат дотроос хааны худалдаачин байсан нэгэн хүн байжээ Тэр гурван илжиг хулгайд алдсаныг хаанд айлтгав. Хаан худалдаачны ноёнд

– Илжгийг хэн хулгай хийснийг мэргэлж үйлдэгтүн гэсэнд худалдаачны ноён

«Нэг хоёр хэмээн тоолсон учраас боовны тоог мэдсэн, сэтгэл үймж байшин дээр суугаад завшаанаар хааны морийг илт мэдэв. Одоо эс дутааваас алагдах буй за» хэмээн сэжигдээд, шувууны мөрийг үйлдэж гадагшаа гараад зүүн тийш дутааж явав. Гэтэл нэг хүн дэр дэр чимээ гаргаад явж байв. Түүнтэй «ханилан явья» гээд гүйж очсонд тэр хүн буцаж эргэж толгойгоо бөхийлгөж худалдаачны ноёнд мөргөхөөр ирэв. Тэр нь илжиг хулгайлсан ханьдаа хоол хүргэж өгөхөөр явж байгаад тохиолдсон хүн ажгуу. Тэр хүн

– Илжгийг чинь өгье. Амь өршөөнө үү гэв.

– Илжиг чинь хаана байна? гэсэнд

– Давааны ард буй гээд, тэр өөрөө дагуулан илжиг ба ханиа дагуулж авчраад аминд хүрэх ял олгохгүйг гуйн айлдаж илжгийг эгүүлэн өгөв.

Бас нэгэн үе болоход хааны сүлдний оюу алдагдав. Түүнийг хааны А Ша хэмээх түшмэл хулгайлсан ажгуу. Хаан

– Худалдаачны ноён оо. Бид сүлдний оюугаа алдсаны тул эрж олно уу гэсэнд худалдаачны ноён

«Нэг хоёр хэмээн тоолсноор боовыг илт мэдсэн, сэтгэл зовж байшин дээр сууснаар хааны морийг илт мэдсэн. Дэмий дутааж яваад илжгийг илт мэдсэн. Одоо би дутаая» гээд байшиндаа буцаж ирэв. Тэр үед түшмэл А Ша хэмээгч

– Миний хийж явсан энэ ажил ямар гутамшигтай ажил болох бол хэмээн шөнө дунд босоод худалдаачны ноёны байшингийн ард очиж зогсов. Тэр үед худалдаачны ноён

– Урьд их л буян эдлэв. Өвгөн эцгийн нэр А Ша гэдэг хэмээгээд уйлсанд А Ша түшмэл үүнийг сонсож

– Найз минь. Би энд байна гэв. Худалдаачны ноён баясаад

А Ша ороод ир гэсэнд А Ша орж ирээд худалдаачны ноёнд

Гэгээн цагаан өдөр би зам эндүүрээв гээд сүлдний оюуг гарт чинь өргөө. Миний амийг өршөөж өнгөрүүлэхийг айлтгая гэсэнд тэр худалдаачны ноён

Оюуг авчир. Би айлтгаж өргөх хэрэгтэй гэсэнд түшмэл худалдаачны ноёнд сүлдний оюуг өргөв.

Худалдаачин тэр оюуг аваад хааны дэргэд очиж сүлдний оюуг хааны мутарт өргөж

– Миний илт мэдлэгийг түшмэлүүд үл итгэж А Ша түшмэл сүлдний оюуг нуусан ажгуу. Дэргэдээс олзлох гэсэн бус байна хэмээн айлдаж сүлдний оюуг мутарт нь өргөв.

Сүлдний оюуг олсон нь маш сайн хэмээн хаан айлдав. Түүнээс нэгэн үе болоход, хааны охинд худалдаачны ноён:

Нэг лонх сайхан архи авчиртугай гээд цонхны дэргэд хэвгэв. Хааны охин архийг худалдаачны ноёнд авчирч өгсөнд тэн хувийг ууж гүйцээд

– Нэг хоёр хэмээн тоолсноор боовыг илт мэдэв. Сэтгэл үймснээр байшингийн дээр суугаад хааны морийг илт мэдэв, дэмий дутааж яваад илжгийг илт мэдэв. Шөнө дунд А Шаг дуудаад сүлдний оюуг илт мэдэв. Худалдаачны ноён хэмээх оронгүй тэнэмэл би, орон ба эцэг эхээ ч санаж байна. Охин чиний эр би батгүй шүү гэсэнд охин уур нь хүрээд хааны дэргэд гүйж очиж

– Миний энэ эр бузар амьтан байна хэмээн хаанд айлтгав.

Чиний нөхөр худалдаачны ноён энэ бол торолтгүй илт мэдэлтэй мэргэн хүн мөн. Төрсөн газар, язгуур үндэс ямар ч болов охин чиний эр мөн. Чи дуугүй буцаж яв гэсэнд, охин

– Нэг хоёр хэмээн тоолсоор боовны тоог би ч мэдэж чадна. Хааны морийг хулгайлснаа ярилцаж байгсдыг толгой дээр арьсны үс бутарган унагаж түүгээр илт мэдэж би ч чадна. Дэмий дутаан явж байгаад илжиг хулгайлагчтай тааралдаад илт мэдэж би ч чадна. Тэр өөрийн өвгөн эцэг А Шаг дуудсанаар А Ша түшмэл оюуг өгсөн байна. Ийм илт мэдэл надад ч байж болно. Би түүний эхнэр болж үл чадна гэсэнд хааны дэргэд байсан нэгэн ухаант түшмэл

Урьдын явдал ч үнэн билээ. Охин чингэж өгүүлж байгаа бол тэр ч үнэн буй за. Маргааш голын ардуудыг цуглуулья гээд тэр түшмэл бяцхан хэсэг хүнс үүрээд давааны ард очиж дөрвөн зүг тийшээ харсанд хүний бараа ганц ч үгүй. Гөрөөс, мануул зэрэг нуугдан дутаав. Хэсэгхэн цэцгийн дунд нэгэн батгана сир сир хэмээн дуугарч байв. Түүнийг барьж таван өнгийн хив дотор боож ирээд нутгийн ардуудад зарласанд ардууд «найр хурим болох буюу» гээд нэн олноор цугларав. Тэнд тэр хааныг алтан ширээн дээр урин залав. Худалдаачны ноёныг «Ир» гэв. Ноён ирсэнд түшмэл

– Торолтгүй илт мэдэгч мэргэн худалдаачны ноён оо. Миний гарт юу буй гэсэнд худалдаачны ноён

– Нэг хоёр гээд боовны тоог илт мэдсэн. Сэтгэл гансарч байшин дээр суугаад хааны морийг илт мэдсэн. Дэмий дутааж яваад илжгийг илт мэдсэн. Шөнө дунд А Шаг дуудаад сүлдний оюуг олсон билээ. Энэ өдөр насны хэмжээ гүйцсэн батгана түшмэлийн гарт үхэх нь шиг байна гэсэнд тэр ухаант түшмэл «Ха ха» гээд

– Охин тэргүүлэн голын ардууд миний дэргэд ир гээд

– Давааны ард саяхан хүн, гөрөөс, ямар ч амьтанд үзэгдүүлэлгүй нэгэн найлзуурын цэцэг дээр эргэж байсан батганыг барьсан бөгөөд одоо худалдаачны ноёны хэлснээр үхсэн байх гээд хивийг улам улмаар тайлсанд батгана нисэж чадахгүй байсанд худалдаачны ноёныг хаан түшмэл цөм итгэмжлэв. Тэр охин ба худалдаачны ноён хоёрт хаан гүрнийг эзлүүлээд хаан номыг үйлдэн суув. Албатууд ч дэлгэрэн мандаж байв гэсэнд Сайн амгалан явдалт хаан

– Тэр хүн буян ихтэйеэ. Хэлсэн бүгд нь ёсоор болох буюу гэсэнд

Хүүрт үг хэлэв хэмээн төмөр торыг гал бадартал гурав дэлдээд харцага мэт хүр хийтэл нисэж араас алдагдав.

Бранма Сэрчүн, буяны хүчээр хаан төрийг эзэлсэн тавдугаар бүлэг болой.



# АМИЛСАН ХУТГАНЫ ХҮЧЭЭР ХААН ТӨРИЙГ ЭЗЭЛСЭН БҮЛЭГ ОРШВОЙ

Сайн амгалан явдалт хаан модны дэргэд очоод

– Лам минь Наганжуна Зүрхэн мөн. Тор минь есөн нүхт төмөр мөн. Тогшуур минь хүрэн сэндэн мод мөн. Хүлэг минь мэхт гинж мөн. Хутга минь чулуу таслагч иртэй мөн. Тостой гурил минь барагдашгүй идээ мөн. Хүүр буухгүй буюу? Модыг чинь унагана гэсэнд тэр бууж ирэв. Түүнийг тогшуураар дэлдэж, торон дотор чихээд, хүлгээр хүлээд зорьсон газар тийшээ үүрэн явав.

Зам хол уйтгартай тул хаан түүх ярьтугай. Эс бөгөөс би түүх ярья гэсэнд, хаан тэр учрыг сайн мэднэ хэмээн бодож эс дуугарав. Хүүр

«Үйлээ барсан хаан чиний амнаас үг эс гарах буюу. Би хулганын хумсын төдий нэг түүхийг ярья. Сонсогтун» гээд өгүүлэв.

Нэгэн голд нэг хаан байжээ. Түүнд хоёр хөвгүүн мэндэлсэн ажгуу. Их нь балай тэнэг болж, бага нь хэрсүү хянамгай болов.

Дүүд нь хаан төрийг бариулж, ахад нь хэсэг нутгийг тастан өгч тусгай суулгав. Эцэг эх хоёр нь нас нөгчсөний дараа дүү хаан ахынхаа нутгаас хэсэг газрыг хил тогтоон тастаж авсанд их хөвгүүн зовнин алжааж байв. Тэр хаан очирваанийг шүтэж түүний урилгыг унших болов. Хэдэн шөнө дараагаар залгамжлан «амилсан сайн хутга ирнэ» гэх үг сонстов. Чингээд байж байтал нэг өглөө тэр нутгийн нэгэн баян хүн хумханд архи дүүргээд хэт хутганы хамт авчирч хаанд өргөж мөргөөд

Эцэг эх минь өгсөн энэ хутганаас өөр сайн юм үгүй билээ. Тариагаа хурааж үл гүйцдэг учир, хаан та энэ хутгыг газар тариагаар "арилжиж авбал надад ч тус болох ба хаан танд ч үлэмж тус болно. Надад эш үзүүлэв гэжээ. Хаан:

Чамд ямар эш үзүүлсэн бэ? гэхэд баян хүн

Намайг нойр хүрч зүүрмэглэж байхад, чи энэ хутгыг голын эхний их хаанд өргөгтүн хэмээн эш үзүүлсэн билээ хэмээн айлтгав.

Надад үзүүлсэн эштэй нийлж байна хэмээн таалаад хаан хутгыг худалдан авч оронд нь тариагаа өгөх цаг болзож тогтоов. Баян хүн баясаад голын адаг руу явав. Хаан хутгатай болсондоо тайвширч сэтгэл нь амарчээ.

Нэгэн үе болсонд бас нөгөө хутга

Энэ даваанаас цааш гарваас нэгэн их хэрэг бүтнэ. Хурдан явтугай хэмээн хан хөвгүүнд хэлэв. Хан хөвгүүн явсаар даваан дээр гарч харсанд тэр доор олон хүн бөөгнөрөн байв. «Их хурим болж байгаа юм уу?» хэмээн таалаад даваанаас бууж очоод харсанд олон хүн цуглаж шоо орхиж байх бөгөөд тэдний дотроос гурван хүн мөрий алдсан ажгуу. Түүнд голын хүн бүгдээрээ элдэв зүйлийн идээ өгч төрөл садан нь цуугилдан гашуудал болж байжээ. Хан

хөвгүүн:

Энэ гурав ямар гэм хийв хэмээн асуусанд ардууд

Энэ хүмүүс гэмгүй. Манай энэ голд байсан Номч их хаан хатан хоёрт нэгэн охин мэндэлсэн билээ. Номч хаан эцэг эх хоёр нь нас нөгчсөний дараа охины сэтгэлд ад оршиж, дотоод түшмэл ба нөхөд бүхнийг идэж дуусав. Одоо голын хүмүүсийг цуглуулж өдөр бүр гурван хүнийг өгөх хэрэгтэй боллоо гэв. Хаан

– Эд бүхэнд сэтгэлийн зовлон цаглашгүй тохиолджээ. Надад сэтгэл зовох хүнгүй хэмээн таалаад «би эдний төлөөнөө очъё хэмээн айлдсанд ардууд баясаад тэр гурван хүн хийгээд ойр хавийн хүн бүгдээр оточ бурхны харшид мөргөх мэтээр мөргөцгөөв. Сайхан идээнүүдийг хаанд өргөөд маш их өргөл хүндлэлийг үйлдэв.

Хаан өөд яваад тэд нарын очих харшийн үүдэнд хүрсэнд хүн нохойн чимээ огт үгүй ажгуу. Нэгэн том шат байв. Түүгээр өгсөж явахад бөөн олон хүүрийн дунд толгойгүй хүүр баруун талд зуун найм, хөлгүй хүүр зүүн талд зуун найм байв. Хан хөвгүүн

– Өдий олныг хураагаад идчихээд байдаг тэр этгээд нь хаана байна? хэмээн таалж цааш өгсөхөд нэгэн хаалга тулав. Түүнийг нээгээд орсонд найман баганатай ордны дунд сайхан оюу ширээн дээр харваас гоо тунгалаг сайхан царайтай арван найм орчим насны охин, гөрөөсний арьсан дах өмсөөд сууж байв. Бусад зүгт харахад цоожтой хаалга огт үгүй байв.

– Иддэг чөтгөр нь хаана байна? гээд ойртож очсонд хаана ч үл байв. Тэр оюу ширээн дээр байгаа хатанд «хатан аа» гээд толгойг өргөвч өндийж өгсөнгүй. «Хамраар нь амьсгал гарч байна уу?» хэмээн харсанд бараг амьсгалгүй мэт байв. «Тэнд чөтгөр ирээгүй буюу. Эс бөгөөс авч дууссан буюу?» хэмээн бодоод хоол ундны газар цааш орсонд бусаг бусаг мах тоснуудын дээгүүр тоос бүрхэн тогтсон байв. Мах тосыг гаргаад нарийн гурилаас толгойн төдийг зуурч их тостой найруулаад охины ширээн доор орж идсээр суув.

Тэнд наран үдээс хойш болоход охин ширээн дээрээс хөлбөрөн тэлчилж ухасхийхэд хан хөвгүүн ширтэж харав. Хутга ч хуйнаасаа сугарч байв.

Энэ охин ч хялбар л байна. Идчихдэг чөтгөр нь хаана байгаа бол? хэмээн сэтгэж Очирваанийн тарнийг урин сууж байв. Наран шингэх үед охин мөн тэлчлэн өндийж ухасхийсэнд хутга ч мөн хуйнаасаа сугарч байв. Тэр охин ч дайвалзан балбалзаж байв. Баганын завсраас дин дин хэмээх дуун хоёр дахин гарч, эмийн хамраас хоёр могой цухалзав. Хаан түүнийг хараад айн боссонд хутга

– Хаан аа. Суу гэв. Хоёр могойг гарч ирмэгц хутга нь хуйнаас сугарч хан хөвгүүн муужран унав. Хуйнаас сугарсан хутга нь хоёр могойг хүзүүгээр нь тастаад эр эм шулмасуудыг номтгон дарсанд тэр охин хан хөвгүүний дэргэд ирж

Цэцэн ухаант минь хэмээн толгойноос нь өндийлгөв. Хан хөвгүүн боссонд тэр хутга ч хуйндаа орлоо. Хан хөвгүүн охиноос

Тэр хоёр могой хаашаа одов хэмээн асуусанд

Чиний хутга, хоёр могойг хүзүүгээр нь тас огтлоход түүний хэрчигдсэн хэсгүүд хутганы ишний завсраар доош орсон гэв. Хан хөвгүүн тэр хутганы талыг гаргаад Могой буй буюу гэсэнд тэр хутга хаанд

Эр эм шулмас одоо дарагдаж үгүй болсон. Могойн хэсгийг идэж дууссан гэв. Охин хаанд

– Танд орон буй буюу, үгүй буюу? Манай голын хүн биш бололтой гэсэнд, хан хөвгүүн өөдөөс нь ширтэж юу ч эс өгүүлэн байтал хутга

– Оронтой байсан учир төрсөн эр буй за. Язгуур үндэс ариухан хааны хөвгүүн мөн. Та хоёрыг өөд татахыг би гүйцэтгэнэ гэсэнд охин

– Энэ сайн хутгыг эцэг эх чинь өгсөн буюу? Хаанаас олсон бэ? гэсэнд

– Сайн хутгыг хэнд ч хэлэхийн хэрэггүй. Явбаас өмнөө зүүдэг юм. Хэвтвээс дэрэн доороо хийдэг юм. \*\*\*\*\* гадас мэт бат сахиус юм. Бэрх хатуужилтын шүтээн юм гэв. Түүний маргааш голын хүн бүхэн цуглараад мөрийтэй тоглоом эхлэхэд хаан үүдэнд ирээд

– Мөрийцөхийн хэрэггүй. Бүгд дотогшоо ортугай хэмээн айлдав. Ардууд

– Өчигдрийн орлож гарсан танихгүй тэр хүн зориг нь шантарч нутгийн хүн бүгдтэй үг тааруулах гэсэн болов уу хэмээн эргэлзэж байтал нэг нь

– Ухаант хүн очвоос сайн гэсэнд, нэг ухаант хүнд орж болох зөвшөөрлийг олгож

– Урьдаар явбаас зохино гэсэнд тэр ухаант хүн сонсоод маш айн урьдаар очиж дотор ороход тэр орны хатан ба төлдрийн тэр хүнээс бус хэн ч байсангүй ажгуу. Тэр хүн маш айгаад нулимсаа хамар дээгүүрээ цувруулаад, хатанд мөргөхийг завдав. Хатан

– Надад бүү мөргөтүгэй. Хаан их эрдэнэд мөргөтүгэй гэсэнд оточ бурхны сүмд мөргөдгийн адил мөргөл үйлдэв. Тэр хүн гадагш гарч ирээд учир шалтгааныг нарийн ярьсанд албат цөм баясаж бүгдээр гүйлдсэн тул ядуу дорой нь үлдэж хоцров. Хаан хатны дэргэд ирээд бүгд мөргөв. Голын хүмүүсийн дээдэс нь түшмэлийн тушаалд дэвшин орж хаан хатан хоёр нь төрийг барив. Албат бүгд өдөр шөнийн цаг бүхэнд ариун явдлаар аж төрж урьдынхаас ч их дэлгэр болов.

Хаан давааны арын баян хүнтэй цаг болзсон тэр тариагаа баян хүнд өгч хоёр хааны төрийг нэгэн доор нийлүүлэн ялгаваргүй тэтгэж номын ёсоор явав гэсэнд Сайн амгалан явдалт хаан, тэр бясалгал гүйцсэний эрдмийг бодоод

Хаан хилэнцийг огоот тэвчсэн буяны хүчээр тэр мэт болсон ажгуу хэмээн өгүүлсэнд

– Хүүрт үг хэлэв хэмээн төмөр торыг гал бадартал гурав дэлдээд харцага мэт хүр хэмээн нисэж араас алдагдав. Хан хөвгүүн ийн сэтгэрүүн:

Ламын сургамж бол тэр хүүр юу яривч үгний хариу хэлж болохгүй гэсэн байтал би сэтгэл алгасаж уршиг болов. Одоо хүүргүй буцваас зарлигийн зэм ирэх буюу гээд бас хүүрийн зүгт одов.

Очирваанийн бясалгалыг гүйцээсний эрдмээр амилсан хутгыг авч хаан төрийг эзэлсний зургадугаар бүлэг болой.

# ХУДАЛ ҮЛ ХЭЛЭГЧ ХӨВГҮҮН ГАНЦ Ч ХУДАЛ ХЭЛЭЛГҮЙ ЭЦЭСТ ХҮРСНИЙ БҮЛЭГ ОРШВОЙ

Бас хан хөвгүүн модны дэргэд хүрч

– Лам минь Наганжуна Зүрхэн мөн. Би өөрөө Сайн амгалан явдалт хаан мөн. Тор минь есөн нүхт төмөр мөн. Тогшуур минь хүрэн сэндэн мөн. Хүлэг минь мэхт гинж мөн. Хутга минь чулуу огтлогч иртэй мөн. Тост гурил минь үл барагдах идээ мөн. Хүүр чи буухгүй буюу? Модыг чинь огтолно гэхэд хүүр бууж ирэв. Түүнийг торын дотор хийж хүлгээр баглаж үүрээд долоон алхам өнгөрөхөд

– Хан хөвгүүн, хан хөвгүүн! Зам хол энэлгээтэй учир та нэгэн түүхийг ярина уу. Эс бөгөөс хүүр би хулганын хумсын төдий нэг түүхийг ярья. Сонсогтун.

Нэгэн голд нэг их хаан байсан бөлгөө. Бас голын цаад талд нэгэн хаан байв. Голын энтээ талын хаанд дотоод эдлэл чандмань эрдэнэ олон бөгөөд гадаад эдлэл морь, үхэр ба морьдын дунд гайхамшигт Толин алаг хүлэг байв. Түүнийг адуулагч ухаантай бөгөөд худал үл хэлэгч нэгэн хөвгүүн байдаг ажгуу. Хэзээ нэгэн үед хоёр хаан хурим хийхдээ бие биеэ урин залдаг байв. Энтээ талын хаан цаад талын хааныг урин залахын үед эд таваар төгс эдлэлээ ярилцав. Цаад талын их хаан

– Үлэмж сайн сайхан эдлэл юу юутай вэ? хэмээн асуужээ.

Гайхамшигт эдлэл цагаан толгойтой бодь гөрөөс дотор нь буй мянган бурхан гаднаасаа тов тодорхой харагддаг нэгэн юм бий хэмээвээс, энтээ талын хаанаас

Гайхамшигт эдлэл юу юун буй? хэмээн асуусанд

– Сайн морь олон байвч үлэмжийн сайн морь ганц буй. Түүнийг адуулдаг адууч бөгөөд худал хэлэхийг огт тэвчсэн худал хэлдэггүй нэгэн хөвгүүн бий хэмээхэд цаад талын хаан

Худал хэлэхийг тэвчсэн болбоос их гайхамшигтай байна. Гэвч мөрийцвөл мөрийгөө алдахаас гарцаагүй болно биз гэсэнд

Чи чингэвэл мөрий тавьцгаая гээд улсынхаа тэн хагасыг мөрийд тавих болов. Ухаант хөвгүүн худал хэлбэл энэтээ талын хаан улсынхаа тэн хагасыг цаад талын хаанд өгнө. Худал эс хэлбэл нааш нь нөгөө улсын тэн хагасыг авахаар хэлэлцэв. Ухаант хөвгүүнийг хаан

Огт худал хэлж болохгүй гэж андгайлуулав.

Дараа нь цаад талын хаан нэг охиндоо сайхан амтат идээ өгөөд ухаант хөвгүүнийг худал хэлэх ба үл хэлэхийг сорихын тул хуурахаар явуулсанд тэр охин голын эх өөд өгсөж ирээд ухаант хөвгүүнийг эрж сурагласаар очиж

– Ухаант хөвгүүн ээ, би өнөө шөнө энд хононо. Гадагш явахгүй тул адуучин ноён та, хонох газрыг таалалдаа болгоохыг айлтгая хэмээн өгүүлсэнд, ухаант хөвгүүний зарц нар өөр газар

байгаа тул энд зарагдах хүнгүй учир, тэр өчүүхэн жийрхээд

Би энд хонох байр өгөх зарцгүй. Чи давааны цаад талд байгаа адуучин үхэрчин дээр очтугай гэсэнд охин

– Энэ шөнө явсан ч хүрэхгүй. Өнөө шөнө энд яавч хонох зөвшөөрлийг олгоно уу гэсэнд хөвгүүн өөрөө ганцаар тул

– Энд иртүгэй гээд хонох газар өгөв. Чингээд тэр шөнө тэнд унтав. Түүний маргааш шөнө ч бас тэндээ унтсанд ухаант хөвгүүн тэр охинтой хурьцаж нийлэв. Чингээд охин хэд хоног тэнд байгаад нэгэн үе болсонд охин

– Би өвдлөө хэмээн хэлж баруун завжиндаа улаан будаг зүүн завжиндаа хөх будаг түрхэж хөх улаанаар бөөлжүүлэн худал өвдөж хэвтсэнд тэр адуучин хөвгүүн сэтгэл нь зовоод

– Охины өвчин, юун болов? хэмээн асуусанд

– Тэсэхийн аргагүй өвдөж байна хэмээн охин хэлэв

Урьдын хуучин ийм өвчинтэй буюу? хэмээн асуусанд

Хуучин үгүй болой хэмээн хэлэхэд

Өвчинд чинь юу тус болох вэ хэмээн хөвгүүн асуув. Тус болох юм бий боловч түүнийг үйлдэх арга үгүй гэсэнд

Охинд туслахын арга байдаг ахул заавал үйлдэнэ хэмээн хэлэв.

Арга байж ч болно. Үйлдэхийн арга алга гэсэнд

Чамайг үхвэл яах ч аргагүй болох тул би заавал үйлдье гэсэнд

– Энэ гайхамшигт Толин алаг хүлгийг алаад махыг нь өгвөл миний өвчинд тус болно хэмээн хэлэв. Ухаант хөвгүүн

– Охин өөр нэгэн арга байна уу? Энэ морь, бидний албатын чандмань эрдэнэ буюу. Хаанд үүнээс үлэмж эрдэнэ үгүй. Бус арга байхгүй буюу? гэв. Охин

– Бус аргагүй тул би үхвэл зохино гэхэд ухаант хөвгүүн

– Энэ охин үхэх аваас өөр ийм сайхан охин яагаад ч олдохгүй тул хайртай боловч морио алах хэрэгтэй гээд охины дэргэд ирээд

– Өвчин ямар байна? гэхэд

– Өвчин цаглашгүй хэмээн охин хариулав. Хөвгүүн

– Энэ охинд үхэхийн янз орлоо гээд гартаа нэгэн бөөн гурил аваад баруун гартаа морийг алах хутга бариад гайхамшигт Толин алаг хүлгийн дэргэд очив

Гайхамшигт Толин алаг морио хэмээн дуудсанд морь ажнай хүлэг мөний тул

– Үүний хэргийг эс бүтээвээс хаан төр үл олохын дээр бас улсын тэн хагасыг чанагш алдах буюу хэмээн бодоод урдаас нь толгойгоо бөхийлгөөд ирэв. Тэр мориндоо гурилаа өгөөд түүнд арайхан ч халдаж чадсангүй маажиж байгаад буцааж явуулав.

Охины дэргэд очиход охин төлдрийн хоол идээгүй, унд ч уугаагүй хэвээрээ бөгөөд ам хамар нь хатаж хир тогтож, хамар нь хавчийгаад нүд нь хөнхийгөөд байсанд хөвгүүн айгаад ямар боловч морио алахаар явья хэмээн сэтгэж, бас гурил барьж, бас алах хутгыг гартаан бариад очив. Тэр морины дэргэд хүрээд морийг «Ир! ир!» гэж ажнай хүлгээ үзээд нулимс асгаруулан

– Морь чамд над мэт нэгэн адуучин байгаад чамайг алваас би яах вэ? Хааны гадаад эдийн дээд чи мөн. Чамайг эс алваас энэ гоё охин үхэх больюу. Явал сайн бэ? гээд уйлсанд тэр морь дэргэд нь очоод түр зуур хэвтсэнд

– Би шившлэг тавья. Морь чамайг алах хүсэл үгүй тул чи босоод шилгээж уул жалгаар дугаагаад үл баригдах болтугай. Чамайг алахын хэрэг үгүй. Чи өөрөө үхэх болтугай хэмээн шившсэнд хөвгүүний санаа асар ариухан хийгээд тэр морь ажнай морь мөний тул морь өгүүллрүүн:

– Манайд байдаг энэ борогч гүүг миний дэргэдүүр нааш цааш нь гурав дахин хөтлө гэв. Тэр хөвгүүн явж гүүг барьж авчраад морины дэргэдүүр нааш цааш нь гурав дахин хөтөлж явсанд тэр гайхамшигт Толин алаг хүлэг нь нүдээ хялайгаад үхэж одов. Гүүгээ тавиад уйлж байгаад тэр морины арьсыг өвчив. Чингэхдээ

– Ямар зэмлэл ирэх бол? Хаан юу гэж айлдах бол? хэмээн санаа сэтгэл маш зовж байв. Бүх махыг өөрийн байдаг газар тийш үүрч очоод тэр махнаасаа чанаж охинд цадтал өгснөөр охин ч эдгэрээд

– Өөрөө ид гэсэнд идэж эс чадав. Хөвгүүн голын эхний морьдоо бөөгнөрүүлэн бүрэн эсэхийг ажиглаж «осол ороогүй байгаа буюу?» хэмээн үзэхээр явсны хойгуур тэр охин морины толгой арьсыг үүрээд өөрийн хааны газар очиж огт оргүй алга болсон байв. Ухаант хөвгүүн сэтгэрүүн

– Маш их гэмтэй хэрэг болов. Ажнай морио алаад бас тэр охин ч алга болжээ. Одоо юу гэж хаанд айлтгах билээ? Хааны дэргэд сар бүр нэгэн удаа мэдээ өгдөг учиртай явал сайн болох билээ? гээд цагаан эсгий хэвнэг дээл өмсөж нэгэн гүвээ өөд авираад тэр даваан дээр гарч

– Би худал хэлвээс таарах буюу? хэмээн даваан дээр овоо босгож засаад түүнд дээлээ нөмөргөж малгай өмсгөж хаан хэмээн орлуулаад өөрөө айлдахын ёсон үйлдэж, тэр биед гурав мөргөж биеийн дэргэд очоод хаан зарлиг болж буй мэт болгон өөрөө

Худал үл хэлэгч ухаант хөвгүүн хүрч ирэв үү. Адуу бүрэн буюу? Осолдоогүй биз. Гайхамшигт

Толин алаг хүлэг мэнд байгаа буюу? гээд өөрөө доорд талд очиж мөргөөд

– Бусад нь бүрэн. Осол ороогүй. Гагцхүү гайхамшигт Толин алаг хүлгээ хулгайд алдсан гэсэнд бие нурав. Тэр хүү

– Худал хэлж болохгүй учир, өөр зүйлийг үйлдье хэмээн сэтгээд биеэ босгоод түүнд эсгий дээл малгайгаа өмсгөж бас доорд талд очоод мөргөсөөр дахин биеийн дэргэд очоод хаан зарлиг болж буй мэтээр

– Ээ ухаант хүү хүрч ирсэн буюу? хэмээн урьдын адилаар хэлэв. Бас доорд талд очиж урьд мэтээр айлтгасны эцэст гайхамшигт Толин алаг хүлгийг шаварт унагаж үхүүлсэн билээ гэсэнд тэр бие нь бас нурав.

Худал хэлж болохгүй нь. Шударга өгүүлвээс сайн гээд биеэ дахин босгож малгай дээлээ өмсгөөд, доор талд нь очиж мөргөв. Бас биеийн дэргэд очоод

– Худал үл хэлэгч ухаант хөвгүүн ирсэн буюу? Адуу бүрэн буюу? Осол ороогүй буюу? Гайхамшигт Толин алаг хүлэг морь мэнд байгаа буюу? гээд доош очиж мөргөөд

– Адуу бүрэн бөгөөд осол ороогүй. Харин нэгэн охин толгойг минь эргүүлсэн. тул хууртаад гайхамшигт Толин алаг хүлгийг алах хэрэгтэй боллоо. Арьс толгойг охин аваад дутаасан хэмээн өгүүлсэнд бие нь тэр хэвээрээ байв.

За худал хэлвээс зохихгүй тул, шударгаар айлтгаваас сайн гэж хүү сэтгээд түүний маргааш эрт морио эмээллэж унаад бусад адуучинд адуугаа тоолж тушаагаад, өөрөө хааны дэргэд хүрч очив. Тэр хааны дэргэд давааны цаад талын хаан ч ирсэн байв. Төлдрийн хуурдаг тэр охин ч хүрч ирсэн байв. Тэр хүү хаанд мөргөв. Хаан урьдаасаа царай нь барайж

– Худал үл хэлэгч ухаант хөвгүүн ирэв үү? Бүгд адуу бүрэн буюу? Осол ороогүй буюу? Гайхамшигт Толин алаг хүлэг мэнд сайн буюу? гэсэнд, адуу бүгд бүрэн. Осол эндэгдэл ороогүй. Нэг муу охин толгойг минь эргүүлж хуураад гайхамшигт Толин алаг хүлгийг алуулж толгойноос дооших арьсыг өвчив. Толгой, арьсыг охин аваад дутаасан хэмээн өгүүлэв. Хаан маш баясаад

Миний энэ хүн худал үл хэлэх хэмээн төлдөр хэлсэн биш үү гэсэнд нөгөө хааны нутгийн тэн хагасыг, энэ хаанд өгсөн бөлгөө. Түүнийг аваад ухаант хөвүүнд өгөв. Морины дэргэд хөтлөн ирж байсан борогч гүүнээс тэр жил дахин урьдын гайхамшигт Толин алаг хүлэгтэй адил нэгэн унага төрөөд урьдахаас улам илүү морь болов.

Голын цаадах тэр хаан нутгийнхаа тэн хагас ба эртний хуурахаар илгээсэн тэр охиноо ч ухаант хөвгүүнд өгөөд тэр номыг ёсоор явав. Хаан өөрийн гүрнийг адуучин хөвгүүнд бариулав. Албат нар ч урьдаас улам дэлгэрэн мандаж, өдөр шөнөгүй номын ёсоор явсан бөлгөө хэмээн хүүр өгүүлсэнд Сайн амгалан явдалт хаан

Хуурах зохистой мэт байхад, шударга айлтгасан нь сайн болжээ. Бас тэр охин буян ихтэйеэ хэмээн амнаас үг алдсанд



Хүүрт үг хэлэв гээд төмөр торыг гал бадартал гурав дэлдээд харцага адил хүр хэмээн араас алдуулав. Сайн амгалан явдалт хаан сэтгэрүүн:

– Лам, хүүр юу яривч чи үгний хариуг бүү өгүүлтүгэй хэмээн айлдсан бөгөөтөл тэр хүүр илбээр толгойг минь эргүүлсэн ба би сэтгэл алгасаж уршиг болов. Өдгөө гэдэс ч өлсөж байна. Буцаж очих хэрэгтэй гээд очсонд дорно үүдний цээрт нэгэн бичиг байв. Төлдрийнхөөс нэлээд их тостой гурил оюуг тавьсан байв. Бичгийг уншсанд

– Сайн амгалан явдалт хан хөвгүүн чи үгний хариу гаргаснаар долоон үе хүрсэнд өвдгөөс дээш нь алтан үл болох болов. Эс хичээвээс тэр хүүр ярихдаа мэргэн бөгөөд маш олон түүхийг мэдэх тул дараа юу хэлэв ч дуунгүй байваас зохино. Бурхны шажин үүнд тус хүргэх болно. Чин зоригийг гаргатугай гэсэн байх бөгөөд төлдрийн тостой гурилаас энэ их буюу. «Төлдрийн гурил ч долоо хоногт хүрэхүйц байсан, энэ өдрийн гурил ч мөн болохуйц ба өлсөх умдаасах хоёрт тэсвэрлэж чадах тул тостой гурил, энэ тэнгэрийн рашаан мэт буюу. Ламын зарлигаас үнэн юм үгүй. Би чин зоригийг үүсгэсүгэй» гээд хүүрийн дэргэд очсонд тэр хүүрүүд урьдынхаас хэрцгий догшрох ба захын хүүрүүд «Хала хала» хэмээн толгойгоо өндөлзүүлэн, зарим нь «хүлү хүлү» хэмээн гараа сарвалзаж байсан ба гол модны дээрх тэр хүүр сайтар шургаж «хала хала» гээд олон хатуу үг чалчиж байв. Нүдээ ширтэж шүдээ зуух зэрэг аймшигтай байдал олныг үзүүлж байв. Тэр хаан ламаа орой дээрээ бясалгасан бөгөөд айж цочих тэргүүтэн огт гарсангүй болой.

Худад үл хэлэгч ухаант хөвгүүн агшнаа худал хэлэлгүй байж эцэстээ хаан төр барьсан долдугаар бүлэг болой.

# ТОМООГУЙ ХААНЫ ОЮУТ ТҮШМЭЛ, ХАТАН БА ХААН ШИРЭЭГ ЭНЭТХЭГИЙН ЗААН ХОНХРООС ЭРСНИЙ БҮЛЭГ ОРШВОЙ

Хааны хөвгүүн: «Хала» хэмээсэн хүүрүүдийг тогшуураараа дэлдээд «хүлү» хэмээснүүдийг тогшуураараа нэжгээд дэлдээд хутгаа сугалж гарган

– Лам минь Наганжуна Зүрхэн мөн. Бясалгал минь Сайн Самиди мөн. Би өөрөө Сайн амгалан явдалт хаан мөн. Тэсвэр чин зориг асар их. Тор минь есөн нүхт төмөр мөн. Торын оосор өдгөө сайн байна. Хүрэн сэндэн тогшуур минь дэлдээд хагарч бяцрахгүй. Хүлэг минь мэхт гинж мөн. Одоо хүлэхэд тасрахгүй. Ирт хутга чулууг огтлогч мөн. Ир нь улам хурцатсан байна. Тостой гурил барагдашгүй. Урьдынхаас хоёр хувь нэмэгджээ. Хүүр буухгүй буюу? Модыг чинь унагалаа гээд хутгаар модны гуравны нэгэн хувийг цавчсанд тэр хүүр бууж ирэв. Тогшуураар дээд оройгоос доорх улыг хүртэл сайн дэлдээд тэр хутгаар мөч хөлийг салтал цавчаад торын дотор чихээд дээрээс нь доош эргэн тойрон сайтар чигжээд хүлгээр чандлан хүлж арван алхам төдий явахад

Хан хөвгүүн, хан хөвгүүн гэсэнд, тэр хаан хариу үл хэлэв.

Үйлээ барсан хаан чамтай уулзсанд чи үгний хариуг хэлэхгүй буюу. Үйлээ барсан хаан чи сонстугай. Би хулганын хумсын төдий урьдын долоогоос сайхан түүхийг ярья. Сонстугай гэв.

Энэтхэгийн дорно зүгт нэг хаан байжээ. Тэр хаанд ухаант хөвгүүн, тэнэг хөвгүүн хоёр байв. Эцэг эх хоёрыг өнгөрсний дараа ухаант хөвгүүн, хаан ширээнд суув. Тэр их хөвгүүнд албатууд өчүүхэн ч дургүй байсанд нэгэн ухаант түшмэл

– Энэ хаан хөвгүүн нь мэдлэгтэйгээр барахгүй, ажиглан шинжилвээс нэгэн их хаан болох буюу хэмээн сэтгээд ухаант түшмэл тэрбээр нэгэн өдөр хааны хөвгүүнд бараа болж яваад хан хөвгүүнд

– Энэ өдөр их хаан энэ голын адагт их далайн захаар сонирхон морилох буюу гэсэнд хаан түшмэлийн үгийг сонсоод одов. Үд шахахын төдийд тэр далай дотроос давалгаа цалгилж хөмрөв. Юу болох нь вэ? хэмээн харсанд гайхамшигт гуа сайхан тунгалаг царайтай нэгэн охин усан хөх торгон хувцас өмсөж лавай тэвшийг зүүн гартаа барьж баруун гартаа алтан шанага барин нэгэн заан унаж гарч ирээд сүүг далайд цацсаар байв. Хааны таалалд охин их зохистой байв. Тэр охин усандаа орсонд хаан буцаж ирэв. Түшмэл, хааны дэргэд ирээд

– Энэ өдөр сонин юм их болов уу? гэсэнд хаан

– Манай энэ далай дотроос гайхамшгийн гуа сайхан царайтай охин гарав. Баруун талаас нь харвал гэдийн гэдийсэн мэт. Зүүн талаас харвал бөхийн бөхийсөн мэт бөгөөд гэдийж бөхийж байгаа нь арвайн иш адил. Сүүдэрт тавиваас царцах мэт. Наранд тавиваас хайлах мэт. Наран сүүдэр хоёрын завсар тавиваас гэрэл мэлтэлзсэн далай мэт. Ив илхэн солонго дурайсан, тэр охин усан хөх торгыг биендээ өмсөж, зүүн гарт лавай тэвшийг барьж, баруун гарт алтан шанага барьж их заан унаад, сүүг далайд цацаж байв. Түүнийг авчирвал сайн буюу? Тэсэнд

– Нутаг орныг нь олвол хялбар болох хэмээн түшмэл айлтгав. Хэдэн хоног болсонд түшмэл

хаанд

– Өнөөдөр сайн өдөр мөн тул сонирхохоор одож тэр охины нутаг, овог нэр зэргийг лавлахаар морилохыг айлтгая гэсэнд тэр хаан дурдсан далайн зүгт явж далайн захад хүрэв. Төлдрийн нарны хэмжээний үед тэр далай цалгилсанд

– Урьдын охин ирж буй буюу? хэмээн харсанд тэр охин гарч ирэв.

– Охин чиний орны нэр юу гэдэг вэ? гэсэнд зааныг хуруугаараа заав.

– Эцгийн нэр хэн гэдэг вэ? гэсэнд хамраа хуруугаар заав.

Эх чинь хэн гэдэг вэ? гэхэд гутлаа заав.

– Чи өөрөө ямар нэртэй вэ? гэхэд, охин өөрийн толгойг заав. Сүүг далайд цацсаар буцаад явав. Хан хөвгүүн ч буцаж ирэв.

Өөдөө ирмэгц түшмэл хаанд мөргөж

– Тэр охин юу хэлж байна? гэв.

Тэр охин юу ч хэлсэнгүй гэсэнд түшмэл тэмдгээр дохио өгөхгүй байна уу? гэв.

Дохио өгч байна. Чиний орон чинь хаана буй? гэсэнд заанаа хуруугаараа заав. Эцгийн нэрийг асуусанд хамраа хуруугаараа заав. Эхийн нэрийг асуусанд гутлаа хуруугаараа заав. Чиний өөрийн нэр хэн бэ гэхэд толгойгоо хуруугаараа заав гэв. Ухаант түшмэл учрыг мэдэж

– Хэрэг бүтэх боллоо гэхэд зааныг хуруугаар заадаг нь Энэтхэгийн Заан хонхор гэсний дохио мөн буй за. Хамраа хуруугаар заасан нь эцэг хаан Гүр на (Эгшиг хамар) тэр мөн гэсний шинж мөн. Гутлаа хуруугаараа заадаг нь эх Юм Лхамчмаа мөн гэхийн тэмдэг мөн. Толгойгоо хуруугаар заадаг тэр нь Лхам Үдмаа гэсэн шинж мөн. Одоо хэрэг бүтэх магад гээд баясав.

Түүнээс хэд хоног өнгөрөхөд хаан түшмэл хоёул одох болсонд нэгэн их заанд ачаа ачаад, хаан нэг зааныг хөлөглөөд Энэтхэгийн Заан хонхор тийш одов. Зуур замд ой цэцэрлэг ба хортон араатны хөнөөл олон байвч тэр хааны урьдын буяны сүрд дарагдаж хортон араатнууд сайнаар угтан өнгөрүүлэв. Тэд Энэтхэгийн Заан хонхорт хүрсэнд хутга адил цавчим уул хадны захад хздэн хонгил байв. Тэнд түшмэл суугаад хаан хөвгүүнд сургасан нь:

Энэ өдөр эндээс цааш очихын үед тэр охин дорно үүдний дэргэд ирэх буй. Тэнд хаан өөрөө очоод чулуугаар наадах хүн байна уу? хэмээн өгүүлтүгэй. «Наадаж болно» гээд тэр охин хүрч ирэх буй. Чулуу чулуудахын үед «Үржинбадмасамбавад мөргөмүү. Таван аймгийн дагинасыг тангараглуулан адистидла» гээд гол дунд нэгэн цагаан чулууг тавьтугай. Түүнээс охин «манай баруун зүгийн Үржиний орноос ирсэн бололтой» гэх болно. «Үржиний оронд явж үзээгүй. Хааш яаш битгий дэмий ярь» хэмээн өгүүлтүгэй. «Үржиний оронд эс очсон бол Бадмасамбавад мөргөмүү. Таван аймгийн дагинасыг тангараглуулахыг адистадла гэсэн тэр юун өгүүлж буй?» гэвээс «Би дорждолуул мөн бөгөөд найман хүүрийн дотор эрхшээсэн мөн» гэхээс бус юу ч бүү өгүүлтүгэй. «Өнөөдөр чулуу тавьж үл болох тул дотогшоо морилсугай»

гэвээс дотогшоо орвоос зохино. Охин дэвсгэр дэвссэний дээр «Авралын орон чухаг дээд гурав оршин соёрх» гээд бус юу ч бүү өгүүлтүгэй. Охин архи тэргүүтэн өргөвөл чухаг дээд гуравт тахил өргөнө» гээд бусад үг бүү өгүүлэгтүн. Тэр дотор түр байзнаваас охин үг асуух болно. Найман их хүүрийн дотор найман шидэт буй. Тэр хаана оршиж буй бол?» хэмээн асуувал «би дорждолуул хэмээхэд сэтгэл нь элбэрэн эргэнэ. Охины өгсөн юмыг зооглохдоо охины царай руу нүдээ бүлтийтэл ширтэж түр суутугай. Охин хааш яаш өөд уруу олон дахин явах болно. Тэр цагт нүдээ цүрмэн (ирмэн) «Очирт дагина чи хааш яаш холхилгүй суугтун» гээд нүдээ бүлтийтэл ширтвээс тэр охин мөргөөд «намайг очирт дагина ч гэдэг, хувилгаан биеэрээ нигүүлсэн үзтүгэй» хэмээн мөргөөд, дэргэд чинь сууж өргөл хүндлэлийг сайтар үйлдэх болно. «Чухаг дээд гурав оршин соёрх» гэх ба «Чухаг дээд гуравт тахил өргөө» гэх үгсийг огт умарталгүй өгүүлсээр гурав хоног болоод «Одоо би хүүрийн дотор явах хэрэгтэй болов» гээд миний дэргэд ир. Намайг сэтгэлдээ бүү умартаарай» хэмээн айлтгав.

Хан хөвгүүн охины харш руу яваад зүүн үүдний дэргэд хүрч ирэхэд ерөөлтэй хатан тэр ч ив илхэн дотроос гарч ирэхэд тааралдаад, үүдний чулууны дэргэд очиж

«Чулуугаар наадагч хүмүүс байна уу?» гэсэнд охин

– «Тоглож болно» гэв. Өөрийн цагаан чулуу авахад охины сэтгэлд

– Энэ нь төлдрийн Амгалан төгс хотын далайд сүүний цацал цацахын цагт далайн захад Амгалан төгссөн хааны хүү үсээ боосон хөвгүүн байсан, тэр мөн бололтой хэмээн яах аргагүй чулуу авч байхад нь дүрийг тов тодорхой санав.

Тэр хааны хүү

Үржинбадмасамбавад мөргөмүү. Таван аймгийн дагинасыг тангараглуулан адистидла хэмээн нэгэн цагаан чулууг тавив. Тэр охин сэжиг төрөөд

– Энэ хэний мэх буй? гээд «Та Үржиний оронд очсон буюу?» гэхэд

Үржиний оронд очсон бус. Би дорждолуул мөн бөгөөд найман хүүрийн дотор эрхшээсэн мөн гэсэнд охин

– Энэ өдөр чулуу тавьж үл болох учир дотогшоо морилохыг айлтгая гээд дотогш залсанд охин нэг дэвсгэрийг дэвссэн тул түүний дээр цомцойн суух сацуу

Чухаг дээд гурав өршөөн соёрх гэв. Охин үрийн архи ба цай барихын цагт чухаг дээд гуравт тахил өргөж үйлдэв. Тэр охин өөрөө бүгдийг айлтгаж байгаад

– Найман хүүрт найман шидтэн орших бөгөөд одоо хаана буй? гэсэнд охины царай руу нүдээрээ ширтэж харав. Тэр охин түр босоод хааш яаш нааш цааш явсанд

– Очирт дагинас чи ийш тийш олон холхилгүй суу гэсэнд тэр охин хаанд мөргөж бишрэнгүйгээр сөгдөөд сууж зөөлөн харж

– Би Очирт дагинас мөн бөгөөд хувилгаан биеэр авран соёрх гээд охин өргөл хүндлэлийг

сайтар айлтгав.

Тэнд гурав дөрөв хоног болоход «чухаг дээд гурав оршин соёрх» гэж хэлэх хийгээд тахихын ёсыг умартав. Охины бодолд «төлдрийн Амгалан төгс хотын далайн захад байсан хаан тэр мэт адил буюу. Ай мөн буюу?» хэмээн сэжиг төрөв. Сарын хагас болоход нөгөө түшмэл хүнсээ барсан ба бага сага юмаа мөрөн дээрээ тавиад Зааны хонхор хэмээх хотод төлөгч болж ирэв. Тэр хотын ардуудад төлгө үзэж байв. Хаан охиныг гадагш ганц ч алхуулахгүй тул хатан аягачнуудад «сайн төлөгч байвал төлгө тавиулах болно» гэсэнд

«Сайн төлгөчин байна» хэмээн айлтгав. Хатан марадийн суулгаар дүүрэн цагаан арвайн багсарсан гурил ба бурам идээний зүйл гурван цагаан, гурван амтаг хийгээд сум хадаг ариун идээг авч төлгөчинд очихыг завдсанд хаан

Охин хаашаа явах нь вэ? хэмээн асуухад

– Төлгө тавиулахын тул одно гэв. Тэр хаанд түшмэл нь бодогдож гэнэт босоод

Охин оо, би ч нэгэн төлгө тавиулахын тул явах хэрэгтэй болов гэхэд охин өгүүллрүүн

– Тусгай нэгэн төлгө тавиулахаар гадагшаа морилох гэж буй буюу? Эс бөгөөс зүгээр өөр дээрээ авчрах хэрэгтэй буюу? хэмээн айлтгасанд

Юу боловч дотогш дуудсугай хэмээн айлтгав. Зарлага төлгөчний дэргэд хүрч

Төлгөчин өө. Манай хаан хатан хоёул биеийн мэндийг үзүүлэх болсон тул дотогшоо морилохыг айлтгая гэсэнд төлгөчин

«Их хүмүүсийн төлгийг тавих нь гайсунуудыг дарах адил их хүчир байдаг билээ. Ерийн хүмүүсийн төлгийг тавих нь ялимгүй учир, хаан хянамгайлан бодоод морилон ирж болох болов уу? Түшмэл би замд сайн морилохын ерөөлийг

тавья. Охин Үдмааг авахыг хүсвээс энэ хаанд өгөхгүй байдалтай тул аргаар ирүүлж болох аваас намайг шатны дээр хүрмэгц надад дорно зүг харж суухад тохирсон цагаан дэвсгэр нэгийг дэвсэгтүн хэмээн хэлүүлээд шууд хүрч очсонд

цагаан дэвсгэр дэвссэн байв. Түүний дээр дорно зүг хараад суув. Хаан «Хэ» гээд боссонд түшмэл нүдээ цүрмээд «Суу» хэмээн гараа дохисонд хаан бөхөсхийн суув. Төлгөчин мөргөсөнд

Төлгөч сайн морилж ирэв үү? гэв. Тэр хатан төлгөний хэрэглэлийг авч ирж төлгө тавиулав. Төлгөч гэрийн хувийг шившиж байхад нь охин сайтар ажиглаж дагинасын байдлаар түр шинжлээд

– Энэ төлгөч гэрийн хувийг шившиж байгаа байдал нь хан хөвгүүн ба төлгөч хоёр нэгэн аймгийнх тул толгойг минь эргүүлж байгаа бололтой хэмээн муушаасанд төлгөч

– Нохой гахай хоёр нэгэн оронд үл нийлэх гэсэн төлгө буув. Энэ намайг туршин сорьж байгаа

боллолтой гэсэнд хатан

– Ха ха Төлгөчинд тоглож айлтгасан болой. Одоо тодорхой өгүүлье. Өөр юм төлгөдүүлэх хэрэгтэй гээд

Энэ бол Амгалантөгс хотын хаан мөн тул энэ хан хөвгүүнтэй би хамтарч эцэг гүрний төрийг баривал болох уу? хэмээн төлгө тавиулсанд төлгөч өгүүлрүүн:

Далайн ус ширгэх шахваас чвндмань эрдэнэ тэтгэх ажгуу. Арслан туйлдаа хүрэхэд цаст шуурга туслах ажгуу. Энэтхэгт Зааны хонхорын хааны үндэс тасрах шахахад хувилгааи номч хаан туслах болно гээд энэ нь ямар мэт болохыг мэдэхгүй байв.

Охин энэхүү үнэн байдлыг сайтар сэтгэлдээ тунгаагаад

– Энэ хоёр нь нэгэн гэрийнх буюу? хэмээн сэжиглэж

Бие биеэ магтан сайшааж байна. Хаа ч очвоос нөгөөгөө сайн гэх ажгуу хэмээн бодов. Албат иргэдийн тухай төлгө тавьсанд «сайн» гээд нэжгээдээс илүү тавьсангүй.

«Төлгө бүрийн дотор аль нэгэн хаан төрийн арван хоёр жил бүрдсэн тул олон дахин төлгөдөхийн хэрэггүй. Одоо энэ төлгө юунд ч тавих боловч маш сайн болно гээд хатны таалалд нэгэн сэжиг байхыг мэдсэн боловч үл сэжигдсэн байдлаар

– Хаан төрийн магнай болоорой гэсэнд хатан баясаад түүнд идээ ундааг бүрэн төгс өргөв. Төлгөч

– Энэ хаан буян ихтэй байна. Би одоо төлгийг үзэж гүйцэв. Энэ арвай надад хэрэгтэй. Хаан багсарсан гурил, бурмын аль хэрэгтэйг таалтугай. Буянтай хаан, өвгөн намайг гадагш хүргэж өгөхийг таалалдаа болгооно уу гэсэнд хатан өгүүлрүүн:

– Манай энэ хаан энд ирээд гадагшаа гарч үзээгүй боловч одоо түргэн зуур үдэж гаргаваас сайн гэв.

Хаан үдэхээр гараад хүнгүй газар хүрэхийн хамт

Та намайг бодохгүй тул миний арга барагдав. Юу болов.

– Охин надад умартуулах идээ ундаа өгсөн бололтой гэсэнд урьд умартуулах идээ ундааг өгсөн нь дамжиггүй. Би сая мэдлээ. Одоо долоо хоног согтуурч, умартуулах идээ ундааг бэлтгэж байна. Түүнийг үдэш унтахын өмнөхөн өгөх болно. Үүнийг өгөхийн учир бол таныг Амгалантөгс хотын хаан мөн гэж ажиглаж таньсан байна. Би ч маш их магтсаны учир тийнхүү өгөх болжээ. Энэ шөнө охины таван зүйлийн эрдэнээс бүтсэн туурга гаднаасаа хуурсын төдий ч овгоргүй. Дотор нь морины хялгасын төдий ч сэвгүй оронд хононо. Тэнд та хоёр хэвтэшнйхээ нөгөө талын туурганд морины нэг төө хялгасыг норгон шавар туурганд наалдуулаад гэдэргээ хараад хэвтээрэй. Охин ижил хоёр лонхтой юм авч ирэх буй за. Хоёр лонхоо тус тус дэрний тэнд тавихад даруй өндийгөөд

- Манай шахадсан сайхан туурга огт зүгээр байснаа хагарсан байна хэмээн өгүүлтүгэй. Тэр охиныг гэрэл авчрахаар явахын хооронд хоёр лонхтой юмыг сольж тавиарай. Хаан та бусдад дурсаж үл болно. Бид нарын дүү албат ганц нөхрийг авагтун. Эд бүгдийг санаандаа хадгалтугай. Өөрөө их болгоомжтой ажиллах хэрэгтэй. Тэр хоёр лонхыг сольсны даруйд үдэш ууваас шөнө дунд боловсрох болно. Уусан даруйдаа сайхан амттай байна. Охин чи үлдээлгүй уу гээд уулгатугай. Шөнө дунд би байшингийн ард очно. Охин согтохын цагт хааш яаш болоод тийчлэх хөлбөрөх болно. Тэр цагт надад үүдээ нээтүгэй гээд түшмэл хадны хонгил руу явав.
- Хаан харшдаа буцаж очиход хатан урьдахаас улам ихээр өргөмжлөв. Тэр хоёр ор засахын үед түшмэлийн хэлсэн ёсоор морины хялгасыг туурганд наалдуулав. Хаан нойрссонд охин согтууруулах архийг лонхонд хийгээд үл согтохыг өөрийн дэрний дэргэд тавиад нөгөөг хааны дэрний дэргэд тавив. Ингээд охин бүсээ тайлахыг завдсанд хан хөвгүүн
- Манай энэ үлэмж сайхан туурга ер гав сэвгүй байсан билээ. Одоо хагарсан байна гэхэд охин гэрэл авч ирэхээр явсны хойгуур хоёр лонхыг солив. Тэр охин ч унтав. Хан хөвгүүн лонхтой усыг авч уугаад
- Охин чи одоо ууваас сайн гэсэнд охин ч уув. Шөнө дунд болоход охин бүдэг бадаг дэмий балай чалчих болж гэдрэг түрүүлгээ урваж тийчилж байв. Хаан өөрийн түшмэлийг дуудав. Түшмэл орж ирээд
- Төлдрийн бодсон хэрэг бүтэв. Нэг аятай хэргийг үйлдэнэ гээд тэр шөнө нэгэн их зул бариад хүү сан бүхнийг хэсэж алт, мөнгө, эд таваар бүхнийг аваад гэнэт сандран босож хаанд сургамжлав. Зарлага, үхэрчин, адуучин нарт,
- Охин Үдмаагийн бие муу байна. Гаднын хүмүүс ба та бүгд дунд ордноос цааш битгий очоорой хэмээн өгүүлгэв. Хаан доош буугаад түшмэлийн сургасан ёсоор зарлав. Тэр ухаант түшмэл согтоох юмыг үрийн архинд холиод бэлтгэж тавив. Өдөр болоход ганц сайн зарлагаас бусад бүх хүмүүст архийг өгөв. Шөнө дунд болоход ажлаа бэлтгэж гүйцэхэд албат ард цөмөөр согтож, хатан ганцаар хэвтэж байв. Түшмэл заануудыг тохшилж засаад нэгэн сайн зааны дээр юм гадагшаа унагаахгүйн тулд модон тэвшийг суулгаж засаад түүнд хатныг суулгав. Бусад заанд сайн эдүүдийг ачив. Хааны охиныг түшиж явахын тул нэгэн зарлагыг модон тэвшийн дотор суулгав. Түшмэл харшаас гарахдаа үүдийг удаа дараагаар түгжиж хаав. Тэр ухаант түшмэл Амгалантегс хотыг хүртэл хоёр хоног явж хүрсэнд тэр охины согтуу нь гараагүй хэвээрээ байв. Түүнийг түшмэл үнэртнээр утаж зандны усаар дахин дахин сүрчсэнд Үдмаа охин ухаан орж нүдээ харваас өөр харшид ирсэн байх бөгөөд тэр хоёрын нүүр өөд харсанд урьдын хаан ба төлгөч хоёрыг таниад охин
- Хаан чи маш их буянтай байна. Түшмэл чи маш аргатай байна. Энэ хааны газарт бид хоёул байхын аргагүй. Хаан эх эцэг хоёр минь маш өндөр настай. Түүнд надаас өөр үр үгүй. Хаан төрийг хагаслан барих нь зохисгүй учир, миний эцгийн хаан төрийг бариваас сайн буюу гэсэнд түшмэл
- Хатныг бид хаан түшмэл хоёр эвсэж авч ирсэн. Хаан төр алиныг ч барихад өнөө үед бололцоотой болов. Хоёр хоног энд сууж амартугай гэв.

Тэр Энэтхэгийн Зааны хонхрын албат иргэд долоо хоноод ухаан орж дайвалзсаар босож үзвэл их хүү сангаас эхлээд хүү сан бүгдээрийг дийзэдсэн байв. Хаан хатан хоёр үгүй. Урьдын төлгөчин

Хаан төр дэлгэрэн мандана гэсэн боловч өдгөө хатан өөрөө үгүй болсон тул хаан төр дэлгэрэн мандах хаанаас болох вэ? гээд бүгдээрээ гашуу болцгоов. Гүр На хаанд учрыг айлтгасанд хаан эцэг эх хоёрын таалал маш их гансрав. Гадаад дотоод дөрвөн түшмэл удирдаж эрэл сурал хийсээр тэднийг олов. Түүнд түшмэл цааш нь

– Хаан хатан хоёрыг буцаж очоод Энэтхэгийн Зааны хонхрын төрийг тэр хоёр барьж эцэг Гүр Наг номын ёсоор амьдруулаад Үдмаагийн харшид сууваас зохистой хэмээн айлтгав. Түүнд Үдмаа хатан

– Бид хоёр, түшмэлтэй санал нэгтэй байна. Цааш очиж сайтар хавсран барилдуулахыг түшмэл чи зохиотугай хэмээн өгүүлэв.

Тэр түшмэл ба ухаант түшмэл хоёр ханилан Энэтхэгийн зааны хонхорт одоод албат бүгдийг цуглуулан ухаант түшмэл хаанд айлтгал өргөв. Тэр ухаант түшмэлийг үзсэн төдийд хаан баясаад

Ухаант түшмэлийн айлтгасан бүхнийг хаан Гүр На сонсож дагав. Амгалантөгс хотоос хаан хатан хоёрыг урин залж хаан төрийг бариулав.

Амгалантөгс хотын хаан хан төрийнхөө тэн хагасыг дүүдээ өгөв. Хоёр хан төр хоорондоо эвлэрч дэлгэрэн мандав. Хөвгүүн эгч дүү гурав мэндлэв. Хотол чуулган амгалан жаргалан болсон буюу гэсэнд Сайн амгалан явдалт хаан

Тэр ухаант түшмэлгүйгээр тэр хаан сайхан боломжийг үл олох байжээ хэмээн үг алдсан тул

– Хүүрт үг хэлэв хэмээн төмөр торыг гал бадартал гурав дэлдээд, харцага мэт хүр хэмээн араас алдагдав. Хаан үүрч байгаа хүүртээ дарагдсаар сэтгэл алмайрснаас үг алдав хэмээн санаад бас дахин хүүрийн газар явав.

Томоогүй хааны ухаант түшмэл хатан ба хан төрийг Энэтхэгийн Зааны хонхорт эрсний наймдугаар бүлэг болой.



# ЛАН-А ЛАНЧҮН ОХИН МАНГАСЫН АМНААС ГЭТЭЛЖ ХАН ТӨРИЙГ БАРЬСАН БҮЛЭГ ОРШВОЙ

Тэр хан хөвгүүн модны дэргэд очоод

– Лам минь Наганжуна Зүрхэн мөн. Би өөрөө Сайн амгалан явдалт хаан мөн. Торны оосор өдгөө сайн байна. Тогшуур минь хүрэн сэндэн мөн. Хүлэг минь мэхт гинж мөн. Тост гурил минь барагдашгүй идээ мөн. Хүүр буух буюу. Модыг чинь унагалаа гэсэнд, тэр бууж ирснийг тогшуураараа дэлдээд торны дотор чихэж хүлгээрээ сайн хүлж үүрээд долоон алхам газар хүрэхэд

– Хан хөвгүүн, Хан хөвгүүн гэхэд дуун эс гаргасанд

Үйлээ барсан чиний амнаас дуун үл гарах буюу? Би хулганын хумс төдий нэг түүхийг ярьсугай. Сонс гэв.

Нэгэн голд өвгөн эмгэн хоёрт гурван охин байжээ. Хонин сүргээ эцэг хариулахаар явдаг ажгуу. Нэгэн үед эцгийг нь даваан дээр нэг мангас идээд бас нэг хар хонийг барьж идээд эцгийнх нь арьсыг хуулж мангас өөрөө өмсөөд дээрээс нь бас эцгийн малгай дээл гутал гурвыг өмсөөд эцгийн янзаар дуурайж эцгийнх нь өөхийг үүрч очиход эмгэн нь хонио угтаж очоод мангастай уулзсанд тэр мангас

– Би өнөөдөр даваан дээр очоод нэгэн баян хүнд их охиноо өгөх болов. Тэр хүргэний өгсөн мах архийг ч идэж уугаад хар хонио ч алж өглөө. Чиний хувь энэ гээд өөхийг өгөв. Эмгэн галд шарж байтал

Эмгэн, эрийнхээ махыг идэж болох буюу? гэсэнд эмгэн нь

Энэ мэт юун өгүүлж байна гэв. Галд шарсныг хэлж буй. Ид гэхэд эмгэн идэв. Мангас их охиныг дагуулж очоод тэр өдөр тэр охиныг алж идэв.

Бас нэгэн том цагаан хонийг нь алж идэв. Охины толгойг эцгийнх нь толгойн хажууд буй хөндий цээжний дэргэд тавьж охины өөхийг эхэд нь авчирч өгөв. Тэр эх нь галд шарж байтал

– Эмгэн, охиныхоо махыг идэж болох буюу гэсэнд

– Энэ юун өгүүлж байна? гэв.

Шар гэсний дохио мөн. Ид гэхэд эмгэн идэв.

Энэ өдөр нэгэн сайн эр хонийг алсан ба хүргэний өгсөн мах архийг идэж уусан. Одоо дунд охиноо ч өгье хэмээн ярилцсан гэв. Маргааш нь дунд охиныг дагуулж очоод алж өөхийг нь дэлгээд бас нэгэн том хонийг алж идэв. Хүүхний толгойг эгчийн толгойн дэргэд тавиад хонио тууж өөхийг үүрсээр ирэв. Эх, хонийг угтсаар ирэхэд өнөөх өөхөө авчирч өглөө.

– Өнөөдөр ч бага охиноо өгье хэмээн ярилцав. Хүргэний өгсөн мах архийг ч идэв уув, Эмгэн

чиний хувь энэ мөн гэсэнд эмгэн

– Бага охиноо бид хоёр, хэдэн жил зарцлах хэрэгтэй юм сан гэсэнд өвгөн:

– Бид эр эм хоёрын бие сайн байгаа үед охин өөрийн амьдралыг харсан нь сайн буй за гэв.

Маргааш өдөр ээж нь их тостой гурил зуураад

– Бага охин минь юм сан даа хэмээн өрөвдөлтэйгөөр өгүүлэн

Өвгөн минь л ийм ажил хийх юм гэж хагацаж ядан байвч өвгөний эрх мэдэл их тул охиныг аваад явлаа. Бас төлдрийн хөндий цээжний тэнд хүрээд

– Чи энд суу. Аав нь тэнд юм хараад ирье гээд явлаа. Нэг хэсэг болсонд нэгэн алаг гөлөг ирээд

– Охин оо, нэг үмх гурил өгвөөс нэг үг ярина. Хоёр үмх гурил өгвөөс хоёр үг ярина. Бүгдийг өгвөөс бүгдийг ярина гэсэнд охин эхээсээ хагацаж сэтгэл гансран гашуудаж байсан учраас гурил идэхдээ дургүй нь хүрээд нохойд бүгдийг өгсөнд тэр нохой үг ярив.

Чиний энэ эцэг хэмээгч нь эцэг чинь биш. Мангас мөн. Чиний эцгийн толгой хоёр эгчийн чинь толгойнууд тэр хөндий цээжний тэнд буй хэмээн зааж хэлээд гөлөг дагуулан үзүүлэв. Охин, толгойнуудыг үзээд айж цочиж

– Чамд мэдсэн арга үгүй буюу. Арга хэлж өгөөч гэсэнд гөлөг:

– Чамайг өрөвдсөн тул би хэлэх хэрэгтэй. Тэр нэг тогоог аваад явтугай. Чи өөрөө энэ тогоог аваад давааны онь тийш дутаатугай. «Охин оо, аав чинь энд байна шүү» гэвч дутаатугай. Давааны өөд барих шахаж ирэхэд буцаж харалгүй энэ тогоог өнхрүүлээд тогооны хойноос «Миний тогоо, миний тогоо» гээд хаа өнхөрч хүрсэн газар очих ахул охин чи гэтэлж болно» гээд үл үзэгдэн одов.

Охин тогоог үүрээд даваа өөд дутаасанд тэр мангас охины мөрөөр гүйж ирээд

– Охин оо, эцэг чинь энд байна, хааш явах нь вэ? гээд хурдлахад даваа өөд авирч баригдахыг шахахад тогоогоо өнхрүүлээд түүний хойноос

– Миний тогоо, миний тогоо, гээд тогооны өнхөрсөн газарт гүйж хүрсэнд тогоо нь шар аргалын доогуур шургаж оров. Охин ч түүний доогуур шургаж орсонд нэг модон хаалганд тулав. Түүнийг нээгээд орсонд нэг төмөр хаалга байв. Түүнийг нээсний дотор алтан хаалга байв. Түүнийг нээсний дотор нэгэн шат илхэн харагдаж байв. Тэр шат өөд авирч очсонд нэг тахиа өдөө дэлгээд сууж байв. Тэр

– Гоо гоо, охин сайн явж ирэв үү? гэхэд охин

Зүдэрч ирлээ гэв.

Охин зүдэрсэн тул мах тосыг авч ид гэхэд охин цадтал идээд амарч. жаргав.

Тэнд нэгэн үе болоход тэр тахиа охинд

– Хүү сангийн мухарт гутал дээл чимэг зүүлт бий. Түүнийг өмсөж зүүгээд, голын адагт болох сонирхолтой их наадмыг үзэхээр очтугай хэмээн өгүүлэв. Тэр охин хүү санд очиж өөртөө таарах гутал хувцсыг өмсөөд чимэг хэрэглэлийг зүүгээд наадамд очив. Охиныг явсны сүүлд тахиа нь харанхуй мухраас нэг сайн морийг гаргаад шувуун дээлээ хуйлж хүү сангийн дотор хийгээд сайхан чимэг хувцсыг өмсөөд тэр морийг унаж голын адаг руу наадам үзэхээр очив. Тэр цуглаанд очоод цуглааныг зөв эргэхэд тэр өөрийн нь эхнэрээс сайхан охин байсангүй. Бас буруу эргэвч мөн тэр охиноос сайхан охин үгүй байв. Охин ч зөв эргэсэнд тэр нэг эрээс сайхан эр харагдсангүй. Буруу эргэвч мөн түүнээс гайхамшигт эр үгүй байв. Тэр цуглаан тархах болоход тэр эр богц дүүрэн бурам ба үнсийг цацахад зарим нь бурам түүж, зарим нь үнсээр нүд нь бүрхэгдсэнд тэр эр Хаянхирвааг оройдоо бясалгаж морио нэгэнтээ гуядаад голын эх рүү хүрч очив. Тэнд морины эмээлийг аваад харанхуй мухарт оруулав. Эмээл чимэг хэрэглэлийг нуугаад шувуун дээлээ өмсөж Хаянхирваагийн бясалгалыг үйлдсээр сууж байх цагт охин ирсэн бөлгөө.

Оо оо, охин оо ирэв үү? гэсэнд охин

– Ирлээ, Халамжит минь өдөр урт байна уу? гэсэнд

– Эрийн дээдэд хэн шалгарав? Эмийн дээдэд хэн шалгарав? гэсэнд охин

– Эрийн дээдэд Голын эхний тахиа хэмээгч шалгарав. Эмийн дээдэд олон охин шалгарав гэсэнд тахиа хоолны газраас хүнс хэрэглэлийг гаргаж

– Охин өлссөн бол мах тос идтүгэй гэв. Охин тахианд өгөөд өөрөө идэв.

Бас нэгэн үе болоход тахиа,

– Охин, энэ өдөр бас урьдын газарт наадам үзэхээр очвоос сайн хэмээсэнд тэр охин мөн чимэг хэрэглэлийг өмсөөд наадам үзэхээр очив. Тахиа ч урьд мэтээр мөн чимэг хэрэгслийг өмсөж очив. Бас олон хүн цугласанд урьд мэтээр үзвээс өөрийн эхнэрээс сайхан охин үгүй байв. Охин ч харваас түүний сайхан эр үгүй байв. Цугласан ардын ярьсан нь:

– Энэ эр тахиа хэтэрхий гайхамшигт тул албинд автах буй за. Энэ охин ч лавтай гайхамшигтай шалгарав хэмээлцэв. Чингэхэд тэр эр, мөн бурам ба үнс цацсанд, хүмүүсийн зарим нь бурмыг түүж нүд нь алгасаад зарим нь үнсэнд бүрхэгдэж байхын завсар тэр эр голын эхэнд хүрч ирэв. Бас морь, чимэг, хувцсыг нууж шувуун дээлээ өмсөөд, бясалгал хийж суув. Охин хүрч ирэхэд,

– Охин хүрээд ирэв үү? Хурим наадам сонирхолтой сайхан болов уу? Эрийн дээдэд хэн шалгарав. Эмийн дээдэд хэн шалгарав? хэмээсэнд охин

– Эрийн дээдэд Голын эхний тахиа хэмээгч шалгарав. Эмийн дээдэд олон охин намайг

шалгарав хэмээв гээд бас хоолны газраас хүнс хэрэглэлийг гаргаж тахианд өгөөд өөрөө идэв.

Бас нэгэн үе болоход тахиа

Өнөөдөр голын адагт сонин хурим болох тул очвоос сайн гэв. Охин чимэг хэрэглэлийг өмсөж зүүгээд

– Явья гээд Голын эхний тахиа гэдэг нь энэ мөн болов уу? хэмээн бодоод зайлж нэг жалганд нуугдаж суув. Тэр тахиа чимэг хэрэглэл бүгдийг өмсөж зүүгээд шувуун дээлээ хүү сангийн дотор хийгээд одов. Тэр цуглааныг наран зөв эргэвч. охин байсангүй. Буруу тойровч охин байсангүй. Охин түүнийг явсан хойгуур шувуун дээлийг нь гаргаад бөөн галд шатаав. Тэр тахиа урьд мэт бурам үнсийг цацаад давхиж ирээд дотор орсонд охин шувуун дээлийг шатааж дуусаад үгүй болгосон байв. Тэр тахиа

– Охин бид хоёр ханилах заяагүй болов. Миний шувуун дээлийг арван жил болтол эс шатааваас бид хоёр ханилж болох байсан гэсэнд охин уйлаад

Арга байхгүй буюу? гэсэнд

Арга бололцоо байхгүй гэв.

Өдгөө арга бололцоо даанч байдаггүй аж хэмээн зуурч уйлсанд тэр тахиа

– Тэр голын адгийн хотод мах архи түгээдэг нэгэн газар бий. Миний Ядам Хаянхирвааг тэнд үүрээд чи оч. Хэвлийд буй хүүхдийн эрдмээр саднаа сайнаар угтдаг, дайсныг дайран зандаг миний нохой бий. Нэг хорооны завсар газар миний хөгшин эх бий. Тэр босоод чамайг угтаж ирэх тул урьд тохиолдож барьсан учир байдлаа яриад чи тэнд суу. Чи бид хоёр одоо учрахад бэрх болов гэсэнд тэр охин голын адаг руу явж, тахианы хэлсэн ёсоор очсонд түүний

хөгшин ээж үзээд

– Тэр замаар хүн явна гээд хоёр нохойдоо

Дайсан бол дайрагтун. Садан бол угтагтун хэмээн турхирсанд хоёр нохой давхиж очоод охинд сүүлээ шарвалзуулж байхыг ээж нь үзээд угтаж ирээд хөгшин ээж

– Охин сайн ирэв үү? гэхэд охин

Ээж сайн сууж байна уу? гэв. Тэр хөгшин Ээж Чи хааш явж буй? хэмээн асуусанд охин

– Би хоол элбэгтэй газар дээс томж амьдрахаар явж буй гэсэнд эмгэн охиныг дотогш дагуулж оруулаад хоол өгөв. Тэр охин «хүй» хэмээн шүүрс алдсанд эмгэн

– Охин чиний сэтгэл их зовж байгаа бололтой. Миний хүү хүрч ирэхгүй, нүдэнд үзэгдэхгүй болсоор удав. Хааш явсан ба энэ өөд явсан гэх тийм сураг ажиггүй таван жил болов. Чиний сэтгэлийн зовлон нь минийхээс ихгүй. Охин чамд юу болсон бэ? хэмээн асуусанд тэр охин өөрийн эрхгүй нулимс асгаруулаад

Би урьд төрөлдөө буян үл хураасны учир эцэг эх, эгч нараа мангаст идүүлэв. Би арайхан амь гэтэлсэн гэхэд охиныг эмгэн:

– Хөөрхий гээд эмгэн өөрөө ч нулимс алдав.

Миний хүү огт үгүй болсон. Хүүр нь ч нүдэнд харагдахгүй таван жил болсон. Сэтгэлийн зовлон аажмаар хөнгөрч байна гээд тэр эмгэн дээс унгас тэргүүтний ажлыг хийлгэв.

Охин нэгэн тусгай жижиг байшинд Хаянхирваагийн хөргийг өндөр ширээнд дээр оршуулаад дээс томсны хөлсөнд тос аваад үргэлжид зул өргөж хаянхирвааг бясалгаж суув. Мангаст автагдах үед тусалсан тэр алаг гөлөг бол Хаянхирваагийн хувилгаан мөн байсан ба охин урьд төрөлд Хаянхирвааг бясалгаж байгаад дамжиг санасны үрээр охин төрлийг авч тэр мэт зовсон байжээ. Тэр охин хэдэн сар болоод бие жирэмсэн болсонд бусад малчид эмгэнд

– Бид нарын нэг нь гаднаас ирсэн энэ охиныг жирэмсэн болгосон бололтой хэмээн хэлэв.

Таван сар болсонд охин Хаянхирвааг бүтээж үүр шахах үед барсын арьсаар хормогчилсон орой дээрээ ногоон морин толгойтой, амнаас «хүлү хүлү даргирд» хэмээн дуун гаргасан нэг эр хүн ирээд

Охин чи намайг дуудаад юу хийх гэсэн бэ? гэв. Тэр охин уулын толгойд манан татсан мэт төрлөө дурдаад айлтгав:

– Миний урьд насны бүтээсэн Ядам чи мөн. Чамайг номчлон бүтээсний эрдмээр миний ашдын нөхрийг ирүүлэн өршөө гээд мөргөв. Хаянхирваа

– Одоогоос эхлээд буяны сайн өдөр мах архийг бэлтгээд охин чи хүнтэй ярилгүй, урьдын ёсоор оройдоо бясалгаж суутугай. Нөхөртэй учруулахыг би бүтээе гээд үл үзэгдэн одов. Тэр охин бясалгалыг бясалгаж байх үед бүх зарц нар буруушаан ярилцахыг эмгэн мэдээд охинд

– Чи жирэмсэн бололтой байна. Манай адуучин, хоньчин нарын хэнийх вэ? Хэлэгтүн. Бид нарт сонсгоход гэмгүй гэсэнд охин

Надад ганцхан сайн бурхан байна. Төлдрөөс дахин дахин зүүдэлсэн сахиулс минь «Мах архийг сэлбэх ба ариутгалыг олон дахин сайн үйлдэх хэрэгтэй» гэв. Намайг сэжиглэвээс адуучин, хоньчиноос асууваас тодорхой. Гаднын хүний үг бол худал үг мөн. Миний энэ нь хуучин өвчин мөн гэсэнд эмгэн буцаж харив.

Түүнээс хэд хоног өнгөрсөнд охины гэрийн дорнод үүдний дэргэд улаан морь унаж, улаан нохой хөтөлсөн улаан хүн ирээд

– Охин Лан-а-Ланчүн (Тогоо, тогоохон сайн уу? Дэвсгэрт ширээ тавьж зассан уу? Орон дээр дэр тавьж бэлтгэсэн үү? Дээр нь дээл нөмөргөсөн үү? Дэрний дэргэд бурмын ус тавьсан уу? Хоолонд тостой гурил тавьсан уу?) гэсэнд охин

– Халамжит тахиа сайн уу? Хэвтэх газарт дэвсгэр засаастай. Суух газар жижиг байшингийн дотор. Орон дээр дэр тавиаастай. Бүсээ нугалаад дэрлэж байдаг. Дээрээ хөнжил нөмрөөтэй.

Өдөр шөнийн хувцас ганцаас илүү үгүй. Дэвсгэрт зөөлөн дэвсгэр дэвсээгүй. Өмдөө дэвсэж байдаг гэсэнд тэр дотогш ороод хоёул ярилцав. Охин

Одоо хүрч ирэх болоогүй буюу? гэсэнд тэрбээр

Би ирж болох л байсан. Чи шувуун дээлийг минь галд түлсэн тул би албинд автагдаад байна гэв.

– Одоо яагаад ч ирж болохгүй юу? гэсэнд

Намайг эндээс аваачсан даруйд төрөлхийн цэвэрч. хэмээн алдаршсаны учир, албин цай баригч болгов. Түүнээс сайшаагаад нойрсуулагч ноён болгов. Төлдөр нойрсолгын архийг нэг хоёр удаа тасалсанд, одоо дуугарахаа больсон бөгөөд шөнийн унтлагын архи тасалдуулсан гэж хилэгнээд урьд шөнө адуучнаар гаргасан тул сая ирж буй учир нь энэ билээ. Одоо хааяа уулзаж болох буй за гэв. Охин

– Одоо уулзаж байсаар бүр буцаж ирж болох уу? Буцаж ирэх аргыг ч үл мэднэ. Чи өөрөө ээжид дамжуулан хэлбээс доор дэвсэх дэвсгэр, дээрээс хучих хучлага, дэвсгэр хэрэглэл. хоол тэргүүтэн чинь үүнээс сайн болох буй за гэв.

– Чи үл ирэх аваас надад энэ байгаа нь болох ажгуу гэхэд тэр үүр шахахад

– Явах боллоо гээд явав. Охины бодолд

Миний Ядамын эрдэм мөн гээд урьдынхаас улам бишрэн бясалгалыг үлэмж үйлдэв. Түүний маргааш адуучин зарц нар ээжид нь

Биднийг зэмлэх хэрэггүй байтал зэмлэв. Энэ охин жирэмсэн болсон нь лавтай. Шөнө нааш цаашаа дуу дуулах ба харилцан ярилцаж байв гэсэнд эх албатуудад архийг тавьж өрөөд мах арзыг шинээр бэлтгэв. Өгөх учиртай дунхан байгаа юмнуудыг ч нэмж сэлбэв. Тэр ээж, охины дэргэд очоод

– Чи шөнө дуу аялж түжигнэн ярилцаад байв, Түүнийгээ надад хэлэгтүн гэсэнд

Надтан хүн ирж хэн ч ярилцаагүй гэв.

– Яавч ирсэн тул хэлэгтүн гэв. Охин

– Урьд төрөлдөө буян хурааснаар Ядам бурхантай уулзсан. Нэгэн үед буруу үзэл төрснөөс энэ мэтийн зовлонд учрав гэсэнд түр ажиглан, доор нь ширээ тавьж, ширээний дээр зөөлөн дэвсгэр дэвсэж түүний дээр хучлага, дэр тавьж дэргэд нь бурмын ус хийж тавиад хоолонд нь тостой гурил бөөрөнхийлж бэлтгэв. Тэр ч шөнө ирэхэд төлдрийн ямар мэт хэлсэнчлэнгээр болсон тул охин хэлэв.

– Хэвтэх газар ширээ тавьсан буй. Түүнд дэр тавьсан. Дээр нь хөнжил нөмөргөсөн. Хоолонд тостой гурил бэлтгэсэн болой гэхэд тэрбээр

– Дотогш ороод хаалгаа хаагаад уулзъя гэв. Дүүрэн бурмын усыг уулгаж гурил тосыг өгсөнд

Би хүний идээг идэх болов гээд тэр баясав. Тэр ч

– Өчигдөр хожимдсон тул намайг зэмлээд адуучнаас хасаад ус зөөгч болгов гэв. Охин

– Дутааваас гэтэлж болохгүй буюу гэсэнд

Албины морьд хурдан учир үл гаргана. Тэд бүгдийн гараас хааш гэтлэх аж. Угтан авагч нэгэн хүн байвал би гэтэлж болох ажгуу гээд гэнэт яарч босоод явав.

Чингээд үүр шахахад Ядам Хаянхирваа ирж

Охин оо, хэвгээд тусгүй. Босогтун гэв. Охин яарч босоод мөргөж өлмийд нь оройгоо хүргэж цаглашгүй их сүсэглэн бишрэв.

– Охин чи одоо өрөвдмөөр байна. Өчигдөр дуу аялгуулснаас нэгэн гэм болсон байна. Өнөөдөр сайн өдөр мөний тул үдээс өмнө надад тахилыг сайн бэлд. Үдээс хойш махыг гартаа бариад арцын модны дунд суугаад, амандаа энэ жижиг оюуг хийж огт унагалгүй, гар дахь махаа ч алдалгүй, намайг орой дээрээ бясалгаж суутугай. Баруун талаар зуугаад улаан морьтон зүүн талаар мянгаад улаан морьтон ирэх ба Дигваранзын толгойтой уулын чинээ улаан хүн ирээд байшинг эврийн завсар оруулаад тэнгэр газаргүй дэлдэвч намайг орой дээрээ бясалгаж суугтун. Аль хэдийнээс бэрхшээлийг үйлдсэний хэрэг ч энэ өдөр энд бүтнэ гээд үл үзэгдэн одов.

Тэр охин тахилыг сайтар бэлтгээд амандаа жижиг оюуг үмхэж, махыг гартаа бариад Ядамыг орой дээрээ бясалган сууж байх цагт тэр Ядам нэг хөх морь болон хувилж, булгийн дэргэд зогсож байв. Тэр хөвгүүн ардаа зэс хумх үүрээд гартаа галбага бариад, хэсэг зүлэгтэй газрыг өнгөрч тэр зүлэгнээс доош уруудан бүжиглэж дуу аялгуулан

Цавчим улаан хад нь өнгийсөн, царс модны үзүүр хүрчигнэсэн магад албин орны хадан хонгил уйтгартай манай шавар хот зүрх шантралтай. Мах хоол элбэг боловч, дөрвөлжин шавар хот дахь охин Лан-а Ланчүн уйтгартай хэмээн уйтгартай дуулсаар булаг дээр хүрсэнд хувилгаан морь

Хөвгүүн чи таван жил Ядамыг бүтээсэн ба урьд насны буян хураасан тэр охин таван сар Ядамыг бүтээсэн байна. Чи орондоо буцахыг дурлаваас хувилгаан морь намайг унаад буцаж харалгүй одтугай гэсэнд тэр маш баясаад моринд мордсоноос салхин адил сэр хийгээд өөрийн оронд хүрэв.

Түүнд албины орноос өөрийн орны хооронд хань хамсаа морьтнууд үргэлжлэн дүүрч байв. Том жижиг улаан хүмүүс ба Дигваранзын толгойтой уулын төдий нэгэн амьтан эврийнхээ завсар тэр хотыг аваад заримдаа өөд нь өргөж, заримдаа газар дэлдэвч охин үл айхын дээр, түүнд цалашгүй өрөвдлөг төрж охин Дигваранз толгойтод өгүүлрүүн

Урьд насандаа муу үйлийг хураасан Дигваранз толгойт чи орчлон хэдий хоосрохыг хүртэл

тамын ёроолын чулуу болох амой. Аяа хөөрхий гэсэнд тэд бүгдээрээ үл харагдах болов.

Тэднийг орны бусад хүн харсангүй. Зөвхөн охин махыг гартаа бариад архины дэргэд сууж байгаа төдийхнийг хараад

– Хатан аа, төлдрөөс хойш, энэ охинтой ярилцагч этгээд буй болсон бөгөөд сая байшин хөдөлсөн нь охины хутгасан үйл мөн. Бид бүгд дутаавч гарах газаргүй тул байшинд орвоос сайн. Эзнийг аваачигч нь тэр мөн буй за хэмээн ярилцаж байв. Гэтэл тэр охин шатаар бууж ирээд шатны эхэнд шувуун дээлт хаан ганцаар морилж байхтай уулзаж баясан зуурав.

Ээж нь хан хөвгүүнээс зуураад муужрав. Дэргэдэх хүмүүс хан хөвгүүнийг хараад гадагш гарч зарласанд ард олон ирж баярлалцан уйлалдав. Бүгдээр хан хөвгүүнд ирсний зоог тахилыг санаж гүйцэшгүй үйлдэв. Тэр охин гурван хөвгүүн, гурван охин төрүүлэв. Охины буяны хүчээр урьдынхаас тэр орон амгалан жаргалтай болов.

Тэр оронд нэг их хаан байсан бөгөөд түүний үндэс тасарч ирэхэд хан төрийн угсааг тэр хоёр барьсан болой гэсэнд хан хөвгүүн

Тэр охин Ядамыг чин зоригоор бүтээсэн буян ихтэй аж хэмээн үг алдсан тул

– Хүүрт үг хэлэв гээд төмөр торыг гал бадартал нэг дэлдээд, харцага нисэх адил хүр хэмээн бөөн тоос татуулан алдагдав. Хан хөвгүүний санаанд

– Лам, хүүрт үгний хариу бүү хэл гэсэн бөгөөд сэтгэл алгассаны уршгаар үг алдав. Одоо хүүргүй очвоос тусгүй хэмээн бодоод бас хүүр руу одов. «Хүлү хүлү» хэмээгчдийг алхаж гишгээд, «Хала хала» хэмээгчдийг тогшуураар дэлдээд одов.

Охин Лан-а Ланчүн, урьд насандаа Ядам бясалгасны эрдэм энэ насанд боловсорч мангасын амнаас гэтэлж, хадны хонгилын албины гараас хан хөвгүүнийг гаргаж, хан төрийг барьсан есдүгээр бүлэг болой.



# ОХИН СОХАДИЛИМАН, АЖНАЙ МОРИНЫ АЧААР МАНГАСЫН ГАРААС ГЭТЭЛЖ ХАН ТӨРИЙГ БАРЬСНЫ БҮЛЭГ ОРШВОЙ

Бас хан хөвгүүн тэр модны дэргэд очоод хутгаа сугалж

– Лам минь Наганжуна Зүрхэн мөн. Би өөрөө Сайн амгалан явдалт мөн. Тор минь есөн нүхт төмөр мөн. Тогшуур минь хүрэн сэндэн мөн. Хүлэг минь чулууг огтлогч иртэй мөн. Хүүр буухгүй буюу? Модыг чинь унагалаа гэсэнд тэр хүүр бууж ирснийг тогшуураар дэлдэж, торын дотор чихээд хүлгээр сайн хүлээд одов. Долоон алхам газарт хүрэхэд

Хан хөвгүүн ээ, хан хөвгүүн ээ. Зам хол уйтгартай тул үлгэр ярих буюу гэхэд хан хөвгүүн

Тэр учрыг мэднэ хэмээн сэтгээд дуун эс гаргав.

– Үйлээ барсан хаан чиний амнаас үг эс гарваас би хулганын хумсын төдий нэгэн үлгэрийг ярина. Сонс.

Нэгэн их голд эмгэн өвгөи хоёр байв. Тэдэнд дагинасын шинж тэмдэгтэй үлэмжийн нэгэн охин байв. Итгэл явуулж номын ёсоор явагч охин тул түүний хоол ундыг эх нь бэлтгэж өгдөг байв.

Нэгэн үе болоход нэг мангас охиныг гуйхаар очихдоо залуу хүн болж хувилаад цайвар дээл өмсөж, нум сумыг гартаа барьж ирээд

– Өвгөн эмгэн та хоёр энэ охиноо надад өг гэв. Тэд

– Миний охины нэрийг мэдвээс өгч болно. Эс мэдвээс үл өгнө гэсэнд тэр мангас буцаж одов.

Нэгэн үе болоход мангас баруун мөрөн дээрээ нэгэн морины хүүрийг тавиад, зүүн мөрөндөө нэгэн хүний хүүрийг тавиад нялхсын нэгэн хүүрийг мэргэ дохиг дохиг хийгээд явж ахуйд нэг үнэг сэгийтэл хатирч явав.

– Эрэмгий мангас надад мах өгтүгэй гэсэнд

Өгч ч болно. Чи голын адгийн эмгэн өвгөн хоёрын охины нэрийг мэдээд ир. Чамд мах өгч болно гэсэнд үнэг нэг өмхөрсөн модны хөндий дотор чагнаж суув. Тэр үдэшдээ яриа өгүүлэл огт болсонгүй. Маргаашийн наран ургахын үед тэр эмгэн

– Охин Сохадилимин цайгаа уу гэсэнд тэр үнэг

Олж сонслоо гээд давхиж очсонд тэр мангас хүлээж байв. Үнэг түүний дэргэд хүрэх шахаж нэгэн эргэн дээр хол харайхдаа охины нэрийг умартаад эргэн дотор нааш цааш харайж байв. Мангас

– Үнэг чи нааш ир, Чи юу хийж байна гэсэнд

– Түүний нэрийг мэдсэн боловч эрэгний дотор орохдоо нэрийг умартсан учир, дахин санаанд

орж ирэхгүй болов гэсэнд

– Одоо энэ махыг идээд чагнатугай гэв. Бас үнэг мах идээд сонсохоор очоод урьд мэтээр өмхөрсөн модны хөндий дотор хэвтээд чагнав.

Шөнө яриа гарсангүй. Өглөөгүүр наран ороход эмгэн

– Охин Сохадилиман аа, цайгаа уу гэсэнд

Мэдлээ. Сонслоо гээд умартахаас сэжигдэж

Охин Сохадилиман хэмээн амандаа өгүүлж нөгөө эрэгний наад захад гарч

– Сохадилиман гэсээр мангасын дэргэд хүрэхэд тэр мангас сонсоод алт, оюу олныг авч охиныг гуйн авчрахаар одов.

Тэр өвгөн эмгэн хоёрт алт, оюу олныг өгөөд

– Таны энэ охиныг авья гэхэд алт оюуд баясаад

Төлдөр миний охины нэрийг мэдвээс өгнө, мэдэхгүй бол үл өгнө гэж хэлсэн шүү гэв.

Нэрийг мэдэх аваас өгөх буюу гэв. Нэрийг мэдвээс өгнө гэхэд нэр нь Охин Сохадилиман хэмээн хэлсэнд

Чингэвэл охиныг өгөх хэрэгтэй болов гээд өвгөн эмгэн хоёрын царай барайж байв.

Охиныг угтаж авахдаа морьгүй байгаа юм уу? гэсэнд

– Эртнээс морь авчрах гэсэн боловч морь байхгүй байв. Одоо явган аваад явна гэв.

Бид охиноо морь унуулж явуулна гэв.

Та морио хайрлах бус уу? Өгөхийн хэрэггүй гэв. Охин

– Өвгөн эмгэн хоёр ганц охиноо мангаст өгөх гэж буй буюу. Хүний үзэгдэл ёс буюу. Шөнийн зүүдэн буюу. Охиноо ч өгөх хэрэггүй бололтой билээ. Эцэг, эх хоёрын зарлигийг зөрчвөөс үл болох ажгуу гэсэнд эх эцэг хоёр

Юм өөрөө ирэх нь бэрх. Эрдэнэ, алт оюугаас үлэмж үнэтэй юм үгүй тул явахыг бэлтгэгтүн гэв.

Эцэг эхийн зарлигийг няцаалгүй явахыг бэлтгэж тэр охин. ажнай сайн мориныхоо дэргэд очсонд морь

Энд суувч түүний идэш болохоос зайлшгүй учир одоо охин явбаас сайн. Долоон ширхэг арвайг боогоод бэлхүүсэндээ зүүтүгэй. Одоо хэрэггүй боловч хэрэг болох цаг ирнэ. Тэр цагт

энэ долоон арвайг өөд нь цацваас чи гэтэлж болно. Одоо явтугай гэв.

Тэр охин мангасын хойноос даруйхан явж, голын адагт очсонд мангас хонины толгойг унаж ирээд

– Охин чи миний морины араар сундал гэв. Тэр охин сундлахгүй байхын аргагүй болоод сундлав. Гурван зам байсны алаг цоохор болсон замаар явсанд тэнгэрт тулсан есөн давхар төмөр хот дайралдав. Түүний дотор орж суухад хоол унд, эд таваар элбэг байв. Чингээд мангас өдөр бүр хэргээр явдаг байв.

Чамайг өдөр бүр явахад би уйдаж байна гэсэнд нэг өдөр нэг нохойн гөлөг, нэг бөөрөнхий гурилыг орхисонд үдээс урагш гөлөг нь бөөрөнхий гурилаа идэж орхив. Үдээс хойш бөөрөнхий гурил нь гөлгийг идлээ. Бас нэг өдөр нэг ишиг, нэг багц өвсөө идэв. Үдэш багц өвс нь ишгээ идлээ. Мөнх бусын дохиог үзүүлэн байв.

Бас нэг өдөр түлхүүрийг охинд хадгалуулж орхив. Нүд урвуулах үүдийг нээхэд охины нүд урваж заримдаа өвөл болж газар хөлдөж, заримдаа тариа тарьж байв. Заримдаа тариаг мөндөр дарсан байв. Заримдаа үүднээс харахад хадлан хадаж байв. Заримдаа тариа цохиж байгаа тэргүүтэн хоромхон төдийд нүдний эндүүрэл урвалт олон янз үзэгдэв. Тэнд хирд дарагдсан нэгэн хар хаалга байв. Түүнийг ямар ч түлхүүрээр нээхийг оролдовч үл нээгдсэн тул архи уугаад гэдрэг харж хэвтэхэд нурууны завсарт түлхүүр харагдав. Тэр түлхүүрийг авч өнөөх хаалгыг нээхэд түүний дотор баруун дээд талд нэгэн эмгэн унан тусан байв. Зүүн талын чанадад амьсгаадаж хахаж цацсан хүмүүс байв. Өрөө тус бүрд олон хүн байгаа харагдав. Тэр эмгэн

– Буян муутай охин чи ирэв үү? гэхэд охин

– Ирлээ гэсэнд

Чамаас үлэмж урьд бид бүгд ирсэн бөгөөд бүгд хөгшрөв. Энэ хүүрүүдийг үзэж байна уу? Залуу цагт нь эхнэрээ болгоод, өтлөх цагт бидэн шиг болгоно гэсэнд охин айгаад эмгэнд

– Одоо арга байхгүй буюу? хэлж өгөөч гэсэнд

– Одоо чамд түлхүүр байгаа нь заяа ихтэй болно. Бидэнд түлхүүр орхидоггүй байсан. Одоо чи энэ эмгэний оройгоос нь татаж, энэ оюу, алт бүгдийг аваад энэ эмгэний арьсыг нөмрөөд уранхай тамтархай хувцас өмсөөд энэ голын адагт буй номч хааныг чиглээд явтугай! гэв. Тэр охин айгаад алт, оюунуудыг авч эмгэний арьсыг нөмөрч, бас дээрээс нь тамтархай хувцсаа өмсөөд хаалгыг хааж, тэндээс хоёр суулга арвайн гурил аваад голын адаг руу одов.

Мангас ирээд дотуур явж охин алга болсныг мэдмэгц тэр хонины толгойг унаад охины хойноос давхив. Хар, хүр гэсээр охины дэргэд хүрээд

– Үүнээс доош нэг охин явж байгааг үзэв үү? Эмгэн ээ гэсэнд

– Харсангүй гэв. Тэр үлээсэнд охин уналаа. Охиныг унахад нэг юм харжигнан дуугарав.

– Харжигнадаг юу вэ? гэв.

Хөгшрөөд яс харжигнаж байна гэв. Тэр мангас яваад түр нэгэн болж дахин эргэн ирээд, бас пүдхийтэл үлээсэнд тэр эмгэн унав. Унахад бас юм харжигнав.

– Чиний энэ харжигнадаг юу вэ? гэсэнд

Хөгшин хүний яс харжигнаж байна гэв. Гурван удаа ийнхүү учирсны сүүлд охин тэр хааны зоогийн тарианы дунд очоод нуугдан сууж байв.

Хаан харшийн орой дээрээс тариа руу хараад бархиран дуудсанд охин үл сонссон тул хаан доош бууж охины дэргэд ирсэнд таяг тулсан муу хувцастай хөгшин змгэн байв. Хаан:

– Эмгэн чи хаанаас ирэв? гэсэнд

– Тэр голын эхнээс ирлээ. Энд хуурга хуурах ус авагчийг эрж буй хүн байдаг болов уу гэсэнд

Чи хуурга хуурч ус авч чадах буюу гэв.

– Даарч өлсөхгүй бол яавч чадна гэв.

Чадваас ирж сурагладаг хүн буй гээд түүнийг дагуулан явав. Түүнийг дотогш оруулж ус авах, үнс зөөх ажлыг даалгав.

Нэгэн үе болоход охин нөмрөгөө тайлахаар нэг газарт хүрээд арьсаа мултлаад бөөсөө арилгаж байтал нэг адуучин морь услахаар явж байгаад дайралдав. Тэр охины гайхамшгийн сайхан гэрэл тогтсон алт оюу янз бүрийн чимгээр давхар давхар чимснийг адуучин үзээд хурдан дотогшоо очиж хаанд айлтгав. Хаан зарлиг болруун

– Охиныг нааш ирүүлэгтүн. Энд ирмэгц манай ноёд зарц нар охины хуурмаг хувцсыг цөм тайлтугай гэв.

Тэр охиныг дотогшоо ирэхийн сацуу тэр адуучин ба бас нэг зарц хоёул тоглоомоор шалтгаалж эмгэнийг нааш цааш нь татаад тэр эмгэний хуучин хувцас арьсуудыг урж бутаргаж орхив. Чингээд хааныг ирэхэд гайхамшгийн гоо тунгалаг царайтай нэгэн охин байв. Хаан охинд

– Чи энэ мэтийн хуурмаг өмсгөл өмсдөгийн шалтгаан юу бэ? гэсэнд охин урьдын учир шалтгааныг айлтгаж

– Миний энэ арьсыг уралгүй хоёр хоносон аваас зохих байсан гэв. Хаан

Охин чи дотор суутугай. Голын эхний тэр мангас хэрхэвч үл ирнэ гэсэнд охин

– Хэрхэвч үл ирэх аваас сууж болно гэв.

Охин хааны хатан болоод хэдэн жил өнгөрөөд бие жирэмсэн болов. Хатныг амаржихаас

урьдхан тэр их хаан ноёд зарц нартайгаа худалдааны газрыг эргэхээр явцгаав. Хааны явсан хойгуур тэр хатнаас алтан цээжтэй, оюу бөгстэй. лавай бэлхүүстэй эрдэнийн нүдтэй нэг хүү төрөв. Түүнд түшмэд албат бугдээрээ маш баясаж айлтгал явуулав.

– Манай энэ хатнаас алтан цээжтэй, оюу бөгстэй, лавай бэлхүүстэй, эрдэнийн алаг нүдтэй, үлэмжийн нэгэн хөвгүүн мэндлэв. Худалдааны газрыг эргэх нь сайн боловч түргэн морилж ирэхийг айлтгая хэмээн элч бичгийг хүргүүлэв. Тэр элч нэг их даваан дээр авирч гарсанд давааны оройд мангас дохиг дохиг хийгээд зогсож байгаад

Ува сайн болой хэмээн амар мэндийг эрээд «Чи хааш явж буй?» хэмээн асуусанд «Бид хатан Сохадилиманаас үлэмжийн нэгэн хөвгүүн мэндэлсэн учир элч болж явна гэв. Мангас

– Чи хэр өлсөж байна? Идээ идтүгэй гээд тэр элчид идээ өгөв. Түүнийг идэхийн завсар бичгийг сольж бичсэн нь

– Хааны шадар албат бид айлтгая. Манай энэ хатнаас цээж нь охины дүрстэй, бичин толгойтой, нэг муу ёрын хөвгүүн төрөв. Үүний хэрхэх вэ? хэмээн мангас бичив. Тэр элч хаанд бичгийг өргөсөнд хаан бичгийн хариуг зохиов.

– Өөрийн албат түшмэлд захих нь: Миний хатнаас ямар хөвгүүн төрөвч миний өөрийн үр мөний тул намайг очихыг хүртэлх түүнийг авч байгтун хэмээн бичжээ. Бас элч нааш ирэхэд төлдрийн мангас

Өлсөж цангаж байгаа биз гээд хоол унд өгөхийн завсар бичгийг засав.

– Манай эрчүүл хөө хуягийг өмсөөд охид үнсийг аваачаад тэртээ давааны чанад намайг очихын өмнө түүнийг үгүй хийгтүн хэмээн бичээд өгөв.

Тэр элч, нутагтаа хүрээд бичгийг уншсанд эх хөвгүүнийг хамт зайлуул хэмээн бичсэн байв. Үүнд албатууд үл дурлавч, голын ардууд хааны зарлигийг зөрчиж үл болох тул тэр охиныг халзан илжиг унуулан давааны өөд хүргэж ирэв.

Охин даваан дээр ирэхэд тэр мангас угтаж очоод

– Охин чи ирэв үү? гэхэд охин

Ирлээ гэв.

– Хөвгүүн чинь хаа байна? Үзье гээд хүүг гартаа аваад

– Урьд энэ мэтийн мах идэж үзээгүй гээд бүхлээр залгив. Охин чи өлсөж байгаа биз хэмээн цадахуйц юм өгөөд тэр охинд

Хөвгүүний алтан цээжтэй байдаг нь миний хамаг алтыг аваачсанаас болов. Оюу бөгстэй байдаг нь миний хамаг оюуг аваачсанаас болов. Лавай бэлхүүстэй байдаг нь би чамд сайхан санаснаас болжээ. Нүд нь эрдэнээр бүтсэн тэр нь

би чамайг хаа байдаг болов уу хэмээн харснаас болсон байна. Одоо чамайг идэх учиртай болов. Миний толгойн бөөсийг түүгтүн, хөөрхий гэсэнд охин түүний толгойн бөөсийг түүж байгаад нэг санаа бодов.

– Надад үүн шиг айхавтар зовлонтой юм үгүй гээд бэлхүүснээсээ долоон ширхэг арвайгаа аваад цацаж

– Миний ажнай морь гэсэнд морь нь гэнэт хүрч ирэв.

Мангасын толгой доогуур аажуухнаар нэг цамцыг хийж орхиод морио унаад зугатаав.

Тэр мангас гэрээсээ морь авчрахаар явах завсар тэр хүн морь хоёр нүдэнд үл үзэгдэх болов. Тэр охин нүдэнд харагдахгүй маш хол эзгүй газар хүрсэнд тэр морь

– Би үхлээ гэв. Охин уйлсанд их шуурга болов. Тэр морь, хэнд өгүүлрүүн:

Охин бүү уйлагтун. Уйлваас чи хөлдөж үхнэ. Би чамд жаргал ирүүлнэ. Чи ха ха хэмээн миний хүүрийн арьсыг хуулж энэ талд хүргэж дэлгэж тавьтугай. Тархийг минь гаргаад эхний тэр хадны оройд тавь. Үсийг минь зулгаагаад уулын хажууд цац. Толгойг минь арьсны дунд тавь. Зүрх хийгээд хоёр бөөрийг минь толгойн дэргэд тавь. Дөрвөн мөчийг минь дөрвөн өнцөгт нь тавь. Гэдсийг минь арьсны захаар тойруулан тавь. Хоёр нүдийг минь арьсны голд тавь. Уушги зүрх бүгдийг дотор нь тавь гээд тэр морь үхэв.

Охин уйлсанд цасан шуурга болов. Охин уйлахаа зогсож ха ха-а хэмээн арьсыг хуулахад бүлээн наран гарлаа. Морины хэлсэн ёсоор үйлдээд охины тэнхээ нь тасарч унтав. Түр болоод сэрсэнд нохойн дуун гарч байв. Тэр гэнэт боссонд голын эхэнд цаст уул тогтож, ус урсаж адагт тариалан харагдав. Дунд нь оюу дэвссэн мэт өвс ногоо байв. Хот нь тэнгэр тулахад тохой зайтай, газар хүрэхэд тохой зайтай. Тэр харшийн гадуур төмөр уул, суваг сэлт буй. Дөрвөн талд нь дөрвөн их уултай. Түүний дотор хүрэхэд олон хүн сууж байв. Дотогшоо орсонд бүгдээрээ

– Хатан сайн явж ирэв үү? гэлцэж байв. Тэр хүмүүс, уушгины эрдмээр буй болсон ажгуу. Төв дундаасаа салаавчилж үргэлжилсэн холбоос нь толгойноос уламжилж гарав. Хоёр нохой нь хоёр бөөр мөн. Гадна, урьдын мориноос залуухан нэг морь байгаа нь зүрхний эрдэм мөн. Тэр хотын хоёр хажууд нэжгээд булаг байгаа нь нүдний эрдэм мөн ажгуу. Ган төмөр уул байгаа нь элэг уушги хоёр хавирганы дотор байсны эрдэм мөн. Цөс дотор нь байсны хүчээр, алт оюу тэргүүтэн үлэмжийн эд таваар элдэв зүйл бүтжээ. Умс нь талд тархсаны эрдмээр найлзуур мод ба оюу тэвш мэт зүлэг болсон байв. Тархийг голын эхэнд тавьсанаас тэнгэр баганадан тулсан мэт цаст уул болсон ажгуу. Үсийг ууланд цацсанаас алин хэрэглэгдэх жимстэй мод гарсан буюу.

Тэр охин хатан болон нэг жил жаргасан бөгөөд тэр охины эр нөхөр хаан түүнийг эрж байв. Тэр охин нэг өдөр харшийн оройд гарсанд урьд хожид үзэгдээгүй олон морьтой хүмүүс ирэхэд охин сайтар нягтлан харж, урьдын хаан мөнийг таниад шатны зарим гишгүүрийг алгасан харайсаар хааныг мориноос буухад очиж уулзав. Баясах нь дэндээд хаанаас зуурч хаан ч нулимс гаргаж охиноос зуурч байхад урьдын учир шалтгаанаа хаанд айлтгав. Хаан

өгүүлрүүн:

– Охин чиний зөв. Би тэр мэтийг хаанаас хэлэх аж. Түшмэл хаанд үл хамаарна. Элч хүний болгоомжгүйгээс болсон тул хатан чиний зөв болой гэв. Чингээд хаан түшмэдийг дотогш урин залж өргөл хүндлэл, хотол чуулганыг айлтгасанд хаан:|

– Энэ нь хүүхний эцэг өвгийн орон мөн буюу? гэсэнд эцэг эхтэйгээ уулзах заяатан би биш. Надад нэгэн ажнай морь байсны ачаар ийм болсон амой гэсэнд

– Манайд ирэх үед морьгүй байсан. Хаанаас морь гарсан бэ? гэхэд охин урьдын учир, түүхийг хаанд нягтлан айлтгасанд баясав.

Тэр ажнай морь эцэг эхээс ачтай ажгуу хэмээн айлдав. Тэр хаан хатан хоёул хоёр хан төрийг ялгаварлалгүй тэтгэж, албатууд ч дэлгэрч, өдөр шөнө үргэлжид номын явдлаар явах болсон ажгуу гэсэнд Сайн амгалан явдалт хаан

– Тэр морь нь охинд их ачтай болжээ хэмээн үг алдсанд хүүр

– Хүүрт үг хэлэх нь муу ёр мөн хэмээн төмөр торыг гал бадартал гурав дэлдээд араас алдагдав. Хааны бодолд «Лам хүүрт үгний хариуг бүү хэл хэмээн захисан бөгөөтөл миний сэтгэл алмайрч үг алдаад уршиг болов гээд басхүү хүүрийн дотор явж «Хала хала» хэмээгчдийг тогшуураар цохиж «Хү-лү хү-лү» хэмээгчдийг гишгэлсээр очив.

Охин Сохадилиман ажнай морины ачаар мангасын гараас мултарч хан төртэй учирсан аравдугаар бүлэг болой.

# ЭХ ОХИН ХОЁР МАНГАС НЬ ХҮНИЙ ОХИНЫ ТОЛГОЙГ ЭРГҮҮЛСЭН БОЛОВЧ ЭЦЭСТЭЭ ХҮНИЙ ОХИНЫ ЭХ НЬ БЭЛГЭ БИЛГИЙН ДАГИНА МӨНИЙ ТУЛ МУУГИЙН ХАРИУГ ХАРИУЛЖ ОХИНОО ХААНЫ ХАТАН БОЛГОСОН БҮЛЭГ ОРШВОЙ

Бас хан хөвгүүн буцаж хүүрийн газарт очиж

– Лам минь Наганжуна Зүрхэн мөн. Би Сайн амгалант хаан мөн. Тор минь есөн нүхт төмөр мөн. Тогшуур хүрэн сэндэн мөн. Хүлэг минь мэхт гинж мөн. Хутга минь чулуу тастагч ирт мөн. Тостой гурил минь барагдашгүй идээ мөн. Хүүр чи буухгүй буюу? Модыг чинь унагалаа гэсэнд тэр хүүр бууж ирэв. Тогшуураар дэлдэж торын дотор чихэн хүлгээр хүлж үүрээд арван алхмын төдий хүрэхэд

– Хан хөвгүүн. Хан хөвгүүн. Эс бөгөөс хан хөвгүүн нэгэн үлгэр яригтун. Эс бөгөөс би нэгэн үлгэр ярья. Сонс гэхэд хан хөвгүүн «учрыг мэдэж байна» хэмээн бодож дуун эс гаргасан тул

– Хан хөвгүүн чи юм эс яриваас сонсогтун!

Урьд цагт нэгэн голын адагт нэг хаан байжээ. Голын эхэнд эх охин хоёр байсан ба түүний айл эм мангас охинтойгоо хоёул байсан бөлгөө. Нэгэн үе болоход хүний охин мангасынхаас гал гуйхаар очсонд мангас охин хоёр тэр охинд хүний чихний өчүүхэн омгийг шарж өгөв. Охин

Амттай байна гэсэнд

Чи бидний хань болж иртүгэй хэмээн хэлэв.

– Би ирье гэвч ээж минь явуулахгүй гэв.

– Чи эхээ алаад ирвээс болох буй за гэхэд охин

– Хэрхэн алах вэ? гэсэнд мангас сургасан нь

– Чи өөрөө би өвдлөө гэхэд ээж чинь «Чиний өвчинд юу туслах вэ?» гэх болно. Чи «миний өвчинд арга байвч ээж яасан ч үйлдэхгүй буй за» гээрэй. «Арга байваас яавч үйлдэнэ» гэх болно. Чингэхээр тээрмийн чулууг над бариулаад ээжийн хөхөөр тэр чулууг цохивоос тус болно» хэмээн хэлтүгэй. «Охинд тус болбоос яавч үйлдэнэ» гээд «Чулууг цохьё гэхэд тээрмийн чулуугаар цохиж алтугай» хэмээн сургасанд тэр охин мангасын сургасан ёсоор үйлдэж эх нь хөхөөр чулууг цохиход охин нь чулуугаар хөхийг тас цохисонд хөх нь тасраад эх үхэв. Тэр охин

– Мангас охин хоёр түргэн иртүгэй. Би эхийгээ алсан гэсэнд мангас охинтойгоо ирэв. Тэр мангас охинтойгоо хоёул махыг нь идэж ясыг нь мэрж, махны үлдэгдлийг эм мангас идэв. Охинд заваан гурил өгөөд тэр охиныг түлээ түүх үхэр хариулахаар захив. Охины сайн гутал хувцсыг мангасын охин өмсөж мангасын муу хуучин гутал хувцсыг охин өмсөж охин үнээ хариулж түлээ үүрэх ажлыг өдөр бүр хийх хэрэгтэй болж зовж зүдэрч байхад түүний ээж нь удалгүй охины байгаа газарт мангасын үнээ болон төрөв.



Тэр үнээнээс саасан бүгд тараг болдог хутгасан бүгд нь тос болдог ийм үнээ байв.

Хэд хоног болсонд тэр үнээ охинд

– Жаргалыг хойш тавьж зовлонг худалдан авагч чи хормойгоо дэвсээд унт гэв. Тэр охин хормойгоо дэвсээд унтсанд үдэш болсон байв. Гэнэт босоод харсанд байсан ноосыг урьдаас их эрчилж томсон байв. Үүрэг түлээг ч түүсэн байв. Хормойд нэгэн их хоол тавьсан байв. Үхэр бүгд урьдаасаа илүү түхийтлээ цадчихаад налайгаад хэвтгэцгээж байв. Тэр мэт хэдэн хоног жаргаад нэг үе болоход мангас

– Би охиндоо мах тос, бурам өгсөн. Чамд зуурсан гурил өгч байхад царай орж таргалаад байдаг нь ямар учиртай вэ? гэсэнд Тэр охин «Үнэнийг эс өгүүлвээс алах буй за» хэмээн. сэжиглээд хэлсэн нь:

– Манай энэ улаагч үнээ жаргалыг зовлонгоос худалдагч чи хормойгоо дэвсээд унт гэсэнд би хормойгоо дэвсээд унтсан учир, сайн хоол бэлтгэж ноосыг өөрөө томсон, түлээг ч бэлтгэсэн. Үхрийг түхийтэл цадтал нь хооллосон байв. Тэр мэтээр жаргалтай болсон болно гэсэнд

– Чи төлдрийн хэлэхгүй яасан юм бэ? Маргааш би хүүхнээ явуулна. Энэ гуйранч эмийн энэ хэртэй болсныг мэдсэнгүй. Одоо чи суу. Эгчийг чинь явуулья гэв. Түүний маргааш мангасын охин үхэр хариулахаар очсонд

– Охин оо, жаргалыг зовлонгоо худалдагч чи хормойгоо тосоод унттугай гэв. Охин хэвтэж унтаад босоход хормойн дотор нэгэн баас буй болсон ба ноос нь цөм модны оройд өлгөгдөж. үхрүүд жалганы нэг тархсан учир, тэр охин ажилдаа самгардаж үймээд оройтож харив.

– Охин яагаад удав хэмээн мангас ээж зэмлэв. Охин ээждээ:

Тэр үнээ жаргаланг зовлонгоор худалдагч охин хормойгоо тосоод унт гэсэнд тэр ёсоор унтав. Хормойд нэгэн их нойтон баас бааж, ноосыг цөм модны оройд өлгөж, үхэр бүхэн жалганы нэг болон тархсан учир самгардаад удлаа гэхэд

– Муу гуйранч эмийн эх нь үнээ болсон ажгуу. Түүнийг ална гэв. Охин дараа дахиж очсонд тэр үнээ охинд ийн хэлэв.

– Жаргалыг хаяж зовлонг худалдан авагч охин оо. Одоо тэр хоёр намайг алах болно. Алсны сүүлд охин чи алагдсан ээжийн махнаас надад хувь хэрэгтэй байна. Дөрвөн тагалцгийг өгнө үү гээрэй. Дөрвөн мөчийн хэсэгхэн арьсыг, мөн хэсэгхэн гэдсийг гуйж ав. Дараа нь уран аргаар мангас ээжээс аливаа махны зүйлийг гуйж түүний өгсөн махыг арьсны дотор хийж босгоны доор булагтун хэмээн сургав. Тэр үнээг мангас алаад

– Охин чи эхийнхээ махнаас хувь юу хэрэглэх вэ? гэсэнд охин урьд сургасан ёсоор гуйж, авсан зүйлээ арьсан дотор боож үзүүлэлгүй босгоны доор булав. Нэгэн үе болоход голын адагт сонирхолтой нэг их наадам болох үеэр мангас охинтойгоо хамт хувцаслаж чимэглээд тогоо дүүрэн арвай, тогоо дүүрэн юнгар хольж тавиад

– Охин чи үүнийг энэ өдөр нүдэж эс гүйцэтгэвээс үхэхээ бэлдтүгэй гээд тэр хоёр одов. Түр нэгэн болоход хүүрзгэнэ ирээд

– Жаргалыг зовлонгоор худалдагч охин босгон доор булснаа гаргаад дээл гутлаа өмсөж, бүсээ бүслээд, алт оюунуудыг зүүгээд наадамд явагтун гэв. Охин тэдгээрийг авч үзсэнд арьс, нь хувцас болж, хоёр тагалцаг нь гутал тэргүүтэн болж, гэдэс нь бүс болсон ба бусад хэсэг бусаг нь мах нь алт оюу болсон байв. Тэр дээл гутлыг өмсөж бүсийг бүслэв. Нөгөө хоёр тагалцаг нь хоёр суулга болсон байжээ. Түүнийг бариад алт оюунуудыг зүүгээд тэнд ирж хүүрзгэнэд

– Хувцас чимгүүд маш сайн бөгөөд гэтэл тогоо юнгар, тогоо арвайг талхалж эс гүйцэтгэвээс үдэш ирж ална эгснийг хэлэв.

– Юнгар арвайг би нүднэ. Чи өөрөө наадамд очоод эртхэн буцаж иртүгэй гэв. Тэр охин наадамд очоод цуглааныг зөв эргэн үзэхэд өнөөх хоёр нь хоол гуйгаад явж байв. Тэр охин бас наран буруу эргэсэнд хамгийн гайхамшигтай сайхан нь их хаан байв. Тэр наадмыг их сонирхож үзэв. Цуглаан тархахаас урьд хурдлан гэртээ буцаж явах замд нэг усыг харайж гарахдаа нэг суулгаа тэнд гэв. Тэр охин гэртээ ороод хувцас чимэг хэрэглэл бүгдийг нууж тавив. Арван юнгар хоёрыг нүдэж дууссан байв. Тэр хааны унагыг хадгалдаг хүн морио услах гэж явгал хул шарга хүлэг нь ус уулгүй өөдөө явжээ. Морь адуулагч түүний хойноос явав. Тэр морь сайхан суулгыг үнэртсэнд хүлэг адуулагч тэр суулгыг авч морио ус уулгаж хангаад хүлэг морио хөтөлсөөр явж тэр суулгыг хаанд өргөж учир шалтгааныг айлтгасанд хаан өгүүллүүн:

– Өчигдрийн цугларагсдын дунд арван таван насны хэртэй дагина шинж тэмдэг бүрдсэн нэг охин байсан билээ. Түүнийг энэ өдөр ирвээс ажнай мориор эрж олоод хааны харшид авчирч хатан болгож авна гэв. Мангас охин хоёрыг хүрч ирэхэд

– Ээж эгч хоёр наадамд очиж сонирхсон буюу? Эрийн дээд хэн шалгарав? Эмийн дээд хэн шалгарав? хэмээн асуув.

Эрдийн дээдэд их хаан шалгарав. Эмий дээдэд миний охин шалгарав. Чи юнгар ба арвайг нүдэж дуусав уу? гэв. Суулгатай байсныг талхалж дууссан гэсэнд

– Чи маш сайн байна. Энд сууваас зохино гэв. Мангасын охин

Чамтай адилхан нэг хүн маш гоёхон чимэгтэй сайхан хувцастай явж байсныг хараад чамайг мөн байна гэж би Амад хэлсэнд Ама огт сэжиглээгүй билээ. Амагийн зөв байсан буюу гэв. Чингээд шөнө унтаад босоход наран гарч байсан ба бас юнгар ба арвайг тогоо дүүрэн хольж

– Үүнийг нүдэж гүйцэтгэтүгэй гээд тэр эх хүүхэн хоёр наадамд явав. Бас түр нэгэн хэсэг болоход нэгэн сүрэг хүүрзгэнэ ирэв. Түүний дундаас нэг хүүрзгэнэ охинд

– Охин оо, өчигдрийн чимэг хэрэглэлээ өмсөж зүүгээд тэр суулгаа аваад явтугай. Чи мангасын гараас гэтлэх болно гэв. Тэр охин чимэг хэрэглэлээрээ чимэглэж суулгыг гартаа бариад цугларагсдын дотор хүрсэнд тэр хааны нэг түшмэл урьдын тэр суулгыг гартаа барьж

Үүний дотор хэн багтваас түүнийг хааны хатан болгоно гэсэнд суулгад багтах охин

гарсангүй. Мангасын тэр охин баруун хөлөө оруулавч багтсангүй. Мөн зүүн хөлөө оруулавч багтсангүй. Хөлийн хурууны үзүүр нь ч суулганд багтсангүй. Түүнд өөр багтах хүн үл гарсанд, сүүлийн өнөөх охин хоёр гутлаа мулталж мөрөн дээрээ тавьж очоод

– Энэ суулга ч минийх байна. Өрөөсөн нь энэ байна гээд хоёр суулгад ээлжлэн орсныг тэнд байсан мангас охин хоёул үзээд охин нь

– Тэр охин, манай өнөөх охин мөн байна гэсэнд ээж

– Тийм буян түүнд хаанаас байх вэ? гэв. Тэр охиныг хааны хатан болгов. Мангас, охин хоёр буцаж харьсанд гэр дотор шувууны мөр энд тэндгүй дүүрэн байв. Үр тариа бүгдийг задлан гаргаж идээд саван дотор нь баасаар дүүргэсэн байв. Мангас

– Тэр эм ийм болгох гэж санаад ийм болгосон байна. Түүний эх эм шулмас, лавгай хүүрзгэнэ болж төрсөн байна.

- Хааны хатан болсны дараа түүнээс нэгэн хөвгүүн мэндэлсэнд, Дондов хэмээн нэр зүүв. Охин ирснээс хойш тэр оронд амгалан жаргал бүрэн төгс болов. Нэгэн үе болоход

– Танилтайгаа уулзана гэж мангасын охин ирсэнд

– Түүнийг оруул гээд ирүүлэв. Хатан

– Эрхтэй байх цагт дээрэнгүй зангаа багатгах хэрэгтэй гэж санаад өөртэйгөө адил хоол идүүлж ижил хувцас өмсгөж байв. Нэгэн үе болоход «Ажаа» хэмээн мангасын охин сонжуурлаж асуусан нь:

Аяа, их хаанд юу барих вэ? Албат зарц нөхдөд юу өгөх вэ? гэсэнд

– Аяа их хаанд зуган гурилыг өгнө. Зарц нөхдийг гурван амттаны дээжээр тахина гэв.

– Хул шарга хүлэгт юу өгөх вэ? Цагаан галуу, дүнчүн нохойд юу өгөх вэ? хэмээн асуусанд «Хул шарга хүлэгт яс өг. Цагаан галуу, дүнчүн нохойд морины тэжээл өгтүгэй гэсэнд мангасын охин

Хөвгүүн Дондовыг аль хэр асардаг вэ? Албат нөхдийг хэрхэн үздэг вэ? гэсэнд

Дондов хөвгүүнийг өөд явахдаа нэг алгадаж, уруу явахдаа нэг алгаддаг. Албат нөхдийг өөд явахаа хялав цайлав хардаг, уруу явахдаа хялангарлаж хардаг гэв.

– Үүд ба шатаар яаж явдаг вэ? гэсэнд

– Үүд хаалгыг тас дэлддэг. Шатыг тар түр дэвсдэг гэсэнд

Бас галын голд юу шургуулах вэ? гэсэнд

– Цул бөөрөнхий түүдэг шургуулна гэв. Нэгэн үе болоход мангасын охин

– Ажаа, толгойнхоо үсийг угааваас сайн. Би үсийг чинь угаалцаж тусалъя. Хааны хатан болохоор сайн угааж байх хэрэгтэй. Хөхлийг чинь задгайлъя гэсэнд тэр хатан дурамжхан зөвшөөрч, усаар толгойгоо угаахыг завдсанд

– Хааны хатан очир далайд очиж угааваас сайн гэж хөтлөөд явав. Далайн захад хүрээд чимэг хувцас хунарыг тайлж дан хувцас өмсөж үсээ угаахаар толгойгоо бөхийлгөмөгц, мангасын охин далай уруу түлхэж орхив. Мангасын охин хатны чимэг хувцас хэрэглэлийг зүүгээд буцаж ирэв. Өнөөх урьдын хатны янз байдлыг гаргаж үүд нээх хаах бүрдээ эвдэрч хагартал савах болсон ба шатаар гишгэхдээ тас дэвсэж одох болов. Өөд уруу явахдаа Дондов хөвгүүнийг нэжгээд алгаддаг болов. Хаанд сувс үлбэгэр зутан өгөх болов. Сайн амт шимттэй идээг албат нөхдөд өгч, цагаан галуу, дүнчүн нохойд морины бордоо өгч, хул шарга хүлэг моринд нэжгээд ясыг өгч дэргэд ирсэн ноходод аашилж мугуйд авирлах ба хол байгаа хүмүүсийг хялав цайлав хийж хялангарлан хардаг болов. Цул бөөрөнхий түүдгийг галд шургуулсан тул өдөр бүр гаднаас гал гуйх хэрэгтэй болов. Албат иргэн

– Мангасын охин явснаас хойш энэ хатны явдал буруудав. Ам хэл, зан авир бүгд урвасан бөгөөд бид жаргалыг үзнэ гэж үү? хэмээн ярилцах болов.

Бас нэгэн, үе болоход хүлэг адуулагч нь хул шарга хүлгийг услахаар хуучин усалдаг булагт очиход хүлэг нь түүнээс уухгүй урьдын үзсэн далай өөд тэмүүлээд алдуулав. Тэр далайгаас өчүүхэн уугаад нулимсаа бөөн бөөн унагасанд далайн дундаас толгой дээрээ оюу үстэй алтан болжмор гарч ирээд далайн захын нэгэн модон дээр бууж ийн өгүүллрүүн:

– Аяа, их хаанд урьдын хатны хүндлэл их үү? Сүүлчийн хатны хүндлэл их үү? Дондов хөвгүүнд урьдах ээж асрамж ихтэй буюу? Хойдох нь асрамж ихтэй юу? Албат зарц нөхдөд урьдах хатан асрамжтай буюу? Сүүлчийн хатан асрамжтай буюу? Цагаан галуу, дүнчүн нохойд урьдах эзэн асрамжтай буюу? Сүүлчийн эзэн асрамжтай юу? Хул шарга хүлэгт урьдах эзэн асрамжтай юу? Сүүлчийн эзэн асрамжтай юу?» хэмээн хэлээд усан дотор одов. Тэр хүлэг адуулагч хүлгээ услаад хурдан буцаж хаанд айлтгасан нь:

– Манай хул шарга хүлэг булгийн уснаас уусангүй, далай руу алдуулан очоод далайгаас ууж янцгаагаад нулимс унагасанд далайгаас оюу үстэй алтан болжмор гарч далайн захын модон дээр бууж ийнхүү өгүүлэв хэмээн урьд юу хэлснийг ёсоор айлтгасанд хаан

– Маргааш очиж үзнэ. Зүүд минь ч муу байна. Энэ охины зан авир ч урвасан байна хэмээн айлдаад, маргааш нь хаан, түшмэл, хүлэг адуулагч гурвуул явж далайн захад очив. Түүний хэлсэн ёсоор төлдрийн болжмор гарч ирээд модон дээр бууж урьд өгүүлсний адил өгүүлсэнд хаан нулимс алдаж

. – Чи энд ирээд хэлэгтүн. Би сайн чагнаа хэмээн хэлсэнд хааны толгой дээр бууж ирээд хэлэв.

– Болжмор чи миний гар дээр буугаад хэлэгтүн хэмээн айлдав. Алган дээр нь ирж урьд мэт хэлсэнд түүнийг хаан барьж авав. Болжмор

– Охин миний буруу боллоо. Болжмор намайг тавь хэмээн хоёр гурав дахин айлтгасанд хаан

– Аргагүй буюу? Аргыг хэлж өгтүгэй. Бэлгэ бүрдэхгүй буюу. Бэлгэ бүрдэхийг хэлж өгтүгэй. Чамд ямар гай ирээд байна вэ? гэсэнд болжмор хаанд айлтгав.

– Гэрт байгаа тэр нь мангасын охин мөн. Урьд насны өр төлөөсөөр охин би балар харанхуйд дарагдсан мэт болоход тэр охин намайг дагуулж далайд хаяж орхисон билээ хэмээн айлтгасан ба

– Одоо сайн арга бололцоо бий, хаан түшмэл та нар намайг энд байна гэж бүү яригтун. Эндээс харшдаа очоод намайг таван өнгийн хив хадгийн дотор боож хүү сангийн дотор тавиад олон ноёд, долоо хоногийн турш буян хишиг дуудаж насны бүтээлийг бүтээ. Асар их гал түлж архи нэрье гэж мангасын охины суудлын доор бие багтах хэмжээний нүх ухаад дээд талаар тэгшхэн болгож амыг нь бүрхүүлээр бүрхэж, түүнийг дээр тэр охины дэвсгэрийг дэвсэж суулгаваас тэр охин цөмөрч толгойгоор нүх руу онхолдох буй за. Чингэхэд бэлтгэсэн их галыг дээрээс нь хийвээс тэр үхэх болно. Чингэсний дараа би сэргэх болно гэсэнд хаан түшмэл тэдгээр баярлаж, охины хэлсэн ёсоор бэлтгэв. Мангасын охин суудал дээр гармагц толгойгоороо онхолдож унав. Түүний дээр их гал хийж, тэр охиныг түлж алаад, хүү сангийн дотор очвоос нөгөө охин урьдахаасаа дутуугүй сайхан царайтай болж сэргэсэн байв. Хааны хатан ирж албатуудад

Мангасын охины толгойг огтол гэж мангасын охины толгойг түүдгийн гол болгон нарийн утсаар тогоон чинээ түүдэг хийж сайхан амттай элдэв идээг нэгэн саванд хийж, тэр хоёрыг хул шарга хүлгийн эмээлийн хойдох бүүргэнд ганзагалж мордоод мангасын эхийн нутагт хүрэв. Мангасын төрсөн охин мэтээр дэргэд нь хүрч сайхан амттай идээг эхдээ өгч

– Ээж ганцаар амгалан сайн байв уу? гэсэнд

– Би ганцаар мэнд сайн байна. Охин чи тэр хатан эмийг хуурч чадав уу? Хаан мэдээгүй биз. Тэр охинтой чи адил байж чадав уу? гэв. Чингээд охин дээш гарч цонхны нүхээр бүхэл улаан торго дэлгэн уяв. Тэр доошоо буугаад бас өгүүлсэн нь:

– Хаан зэмлэх болно. Ээж миний энэ түүдгийг задлахад тусалж байтугай. Би явья гэсэнд

– Явбаас сайн. Хаанд мэдэгдэлгүй үйлдэгтүн. Албатуудыг хэрхэн тэтгэмжлэх ба Дондов хөвгүүнийг яаж асарч байхыг тэр охины нэгэн адилаар үйлд хэмээн мангас ээж сургамжлав. Чингээд хөгшин эмгэн тэр түүдгийг барьсанд охин утасны үзүүрээс бариад явав. Шувтрах хэрд мориндоо мордож санд мэнд зугтааж одов. Утас шувтрах цагт тэр түүдгийн дотроос чихний омог харагдахад түүнийг лавлан магадалж хараад эмгэн өөрийн охины толгой байгааг таниад тэр даруйд охины хойноос нэхэн хөөж охиныг барих шахсанд охин

– Мангас ээж намайг элдэх ч яамай. Танай гэрт гал гарч байна. Миний морь хурдан тул гүйцэгдэхгүй гэв. Мангас ээж эргэж харсанд цонхноос улаан торго хийсэж байхыг үзээд буцаж харив. Тэр охин өөрийн хааны дэргэд хүрэв. Хатан мангас эх охин хоёрын муу хийсний хариуг авч, тэр хаан хан төрийг номын ёсоор тэтгэж, албатууд ч урьдаас нэн ихээр өрнөн мандсан бөлгөө гэсэнд Сайн амгалан явдалт хаан

– Тэр хатан, урьд эхээ эс алсан болбоос маш жаргаж болох байжээ. Эх охин хоёрын эх нь

дагинас болж охин нь мангасын амнаас гэтэлж хааны хатан болсон нь буян ихтэй ажгуу гэсэнд

– Хүүрт үг ярив гээд төмөр торыг гал бадартал гурав дэлдээд харцага адил хүр хэмээн араас алдуулав. Хан хөвгүүн «сэтгэл алгассанаар уршиг болов. Буцаж хариваас лам зэмлэх болно» хэмээн сэтгэж, тэр хүүрийн зүг одов. «Ха-ла» гэсэн хүүрийг тогшуураар цохиж «Хү-лү» гэсэн хүүрийг алхаж гишгэсээр модны дэргэд хүрэв.

Эм мангас охины толгойг мэхлэн эргүүлэх гэвч, түүний ээж нь бэлгэ билгийн дагина мөн учир, хорлолыг хариулж охиныг хааны хатан болгосон арван нэгдүгээр бүлэг болой.

# ТӨӨРСӨН ХУДАЛДААЧИН ТӨР БАРЬСАН БҮЛЭГ ОРШВОЙ

Бас хан хөвгүүн тэр модны дэргэд очоод

Лам минь Наганжуна Зүрхэн мөн. Би Сайн амгалан явдалт хаан мөн. Хутга минь чулуу огтлогч иртэй мөн. Тор минь есөн нүхт төмөр мөн. Тогшуур минь хүрэн сэндэн мод мөн. Хүлэг минь мэхт гинж мөн. Хүүр буухгүй буюу? Модыг чинь унагалаа гэхэд хүүр бууж ирэв. Түүнийг тогшуураар дэлдэж, торны дотор чихэж хүлгээр хүлээд үүрч арван алхам төдий явахад хүүр өгүүлрүүн:

Эсбөгөөс хан хөвгүүн нэгэн үлгэрийг ярь. Эсбөгөөс би нэгэн үлгэр ярья. Сонсогтун.

Нэгэн голд нэг их хаан байсан бөлгөө. Тэр хааны албат төгс эдлэл бүрдсэн нэг баян өвгөн байв. Түүнд ганц хөвгүүнээс өөр хүүхэдгүй билээ. Эцэг нь өдөр шөнөгүй үргэлж номыг үйлдэгч бөгөөд хүү нь цэцэн хэрсүү тул айл аймгийнх цөм түүнд сайн байдаг ажгуу. Нэгэн үе болоход тэр орноос олон худалдаачин худалдаанд явахдаа тэр хөвгүүнд идэж уух юмыг өгөөд

Чи худалдаанд явбаас эд идээ барагдашгүй ихтэй болно гэсэнд тэр хөвгүүн эцэг эхийнхээ дэргэд очоод

– Худалдаанд явья гэсэнд эцэг нь

Манайхан угаас худалдаанд явалгүй жаргасаар ирсэн буй. Явахыг их дурлавч бид хонжворт худалдаа хийгээгүйгээр баян болсон билээ. Худалдаанд үл явуулна гэсэнд хөвгүүн эхийн дэргэд очоод

Худалдаанд явья гэв. Эх

Худалдаагаар юу хийх вэ? Эцэг өвөг ч худалдаанд явдаг ёс заншил байгаагүй. Эцэг өвгөд сайхан санааг үүсгэж муу явдал ба хөнөөлийн сэтгэлийг тэвчиж, ашиг хонжоог бусдад өгч, номын ёсоор явснаар жаргасан юм. Эх би чамаас өөр үргүй тул худалдаанд үл явуулна. Би хаана үхэхийг чинь үл мэднэ гэсэнд

– Эх эцэг та хоёр үл явуулбаас би оргож явна гэсэнд эх нь эцэгт сонсгов. Эцэг

– Түүнийг ирүүл гэсэнд хөвгүүн ирмэгц

– Чамд энэ насанд хэрэглэж гүйцэх эд таваар буй. Хойдод тус болгохоор буяны зүг өөд урьд ч өгсөн. Одоо ч өгье гэвээс бас болно. Ашиг бодоод амиа худалдах гэж явах нь мөн буюу? Чамайг явуулахгүй гэсэнд

– Эс явуулбаас оргож явна гэв. Ээж нь

Далдуур нууцгай явна гэж муу үг хэлж байна. Аль нь дээр вэ? Ил явуулбаас дээр биш үү гэв. Эцэг нь

Үл явуулна гэв. Эх нь

Энэ хөвгүүний явах нь лавтай байна. Хязгаар газрыг тойроод эс үзэгдэх боловч дахиад уулзаж болох буй за гэсэнд эцэг

– Манай нутгийн хүмүүс ба айлын хүмүүсийн ганцхан хардаг сайн сайхан хүүгээ бөглүү хол газар явуулж, үлэмж өтөлсөн хойноо хагацах хэцүү байна гэсэнд эх нь

Суу гэвч үл сууна. Бид мэнд сайн сууваас ирэхийг үзэж ч болох буй за гээд худалдаанд явах хэрэглэлийг бэлтгэж өгөөд явуулав.

Тэр хүү худалдаачидтай ханилаад явлаа. Сарын хагас төдий явж худалдааны газарт хүрэв. Тэр оронд ачаагаа бэлтгэж байтал тэр орны эзэн хэлрүүн

Хань нөхөд чинь буй буюу гэхэд

– Байхгүй. Бүгд явсан тул би бас явна гэсэнд

– Энэ замаар өөдөө явахад маш бэрх. Эсбөгөөс гэртээ буцваас сайн. Эсбөгөөс тэр нөхдийг иртэл хүлээвээс сайн гэв. Хөвгүүн

– Би эдгүй учраас худалдаанд явсан бус. Эх эцэг хоёр минь явуулахгүй хориглож байхад нь би үгийг сонсолгүй ирсэн юм гэв. Гэрийн эзэн

– Одоо яавч явах ахул энэ хутгыг аваад яв гээд нэгэн сайн хутгыг өгч

– Энэ хутганаас хэрхэвч салж үл болно. Нүдэнд харагдах дайсанд бол цавчих хэрэггүй. Зөвхөн гаргасан төдийхнөөр болно. Далдын тэнгэр чөтгөрт гаргахын ч хэрэггүй. Биеэс салгаагүй төдийгөөр болох тул хагацаж үл болно гэв. Тэр хутгыг зүүгээд ачаагаа ачаад худалдаачны мөрөөр хойноос нь явж нэгэн их голд хүрэхэд наран ч шингэх болж тэдгээрийн зам мөр ч үл мэдэгдэх болов. Олон арзайж сэрзийсэн барилга байшин байв. Хааны харшийн дэргэд хүрэхэд эрээн хаалгыг онгойлгож орхисон байв. Түүгээр дотогш ороод цааш явсанд ганц ч хүнгүй. Харин адууны том хашаа байв. Дээгүүр нь өнгийгөөд харсанд зарим адуу хөсөр ойчиж, зарим нь үхэж байв. Ганц ч хүнгүй ажгуу. Бас өөр малын нэг хашаа уруу харахад үхрүүд урьдынхтай адил үхэж байв.

Хөвгүүн ачаагаа буулгаж, тэнд тавиад хааны харш өөд тавьсан шатаар авирсаар тэр байшинд хүрсэнд албат иргэд ноёд бүгдээр үхсэн байв. Түүнээс дээшээ явсанд алтан ширээн дээр хаан хальсан байв. Оюу ширээн дээр хатан нас барсан ба дотор ганц ч хүнгүй байв. Бас тэр хөвгүүн доош уруудаж адууны хашааны дэргэд очоод адуунд өвс цадтал тавьж өгөөд үхрүүдэд ч мөн цадтал өвс түгээж өгөв. Өөрийнхөө ачааг нэгэн хөндий мухарт тавиад гаднах үүдийг хааж чулуу давхарлаж түшүүлээд бүх үүдийг дараа дараагаар нь хааж орхив. Эргэж ирээд алтан ширээ ба оюу ширээн дээрх хүүр ба бусад олон хүүрийг хайхарсангүй. Мах архи төгс эдлэл цаглашгүй байснаас их үнэр анхилсан амтлаг сайхан архи, цээж мах ба нэг аягыг авав. Өөрийн хувийн идэш хүнсний хүүдийгээс гурил гарган зуурч дэргэдээ тавиад нэгэн их гал түлж тэр архинаас ханатлаа уугаад бүхэл цээж махны сэрвээнээс барин шарж болсныг идээд

улаан түүхийг үлдээж байв. Шөнө дунд өнгөрөхөд үүд нээгдсэнд хэн ирдэг бол хэмээн



хутганыхаа бариулыг бариад гараар барьж хутга үзээд ил дайсанд далайхын хэрэггүй. Далдын тэнгэр чөтгөрт сугалж гаргах хэрэггүй хэмээн хэлснийг бодож уужуухан сууж байсанд тэр, шатаар тог тог хэмээн авирсаар нэг юм ирэв. Түр болсонд хар хялгасан чимгүүд мөрөндөө зүүж уясан ясан гавалтай, аймшигтай нэг бич шатны оройд гарч ирэхэд түүний хойноос зургаан бич дагаж ирэв. «Эи эй» хэмээн дуугарсаар хөвгүүнийг гурав дахин эргэж тэнд байгаа нэг хар хайрцгийг бас гурав дахин эргэв. Бичин бүгд тэртээ явж очоод ам омруугаар нэг нэгэнд тулаад унтаж хурхиран ийм тийшээ хөндлөн гулд

байв. Үүр шахахад хутга нь сугаран гарваас бич бүгдээрээ оргүй алга болов. Өглөө болоход хутга хуйндаа оров. Наран ургахад «Одоо явья» хэмээн сэтгэж, шатаар бууваас үүд хаалга бүгд хаалттай хэвээр байв. Тэр бас морьд үхрүүдэд өвс ус өгч үүд хаалгыг дараалан хаагаад урьд шөнийн хоносон газар очиж нэг их гал түлж үхрийн мах, багсарсан гурил, архи авч, мах шарж идээд архи уусаар суутал шөнө болж, бас урьдаас их чимээтэй «тог тог» хэмээн дуугарав. Түр нэгэн болоод дотор үүд нээгдэхэд «урьд шөнийн бич мөн бололтой» хэмээн сэтгэж байтал нэгэн том бич шатны эх рүү дүүлэн ирэв. Баруун гартаа Пүрэв зүүн гартаа гавал барьсан ба толгойдоо дугуй заг тав малгай өмссөн байв. Түүний хойноос тус бүр пүрэв ба гавал барьсан долоон бич, бас түүний хойноос нэгэн бич хэнгэрэг барьж нэгэн бич лавай барьж, нэг бич цан барьсаар орж ирэв. Чингэзд бичнүүд хөгжмөө дуугарган цохисоор ойртож ирсэнд хүү хутганы бариулаас зуурсанд тэр хутга ч өчүүхэн төдий сугарав. Бас бичнүүд хөгжимдөж цамнаж нэгэнтээ эргэв. Тэр хутга ч гар хүрээгүй атал төө хэртэй сугарч гарав. Бич бүгдээр «Эй эй» гээд нэг доор овооролдов. Бие бие уруугаа бүлтэгнэн харцгааж байв. Нэг нэгээр цувж шатаар уруудаж бууцгаав. Тэр шөнө хөвгүүн ч архи махаа идэж уусаар суутал өглөө болж наран гарсны дараа бас доош бууж үүд хаалга бүгдийг нээж адуу үхэрт өвс өгөөд гадагш гарч ус авч ирээд суутал үүдний дэргэд хүний дуун ив илхэн сонстов.

— Төлдөр хүний дуун огт үгүй байсан билээ. Одоо энэ юу вэ? хэмээн сэтгээд харсанд үүрэг үүрсэн архины сав барьсан хоёр тарничин ирээд

— Гадагш гарч ирнэ үү гэсэнд, тэр хөвгүүн хутгаа зүүгээд очив. Тарничин

— Цэцэн ухаантан та морилж ирээд байгаа буюу? гэв.

— О сайн болов. Багш морилж ирэв үү? Одоо дотогш ортугай гэсэнд

— Зарлиг үг байвал энд ярьтугай гэв. Дотор орж асууж лавлацгааваас болох буй за гээд тэрхүү хоёр тарничинтай дотогш ороод хаалга үүдээ хаамагц тарничин өгүүллрүүн

— Буянтны дэргэд шадарлаж бараалхахад таны сайн хутганы эрдмээр далдын сахиус ч завсар чөлөө олж чадахгүй. Ил хүмүүсийг ир гэвч гадагшаа дутаадаг тул үүд түгжихийн хэрэггүй гэв. Тэр хөвгүүн үүдийг түгжилгүй дотогш явж оров. Тарничин хөвгүүнд муу арга үл хийхийг андгайлав. Хөвгүүн ч хутгаа үл гаргахыг тангараглав. Нэг нэгээ хорлохгүй гэлцэж, тэр хөвгүүн бэлхэн байсан мах ба тос идээ элдэв зүйлийг түгээж өглөө. Хоёр тарничин нэг нэг дүүрэн архи бариад тавтай ярьсанд тэр хөвгүүн

— Тэр хаан, хатан алт оюу ширээний дээр үхсэн ба албат нөхөр зарц нар ч үхсэн байдаг нь яагаад энэ вэ? гэсэнд тарничин

Миний сахиулс (сахиус) эд таваарт дуртай, хүч ихтэй юм. Эд нар ундууцаж хилэн хүрсэн биз. Бид сахиулсандаа өргөл болгон тавьсан чандмань эрдэнээс үлэмж маш чухаг нэгэн хөө хуягийг энэ голд хаан хатан хоёрт өрийн барьцаанд бариулж, өрийг дөрөв дахин давхар төлөвч хөө хуягийг эргүүлэн өгсөнгүй олон жил болсон билээ. Бусдаар дамжуулан айлтгуулавч үл хайхарсан тул сахиулс хилэгнэж харанхуй шөнө чөтгөрийн ид шид гаргасанд хаан хатан, албат нөхөр бүгдээр тааж чадсангүй үхэж байна. Их буянтай таны дэргэд шадарлан суухад ч өдгөө бөөн гал бадарсан мэт байна. Энэ сайн хутгыг эс сугалавч өөрөө хуйгаасаа сугарч байна гэв.

– Бид өглөгийн эзэд нэгдэж, энэ орны хаан болохыг айлтгая. Бид хоёр урьдын ёсоор тахилын орны лам больё. Бидний хөө хуяг тэр хар хайрцгийн дотор буй. Түүнийг харгалзаж дэмжилгийг үзүүлнэ үү. Бид таныг идээ эдлэлээр дутагдуулахгүй хангаж байя гэсэнд худалдаачин хөвгүүн

– Би хөө хуягийг чинь гаргаж өгье. Та нар ч танил, найртай өглөгийн эздийн гэрээр хэсэж уулзаж иртүгэй гэсэнд лам нар яваад голын хүмүүст зарласан нь

Манай хаан хатан хоёр чөтгөр болоод, эдийг авахуулахгүй байхад нэг номч хаан ирж, хаан хатан эхлэн чөтгөр болсон бүгдийг номхтгож дууссаны хойно бид хүрч очив. Бодьсад номч хаан хүрч ирсэн байна шүү гэхэд голын хүмүүс мэдэцгээж тэр худалдаачны дэргэд хүрч

– Та бидний хаан болон соёрх. Бид албат чинь больё хэмээн албат нар айлтгал өргөв. Тэр худалдаачин төгс эдлэл бүрэн гүйцэд болов. Чингээд нэгэн өдөр болоход урьд ханилж явсан худалдаачид хүрч ирэв. Тэдний нэг нь өвс эрж хааны харшийг чиглэн ирэхэд хөвгүүн дээд давхраас буухдаа харж

– Миний хань, нутгийн хүн мөн байна хэмээн таниад, нэгэн зарцад хэлрүүн

– Энэ гадна явж буй хүнийг дуудаж авч ир гэсэнд зарц худалдаачны дэргэд очоод худалдаачны ноёнд

– Хаан хүрээд ир хэмээн дуудуулж байна гэв. Худалдаачин

– Энэ хааныг урьд танихгүй. Энэ шалтаг эрж ядан буй буюу хэмээн сэтгээд тэр худалдаачин буцаж хань нөхөд дээрээ очив. Бас зарц хааны дэргэд одоод

– Миний хань нөхөд энд буй гээд буцаад явчхав хэмээн айлтгасанд хаан

«Өдгөө түргэн очиж та нарын худалдааны газар орхисон тэр хань чинь мөн. Өвс ба аль хэрэглэх зүйлээ ав гэж хэлэгтүн хэмээн айлтгасныг зарц тэр танил худалдаачны дэргэд хүрч, хааны юу айлтгасныг өгүүлсэнд тэр худалдаачин нар баясаж хааны харшийг чиглээд ирэв. Тэр худалдаачид хөвгүүний дэргэд ирээд нэг нь нөгөөгөө ширтэн харж гайхацгаав. Тэр хаан тэднийг хоол унд, эдлэлээр бүрэн төгс хангаж хэд хоног байлгав. Тэр хөвгүүн, өөрийн хаанд нэг заан ачаа ба бодь гөрөөс тэргүүлсэн алт мөнгө, элдэв эрдэнэ тэргүүтнийг айлтгалын бичиг сэлтийг дагуулан хүргүүлж, бас нэгэн сайн боломжтой түшмэлээр удирдуулсан морьтон хүмүүсээр эцэг эхийн мэнд амрыг эрсэн захидал бичгийг явуулав. Нутаг орны

хүмүүсийг хөө хуягтай морьт цэргээр үдэж маш их ёсолж орон нутагт нь явуулав. Тэд нутагтаа буцаж очоод хаанд учир шалтгааныг айлтгасан ба түшмэл ч түүний хүргүүлсэн захиа бичиг бэлгүүдийг өргөж айлтгав. Хаан

Түүний эцэг эхийг явуулахгүй, цэрэг татаж өөрийн албатад оруулваас болох болов уу? гээд тэр хааны албат нарын төгс эдлэл, хүчин чадлын их бага зэргийг асууж, албатын төгс эдлэл ба зам эндүүрсэн худалдаачны хүчин чадлын их багыг мэдээд эх эцэг эд таваар бүгдийг угтаж ирсэн түшмэлийн дэргэд хүргэж явуулав. Бас хаан ганц охиноо ачаатай арван заан ба чимэг хэрэглэл зарц охидын хамт явуулж, зам эндүүрэгч худалдаачинд хүргүүлэв. Түшмэл ба хааны охин, эцэг эхийн хамт хааны харшид хүрээд эх эцэг хатан цөмөөр баясав. Хааны охин ч албат нөхөд зарц, төгс эдлэлүүдийг болгоогоод баясав. Нэг сайн түшмэл явуулаад урьдын худалдааны газрын хутга өгсөн хүнийг эрж сураглаж олоод хааны зарлиг захиаг өгснөөр тэр эр эм хоёр баясаад түшмэлтэй ханилж хаанд бараалхахаар одов. Тэднийг хааны харшид хүрч ирэхэд тэр хоёр хүнийг ихээр өргөн хүндлэв. Тэр гэрийн эзэн эрийг шадар түшмэл болгож алт мөнгө, эд таваар, үхэр морь тэргүүтэн алин хэрэглэхийг өгөв. Чингээд тэр эр эм хоёр өөг цаггалан баян болов. Тэр хаан ч хан төрийг номын ёсоор тэтгэж, албатууд ч урьдаас нэн баялаг дэлгэрэв. Охиноо өгсөн эцэг хаантай хан төрийг ялгалгүй нэгэн адил барив. Төрийн хаан хоёул хоорондоо өдөр шөнө үргэлжид номын явдалд ажиллаж байв гэсэнд Сайн амгалан явдалт хаан

Тэр хүн буян ихтэй еэ. Гэрийн эзэн эр эм ач их хүргэсний хариуг сайн хариулсан ажгуу гэсэнд

Хүүрт үг ярив гээд төмөр торыг гал бадартал гурав дэлдэж, харцага адил хур хэмээн араас алдуулав. Тэр хааны сэтгэлд

Лам минь, тэр хүүр юун өгүүлэвч чи үгний хариу бүү хэл гэсэн бөгөөд тэнхээ тасарч сэтгэл алгасаж, үгний хариу алдсанаар уршиг удав. Хүүргүй буцваас зарлигийн зэм ирэх буюу» гээд хүүр тийш одов,

Төөрсөн худалдаачин төрийг барьсны арван хоёрдугаар бүлэг болой.

# АРИУН СЭТГЭЛТ БУЯНТАН ХАН ТӨР ОЛСОН БҮЛЭГ ОРШВОЙ

Бас хан хөвгүүн модны дэргэд очоод

– Лам минь Наганжунай Зүрхэн мөн. Би өөрөө Сайн амгалан явдалт хаан мөн. Тор минь есөн нүхт төмөр мөн. Тогшуур минь хүрэн сэндэн мөн. Хүлэг минь мэхт гинж мөн. Хутга минь чулуу тастагч ирт мөн. Хүүр чи буухгүй юу? Модыг чинь унагалаа хэмээн өгүүлсэнд тэр хүүрийг буун нрэхэд нь тогшуураараа дэлдэж торондоо чихээд, хүлгээрээ хүлж үүрээд долоон алхам хүрэхийн үед

– Хан хөвгүүн. Хан Хөвгүүн ээ. Газар хол энэлгээтэй тул үлгэр ярьтугай хэмээн өгүүлвээс хан хөвгүүн энэ учиртай буй за хэмээн сэтгэн дуун эс гарав. Хүүр

– Хан хөвгүүн чиний амнаас дуун эс гарах ахул би хулганын хумс төдий нэгэн үлгэрийг ярья. Сонсогтун гээд өгүүлсэн нь:

«Нэгэн их голд нэг их хаан байв. Тэр голын адгийн хонхорт байгаа тариан талбай уруу ус татдаг нэгэн их цөөрөм голын эхэнд байдаг бөгөөд түүнийг лусын хоёр их шулмас сахиж байдаг байжээ. Тэр цөөрмийн ус татахаар очсон хүн бүгдийг мөнхүү лусын хоёр шулмас иддэг байсан ажгуу. Үүнд ус тавиулахаар очихдоо мэргэн сайрхаг хэцүү, дорой ба их бага хэмээн алаг булаггүй шоогоор тоглож алдсан нь очих ёстой байжээ.

Тэр нэгэн үед мөрийтэй тоглосонд хааны хүү алдав. Гэтэл мөнхүү оронд ганц хөвгүүнээс өөр эд юмгүй хов хоосон өвгөн эмгэн хоёр байсан нь хааны хүүг явах гэхэд сэтгэшгүй зовж байв. Учир нь өвгөн эмгэн хоёрын хүүд хан хөвгүүн их тус болдог ажгуу. Өвгөн эмгэн хоёрын хүү хааны дэргэд бараалхаад хаан хатан хоёрт ийн айлдруун

– Хаан хатан сэтгэлээ бүү алжаагтун. Хан хөвгүүн одвоос хааны үндэс ч тасрах учир, хаан хатан ч сэтэл алжааж нярваан болохын гэм байх тул одоо намайг таалваас голын хүн хэмээн сонжилгүй таалалдаа анхаарахыг айлтгая. Миний хөгшин эх эцэг хоёрт хоол унд өгөх ба хэрвээ үхвээс буяны үйлийг дутмаггүй хийхийг нэг адил таалалдаа анхаарахыг айлтгая. Би үхэхээс үл эмээх тул таны хөвгүүний золионд одёе гэсэнд хаан хатан баясаж баталгаа бичиг бичиж, хоёр хөгшний тэр хүүд их хоол гурил өгснийг эцэг эх хоёртоо хүргэж өгөөд өнөөх цөөрмийн дэргэд очсон ба хаан түүнийг үхсэн гэж тунхаг тараажээ. Хаан түүний эцэг эх хоёрт өргөл хүндлэлийг үлэмж үйлдэв.

Тэр хөвгүүн цөөрөмд очиж мэлхий могой хоёрын хэрүүл шуугианыг сонсоод хоёулыг алаад хүрч ирэв. Тэр орны хүмүүс түүнийг үзээд

– Чи яагаад буцаж ирдэг билээ? Ус энэ жилийнх шиг сайн гарч байсан удаа огт үгүй хэмээн баясацгаав. Ингээд тэд нар

Хаан өөрөө таалал төгссөн ч түүнээс үлэмж сайн болохгүй буюу гэлцэв. Тэр хөвгүүн

Би буцаж ирэв хэмээн хаан хатан, хөвгүүдийн дэргэд очиход тэд нар түүнийг тэвэрч

– Чи яагаад буцаж ирэв? Ус энэ жилээс илүү сайн гарч байгаагүй гэв. Тэр хөвгүүн

Хаан их буянтай байна. Би өөрөө үхэх үнэхээр дургүй юм. Цөөрмийн дэргэд хүлээж суусанд идэгчин гарч ирсэнгүй. Харин маргааш өглөө нь нэгэн могой, яст мэлхий хоёр «миний уршиг, чиний уршиг» гэж хямралдан байв. Могой «Чамайг алаад таван өнгийн хив дотор боогоод хүү санд агуулваас чандманьтай адил болно» гэв. Яст мэлхий «Чамайг алаад бүхлээр залгиж хаж гэсэнд гарсан цэр нь алт болно» гээд тэр хоёр ноцолдсоор наран шингэхэд нойрондоо дарагдаж унтав. Тэр үеэр би тэр хоёрыг алсан учир одооноос хойш цөөрмийг гаргуулахын тулд мөрийтэй тоглох хэрэггүй болов. Харин чандмань эрдэнийг хаан танд өргөө хэмээн өгүүлээд их алт мэлхийг хаанд өргөжээ.

Хаан өвгөн эмгэн хоёрын хүүг өөрийн ах дүүгээс ялгалгүй үзэх болов. Тэр үед эцэг хаан хатан хоёр таалал төгсөж, өнөөх хүүгийн хөгшин эх эцэг хоёр ч нас барав. Сайн эцэг эхийн төлөө арван найман өдрийн турш буян үйлдэв.

Ном шастир, ганжуур тэргүүтэн бие зарлиг тааллын шүтээн өдий төдий босгов.

Нэгэн үе болсонд хаан «Бид хоёр энэ өдөр уйтгар сэргээхээр явъя» гээд хоол хүнс, нум сумаа аваад голын эх өөд өгсөж олон давааг давж голыг таталж уулын оройгоор хэсэхэд нэгэн их голд олон хүн бөөгнөрч байгааг хараад тэр гол уруу дорогшоо буун одсонд тэрхүү гол дүүрэн хүмүүсийн дунд олон түшмэл чимэг хэрэглэлийг зүүж зааны хоншоорт насны хумхыг уян зүүгээд тэр олны дотор явна. Тэр заан хошуугаа ээтийлгэж, түшмэд дагаж тэр хоёр хөвгүүний дэргэд ирэв. Тэр заан хумхаа өргөж хааны толгой дээр тавьсан даруй түшмэд олон зүйлийн дуу хөгжим дуугаргаж тойров. Чингээд хааш аваачсан нь үл мэдэгдэн дагуулж хөтөлж одов. Нөгөө хөвгүүний толгой эргээд хаашаа ч явахаа үл мэдэн харанхуй газар тулж замгүй явсаар эх охин хоёрын байгаа гэрийг олж тэнд хонохоор суув. Амаа цангасанд

– Архи байна уу? гэв. Эх охин хоёр

– Архины үнэд өгөх юм буй юу? хэмээн асуусанд

Алт буй гэв. Түүнд хамаг архиа өгч уулгав. Хүү тэр шөнө согтож балайран унав. Шөнө дунд болоход бөөлжсөнд эх охин хоёр гэрэл гаргаж харваас бөөлжис бүгд нь алт болсныг үзээд тэрхүү алтанд шунаж

– Дахин бөөлжүүлвээс алт гарна хэмээн сэтгэж ам уруу нь архи нэмэн цутгаж өгөв. Түүнээс дэндтэл бөөлжөөд могой гарсны дараа ерийн бөөлжис болсонд

– Тэр алтны эрдэм нь энэ могойн хүч буй за хэмээн бодоод тэр могойг угааж цэвэрлээд охиндоо залгиулав. Тэр охин ханиаж «Хах» гэсэнд цэр нь алт болж гарав. Хөвгүүн сэргэж босоод архины өртгийг өгье» хэмээн бодоод цэрээ гаргахын тулд

– «Хах» гэхэд юу ч эс гарсан учир, эмгэнд ийн өгүүлрүүн

Шөнийн алт болсон бүхэн чинийх болтугай. Гагцхүү миний могойг надад эргүүлж өг гэсэнд эмгэн өгүүлрүүн

– Тэнэмэл гуйранч хаанаас ирэв? Хааш одох чиггүй чамд шөнө хоол өгсөн, ор дэвсгэр зассан, архи гуйхаар чинь архи өгсөн. Харин архины үнэд алт өгнө гэсэн атал одоо өгөхгүй байж биднийг хулгайд сэргэж байна уу хэмээн өгүүлээд гараас нь чирж гадагш гаргав.

Хөвгүүн сэтгэрүүн:

– Юм хураавч юм болсонгүй. Юм хурааж хааны идээ эдийг адилхан эдэлж байв. Чандмань эрдэнийг олсон боловч буян үл хурааснаар хаан зарц хоёул яваад хааныг хаашаа явсан, энэ өөд явсан гэхийн сураггүй алдав. Би алтаар бөөлжихөө ч болилоо. Одоо буцаж харихад ичгүүрээс өөр зүйлгүй учир, энэ голын эхэнд очиж амиа хорлож үхэх хэрэгтэй хэмээн явав.

Гэтэл, нэг эрэгний дотор гурван хүүхэд

Би түүнийг авна хэмээн шуугилдан тэмдэлдэж байв, Тэр гурван хүүхдийн дэргэд очоод харсанд тэд нар нэг хүүдий, нэг гутал, нэг малгайг булаалдан шуугилдаж байлаа. Хөвгүүн

– Та гурав юу булаалдав? гэсэнд

Бид гурав хүүдий, гутал, малгай гурвыг хувааж тохирохгүй булаалдаж байна гэв. Хөвгүүн

Энэ гурваар яадаг юм бэ? гэсэнд тэр хүүхдүүд:

Хэрвээ энэ гутлыг өмсвөөс аль санасан газар саадгүй хүрнэ. Хүрэх ч өчүүхэн хэрэг. Харин малгайг өмсвөөс хэнд ч үл үзэгдэнэ. Энэ нь гутлаас арай дээр юм. Энэ хүүдий бол «Мах ир» гэхэд мах ирдэг. «Тос ир» гэвээс тос ирдэг- Ер нь аль хэрэглэхийг «Ир» гэвээс бас ирүүлдэг юм. Эдгээрийн төлөө хоорондоо тохирохгүй байна гэлээ. Хөвгүүн

– Та гурав уралдаад аль түрүүн ирсэн нь энэ хүүдийг ав. Түүний удаад ирсэн нь энэ малгайг ав. Сүүлдэж ирсэн нь энэ гутлыг ав гэсэнд гурван хүүхэд зөвшөөрч

– Тантай адил сайн хүн эрээд олохгүй гээд явцгаав. Хөвгүүн тэднийг ирэхээр өгнө хэмээн тэр малгайг толгойдоо өмсөж, хүүдийг гартаа бариад хүлээж сууж байтал өнөө гурван хүүхэд уралдан ирээд

– Тэр хаа байна? Тэр хаашаа одов гэлцээд нэг нэгэн өөдөө нүдээ бүлтэлзэн эрцгээж байгаад нэг нь

Би та хоёрыг аль дуртайгаа ав гэсэн биш үү? Одоо бах чинь ханав уу? гээд тэр гурвуул тарцгаав.

Тэр хөвгүүн нэг хадны оройд авирч нэг том модны дэргэд хүрвээс гурван толгойт нэг мангасыг хүрч ирэхэд нь өнөө малгайгаа өмсөөд сууж байлаа. Мангас түүнийг үзэлгүй нэг хөх цэцгийг зулгааж аваад өөрийн нүүрийг илж нэг хөгшин бич болж хувилаад тэр мод өөд авиран гарав. Наран ургахад бууж ирээд нэг шар цэцгийг зулгааж нүүрээ илсэнд хуучин янзаар болов.

Хөвгүүн шар ба хөх цэцэг хоёрыг зулгааж аваад өнөөх гутлаа өмсөж «эмгэн охин хоёрын

дэргэд очвоос сайн буюу» хэмээн сэтгэж тэдний үүдэнд хүрээд өнөөх эмгэн охин хоёрыг дуудав. Охиныг цонхоор хармагц түүний нүүрийг хөх

цэцгээр илж тэр охиныг бич болгов. Хөвгүүн нөгөө малгайгаа өмссөн учир, «Хүн байхгүй» хэмээн бодоод охин дотогшоо буцаж оров. Охиноо бич болсныг эх нь хараад айн цочиж

– Энэ нь саяын тэр хүний шид мэх мөн буй за» хэмээн бодож, хааны харшийн хавиар эрж сураглавч үл олжээ. Хөвгүүн хүүдий дотор малгайгаа чихэж, гутлаа зүүн баруун хоёр талдаа сугавчлаад эмгэн охин хоёрын гэрт ирсэнд эмгэн:

– Чамайг төлдөр эрээд олсонгүй. Би чиний алт ба могой хоёрыг эргүүлээд өгье хэмээн өгүүлээд түүнд мөргөв. Хөвгүүн эмгэнд өгүүллрүүн

– Боломжтой үг асууваас болдоггүй, бөхийлгөвөл болдог гэдэг тэр аргагүй үнэн байна» гээд «Миний могой ба алтыг авчир» гэв. Эмгэний охин бич болсон боловч сэтгэл нь солигдоогүй тул оточ бурхны сүмд мөргөж байх мэтээр хоёул мөргөв. Тэр хөвгүүний санаа нь ариун тул

– Миний могойг өгвөөс энэ охиныг чийь урьдын янзаар болгоно хэмээн өгүүлсэнд эх нь охиноо бөөлжүүлж могойг гаргаад хөвгүүнд өгвөөс түүнийг усаар угааж хөвгүүн залгив. Хөвгүүн тэр охиныг жижиг байшинд авч очоод

– Эхтэйгээ хамтарч олз хайдаг охин чи хөөрхий гээд өнөөх шар цэцгээрээ нүүрийг нь арчсанд охин урьд мэт болов. Эх охин хоёр аль байгаа алт бүгдийг түүний дэргэд овоолоод оточ бурханд мөргөхийн адилаар мөргөв. Тэр хөвгүүний санаа нь ариун тул өнөө алтнаас эх охин хоёрт амь зууж хүрэхүйцийг өгөв.

Хөвгүүн гутлаа өмсөж, хүүдий дотор алтаа хийж малгайгаа өмсөөд «Би хааны дэргэд хүрье» хэмээн бодмогц, хааны дэргэд гэнэт хүрч очсон байлаа. Хаан түүнийг үзээд босож харилцан тэврэлцэж салж үл чадах мэт болов. Тэр хаанд мөргөлийн харамжинд мах, тос ирүүлдэг хүүдийгээ өргөв. Тэр хоёр заан хүлэглэж, олон түшмэлээр тойруулан урьдын хааны газар хүрээд тэр буянтай хөвгүүнийг хаан болгон өргөмжилж, хан төр хоорондоо ялгалгүй тэтгэв. Энтээ талдаа чандмань эрдэнэ, алтан өнгөг яст мэлхий ба «Хах» гэсэн бүгд алт бологч тэр буй бөгөөд цаад талынхад мах ирүүлэгч чандманийн хүүдий буй бөлгөө. Тэр буянтан хаан сууснаас хойш хан төр нь дэлгэрэн мандаж, өдөр шөнө үргэлжид бие биедээ номоор харилцаж, албат нараа амар сайн жаргуулав хэмээн өгүүлсэнд Сайн амгалан явдалт хаан «Тэр хүн буян ихтэй еэ» гэлээ Шидэт хүүр:

– Хүүрт үг алдав гээд төмөр торыг гал бадартал гурав дэлдээд харцага адил араас нь алдууран алга болов.

Хаан: Тэр олон үгийг ярьсан нь надад уршиг болов. Хүүргүй буцваас зэмлэл болно» хэмээн сэтгээд дахин хүүрийн газар очиж «Хала» гэгчийг тогшуураар дэлдэж тэр модны дэргэд хүрэв.

Асар ариун нэг буянт хүн хаан ширээг олсны арван гуравдугаар бүлэг болой.





# АЖНАЙ МОРИОР АЧИЙГ ХАРИУЛСНЫ БҮЛЭГ ОРШВОЙ

Хутгаар модыг цавчаад

Лам минь Наганжуна Зүрхэн мөн. Би Сайн амгалан явдалд хаан мөн. Тор минь есөн нүхт төмөр мөн. Хүлэг минь мэхт гинж мөн. Тогшуур минь хүрэн Сэндэн мөн. Тостой гурил минь идээд үл барагдана. Хүүр чи буух уу? Үгүй бол модыг чинь унагана гэсэнд хүүр бууж ирэв. Түүнийг тогшуураар дэлдэж, торны дотор чихээд хүлгээр хүлж үүрээд долоон алхам явахад

– Хаан чи нэгэн үлгэрийг ярьтугай. Газар хол, энэлгээтэй байна гэсэнд хаан дуун эс гарсан учир

Чиний мэтийн хааны амнаас үг эс гарваас би нэгэн үлгэрийг ярья. Сонсогтун гээд өгүүлрүүн:

«Нэг голд эх эцэг нь урьд үхсэн эгч дүү хоёр байв. Тэр голын эхэнд Зачэн Зачүн гэгч хоёр мангас байсан бөлгөө. Эгч нь дүүгээ цаглашгүй асардаг байжээ. Тэр хоёрт байсан сүрэг хонийг дүү охин нь хариулан өвс бэлчээр дагаж хамт явж байтал давааны чанад талд тунгалаг царайтай, залуухан сайхан нэг хөвгүүн хонь хариулж явахтай тохиолдож тэр хоёр тэнд уулзсанд хөвгүүн

– Бид хоёр эр эм бололцвоос болох уу? гэсэнд охин

– Болно гэв, Хөвгүүн

– Чиний эгч авгай чинь гуйхад өгөх болов уу? гэсэнд

Гуйваас яасан ч өгөхгүй. Харин түүнийг үхвээс бид хоёр эр эм болж болох буй за гэлээ. Хөвгүүн

Чиний байгаа голын эхэнд Зачэн Зачүн хэмээх хоёр мангас буй. Чи үдэш харимагц

– Би өвдлөө. Элэй халаг хэмээн өгүүлэгтүн. Эгч чинь чамд маш их хайртай тул

– Чиний өвчинд арга байх уу? гэх болно. Тэгэхэд нь миний өвчинд арга байна. Түүнийг эгч та аргалж чадахгүй гээрэй. Чингээд

– Охин чиний өвчинд туслах арга байваас яав ч үйлдье гэх буй за. Түүнээс та

– Миний энэ өвчинд тус болох арга нь манай энэ голын эхэнд байгаа Зачүн хэмээх мангасын ногооны хашаанаас саримсаг авчирч надад өгвөл би эдгэнэ. Түүнийг эгч хийж чадахгүй хэмээн хэлэгтүн. Тэр, охины өвчинд тус болох ахул би заавал очиж авна гээд түүний хашаа уруу явна. Тэр саримсгийг авахад мангасын уур хүрч эгчийг чинь идэх болно. Чингэхэд чи бид хоёр хамт сууж болно хэмээн сургав.

Тэр охин баруун завжиндаа улаан будаг хийж зүүн завжиндаа хөх будаг хийж очоод

– Би өвдлөө. Элэй халаг хэмээн өгүүллээ. Эгч

– Охин юу болов? Өвчинд чинь юу тус болох вэ хэмээн асуув. Охин

– Миний өвчинд арга буй боловч эгч чи бүтээж чадахгүй гэсэнд эгч

– Эцэг эх минь урьд үхсэн. Өдгөө чиний өвчинд туслах арга байваас хэлэгтүн гэлээ. Охин

– Манай голын эхэнд Зачүн хэмээх мангас буй. Түүний хашаанаас саримсаг аваад надад өгвөөс би эдгэнэ. Түүнийг Жо Жо чи авч чадахгүй буй за гэв. Тэр «Охин чиний өвчинд тус болох аваас би авч чадна» гээд ажнай сайн морио унаж хоёр сайн нохойгоо хөтлөөд голын эхэнд одож Зачүн мангасыг ногооны хашаан дотор ороод саримсаг хадаж таар хүүдийгээ дүүртэл чихсэнд Зачүн мангас үзээд:

Урд миний ногооны хашаанаас саримсгийг хэн ч авч чаддаггүй байсан. Гэтэл энэ муу гуйранч хадаж байна гээд гараа сарвайлган хүрч ирэв. Ажнай морь, түүний өвчүүнээс хазаж, хоёр нохой хөлөөс нь зуугаад, өөрөө нүүр өөд нь ташуураар дэлдэж мангасыг гэдрэг нь унагав. Мангас

– Намайг бүү алагтун. Чиний юу хэлснээр чинь явья. Цохь гэвээс эцгийнхээ толгойг ч цохьё. Ид гэвэл эхийнхээ элгийг ч идье. Оч гэвээс Очир тамын ёроолд ч очьё хэмээн тангараглав. Тэр мангаст алагдалгүй саримсгийг даах чинээгээрээ үүрч, Зачүн мангасыг зарц болгон хөтлөөд буцаж харив. Гэртээ ирээд саримсгийг охинд цадтал өгөв. Тэр охин идсэн янзтай болоод хонио хариулахаар одов.

Даваан дээр тэр танил хөвгүүнтэйгээ дахин уулзлаа. Хөвгүүн Чиний Жо Жо үхсэн үү? хэмээн асуусанд охин Жо Жо үхэх байтугай саримсгийг даах чинээгээрээ үүрч, бас Зачүн мангасыг зарц болгон авчирсан гэв. Хөвгүүн

– Чиний тэр Жо Жо чинь аймшигтай байна. Одоо тэр голын эхэнд Зачэн мангас гэгч буй. Түүний ногооны хашаанаас саримсгийг авахуулах хэрэгтэй. Би өвдлөө халаг хуухай. Эс авчирч өгвөөс би үхнэ хэмээн хэлэгтүн хэмээн бас дахин сургав. Охин бас хуурмагаар өвдөв. Тэр охиныг өвдөхөд

Юу тустай вэ хэмээн асууж, урьдын адил явах хэрэгтэй болсонд бас морио эмээллэж, Зачүн ба хоёр нохойгоо хөтлөөд Зачэн хэмээгч мангасын ногооны хашаанд одож. Түүний саримсгийг хяргаж таар хүүдийгээ дүүртэл хийв. Зачэн түүнийг хараад гараа сарвайлган:

– Энэ гуйранч Зачүн муу этгээдийг удирдаж иржээ. Урьд төвдийн хүн энд ирдэг түүхгүй билээ гээд Зачүнд уурлаж алгадаад, эгчийг алахаар ирсэнд морь нь цовхорч, түүний сэрвээн дээрээс хазаж автал Зачүнгийн уур хүрээд түүний өвчүүн дээрээс базаж, хоёр нохой нь мөн түүний шилбэнээс зууж унагав. Зачэн мангас:

– Намайг бүү алагтун. Чиний юу хэлснийг бүтээе. Цохь гэвээс эцгийнхээ толгойг ч цохьё. Ид гэвээс эхийнхээ элгийг ч идье. Чиний юу хэлснийг эс дагаваас дээш тэнгэр, доош газар мэдтүгэй. Очир тамын ёроолд ч одно хэмээн андгайлав. Зачүнд ачаагаа үүрүүлж, Зачэнг

дагуулаад гэртээ ирж, тэр охинд саримсгийг цадтал өгөв.

Охин «эдгэрэв» гээд хонио адуулж даваан дээр очоод түрүүчийн хөвгүүнтэй уулзав, Хөвгүүн

– Чиний Жо Жо алагдсан уу? гэхэд охин

– Миний Жо Жо Зачэнийг дагуулаад их саримсгийг үүрч ирсэн гэв. Хөвгүүн

Чиний тэр Жо Жо чинь аймшигтай этгээд байна. Бас эндээс буцаж очоод «Би өвдлөө халаг» гэсээр хэвгэгтүн. Охины өвчинд юу тус болох вэ? гэхэд

– Миний энэ өвчин урьд саримсгийн хольцоо дэндүү идсэнээс боллоо гэж хэлэгтүн.

Чиний энэ өвчинд арга бий юу? гэвээс

Миний энэ өвчинд арга байж ч болно. Жо Жо та дэндүү зүдрэх юм хэмээн хэлэгтүн.

Туслахын арга байваас заавал үйлдэнэ гэхээр нь гадаад далайгаас жаца (давс) авчирч өгвөөс тус болно хэмээн хэлэгтүн. Чингэхэд Жо Жо чинь жаца авахаар явах бөгөөд тэндээ үхнэ хэмээн сургажээ. Охин, түүний сургаснаар бас хуурмаг өвдөөд

Жаца тусална гэв. Жо Жо

– Чиний өвчинд тус болох ахул миний бие зүдрэх хамаагүй гээд морио эмээллэж Зачүн, Зачэн хоёр мангасыг дагуулан, хоёр нохойгоо хөтлөөд гадаад далайд одов.

Гадаад далайд хүрээд тэрхүү жаца далайн ёроолд байх тул авгай өөрийн бэлхүүсэнд дээс уяж Зачэн мангаст бариулаад хүүдийгээ авч далайн ёроол уруу оров. Чингэхдээ

Би дээс татваас хүүдий дүүрсний дохио мөн тул намайг дээш таттугай гээд одсоноор Зачэн мангас дээсийг татавч юу ч гарсангүй. Зачэн

Надад өөр арга байхгүй болов гээд далайгаас хоёр нохойг долоо гэж долоолгов. Морийг уу гэж уулгав. Хоёр нохой морины хамт далайг яавч татруулж эс чадав. Зачүнд

– Нэг сайн ооч. Харья. Уу гэсэнд Зачүн өчүүхэн дунд орох төдий болтол балгаж шүдээ зууж аманд усыг тогтоогоод давааны ард усаа юүлсэнд нэгэн их хоосон гол үерийн усаар дүүрэв. Тэр аман дотор шүдний завсраар эрсэнд давснаас өөр юу ч олдсонгүй. Өнөөх Зачэн мангас өөрөө уусанд далайг цөмийг ууж чадав. Түүний ёроолд жаца тараг бүрэлдсэн мэт байснаас дөрвөн таар хүүдийд чихээд бас түүний яс байх болов уу хэмээн эрэвч огт олсонгүй. Зачэн балгасан усаа далайд юүлэхэд давс тааралдсан боловч түүний дотор яс байгаа эсэх нь мэдэгдсэнгүй. Шүдний завсраар нягтлан эрсэнд ясны хэлтэрхий гарав. Тэр ясыг үзээд Зачэн нь Зачүнд

– Бидний эзэн зарцын хооронд чанд хатуу тангараг буй тул Зачүн чи тостой гурил үүрч хурдан гүйж өдөртөө явж ирэгтүн. Ноднин жил надад огторгуйн Охин тэнгэр эгчийн өгсөн рашаан сав дүүрэн буй. Тэр юунд хэрэгтэй болохыг мэдэхгүй. Түүнийг дэрний дэргэд нуусан

тул түүнийг аваад ир хэмээн Зачүнг явуулав. Зачүн түүний дэрний хавьд нуусан рашааныг өврийнхөө мухарт хийгээд гурилаа идсээр ирэхэд барай бүрий болж байлаа. Зачэн

– Зачүн чи яагаад удав? хэмээн асуусанд зуурсан гурилаа идэж саатсанаас бус, би хурдан явж ирсэн гэв. Тэр шөнө тэндээ хонож маргааш нь наранд түүний ясыг бүлээсгээд гаднаас нь тэр рашаанаас нэг рилү (үрэл) түрхсэнд мах цус тогтов. Түүний ам уруу нэг рилү хийсэнд мах нь урьд мэтээр дүүрэн болов. Бас нэг рилү өгсөнд арьс тогтов. Чингээд дотроос нэг тун эм өгсөнд бүлээн илч тогтов. Бас нэг тун эм өгтөл амьсгалтай болов. Бас нэг тунг өгөхөд урьд мэтээр ухаантай болжээ. Үхсэнийг сэргээх эмийн эрдмээр босож чадах болж, тэр жаца давсыг авч ариун эзэн, зарц, морь, нохойтойгоо цөмөөр нутагтаа хүрэв. Өнөөх охины доод тагнайд шарх гартал жаца цутгаж өгөв.

Тэр охин «Эдгэрэв» гээд хонио хариулахаар явж, бас тэр хөвгүүнтэй уулзав. Хөвгүүн

– Чиний Жо Жо үхсэн үү? хэмээн асуусанд Охин

– Жо Жо үхсэнгүй. Түүгээр ч барахгүй, жацагаа аваад буцаж ирсэн. Миний амыг шарх болтол жаца цутгаж өгсөн гэв. Хөвгүүн

– Чиний Жо Жо ер нь аймшигтай хүн байна гэсэнд тэр охины сэтгэлд тэрхүү хөвгүүн хоногшоод

Бид хоёр ер нь эр эм бололцохын арга байна уу? хэмээн асуув. Хөвгүүн

Одоо надад арга алга. Чиний Жо Жо-гоос гуйваас өгөхгүй болов уу? гэсэнд охин бөөн бөөн нулимс асгаруулан уйлав. Хөвгүүн

– Битгий уйл. Чи Жо Жо-гоо алж чадах уу? гэсэнд охин өгүүллрүүн

Би алж чадна гэлээ. Хөвгүүн

Чингэвээс чи энэ шөнө Жо Жо чи зүдэрч ядарсан буй за гээд ор засаж, биеийг илэх мэтээр аргадаж, дэрэн доогуур нь нэг жад босгож тавиад шөнө дундын хэрд түүний толгойг том чулуугаар цохиж алагтун. Чингээд хоёр мангаст үл мэдэгдэн морио унаад дутаатугай хэмээн сургав. Тэр охин ч хонио туусаар буцаж хариад урьд хийгээгүй дотнын ажлыг хийв. Жо Жо-доо ор засаад дэрэнд нь жад зоож Зачүн Зачэн хоёр мангасыг тусгай газар хэвтүүлж, Жо Жо-гоо «Ядарсан буй за хэмээн илбэж аргадаад, шөнө дунд болоход охин босож, хоёр мангаст мэдэгдэлгүй нэг том чулуу авч, Жо Жо-гийн дэрний тэнд очлоо. Гэтэл Жо Жо-гийн толгойд дэр нь эвгүй байсан учраас зайлж өөр газар хэвгжээ. Охин Жо Жо-гийн толгой байваас зохих тэр дэрний тус чулуугаа шидсэнд

Жо Жо гэнэт босоод

– Хэн бэ? Зачэн ээ хэмээн дуудав. Зачэн, Зачүн хоёр гэрэл авчирч харваас бус хэн ч үгүй, өнөөх охин морь эмээллээд явахыг завдаж байлаа. Тэр Зачэн

Энэ бол эм шулмас мөн байна гээд хуруугаар имрээд бүхлээр залгахыг завдахад Жо Жо

Охиныг минь бүү залги гэтэл Зачэн мангас аль хэдийн үмхчихсэн байв. Охин юу үйлдсэн боловч Жо Жо түүний төлөө сэтгэл ихэд гансарч «Хөөрхий» гэж байсанд Зачэн мангас

– Чи түүнд сайн хийвч мууг хийвч адил байна. Түүнд эм хүртээж болох боловч хүртээхгүй, эмийг өгч болох боловч өгөхгүй гээд ясыг зажлаад, хуруугаар имэрч байв. Жо Жо

«Тэр охин юу хийвч бид хоёр ижил юм хэмээн энэрч аль бүхий эдээ охины буянд зориулан өгсөн билээ. Ингээд Зачэн Зачүн хоёр өөрийн орондоо буцав.

Жо Жо морио унаж, хоёр нохойгоо дагуулаад бөглүү хол нэгэн газарт уйтгараа сэргээхээр одов. «Далайн захын нэг сайн өвстэй газар мориноосоо буугаад сууя» хэмээн сэтгэж явсаар замдаа нэг сам ба лавай, эрих, бас нэг толь олсонд морь нь

«Эдгээр юм хэрэг болж магадгүй, авагтун гэсэнд тэдгээрийг аваад далайн дэргэд очоод сууж байв. Нэгэн үе болсонд тэр далай оргилон оволзсонд морь

Намайг эмээллэгтүн. Хоёр нохойгоо дагуулж түргэн дутаагтун гэснээр хоёр нохойгоо дагуулж морио унаад явтал тэр далайн дундаас уулын чинээ төмөр чоно гарч хөөгөөд баригдах шахтал морь

– Чи тэр самыг ерөөл тавиад хаягтун гэснээр самаа хаяв. Чингэтэл сам нь нэг их ой болоод халхалсанд хол дутаан одов. Бас баригдах шахахад морь.

Лаван эрихээ хая гэснээр хаясанд тэрхүү лавай эрих нь эрэг мэт цаст уул болж завсарласан учир нэг хэсэг дутаав. Чоно бас барих шахсанд морь нь

Толио шившээд чулуудагтун гэсэнд тэр шившихдээ Толь шиг нэгэн далай болтугай. Далайн цаад талд чоно байх ба наад талд нь өөрөө гэтэлсэн байхын дээр, далай нь тойрч гүйцэшгүй, гаталж гаршгүй, туулж баршгүй болтугай хэмээн шившээд чулуудсанд тэрчлэн болов. Далайн цаанаас чоно:

Гуйранч чамд урьд насны амины өр төлөөстэй байсан юм сан. Гуйранч Зачэн, Зачүн хоёр ба тэр морь чинь амийг гаргаж авсны хүчээр чи гэтлэв хэмээн өгүүлээд хоцров. Тэр охин дүү урьд насны амины өр төлөөстэй тул аминыхаа өрийг авах хэмээн охин дүү болон хуурч төрсөн байжээ.

Жо Жо нэг их эзгүй газар хүрсэнд тэр морь дэргэд нь үхэхийн цаг болоод «Одоо би үхэх цаг боллоо. Үхэхэд уйлах тэргүүтэн огт хэрэггүй. Миний арьсыг хуулан авч сайтар дэлгээд, толгойг дунд нь тавь. Аман дотор зүрхийг минь хийгтүн. Шүдийг минь бяцлаад зүлгэн дээгүүр цац, хоёр бөөрийг минь толгойн дэргэд тавь. Умсыг минь талд дэлгэ. Гэдсийг минь толгойн гадуур тойруулан, тархийг минь эхэн өөд хүргэ. Элгийг минь хэсэглэн хэрчээд, зүүн баруун хоёр хажууд тавь. Үсийг минь зулгаагаад ууланд цац. Цөсийг минь толгойн дэргэд тавь. Бүү уйл. Уйлваас хүйтэн болно гээд тэр морь үхэв. Жо Жо морь үхсэн ба урьд насны дайсан тэр охин дүү зовоосон хийгээд амь аварсан тэр морь үхлээ гээд уйлсанд шуурга болсны дараагаар «Ха ха» гэсэн долоон нар гарав. Тэр морины сургаснаар ажиллаж тэнхээ тасарч ядраад наранд унтав. Нойрон дунд нэг охин

Энэ мэт унталгүй өөдөө бос хэмээн өгүүлээд толгойгоос нь өргөн өндийлгөж байв.  
Нойрноосоо сэрээд

Миний охин дүүгийн амины өр төлөөсийг нэхсэн эм шулмас тэр мөн үү. Морь үхсэн. Одоо хэн байх билээ? гээд хартал дэргэд нь гоо сайхан гайхамшигтай тунгалаг царайтай, чимэг хувцсаар чимсэн нэг охин

– Өөдөө босохыг айлтгая. Би урьд насны ачийг хариулсан тэр морь чинь байнам гээд Жо Жог дотогш нь урин залав. Өнөөх үхсэн морины толгой нь есөн давхар үлэмж харш болсон байлаа. Аманд хийсэн тэр зүрх нь гайхамшигт охин болжээ. Хоёр бөөр нь урьдынхаас ч үлэмжийн сайн морь болчихсон байв. Гэдсээр хүрээлүүлсэн нь сайн төмөр хэрэм болжээ. Хаданд уушгийг цацсаны эрдмээр хатан ч оюун төгөлдөр болжээ. Цацсан үс нь ой мод болоод элдэв зүйлийн мод ургаж, дэлгэсэн умснаас нь үлэмжийн их өвс ургажээ. Зүлгэнд шүд цацсаны эрдмээр тоолж баршгүй хонин сүрэг буй болжээ. Эхэнд тархийг хүргэсний эрдмээр цаст уул тогтож голынхны амьжирлага болсон цасны ус урсав. Элгийг хэрчиж зүүн, баруун хоёр хажууд тавьсны эрдмээр ганц замын хүмүүс бус, эргэн тойрондоо эдээр тахигдагч голынхны нэгэн ноён гарав. Хөвгүүн, эгч дүү тэнгэрийн хөвгүүн адил гурван хүү гарав. Түүнээс өдөр шөнө үргэлж Номын явдлыг төгс эдлэгч болов хэмээн хүүр ярьсанд хаан

Охин дүүг төдий асравч, үхээд бас Жо Жогийн амийг таслахаар ирсэн байна. Түүний амийг аврагч тэр морь мөн их ачтай яа хэмээн өгүүлэв. Хүүр Хүүрт үг ярив гээд төмөр торыг гурав дэлдээд харцага адил хүр гээд гараас алдуурав.

Тэр хаан

– Тамир ч барагдлаа. Гэдэс ч өлсөж байна. Би юун үйлдэвч хүүрийг аваачиж чадахгүй нь гээд хийд хүрээ рүү буцаж одов. Хөл хорьсон чулууг давж чадалгүй эргэж дорноос өмнө зүг очсонд өмнийн хөл хорьсон чулуун дээр нэг бичиг байх бөгөөд түүнийг уншсанд хүү чамд юу өгүүлэвч үл мэдэх буюу. Анх эрт чанд зоригийг гаргасан аваас шажинд тустай нэг алт ирэх байсан бөгөөд түүний дараа чанд зоригийг гаргаваас хүйснээс дээш нь алт болмоор байна. Энэтхэгийн алтанд шуналтнуудад алтыг түгээж өгнө. Аяа, авчрахыг бод. Чанд зоригийг үүсгэсүгэй гэсэн ба тостой гурил саванд урьдынхаас ихийг тавьсан байв. Тэр тостой гурилыг цадталаа идээд үлдсэнийг үүрч, хүүрийн тэнд одов.

Тэр жижиг хүүрүүд олон зүйлийн аймшигтай байдлыг гаргаж зарим хүүр

«Хала хала» гээд өндийн босож байв. Зарим нь «Хүлү хүлү» гээд нааш цааш гүйцгээж байв.

Миний лам үнэн, эдгээр гуранчид намайг доромжилж байна. Тэд өчүүхэн төдий ч айсангүй «хала» хэмээгчдийг өшиглөөд, «хүлү» хэмээгчдийг тогшуураар дэлдсэнд салхи намдсан мэт унацгаав. Тэр том хүүрийн дэргэд хүрээд шүдээ чанга зууж, биеийг нь модноос салгахад тэр, нүдээ нааш цааш бүлтэлзүүлж, модноос дахин зуурч байлаа.

Ажнай морь урьдын ачийг хариулж мангасыг боолчлон эдэлж. урьд насны амины өр төлөөс нэхсэн охин дүүгээс аварч, хот, эд мал, албат сэлтийн ачийг хариулсны арван дөрөвдүгээр бүлэг болой.



# УРЬД НАСАНД БУЯН ХУРААСНААР БАРС ХОРТ МОГОЙ, ХҮН ИДДЭГ ҮНЭГ, ХЯТАД ЦЭРГИЙГ НОМХТГОЖ ХАН ТӨРИЙГ ЭЗЭЛСНИЙ БҮЛЭГ ОРШВОЙ

Хан хөвгүүн хутгаар модыг нэг цавчаад

– Лам минь Наганжуна Зүрхэн мөн. Би Сайн амгалан явдалт хаан мөн. Тор минь есөн нүхт төмөр мөн. Тогшуур минь хүрэн сэндэн мөн. Хүлэг минь мэхт гинж мөн. Хутга минь чулуу огтлогч иртэй мөн. Тостой гурил минь барагдашгүй идээ мөн. Хүүр чи буухгүйюу? Модыг чинь унагалаа гэсэнд хүүр бууж ирлээ. Түүнийг дээд оройгоос нь хөлийн улыг хүртэл тогшуураар балчиг болтол дэлдэж «Амаа зууран зуур» хэмээн «хутгаар зүсэж хоёр нүдийг чинь уйланхай мах болгоно» гээд хутга шааж мөчүүдийг мөлтөртөл нь торын дотор чихэж хүлгээр хүлээд зорьсон газар руугаа явж долоо найман алхам хэр болоход тэр хүүрийн амнаас – Хан хөвгүүн. Хан хөвгүүн. Юу ярих вэ? Юу ярих вэ? гэв. Хан хөвгүүн дуугүй байсанд Үйлээ барсан хан хөвгүүн чиний мэтийн амнаас үг эс гарах ажгуу. Би нэг үлгэр ярья. Сонс гээд ийн өгүүлрүүн:

«Нэгэн голд нэг их хаан байжээ. Тэр голын эхэнд хүн барьж иддэг барс байсан бөгөөд голын хүмүүсээс жил бүр гурван хүн барьж иддэг байжээ. Тэр голын эхэнд нэхмэлчин ганц бие эр байдаг ба адагт эх, хүү, хүүхэн гурвуул амьдарч байсан үүнд хүн иддэг барс нь тэр гурвыг идэх ээлж болсон байжээ. Ганц хүү нь урьдах эхийн хүү мөн бөгөөд эд таваар төгс эдлэл сайтай байв. Тэр эх, хүү,

охин гурвын гэрийн гадна барс ирээд шатаар өөд авирч очоод

– Идэх юм хүнс юу байгаа бол хэмээн бодоод хэвтэж байлаа. Хойд эх хүүгээ урьдах эхийн хүүхэд мөн тул

– Одоо түүнийг барс иднэ. Иймд түүний эд юм үлдэх болно гэж бодоод муу санаа агуулж эх охин хоёр, өөрсдийн идэх мах гурилын дотор тос хийж, хүүгийн идэх гурил дотор мөс хийгээд гал түлж түүнд ээгээд дэмий юм ярьж суув. Тэгтэл эх хүүхэн хоёрын тэр гурил нь галд бүлээтээд тос нь нэвтэртэл гарч байхад нөгөө хүүгийн гурил нь галд халахдаа налчийж балбайгаад мөс нь цухалзан гарсанд хүү

– Урьтаж юу хийсэн ч энэ шөнө үхэх тул хоол хувцсыг эх эзэмших боломж гарахгүй хэмээн үнэн зүрхнээс бодоод эхдээ

– Бид нарыг барс идэх гэж буй тул бид хоёр айж байна гэв. Эх нь түүнд дургүйцэн:

– Хааны албатуудыг идэж дуустал бид гуравт айх явдалгүй. Зүгээр сууж байя. Харин түүнээс илүү аймшигтай нэг юм бий гэхэд хойд эхийн охин өгүүлрүүн

– Биднийг барс идэхээс илүү аюултай юм хаана байх вэ? гэхэд эх

– Барснаас үлэмж аюултай Сог хэмээх нэгэн том амьтан бий. Бас Согоос ч илүү аймшигтай Сурушабо хэмээх амьтан бий. Түүнээс аюултай Даллэ ожа хэмээгч бас нэгэн амьтан бий хэмээн хэлэв. Үүнийг сонсоод барс

– Надаас аймшигтай Сог, Согоос аймшигтай Сурушабо, Сурушабогоос аймшигтай Даллэ Ожа байдаг ажгуу. Бусад хоёроос ч айх юмгүй. Гагцхүү тэр Сурушабо энд ирвээс хэрэггүй юм болох буй за. Энэ шөнө хашааны дотор байгаа энэ үхрийг идээд тагнан туршиж харваас юу болохыг олж мэдэх буй за хэмээн санаад, хашаан дотор орж хөгшин алаг үхрийг идээд хэвтэж байв.

Тэр голын эхний нэхмэлчин ганц бие эр

– Арван тавны саран тэртээ хол мэлтийж байна. Барс хүн идэхдээ үдэш идэх биз. Би эх, охин



хөвгүүн гурвын үхрийг хулгайлж аваад идье хэмээн шувууны мөрийг зохиож, баруун гартаа тогшуур бариад, зүүн гартаа дээс аваад эх охин хөвгүүн гурвын үхрийг хулгайлахаар тэдний үүдний дэргэд хүрсэнд хүний чимээ нэг ч үгүй, арван тавны шөнө дунд болжээ. Барс хашааны завсар харагдахуйц мухарт илхэн эрээнтээд хэвтэж байлаа. Нэхмэлчин ганц эр хүн нохойн дуу ер үгүй тул өөдөө явж очоод, үхэр мөн хэмээн бодож баясаад өнөөх барс дээр харайн мордсонд тэр барс

– Нөгөө Сурушабо гэгч нь энэ болов уу? хэмээн бодоод гэнэт босон дутаав. Нэхмэлчин сэтгэрүүн:

«Одоо явал сайн бол» гээд барсын чихний хоёр уг дээрээс атгаваас арван найман гол хөтлийг давтал харайж одов. Гол хөтөл олныг давж очсон газарт наран цухалзахад харваас нэг их зандан мод байв. Түүнд гарди шувуу үүрээ зассан байв. Арван тавны шөнө гарьдын зулзага нэвчсэн буй. Тэр модны ёроолд байсан нэг том хорт могой арван тавны үдээс өмнө дээшээ авирч, гардийн зулзагыг идсэн байжээ. Нэхмэлчин ганц эр

– Тэр том модноос дээсээрээ урхидаад тогтёе хэмээн сэтгээд мөнхүү модны дэргэдүүр гарах үед дээсээ хаясанд хорт могойн сүүлээс оосорлосон учир тэр могой эргээд барсын эүрхийг хатгамагц барс ч могойг алав. Ингээд барс могой хоёр тэндээ үхэв. Тэр голын олон малчид нэхмэлчин ганц эрийг урьд барс унаад явж байсан ба дараа нь хорт могойд урхи хаяж барс могой хоёрыг ноцолдуулах зэргийг харсан тул хурдан гүйцгээж энэ голын адгийн хаанд айлтгав. Хаан нэг сайн түшмэлийг явуулав. Түшмэл нь барсын арьсыг өчиж байгаа эрийг хараад дэргэд нь очиж түүний амрыг ирж

– Манай хаан таныг урьж байна хэмээн өгүүлсэнд тэрхүү барсын арьсыг өвчиж гүйцээд хааны зүг одлоо. Тэр хааны дэргэд хүрсэнд, охиноо өнөө ганц эрд өгч түүний нэрийг «Манай араатан барсын хөлөгт аварга могойн цаламт» хэмээн цол өгөв. Нэг хэсэг байж байтал тэр голын нэг архины газар түүнийг урьжээ. Тэнд очиж архинд согтоод гэртээ ирж

– Гэргий минь надад ор засагтун, хэвтэе гэв. Охин ор зассанд тэр эр бахархан хөөрөөд

– Гэргий ээ, голын эхний нэхмэлчин ганц бие эр би, эх хөвгүүн охин гурвын алаг үхрийг хулгайлахаар очиж явтал хүн идэгч барстай тулгарч түүнийг үхэр байна хэмээн баясаад дээр нь харайн мордсонд барс гол даваагүй аваад давхив. Зандан модны салаанаас барья гээд цалмаа хаятал хорт могойн сүүл тааралдсанд тэр могой буцаж эргээд барсын зүрх руу ноцож барс үл тэсэн хорт могойн тархийг хэмх хазсан амой. Ингээд би барсын арьсыг өвчиж суусанд түшмэл ирж намайг урив. Хааны дэргэд одсонд хаан охиноо өгөв. Голын эхний нэхмэлчин ганц бие эр, хатагтай чиний эр. Аяа, дэндэхийг үл мэдэх тул голын эхний нэхмэлчин гараар өргөж даахын чинээгээр идэж байгаадаа аяа баясаж байна гэсэнд охин уурлаад, хаанд очиж уйлан зарга мэдүүлэв:

– Эцэг хааны охин ганц надаас өөр байхгүй. Хэнд ч соёрхож болох буй за, Түүнийг масан гэсэн нь ямар масан байх вээ. Голын эхний нэхмэлчин ганц бие эр байна гэсэнд хаан эцэг нь

– Охин чи олон санаа бүү бодогтун. Масан мөн бусыг одоо ч мэдэж болно гээд нэг ухаант түшмэлийг дуудан ирүүлж ийн зарлиг болруун

– Тэр голын эхэнд хүн барьдаг нэг үнэг бий. Түүнд жил бүр нэг хүнийг очуулах хэрэгтэй тул түүнийг номхтгохоор өнөөх халамжит хүргэнийг очуулья. Харин ямар багаж хэрэглэхийг асуу гэв. Ухаант түшмэл сав дүүрэн сайн архи авч өнөөх ганц бие эрийг нэгэн жижигхэн байшинд дагуулж ороод, архи өгч түүнээс

– Бидний байгаа энэ голын эхэнд хүн иддэг нэг үнэг бий. Жил бүр нэг хүнийг түүнд өгдөг болсон юм. Түүнийг номхтгоход ямар багаж хэрэгтэй вэ? Надад хэлж өгөгтүн гэсэнд ганц бие эр

– Миний ажил нь юм нэхдэг, нэхмэлийн ширээнээс өөр юм надад байхгүй тул хэрхвээс сайн болох билээ хэмээн бодож, нэг баганын нуруу өөд бүлгийтэл ширтээд

– Юм бодье гэвч санаанд минь юу ч орохгүй байна. Сур хүлгээр ороосон лугаа адил бүдүүн бөөрөнхий багана, гарди шувууны далавч тэлсэн лүгээ адил баганын сайхан нуруу. нум сайн бөгөөд урт, хорт могой мурилзан явах лугаа адил хэмээн дэмий балай өгүүлсэнд тэр түшмэл «Би мэдлээ» гээд буцаж явлаа. Нэхмэлчинд ч хэлэх юмгүй тул сэтгэл уужрав. Хааны дэргэд тэр түшмэл очоод

– Нэхмэлчинд баганын чинээ сум, нурууны чинээ нум хэрэгтэй хэмээн хэлж байна хэмээн айлтгав. Үүнд хааны цэцэрлэгийн хүрээнээс бургасан нурууг огтлоод нум хийж, бүдүүн ширийг тойруулж зүсээд хөвч урлаж, бүдүүн хуйд нэгэн гуалингаар сум урлаж, дархчуудыг цуглуулж олон зүйлийн төмрийг нийлүүлэн зэв үйлдээд тэрхүү нум сумыг олон хүмүүс дамнан хүргэж өгөөд буцав. Тэр эр очоод үнэг нүхэндээ буй эсэх хэдийд ирж идэх болдоо хэмээн сэтгэн хэвтэж байсанд өнөө үнэг нүхэн дотор байсангүй. Гадна гараад буцаж ирэх замд мөнхүү үнэг нумын хөвчийг үзээд өлсөж байсандаа бас хомхой санаагаар түүнийг тас хазтал тэр нум тийрч үнэгний хоншоорыг цохиж алав. Ганц бие эр

– Өнөөх үнэг нүхэн дотроо байхгүй аж. Хааш явсан бол? хэмээн бодоод харваас үнэг үхсэн хэвтэж байв. Ганц бие эр гүйж олоод сумаа үнэгний дэргэд чирч аваачаад хутгаар хавиргыг нь хадаж сумаа өвчүүнд нь шааж орхив. Чингээд хааны дэргэд очиж,

– Тэр хүн иддэг үнэгийг чинь би алав. Түүнийг очиж автугай гэсэнд үнэгний хүүрийг авахаар түшмэл зарц олноороо явав. Тэгээд тэр үнэгний арьсыг өвчиж, нум сумыг авчирч хаанд өргөв. Хаан, охиноо дуудаж ирүүлээд

– Тэр нэхмэлчин ганц бие эр, масан хувилгаан мөн эсэхийг чи тэр үнэгний арьс хараад мэдтүгэй гэсэнд баясаад тэр хоёр ханилан суужээ. Бас нэгэн үе болоход, хаанд хурим айлтгаад хурим хийж байх үед тэр ганц бие эр архинд согтож

– Голын эхний нэхмэлчин ганц бие эр би үнэгэнд идүүлнэ гээд хэвтэж байтал үнэг нумын хөвчийг тас хазаж хоншоороо тийрүүлж үхсэн байлаа. Би гүнж чиний эр билээ. Хай мэдэхгүй, дэндэж байгаа буй заа. Голын эхний нэхмэлчин гараар өргөж даахын чинээгээр идэж байгаадаа баясаж байна хэмээн хэлснийг охин, хаан эцэгтээ уламжлан

– Хаан эцэг минь танд ганц охин надаас өөр үргүй тул хэнд ч соёрхоход болох буй за. Энэ нэхмэлчин эрд бүү соёрхогтун гэсэнд эцэг нь:

– Охин оо, энэ ганц бие эр чинь их хувилгаантай хүн. Чи энэ эртэй байгтун. Энэ хүн бол голын эхний нэхмэлчин ганц бие эр мөн ч биш ч хамаагүй өнөө маргаашгүй хятад цэрэг ирэх гэж байгаа тул цэргийн ноёнд халамжит хүргэн түүнийг явуулах хэрэгтэй болов. Харин багаж зэвсэг юу хэрэгтэй болохыг ухаант түшмэлд хэлж асуулгах хэрэгтэй хэмээн өгүүллээ. Ухаант түшмэл сав дүүрэн сайн архи аваад нэг ногооны хашаан дотор орж, ганц бие эрд мөнхүү архиа өгөөд

– Өнөө маргаашгүй бидний зүг хятад цэрэг ирж явна. Хятад цэргийг дарах цэргийн ноёнд халамжит хүргэн таны бие явах хэрэгтэй. Ямар багаж зэвсэг хэрэглэхийг надад хариу хайрлана уу гэсэнд ногооны хашааны шарласан сармисгийн ёзоорыг ухахад, тохирох жадны үзүүр байсныг хараад

Миний ажил бол юм нэхэх ажил. Гарын багаж минь нэхмэлийн ширээнээс бус юу ч үгүй хэмээн сэтгэж ногооны хашаа руу дэмий харж бодовч санаанд нь юм орохгүй гайхахдаа

– Үндэс нь шимгүй боловч аманд халуун, үзүүр нь хортой жад гурвалжин үзүүртэй. Олон хань хамсалдсан байна хэмээн өгүүлэв. Ухаант түшмэл «Би мэдлээ» хэмээн буцаад хаанд

– Халамжит хүргэний уналгад ам хатуу нэг агсам морь хэрэгтэй байна. Гартаа барих

гурвалжин үзүүртэй хорт жад нэг хэрэгтэйгээс гадна ар хойноос нь хань хамсаатан олон хэрэгтэй байна. Нөгөөдөр өглөө цэрэг мордоно гэсэн билээ гэв. Ганц бие эрд ам хатуу агсам морь унуулж биед нь баттай хөө хуяг өмсгөөд, гарт нь гурван үзүүртэй хорт жадыг бариулж, хааны удирдсан цэргийн өөдөөс явуулав. Чингэтэл тэрхүү хятад цэргүүд

– Халамжит хүргэн гэдэг нь барс унадаг эрэмгий нэг эр байдаг гэж бидний сонссон, тэр мөн буй эа хэмээн ихэд айцгааж нааш цааш үймэлдэж байтал мөнхүү эрийн морины ам нь халаад хятад цэргийн дундуур давхин оров. Тэр юм сэтгэх гэвч санаанд нь юу ч орсонгүй тул

– Эцэг минь би орлоо хэмээн бархирав. Тэр үг хааны сонорт

– Эр над шиг ортугай хэмээн сонстсоноор хаан

Эр над шиг давшин ор гэж байна гэж хэлээд цэргүүдээ бүгдийг давшин оруулав. Тэр эр мориныхоо амыг дийлэлгүй цааш нааш давхисан учир, хорт жадад өртөж олон хүн үхэв.

Хятад цэргүүдийн бодолд

Нөгөө аймшигт эрэмгий хүн нь энэ ирсэн ажгуу гэлцэж бүгдээр үймэлдэн ухраад хятад цэргүүд, хааны цэрэгт ялагдан бут цохигджээ.

Тэр ялсан цэргүүд хойш буцахдаа

Голын эхний нэхмэлчин ганц бие эр тэр мөн ажгуу. Хүүхэн хүн эртэй бол ядрахгүй. Гүү хээлгүй бол амрахгүй гэдэг тэр үнэн байна гэлцэн ганц бие эрд хааны охин ба хаан түшмэл цөмөөр баясаж итгэв. Тэр хаан нь хөвгүүнгүй тул охин ба нэхмэлчин ганц бие эр хоёулд хан төрөө өгч өөрөө номыг үйлдэв. Тэр охин гурван хүү, хоёр охин бүгд таван хүүхэд төрүүлж, хан төр нь урьдынхаас улам дэлгэрэн мандсан билээ хэмээн өгүүлсэнд хан хөвгүүний амнаас – Эх охин хөвгүүн гурав буян ихтэй байна. Нэхмэлчин ганц бие гуйранч эр түүнээс илүү буян ихтэй байна хэмээн үг алдав.

– Хүүрт үг хэлэв гээд төмөр торыг гал бадартал гурав дэлдэн харцага мэт хүр хэмээн араас алдуурав.

Хан хөвгүүний сэтгэлд

– Хүүр олон үг ярьсан тул миний сэтгэл алгассаны уршгаар ийм болов. Би хүүргүй одвоос лам зэмлэх буй за хэмээн урьдын адил тэр хүүр рүү одож «Хала, хала» гэсэн хүүрүүдийг тогшуураар цохиж «Хүлү, хүлү» гэснүүдийг алхаж гишгэлсээр яваад урьдах модны дэргэд хүрэв.

Нэхмэлчин ганц бие эр урьд төрөлдөө буян хурааснаар идэгч барсны амнаас гэтэлсэн ба хорт могой, хүн идэгчийг номхтгоод хан төрийг эзэлсний арван тавдугаар бүлэг болой.

## ОХИН САЛЭНАГИЙГ АВЧИРСАН БҮЛЭГ ОРШВОЙ

Хан хөвгүүн тэр модыг хутгаар цавчиж

– Лам минь Наганжуна Зүрхэн мөн. Би өөрөө Сайн амгалан явдалт хаан мөн. Тор минь есөн нүхт төмөр мөн. Тогшуур минь хүрэн сэндэн мөн. Хүлэг минь мэхт гинж мөн. Хутга минь чулуу тастагч ирт мөн. Тост гурил минь идэж барагдашгүй идээ мөн. Хүүр чи буух уу? Үгүй юу? Буухгүй бол модыг чинь унагалаа гэсэнд бууж ирэв. Түүнийг тогшуураар дэлдэн хүлгээр хүлээд үүрэн явав. Долоо найман алхам төдий болохын хэрд

– Хан хөвгүүн, Хан хөвгүүн ээ. Зам хол энэлгээтэй тул нэгэн үлгэрийг ярьтугай гэсэнд хан хөвгүүн дуун эс гарсанд

Үйлээ барсан хан хөвгүүн чиний амнаас дуун эс гарах ахул би нэг үлгэрийг ярья. Сонсогтун хэмээн өгүүлрүүн:

– Нэгэн их голд их хаан байв. Түүний албат түлээ ба алт мэтийг эрэгч эх хүү хоёр байв. Нэгэн үе болоход тэр хүү нэг өдөр тоглоомд алгасаад үүрэх түлээ олсонгүй, нэг чулууны нөмөрт хэвгэж байсанд их ус урсаж ирэхээр тэнд байлгүй босоод явав. Түүний маргааш даах чинээгээрээ түлээ үүрч буцахын замд амарч суув. Гэтэл, түүнээс дээшхэн «Эй эй» гэх дуун сонстов. Тэр газрын дундаас чандмань эрдэнийг олж түүнийг аваад буцаж харьсанд эх

– Хөвгүүн чи урьд шөнө ирсэнгүй юу болов? гэсэнд

– Өчигдөр тоглоомд алгасаад түлээ олж чадсангүй учир ээжийг, зэмлэхээс айж суув гэв.

Түүнээс нэгэн үе болоход чандманийн эрдмээр урьдын адил түлээ эрэх хэрэггүй жаргалтай болсонд хаан нь

– Эх хөвгүүнд эрдэнэ буй хэмээн сонсоод тэр чандманийг надад өгөх хэрэгтэй. Эх хөвгүүн та нарыг би гэртээ тэжээж байя гээд түшмэлийг зарж явуулав. Тэр түшмэл эх хөвгүүн хоёрт чандманийг үүрүүлээд авч ирээд хаанд өргөв. Тэр эх хөвгүүн хоёр хаанд мөргөж чандманиа өргөөд

– Бид эх хөвгүүний жаргах зовохыг хаан та мэдтүгэй хэмээн айлтгасанд хаан

– Эх хөвгүүн та хоёрыг яавч жаргуулахыг даана гээд хөвгүүнийг зоог баригч болгож эхийг нэг аглаг газар аж төрөх юмыг өгч явуулав.

Нэгэн үе болоход тэр хөвгүүн гаднах хувцсаар бүтэн, доторх хоолоор цаггалан учраас гайхамшиг сайхан тунгалаг царайтай болов. Хааны хатан түүнд

– Чи ажлаа гүйцээгээд миний нойрсдог жижиг байшинд очоорой гэсэнд тэр хөвгүүн хаанд зэмлэгдэхээс сэжигдээд очиж эс чадав. Тэр хатан уур нь хүрээд

– Би өвдлөө. Элэй халаг хэмээн худал өвдөв. Тэр хаан

Чиний өвчинд юу тустай вэ гэсэнд

Миний өвчинд тус болох арга бий. Бидэнд зоог баригч хөвгүүнийг алаад зүрхийг сугалж надад өгвөөс тус болно гэв. Хаан

– Үхэх боловч түүнийг алж болохгүй. Нүдэнд үл үзэгдэх нэг зүгт цөлөх хэрэгтэй гэсэнд хатан өгүүлрүүн

Цөлөхийн ёс, баруун зүгийн мангасын оронд Салэнаг гэгч ланкийн хүссэн бүхнийг өгөгч нэгэн охин бий. Түүнийг авчиртугай хэмээн хэлэгтүн. Түүнийг эс авчирваас алахаас бус аргагүй хэмээн айлтгав. Тэр хаан хэрэглэлийг том заанд ачиж өгөөд

– Баруун зүгийн мангасын оронд ланк мангасуудад хүссэн бүхнийг өгөгч охин Салэнаг гэгч бий. Түүнийг авчир. Эс авчирваас чи өөрөө аминаасаа хагацна гэв.

Тэр хөвгүүн хаанд гурав мөргөөд баруун зүгийн мангасын орны чиг явсаар мангасын оронд

хүрээ. Мангасын сахиул гайхамшигийн тунгалаг царайтай охин хараад  
Өнөөдөр их буяны өдөр тул энд надаас бусад мангасууд ба эх эцэг бүгд байхгүй. Салэнаг  
авхай бол манай мангасын авхай бөгөөд дагинасын эрхэм охин мөн. Тэр номд итгэмжтэй,  
Өнөөдөр албат мангас бүгдээрээ санваарыг сахидаг довцог дээр бий. Тэндээ гурван хоног  
болно. Тэр довцог дээр хүрвээс мангасууд хүнийг идэхгүй, Салэнаг авхай номд итгэмжтэйн  
эрдмээр ямар нэг хэргийг бүтээх гэхэд бүтээж чадна. Маргаашаас мангасууд санваараа  
тайлах болно. Би чамайг хойд сарын арван тавныг хүртэл энд нууж байгаад гаргая. Чингээд  
хэргээ бүтээ. Ямар хэрэг байгаагаа надад хэлэгтүн гэв. Хүү  
– Хэрэг нь, намайг хүний оронд байх цагт хатан дэргэдээ ир гэхэд би очсонгүй. Чингээд  
хатан хуурмагаар өвдснийг хаан сонсоод  
– Мангасын охин Салэнагийг авч ирвээс сайн. Эс авч ирвээс эрдэнийн аминаасаа хагацна  
гэсэн тул би түүнийг аваачихаар ирсэн юм гэв. Охин  
– Салэнаг бол таван аймаг дагинасын эрхэм мөн. Эгэл хүмүүсийн эдлэхүүн бус. Хурмаст  
тэргүүтэн хүсэгч нар олон ирэвч одоо хүртэл ажраагүй байгаа юм. Чи буян ихтэй хүн байна.  
Чиний хэвтсэн газарт алд хэртэй гэрэл дүгрэглэж байна. Чи эгэл хүн бус тул урин залах  
төдийгөөр болох буй за. Урин залваас хааны авхайтай уулзах хэрэггүй. Хаан албат нарыг  
эрхэндээ оруулж тэр авхайг өөрийн хатан болгож болох буйза. Харин урин залахгүй бол төвөг  
их бий гэв. Тэр хөвгүүн  
– Охин намайг мангаст идүүлэхгүй ба тэр авхайтай уулзуулж туслах буй за хэмээн ихэд  
найдав. Тэр охин өөрийн хэвгдэг нэг тусгай байшинд хөвгүүнийг оруулж үүдийг хааж  
түтжив. Шөнө дунд болоход тэр охин хоол ундыг дутагдуулахгүй авчирч өгч байв.  
Нэгэн үед арван тавны буяны өдөр болоод Салэнаг авхай заларч ирээд  
Бүгдээр цуглагтун гэсэнд, өнөөх охин эцэгтээ очиж  
– Та очвоос болно. Одоо явах гэж байна. Та ээж эгч нартай хамт түрүү очигтун хэмээн  
хэлэлцэж тохирсон тул бусад нь цөм өдөр явлаа. Охин өдөр нууж байсан өнөөх хүүг шөнө  
дагуулан очив. Мангасын таван зүйлийн эрдэнээр бүтсэн харшийн үүдний гадна бул хар том  
чулуу цус болсон байв. Түүн дээр хөвгүүнийг суулгаж өөрөө харшийн дотор оров. Мангас  
цөм сууцгааж тэдний гол дунд, таван зүйлийн эрдэнээр бүтсэн ширээний дээр охин Салэнаг  
сууж байв.  
Тэр охин сөгдөж мөргөөд адистид айлтгав. Салэнаг авхай тэр охиныг ирэхэд цаглашгүй маш  
баясгалантай болж санаа нь амрав. Тэр шөнө байн байн сайхан зүүд зүүдлэв.  
Тэр охин Салэнаг авхайд айлдруун:  
– Маш гайхамшиг нэгэн хөвгүүн нь охин тантай уулзах гээд хүний орноос ирээд одоо миний  
хамт гадна ирлээ гэсэнд  
– Охин чи түргэн яваад нэг гэрт оруулж хорлол хөнөөлөөс хамгаалагтун. Өнөө шөнө уулзана  
гэсэнд тэр охин түргэн гарч  
– Салэнаг авхайтай уулзаж болох болсон. Санаа амар суугтун гээд нэг айлд байлгав. Тэр  
шөнийн санваар гүйцээгээд үүр шахахын үе Салэнаг авхай  
Өчигдрийн тэр хөвгүүнийг дагуулаад ирэгтүн гэсэнд тэр охин Салэнагтай уулзуулахаар  
хөвгүүнийг хөтлөөд дэргэд нь хүрмэгц хөвгүүн мөргөхийг завдсанд  
– Чи агуу их төрөлхтөн мөн. Төрөл тутамд надтай ханилсан учир, чиний мөргөлийг би үл  
дагана гээд тэр хүний гараас шүүрэн барив. Хөвгүүн охин Салэнагт  
– Би урьд насанд буян хурааснаар эрдэнэт хүний биеийг олов. Урьд төрөлд өглөг үл өгснөөр  
хоосон хүний хөвгүүн болон төрөв. Нэг үйлтэй эм шулам хааны хатан болсон ба би урьд  
насанд хүлцэнгүйг бясалгаснаар дүрс царай тэнгэрийн бие мэт болж шулмасын нүдэнд

тохирсон боловч тэр эхнэрийн хүндлэлийг үл бүтээсэн учир хязгаарт цөлөгдөв. Чингээд урьд насны ерөөлтэй үйлийн охин тэнгэр чамтай уулзав гэсэнд охин тэнгэр

– Надтай их төрөлхтөн та урьд насандаа ханилсан юм. Эцгээс намайг гуйгтун. Түргэн ханилаад явъя. Эм шулмасыг номхтгоход би хань болно гээд тэр авхай таван зүйлийн эрдэнээр бүтсэн өөрийн харш дотор түүнийг урин залав.

Тэр авхай түүнд

– Буяны өдөр мөн учир, маргааш эцэгтээ би айлтгая гэв. Маргааш нь тэр авхай, арван толгойт мангас хааны дэргэд бараалхаад

Эцэг хаан минь ээ. Охиныхоо үгийг сонсохыг айлтгая. Миний урьд насны ханилсан их төрөлхтөн, хүний оронд төрөл авсныг хилэнцэт нэг хаан мангасын оронд цөлсөн байна. Урьд насанд ерөөл тавьснаар надтай уулзав. Тэр хааныг номхтгоход туслах хэрэгтэй гэсэнд хаан

– Салэнаг авхай намайг сонс. Хурмаст тэргүүтэн чамайг хүсэгчид олон байлаа. Хурмастаас үлэмж хүний язгуур буянт хаан мөн боловч, хурмастаас үлэмж байх учир байхгүй. Хоёр хөлт эгэл хүмүүст үл өгнө гэсэнд авхай

– Миний дэргэд ирвээс эгэл хүн аяндаа өөд давшина. Бүрэн төгс эдлэлтэй болвоос хаан аяндаа болно хэмээн айлтгасанд эцэг

– Зарцын тоонд багтааж болно. Нөхөр болгож үл болно. Урьд насны ерөөлийн хүч мөн боловч зарц болгоход зохистой болой. Гэвч түүнийг маргааш ажиглан шинжилж байж болно гэхэд тэр авхай айлдруун

Буяны өдөр болохыг хүртэл уулзаж болох ба мах цусны тахилга үйлдэхгүйг андгайлах хэрэгтэй гэхэд

– Охины урьд насны ерөөлтэй нөхөр мөн аваас мах цусны тахилга яаж үйлдэх вэ? Мах цусны тахилга ба төгс эдлэл одоо хүрэлцэхээр байгаа тул одоо андгай хэрэггүй гэсэнд тэр авхай буяны сайн өдөр эцэг хааны дэргэд очоод «Эцэг хаан нь хилэнцийн сэтгэл ихтэй учир айлтгалын цагт талаар болж ч мэдэшгүй» хэмээн санаад

– Аяа, их хаан аа. Миний урьд насны ханилсан тэр эр таны өмнө ирэх тул андгайг хийх хэрэгтэй гэсэнд хаан

– Миний тахилгын өглөг буюу, бэрх ажлыг бүтээлгүйгээр миний дэргэд ирж болохгүй гэсэнд Тэр бэрх үйлийг яавч бүтээнэ хэмээн айлтгасанд

– Бэрх үйл олон. Цаст уулын дундаас арсланг эрэх ба далайн дундаас чандманийг эрэх тэргүүтэн олон зүйл байна. Урьдаар тэр хоёрыг бүтээгтүн хэмээн айлдав. Охин Цаст ууланд явдаг дайчин биш. Далайд шумбадаг матар биш. Надтай урьд насны ханилсан хань мөн тул тэр бид хоёр амь нэг байхаас аргагүй. Тэр мэтийн бэрх ажлыг хэн ч чадахгүй хэмээн айлтгасанд

– Та хоёр хагацаж чадахгүй бол надад байгаа гурван зуун илжгээр нэгг өдөр зүлэг шавар авчиртугай гэв. Тэр охин

– Зарлигийг дагаж бүтээе гээд харшдаа буцаж ирээд охин хөвгүүнд сургасан нь Эдгээр цөм илжиг бус, илжигний арьс нөмөрсөн мангас мөн. Чи миний энэ морийг хөтлөөд тэнд оч. Гурван зуун илжгэнд зургаан зуун хүлэг, гурван зуун тогшуур бэлтгээд тостой гурил гурван зуун хэсгийг өгөөд зүлэг шавар ухах газарт хүрэхийн сацуу илжиг бүрийг тогшуураар дэлдэж «хоолоо идээд ажлаа хийгтүн» хэмээн өгүүлэгтүн. Чи өөрөө даваан дээр гарч суу. Тэнд өөрсдөө зүлэг шаврын ачааг ачаад янцагласаар тар, тар явах болно. Тэд бүгдийг гүйцсэний даруй тогшуураар дэлдэж «сүйрсэн мангасын илжгүүд явахгүй юу. Гутамшигт мангасын илжгүүд явахгүй юу» хэмээн туусаар гүүрэн дээр гартал туугтун. Тэднийг гүүрнээс өнгөрөхийн сацуу, намайг нүдэндээ илхэн бясалгаж энэ морийг унаад харшид

дугааж ир хэмээн сургав. Тэр хөвгүүн Салэнагийн хэлсэн ёсоор илжгүүдийг тууж зүлэг шавар авахаар очоод, урьдын сургасан мэтээр үйлдэж даваан дээр суусанд илжиг бүрийн арьсан доороос нэжгээд мангас гараад зүлэг шавар ухав. Ухаж гүйцээд илжигний арьсыг нөмрөөд зүлгэн ачмаг нэжгээдийг ачаад янцаглан тар тар явсаар гурван зуу болоход хөвгүүн морио хөтөлж, тогшуурт өртсөн бүхнийг нүдсээр одов. Гүүрийг хүртэл дэлдсээр гүүр өнгөрөхийг шахахад охиныг орой дээрээ бясалгаж морио унаад, харш руугаа дугаав. Тэд нар илжигний арьснуудаа мулталж хаяад гурван зуун мангас болоод түүнийг элдэв. Тэр хөвгүүн охины харшид ороод гэтлэв. Түүний маргааш хаан

Миний дэргэд тэр хоёрыг авч ирэгтүн гэсэн ёсоор харшид ороход түүнд нэг жижигхэн ширээг бэлтгээд, охинд оюу ширээ нэгийг тавьсан байв. Тэр хаанд хөвгүүн мөргөхийг завдсанд хаан ширээн дээрээсээ унав. Хаан угтаж ирээд өөрийнхтэйгээ адил нэг ширээг засаж бүрэн төгс өргөл хүндлэлийг үйлдэв. Номтой зохилдох зарлиг яриаг олонтаа үйлдэж хаан

Миний Салэнаг авхайг хурмаст тэргүүтэн хүсэгч олон боловч одоо хүртэл хэнд ч өгөөгүй билээ. Энэ охин та хоёр төрөл төрөлдөө хагацаж чадахгүй байсан учир чамд өгөх болов. Би мах цусан тахилга үйлддэг хаан боловч мангасыг номхтгох хэргээс гадуур арван таван, битүүн, шинийн найман гуравт мацаг барьж ном буяныг үйлддэг. Үүнээс хойшид болох арван таван, битүүнд зургаан цаг санваар сахиж өдөр шөнөгүй номын ёсоор явна. Эд таваар, төгс эдлэл, хан төргүй гэж зовох хэрэггүй. Өөрт хорлол юу боловч хилэнц болголгүй номын ёсоор тусалж дэмжихийг хөвгүүн зохиотугай хэмээн хаан зарлиг захиаг хайрлав. Хөвгүүн хаанд – Урьд насандаа өглөг эс өгснөөр гуйранч болон төрж, буян хурааснаар номч хаан тантай уулзаж, үйлийн залгамжаа байснаас энэ охин тэнгэртэй учрав. Эцэг хааны зарлигийг явч сонсоно хэмээн айлтгав.

Түүнд эд таваар, алт мөнгө, зэс төмөр, үхэр адуу, хонь гурвын алиныг ч өгсөнгүй. Хөвгүүн охинд

– Бага зэрэг хоол хүнс хэлж авч явья. Эндээс гадагш гарсан хойно идэх юм байхгүй шүү гэхэд охин

– Хаа хүрсэн газарт эд идээний хур байх буй за гэж, тэр охин нэг хүрэн морийг унаад бас нэг сайн моринд хөвгүүнийг мордуулав. Түүнд эцэг хаан, нөхөр сэлт гурван бээрийн газарт үдэж, гурван хоног болоход ном лугаа зохилдсон зарлиг захиаг эр эм хоёрт сургав. Охин эцэгт сануулга дуртгал болох үгээ захив. Эцэг хаан, түшмэд буцав.

Охин тэр хоёр Төвдийн оронд ирэв. Тэд хааны нутагт арай хүрээгүй байхад хатан Салэнаг нэг эзгүй их газарт хүрээд ерөөл тавьсанд урьдын хатуу ширүүн газар тэргүүтэн хорт мод навчнууд огт үгүй болж зандан мод, тэнгэрийн цэцэг, мандарваа тэргүүтэн ургаж, найман гишүүн төгөлдөр ус урсаж элдэв зүйлийн үр тэргүүтэн цэцэг дэлгэрч, таван зүйлийн эрдэнээр бүтсэн хот гарч түүний дотор алт, мөнгө, зэс төмөр тэргүүтэн хүү сан санаж гүйцэшгүй буй болов. Албат нөхөр зарц гурван зуу төдий болж амгалан жаргалан төгсөв. Урьд өөрийг нь явуулсан хааны малчид хоньчид түүнийг үзээд

– Бидний эзгүй газарт урьд байгаагүй эрдэнийн харш, бүрэн төгс гүйцсэн сэтгэшгүй хот байна хэмээн айлтгасанд хаан

– Бидний халамжит нэг хөвгүүн эрт цагт мангасын орноос Салэнагийг авчрахаар явсан тэр хүн ирсэн буюу? Үзэхээр түүний эхийг явуулья гэв. Түүний эхэд

Чиний хүү ирсэн байна уу? Очиж үзэгтүн. Манай нутгийн тэр хоосон газарт урьд үзэгдээгүй харш, нөхөр сэлт байна. Үзэгтүн гээд явуулав. Тэр эмгэн аажим явсаар ойртож, харшийг нүдэнд үзэгдэх төдий болоход хатан Салэнаг хан хөвгүүнд

– Их төрөлхтөн чиний эх, далдын дагина тэр ирж явна. Тэр хаан морио эмээллээд угтаж морилоод ээжтэйгээ уулзаж ээжийгээ мориндоо унуулж, өөрөө хөтөлсөөр харшдаа ирэв. Харш дотор хүрээд хатан. Салэнагт ээж нь мөргөв. Түүнд хан хөвгүүн

– Намайг мөргөх гэхэд бүү мөргөтүгэй гэсэн боловч ээжийг мөргөх цагт бүү мөргөтүгэй хэмээн эс өгүүлдгийн учир юу вэ? гэсэнд хатан

– Би бол бурхан дагина мөн. Дагинас бүхнээс эрх ихтэй бөгөөд оройн чандмань мөн. Төрөлхтөн чи бол төрөл төрөлдөө надтай ханилсан их төрөлхтөн мөн учир мөргөж үл болно гэсэнд ээжид идээ ундааг бүрэн төгс өргөв.

Түүний маргааш өглөө ээждээ чандмань эрдэнэ, задь ба үндсээр нь авсан арүүрийн мод тэргүүтэн хаанд өргөх юмсыг өгч нэг морь унуулаад илгээв. Тэр ээж нь хааны харшид хүрээд бэлэг ба айлтгалыг хаанд өргөж

– Миний тэр хөвгүүн, бэрх үйлийг бүтээгээд хүрч ирсэн байна хэмээн айлтгасанд хаан түшмэд албат нөхдийг цуглуулаад

– Урьд манай нэг хүн мангасын оронд очиж Салэнагийг авч ирэхээр явсан тэр Салэнагийг авчраад манай нэг эзгүй нутагт сууж орд харш, нөхөр сэлтээр надтай тэнцүү болсон байна. Явал сайн бэ? гэсэнд дотоод түшмэдийн дотроос нэг нь

– Салэнагийг авчрахаар манай эндээс явуулсан тэр хүн урьд хааны зоогийг үйлдэж байхын цагт гал ба гэгээгүй боловч түүнээс алд дүүрэн гэрэл гарч байдаг хүн байсан. Тэр буян ихтэй тул бид нар цэрэг мордуулах тэргүүтнийг үйлдэвч алагдах болно. Хаан нь хөвгүүнгүй тул түүнийг хөвгүүнээ болгож, хан төрийг тэр хоёрт өгч хаан өөрөө номыг үйлдвээс зохистой болов уу хэмээн айлтгав.

Бас нэг түшмэл босоод

– Манай тэр хүн хаашаа ч явсангүй сууж байгаа ба бид хатан болгон өргөмжилсөнгүй. Өөрөө ирсэн хүүхэн байна хэмээн хаанд айлтгав.

Тэр хаан нэжгээд заан унасан арван түшмэл дагуулж тэдэнтэй уулзахаар очихыг шийдвэрлэв. Түшмэдийн дотроос нэг нь

– Түүнд өгөх эрдэнэ тэргүүтнийг авч очихгүй юу? Хэрвээ тэр омогшиж хөшүүрхвээс өргөлийг өгөх хэрэгтэй. Дээрэнгүй омог эс гаргаваас хишиг болгон хайрлаваас болно хэмээн айлтгасанд хаан

– Тэр зөв байна гээд гурвалжин чандманийг авч одов. Түүний харшийн дэргэд хааныг хүрэхэд тэр хүн

Анх албат байсан тул би угтахаар явна гэсэнд хатан

– Чи бол их төрөлхтөн мөн. Тэр бол өглөг өгсөн хаан мөн гэв. Хаанд алтан ширээ зассанд

– Алтан ширээ үл таарна гээд хаанд лавай ширээ засав.

Чингээд алтан ширээн дээр тэр хүн сууж хатан оюу ширээн дээр сууж байв. Тэр хааныг угтуулахаар түшмэдийг илгээв. Тэр хаан харш дотор ирэв. Тэр хаан охины сүр жавхланд тэсэлгүй сандран мэгдэж хан хөвгүүн хатан хоёрт мөргөв. Тэр хүн анх албат байсны учир хариу мөргөл үйлдсэнд хааны хамар хөлийн үзүүр хоёр нийлээд хаан босож үл чадав.

– Юу болов гэсэнд хатан Салэнаг ийн айлтгав.

– Хаан урьд төрлийн өглөгч хаан мөн. Их төрөлхтөн чи галав турш буян чуулганыг хураасан дээдэс мөн. Одооноос хойш мөргөлийн хариуг бүү үйлд гэж танд захиж айлтгая хэмээн хэлсэнд тэр хүн

– Ширээнээсээ буух буюу? Хэрхвээс сайн буй гэсэнд

Их төрөлхтөн чи алтан ширээн дээр сууж бай. Түшмэд хааныг төлөөлж буй гээд, зуу зуу мөргөвөөс хаан босох болно гэв. Дэргэд байгаа түшмэд, тэр хүнд зэрэг зэргээр мөргөсөнд



хаан гэнэт босов. Түүнээс хааныг лавай ширээнд суулгаж, өргөл хүндлэлийг бүрэн төгс үйлдэв. Хаан нь мөргөлийн харамжинд чандманиа өргөв. Тэндээ зарлиг яриа зөвшилдөж хатан Салэнаг хаанд

– Үйлтэй эм шулмасыг аминдаа хор хийхээс өмнө дэргэдээ авчирч их төрөлхтнийг өргөн хүндлүүлэх юм сан. Гэтэл тэр амиа хорлож дуусав хэмээн хэлэв. Нэг түшмэл босож мөргөөд хатан Салэнагт

– Тэр амиа хорлож үхээд бүгдээс хоцрогдов уу? гэсэнд Салэнаг

– Тэр хүүхэн огт байгаагүй бол энэ албатууд бүрэлгэгдэж балрах байсан учир, тэр өөрөө албат нарт ач тус их болсон гэв. Тэр түшмэл

– Тэр хэдийн үхсэн болбоос өөр нэг хатан аваад хааны үндэс тасрахгүй. Албат иргэд дэлгэрэн жаргах байсан биш гэсэнд хатан өгүүлрүүн

– Энэ их төрөлхтөн надтай урьд насны ханилсан нөхөр мөн учир, би буман мангасыг дагуулж ирвээс хааны энэ албатууд ганц ч хоног болохгүй бүгдээрээ бүрэлгэгдэж сүйднэ.

Сүйдлэгдээгүй мэнд үлдсэн нь энэ хүүхний ач хэмээн мэдэх хэрэгтэй. Хаан чи ч одоо хэрсүү ухаантай байна. Цэрэг татах тэргүүтнээр угтсан аваас өөрөө сүйдэж бодтой хилэнц болох байсан билээ гэсэнд тэр хаан Салэнагт

– Би урьд төрөлдөө буян хураасан минь хөвгүүн ба охин та хоёроос үлэмж болох өөр юм байхгүй тул маргаашнаас би өөрөө номын хүрээнд сууя. Албатыг та хоёрт өргөө гээд тэр хаан хаан төрөө хатан Салэнаг, хан хөвгүүн хоёрт өгөв.

Тэр голын эхэнд үлэмж номын газрыг байгуулж хан төрийг тэр буянт хоёр барьснаас арван таван, битүүний зургаан цаг тэргүүтэнд мацаг барихын ёсыг мөн дэлгэрүүлж хан төрийг номчлон тэтгэв гэсэнд Сайн амгалан явдалт

хаан

– Тэр хүн буян ихтэй еэ хэмээн үг алдсан тул

Хүүрт үг хэлэв хэмээн төмөр торыг гал бадартал гурав дэлдээд харцага адил хүр хэмээн араас алдруулав. Тэр,

Хийдэд очвоос ламын зарлигийн зэмлэл ирэх болно хэмээн сэтгээд, хүүрийн газарт буцаж явав. «Хала, Хала» гэсэн хүүрийг тогшуураар дэлдэж, «Хүлү, Хүлү» гэснийг алхаж гишгэлсээр урьдын модны дэргэд очив.

Үржинбадам Ишчойжил хоёрын урьд төрөлдөө буянтан болж мэндэлсний арван зургадугаар бүлэг болой.

# ГАХАЙ ТӨЛГӨЧ ЭР, ЭМ МАНГАСЫГ НОМХТГОСОН БҮЛЭГ ОРШВОЙ

Бас хан хөвгүүн тэр модыг хутгаар цавчаад

– Лам минь Наганжуна Зүрхэн мөн. Би өөрөө Сайн амгалан явдалт хаан мөн. Тор минь есөн нүхт төмөр мөн. Тогшуур минь хүрэн сэндэн мод мөн. Хүлэг минь мэхт гинж мөн. Хутга минь чулуу огтлогч иртэй мөн. Тостой гурил минь барагдашгүй идээ мөн. Хүүр чи буухгүй буюу? Модыг чинь унагана гэсэнд тэр хүүр бууж ирэв. Түүнийг тогшуураар цохиод торонд чихээд хүлгээр хүлж үүрээд долоо найман алхам явтал хүүр

– Хан хөвгүүн, Хан хөвгүүн. Эсбөгөөс хан хөвгүүн нэг түүхийг ярьтугай. Эсбөгөөс би нэгэн үлгэрийг ярина. Сонсогтун гэхэд хаан үл зөвшөөрсөн байдлаар толгойгоо нааш цааш сэгсчсэнд хүүр өгүүллүүн

– Нэг их голд хаан ах дүү долуул байжээ. Бас нэг оронд хэдэн цөөхөн айл байв. Тэдгээр айлын дотор хэрсүү хүүхэн байв. Түүний эр нь бараг дуун гарч ярьдаггүй, бүсээ ч бүсэлдэггүй, зүв зүгээр сууж байдаг ажгуу. Хожим нэгэн үед цас орж байхад тэр эр ганц удаа гадагш явжээ. Малчин айл нүүсэн нутаг дээрээс нэг хэрээ бяцхан цагаан тосыг олж авч яваад түүний дэргэд унагасанд тэр эр хэсэг тосыг гэртээ авчирч эхнэртээ өгүүллүүн

– Эр хүн гэдэг чинь хэвтэж баймааргүй юм байна. Гадуур хэсэж яваад энэ цагаан тосыг олж ирэв гэсэнд эхнэр

– Хэвтээд байвал бүтэх юмгүй. Эр хүн хэвтвээс сумны толгойг алдана. Сумны толгойг алдваас дайсны толгой хөшүүрнэ. Бүсгүй хүн хэвтвээс ээрүүлийн толгойг алдана. Ээрүүлийн толгой алдваас хувцас тамтаг болно гэдэг билээ. Эр нөхөр хэсэж явбаас аз заяа нэмэгдэж, аливаа эдээр элбэг болно гэхэд тэр эр эхнэртээ

– Надад чи нэг сайн морь, эмээл, хувцас, мөч мах, түүн дээр нэг тэрмэн дээл, толгойд өмсөх нэг цагаан малгай, нум сум, саадгийн хамт годил тэргүүтэн өвч бүрэн нэг сайн нохой уяаны хамт бэлдэгтүн гэв. Эхнэр нь түүний юу хэлснийг ёсоор бэлтгэв.

– Гэр, хувцас хэрэглэлүүдээ өмсөж зүүгээд нохойгоо хөтөлж, морио унаж одов. Эзгүй голд хүрэхэд нэг үнэг явж байгаа харагдав.

– Урьд учирсан олзны дээд үүгээр үнэгэн малгай хийнэ. Элбэг хангалуун больё гэвэл эдийг нягтлан эс хурааваас үл болно хэмээн мориныхоо түрүүнд нохойгоо гаргаад үнэгэнд турхирсанд тэр нохой маш хурдан хөөхөд үнэг нүхэнд шургав. Тэр эр очиж мориноосоо буугаад нохойг морины цулбуураас уяж, нум сум, эсгий дээлээ тайлаад эмээлийн урд хойд ганзаганд ганзагалав. Цагаан малгайгаар үнэгний нүхийг бөглөж нэгэн том чулууг аваад үнэгний нүхийг түншээр нүхний мухарт хүрэхэд цагаан малгай дээш хөдлөв. Түүний дээрээс нь нэг чулууг хаямагц үнэг гарч дутаасан ба нохой түүний хойноос хөөв. Нохойн уяаг морины цулбуураас уясан учир, түүний хойноос морь ч давхисанд өөрөө чармай нүцгэн хоцров. Санааширч

– Юу ч үгүй гэртээ хариваас эхнэр зэмлэх болно хэмээн санаж нэг даваа өөд авирч гарав. Тэр даваан дээрээс харсанд хааны нэг их харш байв. Тэр даваанаас бууж очиход шөнө дунд болоод гадна хүнгүй байв. Тэрбээр морь мал тэжээдэг овоолсон өвстэй газар хүрч өвсөөр биеэ олон давхар хучаад дөнгөж нүдээ харж болох төдий болгож хүнд үзэгдэлгүй хэвтэж байв.

– Чингэтэл хааны авхай гарч ирэв. Харшдаа тогтож суудаггүй тэнүүлч эр авсан тэр авхай, түүний дэргэд ирж шээгээд босоход нь түүнд байсан хааны сүлдний том оюуны оосор нь тасраад унав. Түүнийг өнөөх эр харсаар байсанд нэг үнээ ирээд оюуны дээр баас алдав. Бас

хэвгэж байсанд нэг зарц хүүхэн ирээд тэр баасыг авч хашааны завсарт нааж орхиод явав.

Түүний маргааш өглөө наран ургах үеэр хааны хотод байгаа улсыг цугларуулан – Хааны авхайн хүзүүн дэх сүлдний оюуны оосор тасраад гээгджээ. Үүнийг албат эр хүн олвоос түшмэлийн шадар болгоно. Эм хүн олвоос хатны шадарлагч болгоно хэмээн тунхаг тараав. Түүнд шоочин, төлөгчин, толь буулгачин ба бусад цөм эрж сураглав. Дараа тэр эр өвсөн дундаас тал биеэ цухуйлган сууж, бас босож зогссонд олон хүн түүнийг үзэхээр цугларч бүчив. Тэр

– Та нар цуглаад юу үйлдэж буй гэсэнд хааны нэг түшмэл түүний дэргэд очоод

– Ийм хүнд илт мэдэл байх магадгүй гээд

– Хааны охины хүзүүнээс нэгэн оюуг алдсан тул эрж сурж явна хэмээн өгүүлэв. Надад хэрэглэлийг бэлтгэвээс би илт мэдэж болно гэв.

Юу хэрэглэх вэ? хэмээн асуухад

– Нэг цагаан шийдэм, таван өнгийн хивээр чимсэн нэг гахайн толгой, оготор эсгий хэвнэг дээл, малгай гутлыг авч ирвээс илт мэдээд хэлж өгнө хэмээн өгүүлсэнд тэр түшмэл түргэн гүйж яваад

– Хувцасгүй нэгэн галзуу мэт хүн мэргэлж болно хэмээн өгүүлж байна гээд түүний захисан юмыг хүргэж ирэв.

Тэр дээл гутлыг өмсөж гахайн толгойг гартаа бариад хүмүүсийг дараалан

– Энд байна уу? хэмээн гахайн толгойгоороо заасаар явав. Тэр эрийн гахайн толгойгоор заагдаагүй бусад хүмүүс нь

Бидний хэн дээр тохогдож ирэх бол доо хэмээн бодоцгоож байв. Тэр эр хүн бүгдийг зааж гүйцээд өчигдрийн оюутай баасыг заан

– Энд байна гэв. Баасыг сөхсөнд оюу гарав. Тэр хүнийг дотогш урин залж өргөл хүндлэлийг бүрэн төгс үйлдэв.

Түүнд сайныг үйлдсэний хариуд юу хэрэгтэй вэ? гэсэнд

– Их хэрэгтэй юу хайрлахаа та болгооно буй за.

Та сайн илт мэдсэн тул үл таарах юм өгч болохгүй. Таны өөрийн сэтгэлд юу таалагдаж буй.

Түүнийг чинь өгье гэв.

Чингэвэл та надад бүрэн хэрэглэлтэй морь, түүний дээр монгол маягийн хувцас, нум саадгийг ганзагалж, морины цулбуураас төмөр гинжтэй нохой уяж, далан дээрээ цагаан малгай тавьсан үнэгийг урд нь явуулж, түүний хойноос нохой морь хоёр явж буй тийм нэг юм хэрэгтэй гэсэнд хаан баясаад түүнд өргөл хүндлэлийг бүрэн төгс үйлдэж, үнэгийг тусгайлан барьж авч ирэв. Үнэгэнд цагаан малгай өмсүүлэн хүзүүгээр оосорлоод ганцааранг нь явуулж, морь, эмээл, дээл, нум саадаг тэргүүтнийг түүний хэлсэн ёсоор өгсөнд баясав. Түүнд бус бас юмыг ч өргөв. Хаан түүнд

Төөрөлтгүй илт мэдэгч, гахай төлгөч багш хэмээх алдрыг өргөмжлөн өгсөн тул илт мэдэгчийн алдар маш их болов.

Түүнийг хүргэхэд бэлтгэсэн мах, тос зэрэг үүрэх юм бүгдийг ачиж эхнэрийн байгаа газарт хүргэж явуулав.

Үүдний гадна хүрэхэд түүний өөрийн нохой морь хоёр хүрч ирсэн байжээ. Эхнэр ч тэднийг ирэхэд маш баясан дотогш урин залаад, хүргэж ирсэн хүмүүст идээ ундаа бүрэн төгс өгөв.

Хүргэж ирсэн хүмүүс буцаж харив. Эхнэр нь

– Ээ эрийг минь тэнгэр чөтгөр авав гэж бодоод шоо төлгө тавиулж, гүрэм хийлгэв. Энэ хэрэглэлүүдийг хаанаас авч ирэв? гэхэд, тэр урьдын учир шалтгааныг нягт ярьж

Хааны сүлдний оюуг олсны хөлс мөн. Их эд биш буюу? гэсэнд эхнэр

– Бидний энэ морь, нохой, хэрэглэл юм ирсний сүүлд чи өөрөө ч ирсэн тул их эд юмтай болов. Сүлдний оюуг олсны шангийн эд нь даанч өчүүхэн байна. Би айлтгал бичиг өргөх хэрэгтэй болов гээд тэр эм нь эрээ бичсэн болгон айлтгал хийж хаанд хүргүүлсэн бичигт – Төгөлдөр хааны биед их гай байснаас сүлдний оюуг гээсэн тул, ёгтлон бэлгэдэж хувцас хэрэглэлүүдийг танаас айлтгаж авсан билээ. Одоо надад сүлдний оюуны төлөө аль хэрэгтэйг өгнө гэж амласнаа таалалдаа анхаарна уу хэмээн бичээд өргөжээ. Хаан түшмэдтэйгээ хэлэлцсэн нь

– Түүнийх зөв. Гээгдсэн сүлдний оюуг энэчлэн мэдсэнд тийм бага юм өгч яаж болох вэ гээд алт, мөнгө, зэс төмөр, эд агуурс, үхэр адуу, хонь тэргүүтэн барж дуусашгүй их юмыг тэр хоёрт хайрлан өгөв. Чингээд тэр хоёр жаргалтай сууж илт мэдэгчийн нэр их алдаршив.

Тэр цагт тэндээс олон даваа голын чанад Номч хаан ах дүү долуул хан төрийг номчлон тэтгэж байжээ. Нэг хатныг авах гэвч тэдэнтэй тэнцэх нь эс олджээ. Нэгэн үед ах дүү долуул ой цэцэрлэгийн дунд зугаацан явахад тэнд гоо үзэсгэлэнт охин нэг эр хайнагтай явж байв.

– Та хоёр юу хийж буй? Хаанаас ирсэн бэ? гэсэнд охин

– Би урд зүгийн хааны охин. Энэ хайнагийн хойноос дагаад энд ирлээ гэв.

Чингэвээс бид ах дүү долуул эхнэргүй учир, гэргий маань болох уу? гэсэнд «Больё» гэжээ.

Охин хайнаг хоёр мангасын орноос ирсэн учир нь «Төвдийн оронд буй Номч хаан ах дүү долуул хан төрийг номчлон тэтгэж байна. Тэд нар улам өрнөн ялваас бидэнд цэрэг ирүүлэх учир очиж номхтог хэрэгтэй. Цэрэг мордуулавч дийлэх эсэхийг мэдэхгүй. Аргаар номхтог гэвээс хэнийг илгээвээс сайн бэ? гэсэнд тэдний дотроос их хувилгаантай мангас эр, эм хоёр «явья» гэж андгайлсан учир номхтог ажилд тэр хоёрыг илгээв. Эр мангас нь мухар хүрэн хайнаг болон хувилж, алт мөнгө, зэс төмөр олныг тээж ирэв. Эм мангас гайхамшигт тунгалаг царайтай, үзэсгэлэн гоо охин болон хувирч ирэв. Хааны гадна ирээд хааны хотын хэрмийн ёроолд сууж алт, мөнгө тэргүүтний худалдаа хийж, олон зүйлийн эрдэнийг байн байн цухалзуулж байхад

– Өлөг эд бараа бүрдсэн их юмтай гайхамшигийн охин байна хэмээн их алдар цуурайтав.

Тэр үг, хааны сонорт хүрэв. Хаан нь харшийн орой дээрээс болгоов. Охин ч чандмань эрдэнэ тэргүүтэн чимэг хувцас зүүж өмсөж худалдаа хийсээр сууж байхад хаан охиныг үзээд сэтгэл автав. Хаан язгуур үндэс сайн мууг асуулгаж хүн илгээсэнд охин

– Би Энэтхэгийн зүүн зүгийн нэг хааны угсаа мөн. Өлөг эдлэл эрдэнэ худалдах ба орон нутгийг үзэж одоо буцаж явна гэв. Хаанд түүний учрыг айлтгасанд хаан баясаж хааны угсаа болбоос өөрийн хатан болгон авья. Нааш ирүүлэгтүн хэмээн айлтгав. Түүнийг дотор дуудаж, хан төрийн хатан болгож бүгдийг даатгав.

Нэг хоёр жил өнгөрөхөд хаан хүчир өвчин тусаж халив. Бусад ах дүү нь дараа дараагаар хаан сууж, түүнийг хатан болгосоор байгаад удалгүй үхдэг байв. Тэр охин нь гоо бөгөөд хоол архийг амтлан болгодог, газар тарианы үйлдвэрт мэргэний учир охиныг тэвчиж чадахгүй хатан болгосоор байжээ. Ардууд ярихдаа

– Энэ хатан ер нь тохиромжгүй байна гэлцэх болов. Хамгийн бага дүү нь ширээнд суусанд

– Эмийг ч тусгай нэгэн байшинд байлгаваас тохиромжтой гээд унтлагын жижиг сайхан байшинг хотын өнцөгт барив. Охин ч нойрсох байшиндаа асрагчийг байлгав.

– Хан хөвгүүн одоо халих бололтой. Хэрхвээс сайн болох буй хэмээн түшмэд албат нар зөвлөлдөхөд

– Өөр нэгэн оронд төөрөлгүй илт мэдэгч гахай төлгөч буй. Түүнийг урин залах буюу үзүүлэхээр очих аваас сайн гэв. Гурван шадар түшмэд, олон ард түүнийг эрж олох ба урин авчрахын тулд явсаар тэдний үүдэнд хүрэв.

– Та нар юунд ирэв гэсэнд саяын учир шалтгааныг нягтлан хэлээд  
– Их төлгөч таныг урин залахаар ирэв гэв. Тэр эхнэрийнхээ дэргэд очоод  
– Ноднин их сайн болсон бөгөөд одоо урьд жилийн адил болох болов уу? гэсэнд эхнэр  
– Одоо эс очвоос энэ морьтой хүмүүс буцаад явчих болно. Урьд жилийнхээс илүү сайн болох  
буй за. Очвоос сайн. Урьд мэт их буян ирэх нь гарцаагүй. Айж чичрэх хэрэггүй. Сэтгэлээ  
бататгах хэрэгтэй. Бид нэг юм нэхэх гэхэд оосор шөрх олддоггүй шүү. Хэрвээ хааны өвчин  
эдгэрвээс ташрамд шөрх олж ир гээд тэд нартай цуг явуулав.

Тэр хааны харшид хүрч, хааны нойрсох бяцхан байшинд дэрний дэргэд гахайн толгойг тавьж,  
гүр рагша эрхийг барьж бясалгал хийж суув. Тэнд хатан ирээд илт мэдэгчид зоог барьж  
архийг ч дахин дахин хундага дүүргэн барьж

– Хааны өвчнийг арилгахыг та мэдтүгэй хэмээн хэлээд буцаж одов. Тэр шөнө сайн тахилыг  
үйлдэж хаан ч сэргэж амар болов. Хаан зарлиг болруун

– Мэргэн төлгөч ирсэн учир, миний өвчин намжлаа хэмээн айлдав. Төлгөчийн харах цагт  
хаан уужирч амраад дув дуугүй болсон байв.

– Энэ нь муудаж доройтоод үхэж байгаа буюу хэмээн санаж, төлгөч айгаад шөнө дунд

– Дутааж очих газар байваас дутаая хэмээн бодов. Чингээд балинд хатгасан гахайн толгойг  
сугалан авч хааныг нойрсон амарч байх үед нойрсох байшингаас гарч яваад морины хашаанд  
хүрсэнд адуучин «Хүүе хаая» хэмээн хашхирав. Дутаах газар олдсонгүй. Хонины хашаанд  
очсонд хүмүүс урьд адил хашхирав. Бас тэр хавьд байгаа малын том хашаанд очиход мал энд  
тэнд тархай хэвтэцгээж, хаалганы дэргэд том цээжтэй хүрэн хайнаг хэвтэж байв. Тэнд  
саатаж болохгүй хэмээн бодож түүний сэрвээн дээрээс нь бариад мордохыг завдсанд тэр  
хайнаг гэнэт боссон учир, төлгөч өнхөрч унав. Төлгөч хашааны хажуунаас тэр хайнагийг хаа  
очсон газар хөөж занчив.

Хайнаг мэгдэн сандарч үүд нээгээд дутааж явав.

– Адгуус хаалга нээхийг мэддэг байжээ гээд түргэн харах гэж гараад хойноос нь элдэхэд  
хатан үүдийг нээж өгөөд хайнаг шат өөд авирч оров. Тэнд төлгөч нууцгай чагнасанд охин

– Юу болов? хэмээн асуусанд

– Илт мэдэгч тэр төлгөч намайг мэдэж эрж олж очоод сэрвээнээс зуурав. Дутааж чадахгүй  
байтал чулуугаар нүдэж алах шахав гэсэнд хатан айгаад

– Яавал сайн бэ? Бид хоёрыг тэр яаж үгүй хийх бол гэсэнд

– Одоо бид хоёр үхэхийн муугаар үхэх болно.

– Дутааваас сайнгүй юу? гэхэд

– Дутаагаад гэтэлж гарахын горьдлогогүй. Илт мэдэлт тэр арга ридитэй тул маргааш биднийг  
ингэж устгах нь бололтой. Маргааш наран ургахад албат ардуудад

– Хүн бүр нэжгээд багаж авч ир гээд түлээ авахуулахаар голын эхэн өөд явуулна. Над руу зааж

– Энэ мухар хайнагийг эмээллэгтүн гэнэ. Илт мэдэгч намайг унаж ташуураар занчиж голын  
эхэнд очиж түлээний ажил хийлгэнэ. Тэнхээ тасарч арай чарай уруудаж ирэхэд «Галын  
мандал үйлдэнэ» гээд гадна энэ хавьд түлээ зэрэглэж бид хоёрыг хүлж галын дотор хийнэ  
хэмээн өгүүлж бие биеэн тэврэн

– Бид хоёрыг мангасын хаан ийм юманд хүргэв гэлцэж хошуугаа нийлүүлэн уйлалдаж байв.

Чингэхэд төлгөч маш баярлаж, нойрсолгын байшин өөд буцаж очив. Хаан сайн унтаж  
амарсан тул дуу нь тод тунгалаг гарч байв. Төлгөч гүр рагша эрхиэр хааныг адислаад

– Хааны бие сайжирч байгаа юу? Юу болж байна? хэмээн асуусанд

– Лам ирснээс хойш дотор уужирч өвчний эвэршилгэ нугарч бие амсхийж сэргэлээ гэв. Тэр  
бясалгалыг үйлдэж байгаа маяг гаргаж суух цагт хатан сайн архийг дахин дахин согттол

барьж, ламын дэргэд нэгэнтээ мөргөж

– Хааны өвчин магад арилж сайн болох болов уу хэмээн айлтгасанд төлгөч

– Хааны өвчин бол асар их хүчтэй адын хорлолоос үүссэн байна. Гал мандлыг үйлдэх хэрэгтэй тул хайлах тос, нүнжиг тостой идээний зүйлийг бэлдэгтүн гэв. Тэр хатан хааны дэргэд очоод

– Урьд шөнө бие лагшин чинь аль хэр тунгалаг байв? гэсэнд

– Ламыг ирснээс хойш бузгай сайн болж байна. Ламын захиж айлтгасан хэрэглэлүүдийг түргэн бүтээгтүн хэмээн зарлиг захиа хайрлав. Чингэхэд хатан айгаад хаалгаар год харайн гарч одов.

Өглөө болж шадар түшмэд ба орны эрхэм настай хуучид

– Гахай төлгөч ирснээс хойш хааны бие лагшин тунгалаг болж буй болов уу? гээд бүгдээрээ тэнд цугларч шивнэлдэн ярьцгааж байв. Хаантай уулзуулж болох эсэх тухай айлтгалыг Шимбун (Нойрсолгын ноён)-аар уламжлав. Хаан

– Бие нэлээд сайжирч байна. Орж болох эсэхийг ламд айлтгагтун гэв. Ламын зарлиг

– Аднуудыг бясалгалаар эрхэндээ оруулсан тул хааны бие сайжирч тунгалаг болж байна. Тэд бүгдийг дотогш дуудагтун гээд бүгдийг дуудаж оруулсанд тэд нар баясаж ламд мөргөж, бас хаанд ч мөргөж бие лагшины мэндийг асууж айлтгав. Чингэхэд нойрсолгын өрөөний үүдийг хаагаад лам зарлиг захиаг хайрласан нь

– Хааны өвчнийг язгуураар нь арилгахыг хүсэх үү? гэсэнд

– Яавч хүснэ. Энэ хаан халиваас Номч хааны үндэс тасрах болно хэмээн айлтгав.

Чингэвэл танай хатан эртэйгээ хоёул хааны үндсийг таслахаар мангасын орноос томилогдон энд хүрч иржээ. Энэ хоёрыг галд түлвээс хааны үндэс үл тасрах бөгөөд хан төр ч дэлгэрэн мандах буй эа гэв. Лам хаанд

– Үүнийг түлж чадах уу? гэсэнд хаан зарлиг болруун

– Манай ах нарын эхнэр нь болж, бид ах дүү бүгд эхнэрээ болгож байсан тул үүнийг түлэхэд өрөвдөлтэй. Үүний эрийг түлвээс ялгаваргүй их үйл болно. Тэр эр нь хаана байгаа вэ? гэсэнд

– Эр нь энэ эмтэй ханилж байдаг мухар хайнаг тэр мөн. Миний үгийг сонсвоос хоёулыг түлэх хэрэгтэй гэсэнд түшмэд босоод

– Лам илт мэдлийг эрхшээсэн тул ламын юу айлтгаснаар болгож хоёулыг шатааваас сайн. Тэр хоёр ирээд хааны үндэс угсаанд тотгор хийсэн тул бид ламын зарлигийн ёсоор бүтээвээс зохино гэв.

Хаан ч ламын зарлигийг зөрчихгүй учир ламын өлмийд сөгдөв. Тэдний тухай гадагш үл ярихыг андгайлав.

Харьяат албат нөхөр зарц нар, ачаа зэргийг авч голын эхэнд галын мандал үйлдэх мод бэлтгэхээр очив. Лам ч «Явья» хэмээн

– Мухар хайнагийг эмээллэгтүн хэмээн айлдаж гахайн толгойг ишлэн барьж түр рагша эрхийг мухар хайнагийн сэрвээ руу унжуулж мордоод голын эхэн өөд явав. Зарц, цэргийн хамт, мод огтолж байхад

– Та нар ядарч зүдэрч байгаа буй за. Мухар хайнагийн эмээлийг хуулж ав. Түүнд сүх өгөөд мод огтлуул. Тэр урьд үүд нээж шат өөд авирч байсан тул мод огтолж чадна хэмээн айлдав. Сүхийг гарт нь бариулж мод огтлуулсанд хүн бүхэн итгэмжилж модыг унагаалгаад бүгдийг мухар хайнагт ачиж хааны харшид хүргэв.

Төлгөч түшмэд албатуудад зарлиг буулгаж, моднуудыг дөрвөлжин зэргэцүүлээд төлгөч хааны дэргэд очиход хатан амиа арчлахыг бодож хааны дэргэд очсон байв.

– Тэнд би, тэдний дүрсийг түлэх зуухыг бэлхэн болгов. Та түшмэд, хатад тос нүнжигтэй

идээний зүйлийг цуглуулж гүйцсэн буй за. Одоо түргэн авч ирэгтүн гэсэнд тэр хатан хүү санд очиж нүнжиг тос идээний зүйлийг үүрч авч ирэв. Хаан, төлгөчид

– Ялах арга ба сахиулсныг үйлдвээс хатан минь амьд үлдэж чадах болов уу? гэсэнд

– Гаднын Ядам сахиулсуудын зоог болох хэргийг эмийн эрээр үйлдсэн юм. Урьдын хаадыг ч хатан идсэн болой. Би ирсэнгүй бол чамайг ч идэх л байсан. Хаан чи өөрөө байшин дээрээс болгоож байгтун гээд тэндээс төлгөч морилов. Тэр цэргийн хүмүүсийн дундаас аль их хүчтэнээр

– Энэ хоёрыг хүлэгтүн гэсэнд тэр хоёрыг маханд нь шигдтэл хүлгээр чанга хүлэв.

– Мангасын орноо байдаг жинхэнэ өөрийн дүрсийг гаргах уу, үгүй юу? хэмээн өгүүлж толгой бөгсгүй тогшуураар нүдэж занчсанд хатан

Ичгүүртэй боловч өөрийн дүрсийг үзүүлвээс зохистой бөгөөд зовлонгийн түргэн нь дээр гээд тэр, гадас адил соёотой хоёр толгойтой мангас болсонд түүнийг хүлэв. Хүлмэгц тэр хатан, гадас адил соёогоо ярзайсан, хөхөө мөрөн дээрээ хаясан эм мангас болов. Тэр мангасыг галд хийсэнд эм мангас

– Мангасын хаан бид хоёрыг энэ мэтийн зовлонд хүргэв хэмээн маш их гашуудан цурхирав. Их бархирсан ба өөрийн дүрсийг үзүүлсэн тул хаан итгэмжлэв. Түшмэд, албат ч цөм итгэмжлэв. Нүнжиг тоснуудыг түүний толгой руу цуггасан учир, агшин зуур түлэгдэв. Тэр ламыг дотогш нь залж хаан түшмэд ламыг бурхан хэмээн үзэж мөргөөд

– Ламд нэг өргөл өргөхийг таалалдаа анхаарах болов уу хэмээн айлтгасанд

– Аяа хаантан минь. Бэлтгэж чадах уу? Надад хэрэглэгдэх юм маш олон буй гэсэнд

– Лам танаас өөр ач ихтэй нь үгүй тул манай албатад буй буюу санд байх аваас өргөнө гэв. Төлгөч ийн айлдав.

– Надад арван хоёр оосор, арван гурван шөрх хэрэгтэй тул бэлтгэж чадах болов уу? гэв. Хаан

– Тийм юм хялбар гээд хүлэг дээс шөрхүүдийг өргөж хэвнэг дээл, малгай тэргүүтэн ба их том нөмрөг, бас хэрэгсэл, зааны ачаануудыг өргөв. Хааяа хааяа урин залж, насны авшиг тэргүүтнийг айлтгаж байх соёрхлыг гуйв. Чингээд лам бэлгээ аваад морилоход хаан түшмэд гурав дөрвөн бээрийн газарт хүртэл үдэж гаргав.

Чингээд төлгөч эхнэрийнхээ дэргэд очсонд тэр эхнэр мөргөж угтаад

– Хааны лагшин тунгалаг болов уу? гэсэнд

Хааны лагшин тунгалаг болсон. Чиний хэргийг бүтээсэн гэв. Тэнд хүрч ирсэн шөнө хүмүүсийг

– Түр хүлээж байгтун гээд эхнэр түшмэдэд сургаж захисан нь

– Одоо энэ хүлгүүдийг ёгт бэлэгт хэрэглэн авсан байна. Арван хоёр хүлэг нь хааны үндэс арван хоёр үе болтол дэлгэрэн мандахын бэлгэдэл, арван гурван шөрх нь таны хамт арван гурав байгаагийн шинж мөн. Хааны бие амины тотгорыг арилгасны их өглөг юу хайрлахаа хаан өөрөө мэдтүгэй гэсэн айлтгал бичгийг хамт ирсэн хүмүүсээр өргүүлэв. Тэр хүмүүс буцаж очоод хаанд ламын зарлигийн бичгийг өргөсөнд хаан түшмэд бүгдээр түүнийг зөвшөөрч чандмань эрдэнээр толгойлуулсан алт, мөнгө, зэс, төмөр, морь, заан үхэр тэргүүтэн ба нутаг, хувцас торго лугаа сэлтийг өргөв. Чингээд хаан, улс орноо урьдаас илүү өрнөн дэлгэрүүлж номчлон тэтгэх болов. Төлгөч ч урьдаас мэдлэг нь агуу их болж номын суурь төгөлдөр болжээ гэсэнд хаан,

– Энэ хүн буянтан болсон ба эхнэр нь түүнийг өөд татсан байна хэмээн үг алдсанд

Хүүрт үг хэлэв хэмээн төмөр торыг гал бадартал гурав дэлдэж, харцага мэт хүр хэмээн хүүр алдуурав. Бас хааны бодолд Миний лам захихдаа: «Хүүрт үг бүү хэлэгтүн гэсэн бөгөөтөл түүний олон ярианд сэтгэл алгасаж үг алдав. Хүүргүй очвоос зэмлэл ирнэ» хэмээн санаж,

бас тэр хүүрийн газар өөд буцаж одов. «Хала» гэсэн хүүрүүдийг тогшуураар дэлдэж, «Хүлү» гэсэн хүүрүүдийг алхаж гишгэсээр тэр модны дэргэд хүрэв. Хүндэт гахай төлгөч хааны амь биеийг зольж, үндсийг таслахад хүргэсэн эр, эм хоёр мангасыг номхтгосны арван долдугаар бүлэг болой.



## БУЯНТ ОХИН ТӨРСНИЙ БҮЛЭГ ОРШВОЙ

Хан хөвгүүн хутгаар тэр модыг цавчиж

– Лам минь Наганжуна Зүрхэн мөн. Би өөрөө Сайн амгалан явдалт хаан мөн. Тор минь есөн нүхт төмөр мөн. Тогшуур минь хүрэн сэндэн мод мөн. Хүлэг минь мэхт гинж мөн. Хутга минь чулуу огтлогч иртэй мөн. Тостой гурил минь барагдашгүй идээ мөн. Хүүр чи буухгүй буюу? Модыг чинь унагалаа гэсэнд тэр хүүр бууж ирэв. Түүнийг тогшуураар дэлдэж торны дотор чихэж, хүлгээр хүлж үүрээд явав. Долоо, найман алхам явтал хүүр

Хан хөвгүүн. Хан хөвгүүн. Эс бөгөөс та нэг үлгэрийг яригтун. Эс бөгөөс би нэг үлгэрийг ярья. Сонсогтун гээд ийн өгүүлрүүн:

Нэгэн их голын хаан хатан хоёр нас хөгшрөхөд хамаг албат ард

Манай хаан хатан хоёроос хөвгүүн охин хоёрын нэг эс төрвөөс хааны үндэс тасрах болно хэмээн сэтгэцгээж байв. Нэгэн үе болоход хөвгүүн тогтоод есөн сар гүйцээд арван сарын нүүр үзэж гурван бүтэн хоног, үдийн хагас дөрөв тав мөч болохын үед цэцгийн хур бууж, муу санаатай хүн сайн санаатай болсон зэрэг шинж тэмдэг үзэгдэхүй лүгээ номын хан хөвгүүн мэндлэв.

Тэр хан хөвгүүн мэндлээд найман нас хүрэхэд хаан эцэг хатан эх хоёр нь хальж одов.

Чингэхэд тэр найман настай хан хөвгүүн хаан ширээнд суужээ.

Өөр газарт байсан нэг их хаан түүний эх эцэг хальсан ба бяцхан хан хөвгүүнээс өөр эзэнгүй хэмээн сонсож гурван буман цэрэг татаж хааны нутгийг булааж авахаар ирэв. Гэвч хан хөвгүүний их буянаар тэр голд урьд үзэгдээгүй их ус урсав. Цэргүүд тэр усыг туулж гатлая хэмээн санаж захад ортол усны урсгал улам хүчтэй болж нэг буман цэрэг ба хошуунд нь хутган хүрд зүүлттэй их заан ч усанд автагдав. Урьд энэ голд, усгүй байсан тухайг хаанд айлтгасанд

– Энэ хан хөвгүүн их буянтай байна. Бид огт дийлэхгүй бололтой гэхэд бүгд нийтээр сэжиг төрж буцав.

Тэр голын адагт эх охин хоёр суудаг ажгуу. Байгаа юм нь ганц суулга будаа бөгөөд түүнийгээ – Хаврын урт Жо Жо гэдэг ирнэ. Тэр үед иднэ гэж эх нь хэлдэг байв. Хожим нэгэн үед ээж нь түлээ түүх гэж явсны хойгуур тэр үед ертөнцөд заларч байсан орчлонг эвдэгч хэмээх бурхан Зоонаг нэртэй хотод бигвад идээнд ажрахдаа эх охин хоёрын гэрийн үүдэнд хүрч ирээд эхийг нь бэлгэ билгийн дагина мөн хэмээн үзээд

– Охин оо. Одоохон гэртээ дэвсгэр засагтун хэмээн айлдаад, номт дэвсгэр ба бадар аяга, дулдуйгаа бариад залран суув. Охин бурханд

– Эх бид хоёр өдөр эрж олсныг шөнө иддэг бөгөөд дэвсгэр бэлтгэвч зооглуулах юм байхгүй хэмээн айлтган өчсөнд бурхан

Ганц суулга будаагаа чанаж өг гэсэнд

– Ээж хаврын урт Жо Жо-г ирэхээр идэх хэрэгтэй гэж байсан хэмээн өчсөнд

Хаврын урт Жо Жо гэдэг нь би мөн. Тэр будаагаа чанаж өгөгтүн хэмээн айлдав. Тэр охин, үрийг цэвэрлэж сайн чийглэж дэвтээгээд жигнэж болгосонд өнгө нь цайж, идэхэд дээдийн амт төгөлдөр болов. Бурханд

Цадталаа зооглогтун хэмээн айлтгаж, охин өөрөө идэв. Гэвч будаа нь хорохгүй байв. Чингээд бурхан морилохдоо охинд

– Эх чинь ирээд зэмлэх аваас тэр цагаан замаар ороод, тэр давааны ард байгаа хийдэд оч хэмээн айлдаад залрав. Түүний дараа ээж нь хүрч ирээд

– Охин оо, үүдээ нээ гээд дотогш орж  
– Охин минь гал түлсэн үү? гэв. Охин  
– Таны төлдрийн ярьж байсан хаврын өдрийн урт Жо Жо ирсэн. Цагаан будаа чанаж түүнд өгөөд ээждээ цадаж хүрэх хувь үлдээсэн гэв.  
Ээж нь охиныг савж  
– Гуйранч эм минь, хаврын өдрийн урт Жо Жо гэдэг чинь нэг хүн ирнэ гэсэн үг бус. Хаврын сар өдөр урт болно. Тэр цагт идэх хэрэгтэй байсан юм. Чи гарч зайл гээд хөөж гаргав. Охин өчигдрийн тойны зааж өгсөн цагаан замаар ороод явж очив. Тэртээ хадны завсарт байгаа нүх рүү тавьсан урт шат өөд авирч очоод  
«Жо Жо оо» хэмээн дуудсанд, нэг сайхан хөвгүүн гарч ирээд «Ээ» хэмээн дуугарав.  
– Жо Жо минь, өчигдрийн тэр охин чинь байна. Ивээж авагтун гэсэнд нүхний аман дээр нэг тахиа гарч ирээд  
– Охин оо, өөдөө очтугай гэв. Охин өөдөө авирч орсонд тэнд бурхан заларч байв. Охин мөргөж адистадыг айлтгасанд  
– Ээж чинь чамайг зэмлэв үү хэмээн айлдав.  
– Зэмлэхээр барахгүй, гөвшин хөөж гаргалаа гэв.  
Чиний ээж чамайг донгодож хөөсөн учраас хоёр хоногоос гутаж зовох болно. Бас урт наслахгүй. Охин чи энд суугаад миний хоол хийж өгч байгтун. Их бага ямар ч хоол хийснээ энэ хөвгүүн ба тахиа та гурвуул ав адил хувааж идэж байтугай хэмээн айлдав. Чингээд охин гэрт сууж хоол хийж, бурханд өргөж, бас нөгөө хоёрт өөртэйгөө адилхан хувааж өгөв. Охинд Дар эхийн авшиг эш тэргүүтнийг хайрлаад бясалгалд суулгав.  
Нэгэн үе болоход үдээс өмнө хоол болгож барихад тулга хөдөлж болсон нэгэн үр гарахад түүнийг охин аваад идчихэв. Тахиа, хөвгүүн хоёр ирээд  
– Эгч юу идсэн бэ? гэсэнд  
– Би юу ч идээгүй гэхэд тэр хоёр үг хэл гарган маргаж, болсон ганц үр гарсныг бид хоёрт өгөлцөлгүй эгч ганцаараа иджээ гээд тэр хоёр галыг унтраав. Чингэхэд охин Бурханд айлтгаваас зэмлэл ирнэ хэмээн сэтгэж гал гуйхаар одож тэр тэндээс эргэн тойронд ажиглаваас хааны түшмэлийн нэг хот харагдав. Тэндээс гал гуйхаар явав. Тэнд үдээс урьд цас оржээ. Охин гал аваад буцаж харив. Охины гишгэсэн мөрт лянхуа цэцэг илхэн гарав. Түшмэл морио барихаар явахдаа тэр цэцэгт мөрийг үзээд шадар хүмүүсээсээ  
– Өнөө өглөө манай гэрийн үүдэнд гаднаас хэн ирэв? гэсэнд сахиулч авгай  
– Тэр хадны нүхэнд урьд хүн суудаггүй сан. Лам гал гуйлгаж явуулав гэсээр нэг охин тэндээс саяхан ирээд буцсан. Өөр хэн ч ирсэнгүй хэмээн өчив. Тэр түшмэл их хааны ордонд хүрч хаанд мөргөж хүндлээд  
Манай өмнө зүгт байгаа тэр уулнаа урьд цагт хоёр гурван сайн бүтээлч сууж байсан бөлгөө. Түүнээс хойш хэн ч байгаагүй билээ. Харин энэ өглөө морио эмээллэж гадагш явах гэтэл хүний хөлийн мөрийг дагаж ургасан лянхуа цэцэг харагдав. Түүнийг өөрийн хүмүүсээс сураглаваас  
– Лам гал гуйлгаж илгээв хэмээн нэг охин ирсэн гэж хэлж байна. Гишгэсэн мөрт лянхуа цэцэг ургасан учир бурхан дагина ба гурван цагийн бурхан болохоос өөр гарцаагүй. Би урьд шөнө сайхан зүүд зүүдэлсэн. Энэ голын эхэнд цаст уул тогтож, цасан дээр арслан цухуйж байхыг зүүдлэв. Арсланы оюу зогдор дэлгэрэн цаст уулын бэлээр далай эргэлдэж байхыг зүүдлэв. Номч хаан танд билгийн дагина хатан болох буй за хэмээн өчив. Бусад түшмэл ч мөргөж  
– Бид ч бас сайхан зүүд зүүдлэв гэв. Тэр түшмэл бусад түшмэлтэй зөвлөлдөж

– Одоо манай энэ хаан хатан таалах насанд хүрсэн учир тэр охин байваас хатан болгоё гэлцээд тэр түшмэлтэй хамт явах гурван түшмэлийг томилж, охины байгаа эсэхийг мэдэхээр илгээв.

Тэр охин гал гуйж авчраад хоол болгож гүйцмэгц бурханд зоог барив.

– Охин оо, өнөөдөр яагаад хоол хожимдов гэсэнд

Энэ өдрийн хоол хожимдуулсан нь тэр хоёр гал унтрааснаас болов гэсэнд

Тэр хоёрыг дуудтугай гэв. Тэр хоёр ирсэнд

– Та хоёр энэ өдөр охины галыг яагаад унтраав хэмээн айлдсанд тэр хоёр

Болсон идээг бид хоёрт өгөлцөлгүй, тэр өөрөө идсэн учраас болов? хэмээн өчив. Бурхан

– Бурхан байгаа газарт сууж болох байсан боловч охинд саад ирсэн байна. Одоо охин чамайг

тэр их хаанд өгөх хэрэгтэй болов. Их хаан охин та хоёр энэ галавыг юүлэх хүртэл амьтныг

тусалсаар байж чадах болно хэмээн айлдав. Хэсэгхэн зуур өнгөрөхөд түшмэд хадны нүхний

аман дээр хүрч ирээд ламаас соёрхол гуйсанд бурхан соёрхол хайрлав. Түшмэл

– Танай энд нэг охин буй гэнэ. Тэр охиныг хааны хатан болгон соёрхох хэрэгтэй байна гэсэнд

лам

Энд буй хэмээн хэн хэлэв. Аглаг газар сууж буй даяанчид охин хаанаас ирэх вэ гэсэнд

Охин буйг манай хаалгач хэлсэн билээ. Тэр охин гал гуйхаар очсон юм. Түүний гишгэсэн

мөрөөр лянхуа цэцэг ургасан тул энд буй хэмээн мэдэв. Охиныг хаанд өргөвөөс зохино

хэмээн өчив. Чингэхэд лам түшмэдийг дотогш дуудаж

Хэлээ тосогтун хэмээн айлдаж хэлэн дээр нь нэжгээд дусал шүлс өгсөнд түүнийг амсваас

тэнгэрийн рашаан мэт дээдийн зуун амт төгөлдөр учраас долоо хоног хүртэл идээ идэх

хэрэггүй болов. Чингээд

– Маргааш өглөө та дөрвүүл хаантайгаа ирж угтаж авагтун хэмээн айлдав. Түшмэл ламд

– Охиныг угтахын тулд хаан нааш ингэж морилж ирэх хэрэгтэй юу? гэв.

– Охин хэрэгтэй бол тэр өөрөө ирж автугай хэмээн айлдав. Чингэхэд түшмэд хааны өмнө

хүрч

– Тэр охиныг лам соёрхох болов гэж өчив. Охиныг үзэв үү гэхэд

– Охиныг үзээгүй. Охиныг угтаж авахад хаан өөрөө морилох хэрэгтэй байна хэмээн айлтгав.

– Харьяат нутгийн хүн ирэхэд эзэн нь угтахаар явж үл болно хэмээн айлдсанд

– Хаан өөрөө эс очвоос охиныг эс соёрхох ажгуу хэмээн өчсөнд тэр хаан түшмэд цөм явахаар

бэлтгэв. Хаан даяанчийн охинд зүүх чимэг, өмсөх хувцас байгаа эсэхийг үл мэдэх тул авч явах

хэрэгтэй гэж бодоод тэд нарт өгүүлсэнд

– Өчигдөр бид ламын дэргэд очиход бидний хэлэн дээр дусааж өгсөн нэжгээд дусал шүлс нь

дээд зуун амт төгөлдөр учир бид өдгөө ч идээ идэх хэрэггүй байна. Тэр лам эгэл хүн бус

чимэг хэрэглэл магадтай буй за хэмээн айлтгав.

Чингээд хаан урьдын агуйтай хад өөд морилж очив. Хаан түшмэд цөм ламын гадна очиход

хоёр тойн хадны агуйн үүдэнд гарч угтав. Мянган хигээс төгөлдөр биндэрьяа ширээн дээр

номт дэвсгэр дэвсэж ламыг залжээ. Хаанд алтан ширээ, охинд оюу ширээ тус тус засжээ.

Охины зүүсэн чимэг, өмссөн хувцас сэтгэшгүй гоё байв. Охин босож хааныг угтаж үүдэнд

гарав. Урьд насны хаягдлын эрхээр бие биеэ үзээд эх хүү хоёр учирсан мэт болж бие биеийн

гараас барилцан дотогш морилов. Чингээд хаан ламд мөргөөд, алтан ширээнд заларч охин

оюу ширээнд суув. Хоёр тойн хаан түшмэд, зарц нарт өргөл хүндлэлийг бүрэн төгс үйлдэв.

Лам тэр хоёрт цэцэг цацаж

– Цөвийн цагт амьтанд туслах болтугай хэмээн айлдаж тэр охиныг хаанд соёрхов. Лам охинд

— Чи гэнэдэж нэг удаа үг алдана. Тэр цагт энд ирж зөвшигтүн Нэг жил болтол би сууж байна

хэмээн айлдав. Чингээд хаан хатан нар ордондоо харьцгаав. Хаан хатан хоёр бие биедээ туслан дэмжсэн тул урьд цэргээр довтолж байсан хаан ч харьяат болов.

Нэгэн үе болоход тэр хатан нэг зарцыг дагуулаад харшийн хэрмийг тойрон морилж явав.

Чингэхэд харшийн хаалган дээр хөгшин ээж нь баруун гартаа хуниастай тулам барьж, зүүн гартаа таяг бариад явж байв. Зарцдаа

– Чи урьдаар харьж бай. Би тэр эмгэнийг хаанаас ирснийг асууж ирье хэмээн ээжийн дэргэд очсонд гоё ганган, царай зүс сайхантай тэр охиныг ээж нь эс таньж мөргөв. Охин

– Ээж минь би байна шүү хэмээн хэлээд толгойноос нь өргөж өндийлгөсөнд

– Эвий минь. Миний охин хаанаас ирэх вэ? Ганц суулга үрийн төлөө зэмлэсэн учир гомдоод алга болсон билээ гэв. Охин урьд болсон учир явдлыг ээждээ ярьсанд ээж нь сая танив.

Чингээд ээж охин хоёр ханилаад харш дотуур өөдөө явав. Охин нь нойрсолгын бяцхан байшинд ээжээ дагуулж ороод ээждээ чимэг гутал хувцсыг өгч хоол ундаар хангаж жаргалтай байлгав. Охин хаанаас сэтгэл зовж ичээд ээж буй хэмээн эс айлтгажээ.

Нэгэн үе болоход, тэр ээж нь шатан дээрээс өнхөрч нугас нь тасарч үхэв. Тэр охин Урьд амьд байхад нь хаанд айлтгасан бол сайн байжээ. Одоо хэрхвээс сайн болох вэ? хэмээн сандран мэгдэж нойрсолгын байшингийн буланд байгаа бурхан шүтээнийг түшүүлж тавиад, зэгсэн хөшгөөр халхалж өдөр шөнө тасралтгүй зул өргөж Дар эхэд залбирсанд ээжийн хүүрээс нэг сайхан оюу хумх гарав. Хумхны дотроос үлэмж сайхан Дар эх гарав.

Нэгэн үед хаан охинд

Охин чи үдэш бүр тосон зул авч явдаг байна. Чамд байгаа Ядам бурхныг чинь очиж үзье гээд охины унтах өрөөнд орж оюу хумхыг үзэж охинд

– Чамд энэ хумхыг хэн өгсөн бэ? Урьд ирэхэд байгаагүй хэмээн айлдахад охин сандран босож Ээж өгсөн хэмээн өчив.

Охин чиний ээж эд юм ихтэй байна. Очиж уулзья. Явахын бэлтгэлийг хийгтүн хэмээн айлдав.

Охин маргааш өглөө хаанд мөргөж

– Би ээжийг бэлтгэж бай гэж хэлэхийн тулд одоо явья хэмээн одож ламын дэргэд очоод ийн өчрүүн

– Ээжийг хаалган дээр байхад нь дотогш оруулж байлгасанд, ээж үхээд, түүний яснаас нэг оюу хумх гарав. Хаан оюу хумхыг үзэж

Үүнийг хэн өгсөн бэ? хэмээн асуухад би

– Ээж өгсөн хэмээн үг алдсан тул

– Чиний ээж эд юм ихтэй байна. Очиж уулзья хэмээн айлдав. Энд ирсэн шалтгаан минь хэрхвээс сайн болохыг зөвшин лавлах гэж ирсэн юм хэмээн айлтгав.

– Чамд ноднин хэрэггүй байсан юм хэрэгтэй болох цаг байна. Би нэг жил хүлээнэ гэж хэлсэн тэр ёсоор болж буй. Маргааш чи хаан, түшмэл, зарц нарыг морилж ирнэ үү гэж уригтун.

Давааны цаад талд их ордон харштай хот буй. Тэнд нүдэнд дулаахан нэг эмгэн бий. «Охин хүрч ирэв үү» гэнэ. «Хүрч ирлээ» гээрэй. Оюу ээмэгтэй нэг залуу буй. «Охин ирэв үү» гэнэ. «Ирлээ» гээрэй. Албат зарц нөхөд бүгд мөргөх гэж ирнэ. «Та бүхний бие амгалан сайн уу?» гээрэй. Түүний дараа өргөл хүндлэл, хотол чуулган бүрдэнэ. Тэд бүгдээрээ тус болно. Хожим болтол ээжээ дурсалгүй энэ шил архийг аваачаад хадгалагтун. Даваан дээр очоод энэ хийд рүү эргэж нэг удаа харагтун хэмээн айлдав.

Чингэхэд охин хааныг гэртээ морилж ирэх заллага айлтгав. Хаан албат нөхдийн хамт морилон очив. Тэнд хүрэхэд нүдэнд дулаан нэг эмгэн гарч ирээд

Охин хүрээд ирэв үү? гэв.

– Хүрч ирлээ. Ээжийн бие амгалан сайн байна уу? гэв. Бас оюу ээмэгтэй нэг залуу ирээд

– Охин ирэв үү? гэв.

Ирсэн. Таны бие мэнд сайн уу? гэв. Албат нөхөд зарц нар

– Хатан морилж ирэв үү хэмээн мөргөсөнд

Би ирлээ. Та нар мэнд амгалан байна уу? гэв. Тэд нар хаанд алт мөнгөн суулга тэргүүтнийг өргөв. Охинд бас алт мөнгө өдий төдийг өргөв. Түшмэдэд ч шилдэг сайн бэлгүүдийг өгөв.

Чингээд хаан хатан, харшид буцах замдаа хийдийг үзээд охин нэг удаа эргэж харсанд агуйн тэр чигт огторгуйгаас цагаан туяа цайрч хойноос нь нэг дагина торго эвхэж хумьсаар огторгуйд дэгдэн одов. Хаан хатан, түшмэд албат сэлт харшдаа ирэв. Тэр шил архийг хадгалсны эрдмээр нэг хөвгүүн мэндлэв. Хан төрийг номын ёсоор тэтгэж албатууд ч агуу их өрнөн дэлгэрэв хэмээн өгүүлсэнд хан хөвгүүн

– Тэр охин ганц суулга будааг бурханд өргөснөөр тэр охины буян заяа дэлгэрсэн ажгуу хэмээн үг алдсанд

– Хүүрт үг хэлэв хэмээн төмөр торыг гал манасхийтэл гурав дэлдээд харцага нисэх адил хүр гээд араас алдуурав.

«Миний лам захихдаа хүүрт үг бүү хэлэгтүн гэсэн бөлгөө. Түүний олон үг ярианд сэтгэл минь алгасан гэнэдэж үг алдав. Одоо хүүргүй очвоос зэмлэгдэнэ» хэмээн сэтгээд буцаж хүүрийн газарт хүрч очив. «Хала» гэсэн хүүрийг тогшуураар дэлдэж «Хүлү» гэсэн хүүрийг алхаж гишгэлсээр модны дэргэд очив. Буянт охин төрсний арван наймдугаар бүлэг болой.

## ЗҮҮДЭЭРЭЭ ХООЛ ОЛДОГ ЗҮҮДЛЭГЧИЙН БҮЛЭГ ОРШВОЙ

Бас хутгаа гаргаж модыг цавчив.

Лам минь Наганжуна Зүрхэн мөн. Би өөрөө хан хөвгүүн Сайн амгалан явдалт мөн. Тогшуур минь хүрэн сэндэн мод мөн. Тор минь есөн нүхт төмөр мөн. Хүлэг минь мэхт гинж мөн. Тостой гурил минь барагдашгүй идээ мөн. Үхдэл хүүр чи буухгүй буюу? Модыг чинь тас огтолно гэсэнд тэр хүүр бууж ирэв. Түүнийг тогшуураар нэг дэлдэж, торны дотор чихэж, хүлгээр хүлж үүрээд арав алхтал

– Хан хөвгүүн ээ, Эсбөгөөс хан хөвгүүн чи нэгэн хууль яригтун, эсбөгөөс би нэг хууль ярья гэхэд хан хөвгүүн огт дуугарсангүй тул

Үйлээ барсан чиний мэтийн хан хөвгүүний амнаас үг эс гарах ажгуу. Хүүр би хулганын хумс төдийхөн нэг үлгэрийг ярья. Сонсогтун.

Нэгэн их голд нэг их хаан байжээ. Түүний албатад зүүд сайн шинжиж мэддэг нэг хүн байв. Тэр нь гагцхүү ээжтэйгээ байдаг бөлгөө. Юу зүүдэлсэн бүхнийг хаанд айлтгадаг, хаан хоол хувцсыг өгдөг байжээ. Чингээд нэгэн үе болоход дуг нойрон дундаа «Ха» хэмээн инээд алджээ. Түүнд ээж нь

– Чамд нэгэн зүүд зүүдлэгдсэн ажгуу. Надад хэлэгтүн гэв. Тэр

– Надад өөр юм зүүдлэгдсэн бус. Бөөс бөөсөө унаад явж байна гэж зүүдлээд инээд алдсан гэв.

– Чи зүүдээ надаас нууж байна. Би явж хаанд айлтгана гээд тэр хоёр хааны дэргэд очив.

– Энэ надад зүүдээ хэлэхгүй байна. Нэг сайн зүүд зүүдэлсэн буй за. Түүнийгээ хэлэгтүн гэсэнд тэр

Миний зүүдэнд бөөс биеэ унаж яваа үзэгдсэн тул инээд алдсан билээ. Түүнээс өөр юм зүүдлээгүй хэмээн өчив. Энэ гуйранч худал хэлж байна гээд түүнийг өтөт зооринд хийлгэв.

Нэгэн үе болоход түүний байгаа зоорины амсар дээр эр эм хоёр хэрээ ирээд эр нь

– Эмгэн ээ, энэ оронд хүнгүй бололтой гэв. Эм хэрээ

– Өвгөн өө, энэ оронд хүн байхгүй байна. Аар саар юм хэлж өгвөөс зоорин дахь энэ хүнд тус болох тул яригтун гэхэд эр нь

Зоорин доторх энэ хүн бусдаар дамжуулж хаанд би зүүдэлснээ эрэхээр явья хэмээн айлтгуулж, хааны мутарт буй саран гэрлийн шидэт гинжтэй наран гэрлийн шидэт цалмыг гуйж аваад эндээс алс тэртээ одвоос нэг их даваа бий. Тэр давааны чанад нэг их далай бий.

Тэр далайн захад хонины чинээ цагаан чулуу бий. Арван тавны үдэш тэр чулууны дэргэд цалмыг барьж сууваас зургаан бум зургаан түмэн тэнгэрийн охин ирнэ. Тэдний дунд хөх өнгийн хив торгон дээлтэй цавчуурын үзүүрийг чирсэн нэг охин ирж урьдаар угаалга үйлдэж цэвэрлээд дараа нь цэцэг, түүх бөлгөө. Цэцэг түүж толгойгоо бөхийсөөр ирэхэд нь цагаан чулууны завсраас тэр цалмыг охинд хаяж бариваас чиний зүүдэнд үзэгдсэн бүхэн бүтнэ гээд хоёр хэрээ нисэж одов.

Маргаашийн наран ургахад хааны охин тоглож наадсаар түүний байгаа зоорины амсар дээр хүрч ирэв.

Хааны охин оо хэмээн дуудсанд охин

– Зүүдээ отогч эртний тэр хүн мөн буй за. Та одоо хүртэл амьд буй буюу? гэсэнд

– Би одоо хүртэл амьд байна. Намайг зүүдээ эрж олохоор явья гэж гуйж байна гэж эцэг хаандаа айлтгаж тус хүргэнэ үү хэмээн айлтгалыг уламжлав. Тэр охин эцэг хааны дэргэд очоод

– Зүүдээр хоол олж идэгч манай эртний тэр хүн одоо үхээгүй бөгөөд зүүдээ эрэхээр явья

хэмээн гуйж айлтгал өргөж байна хэмээн өчсөнд хаан

– Тэр одоо амьд бол та хоёр түшмэл очиж түүнийг гаргагтун хэмээн айлдав. Хоёр түшмэл түргэн очиж зоорины аман дээрээс харахад тэр хүн өгийг идэж, арьсыг хуулж өмсөөд урьдаас сайн амьдарч, сайхан царайтай болоод байв. Түүнийг зоориноос гаргасанд хааны дэргэд хүрч гэхэлзэн гурав мөргөж бөхөлзөн гурав мөргөөд нурманд оруулсан уйтан бургас мэт гулзалзаж хошуугаа цорвойж тугалаа хөхүүлж буй үнээ тарианд тэмүүлэх адил гүлдийж – Аяа их хаан минь ээ. Саран гэрэлт гинжтэй, наран гэрэлт цалмаа надад түр хайрлана уу. Би зүүдээ эрэхээр явья хэмээн өчив.

Хаан цалам ба хагас сарын хүнс өгч, зүүдэлснийг эрэхийн тулд илгээв. Хүнс, цалмаа үүрч явсаар их даваа давсны чанад хүрэхэд их далай байв. Түүний захад буй хонин чинээ цагаан чулууны дэргэд сууж байв. Арван тавны саран алсад цухуйж ургах үеэр зургаан буман зургаан түмэн тэнгэрийн охин хүрч ирээд угаал үйлдэж, цэцэг түүж дуулж бүжиглэсээр огторгуй өөд нисэн одов. Түүний дараа лусын зургаан бум зургаан түмэн охин ирж бүжиг наадам үйлдэж, цэцэг түүж байв. Төлдрийн хэрээний хэлсэн ёсоор хөх торгон дээл өмссөн, цавчуурын үзүүрийг чирч яваа нэгэн охин ирэхэд цаламдаж бариад нааш татахад охин Чамд хэн эш үзүүлсэн бэ? гэхэд

– Намайг хааны зоорин дотор байх цагт эр эм хоёр хэрээ ирж надад эш үзүүлсэн гэв.

Чамд эш үзүүлсэн учир, намайг барьсан бариагүй хоёр ялгалгүй. Хатан намайг цэцэг түүгтүн хэмээн явуулсан болой. Тэр эр хэрээ бол их нигүүлсэгч бөгөөд эм хэрээ нь Дар эх мөн. Одоо би таныг үүрнэ. Нүдээ анигтун. Эндээс усны дунд доош ороход таван зүйлийн эрдэнээр бүтсэн лусын ордон бий. Түүний дотор алтан ширээн дээр лусын охин Соцоман гэгч сууж буй. Түүнд би мөргөж цэцэг өргөнө. Чингэхэд «Эгч яагаад ингэж удав» хэмээн надаас асууна. Энэ завсар надад нуугдаж очоод хатны нуруу өөд нэг сайн ёврогтун. Чингэхэд би «Надад хүн саад болов» хэмээн өгүүлнэ. Чингэтэл эгч хэмээн дуудаж «Би өвдлөө. Халаг хоохой гээд «Их ловон ламыг залж авчрагтун» гэх болно. «Шог шог» хэмээх нэрт эмгэн сахиулс ирнэ. Тэнд ловон морилж ирээд «Хум хум пад пад» хэмээн өгүүлнэ. Шог Шогийн хамрын нүхийг шаараар бөглөөд гүвшиж алагтун.

– Ийм чөтгөрийг би үл дийлнэ хэмээн ловон буцаж одох болно. Чингэхэд

– Их оюутныг залж авчрагтун гэнэ. Их оюутан Туулай хэмээх нэрт сахиулс ирнэ. Ловон хум хум пад пад хэмээн өгүүлнэ. Тэр туулай цээжээ гэхэлзүүлж, хамраа дахин дахин шуухитнуулна. Түүний хамрыг нясалж цохивоос үхнэ.

«Одоо ийм чөтгөрийг хэн ч дийлэхгүй» хэмээн өгүүлэн ловон дутаана. «Цэцэн эрдэнийг залж авчрагтун» гэнэ. Тэр эрдэнэ барс ирвэс нэрт сахиулс ирнэ. Бүү хөдлөгтүн. Хөдөлвөөс барсын идэш болно. Чингээд лам ширээг тавина.

Түүний дээр чи харайж гарагтун. Өрөөсөн нүдээ аньж өрөөсөн нүдээ харагтун. Өрөөсөн хөлөө бохирч, өрөөсөн хөлөө жийж суу. «Чи хаанаас яваа вэ? Нэр чинь хэн бэ? гэж асууна. Би Гаадан тэнгэрийн орноос ирсэн. Ганц нүдэт бэлгэ билгийн тэнгэр мөн хэмээн хэлэгтүн. Чингэхээр

Ганц нүдэт бэлгэ билгийн тэнгэр та юуны учир ирсэн бэ? Ямар хэрэгтэй буй? хэмээн асуух болно. «Надад лусын охин Сацоман хэрэгтэй» гээрэй. Тэнд гурав хоногт цэцэг ба зоогийн усыг өргөнө. Тэндээс харигтун. Эс хариваас өлсөж үхэх болно. Чингээд явья гэж хэлэхээр лусын охин Сацоманыг өгнө. Тэндээс хэрээний үзүүлсэн эш бүтнэ» хэмээн өгүүлэв.

Чингээд охин үүрч

– Нүдээ ань гэсэнд аниваас таван зүйлийн эрдэнээр бүтсэн уудам сайхан лусын ордонд хүрэв. Сацоман авхай алтан ширээн дээр сууж байв. Гайхам сайхан тунгалаг царайтай, зөв

талаас нь харваас гэхэлзэж буй мэт, буруу талаас нь харваас бөхөлзөж байгаа мэт, далайн ус адил мэлтэгнэсэн, солонго адил дурайсан сэрүүн сүүдэрт байлгаваас хөлдмөөр, бүлээн наранд байлгаваас хайлмаар нэгэн охин байв. Тэр охин

– Эгч замдаа яагаад удав хэмээн асуув.

Надад нэгэн саад тохиолдов хэмээн айлтгаж тэр охинд цэцэг өргөхийн завсар сүүдрийг дагаж нуугдаж ард нь очоод цээж рүү нь нэг сайн ёвров.

– Би өвдлөө. Халаг. Ламыг дуудаж авчрагтун гэв. Шог шог нэрт сахиулс ирж

– Цааш шог, нааш шог гэж байхад хамрыг хэсэг шаараар бөглөж нүдсэнд тэр сахиулс үхэв.

Лам

– Ийм чөтгөрийг би үл дийлнэ хэмээн өгүүлээд дутаав.

Чингэхэд

– Их ловонг залж авчрагтун гэв. Туулай хэмээх нэрт сахиулс нь «Хум хум пад пад» гэсээр ирэв. Туулайн хоншоорыг нясалж алсанд

– Ийм чөтгөрийг би үл дийлнэ гээд лам дутаав. Дараа нь Цэцэн эрдэнийг залж авчрав. Барс ирвэс хүрхрэх дууныг нижгэнүүлсээр ирэв. Түүнд нэг хайрцаг адил ширээ тавив. Чингэхэд зүүд эрэгч тэр ширээн дээр харайж гараад өрөөсөн нүдээ аньж, өрөөсөн нүдээ харсаар суун байхад

Чи хэн бэ? гэв.

Би Дээд тэнгэрийн орноос ирсэн бэлгэ билгийн ганц нүдэт тэнгэр мөн гэсэнд «Бэлгэ билгийн ганц нүдэт тэнгэр та юун тухай ирсэн бэ? Юу хэрэгтэй вэ?» гэв. Надад лусын охин Сацоман хэрэгтэй хэмээн өгүүлэв. Бэлгэ билгийн ганц нүдэт тэнгэр морилж ирсэн байна.

Охиноо яавч өгсүгэй хэмээн өгүүлэв. Түүнээс гурав хоногийг хүртэл зоогийн ус ба цэцгийг өргөв. Дөрөв дэх өдрийн өглөө наран ургахад

– Одоо би охиноо аваад явъя гзсэнд улаан бэлхэнцгээр оосортой ув улаан нохойг хөтөлж авчраад өргөв. Чингээд

– Гинжийг хөтөлж, нүдээ аньтугай хэмээн айлтгав. Нүдээ аньсанд далайн эрэг дээр гичийтэй хоёул гарсан байв. Чингээд хоол идэлгүй гурав хоног явсан тул гэдэс нь өлсөв.

– Лусын охин Сацоманыг авна гэсэн юмсан, энэ гичийгээр юу хийнэ хэмээн санаж тэндэх модноос нэг бургас хугалж аваад тэр гичийн бэлхүүсэн дундуур нэг ороолгов.

Лусын охин Сацоманыг авна гээд энэ гичийгээр юу хийх вэ хэмээн санааширч байтал тэр гичий «Аа» хэмээн гаслаад тэргүүлэн давхив. Чингэхэд түүний өмнө хадан дээр халуун хоол тавиастай байв. Гичий савраа долоосоор хэвтэж байв. Зүүдээ эрэгч тэр хоолыг идээд

– Энэ нохой сайн нохой байна. Энэ болгосон бэлхэн хоолыг идээгүй байна хэмээн бодов. Бас тэр гичийтэй хамт дорно зүг хэрэн одов. Чингэхэд үд хэвийх үед даваа өөд авирч гарсанд гэдэс нь өлсөв. Бас тэр гичийн бэлхүүсэн дундуур нэг ороолгов. Тэр гичий «Аа» хэмээн урагш бултаж одов. Маш сайхан их хоол чулуун дээр тавиастай байв. Гичий савраа долоосоор байв.

– Энэ гичийг бургасаар цохимогц идэх хоол ирдэг байна хэмээн санаж, тэр хоолыг идэж гүйцээд гэнэт босон харайхад гичий

– Чи бэлгэ билгийн ганц нүдэт тэнгэр хэмээн хэлэвч өлбөрч үхэх шахсан хүн байна. Хүний оронд надаас чи илүү номхтгууныг хэрэглэх буй за. Учир нь чи хүн шүү дээ. Чи жирийн хүмүүсийн дотроос өлсөхдөө тунирхдаг хүн байна. Чи босон харайвч хааш одох чиггүй байна. Чи энэ хоёр нохойг хөтлөөд явж тэртээ тэнд гөрөөс байгаа эсэхийг үзээд үдэш болоход энд буцаж иртүгэй хэмээн өгүүлээд хоёр нохой өгөв. Чингээд нохдыг дагуулж гөрөөс агнахаар явав. Чингэж байтал өдөр түргэн өнгөрч, оройхон болоход гичий байгаа тэр голд буцаж ирэв.



Түрүүхэнд байгаагүй нэг байшингийн дээврийг тавьж байв.

Өчигдөр юу ч үгүй байсан. Одоо юу буй болоод байна хэмээн санасаар хүрч ирэв. Нөгөө гичий нь сүүлээ сөхсөөр угтаж ирэв. Гэрийн дотор элдэв төхөөрөмж олон янзын юм дүүрэн байв. Болгосон халуун хоол уур нь савсаж, түүний дээр нэг хөл мах тавиастай байв. Түүнийг идээд бэлхэн байгаа ор дэвсгэр дээр унтав. Маргааш наран ургахын үеэр нохой дэрэн дээр нь ирж,

– Одоо босож хоолоо идэхийг айлтгая. Энэ өдөр бас авд морилвоос сайн хэмээн өгүүлэв. Босоход болгосон хоол, нэг хөл мах байв. Бас шар тостой гурил дээр хагас хөл мах тавьсан байв. Чанасан хоол шар тостой гурилыг үүрээд авд одов. —

Ингээд зүүд эрэгч явчихсан хүн болж хуураад, далд газар нуугдан сууж байхад тэр барилга нь улам өндөр болж гол байшин нь есөн давхар хүрч, хэрэмлэн тойрсон байшин ч гурван давхар баригдаж байв. Чингэхэд зүүд эрэгч нарнаас далдалж нэг эргэнд очив. Тэнд нэг шоргоолж ирээд

– Надаас өөр нарийхан бэлхүүстэй амьтан байдаггүй нь гайхалтай гэхэд олон хөлт өт

– Надаас илүү олон хөлтэй амьтан байхгүй нь гайхалтай гэв. Мэлхий өгүүллрүүн

– Надаас өөр өргөн магнайтай амьтан байхгүй гэв. Халиу өгүүллрүүн

– Том хумстан надаас өөр байхгүй нь гайхалтай гэлцсээр байв. Бас бус амьтан шороог даах чинээгээр авч хот барилцаж байв. Тэр гичий нохой арьсаа тайлж орхисон байв. Тэр хүн, их гал түлж тэр арьсыг галын дунд чулуудав. Нойрсолгын байшингийн оньсны нүхнээс бусдыг гүйцээсэн байжээ. Охин

– Тэр нохойн арьсыг устгалгүй хоёр хоног байлгасан аваас сайн байсан. Чи огцомхон учир уршиг болов хэмээн өгүүлэв. Одоо арга байхгүй буюу? гэсэнд

Арга ч маш өчүүхэн төдий байна гэв. Хүү сангийн дотор алт мөнгө, эд таваар, зэс төмөр тэргүүтэн дүүрэн байв. Гадна хашаанд адуу үхэр хайнаг тэргүүтэн мал дүүрэн, хэрмэн дотогш хоёр зуу илүү шагтай ажгуу.

Тэнд нэлээд удаж байтал дээр үед зүүд эрэгчийг хааны дэргэд байх үеийн таних хоньчин бэлчээрийн газрыг харсаар тэнд хүрч очив. Зүүд эрэгч охинд өгүүллрүүн

– Миний танил нөхөр ирсэн байна. Гэртээ урин оруулья гэв.

– Чи дэмий балай олон үг чалчихгүй аваас дуудаж оруулж болно гэв. Охины бүх гэрлийг хаалганы эгнээнд далдлав. Охин нь бяцхан хар биетэй охин болон хувилаад сууж байв. Зүүд эрэгч хоньчны дэргэд очиж

– Манайд орох буюу гэхэд

– Оо сайн болой. Чи эдний зарц буюу гэсэнд

– Би эндхийн эзэн нь мөн. Миний эхнэр бол үлгэрлэшгүй сайхан лусын охин болой гэж үг алдав. Чингээд гэртээ оруулж цай хоолоор зочлон гүйцэтгэв.

– Чиний эхнэр Ман нэрт тэр чинь хаа байна? гэсэнд «Чи түр хүлээгтүн» гээд хэсэг зуурт гүйж очиж хаалганы эгнээг нээхэд эгнэгийн гэрэл охинд тусаж, охины гэрэл харш дотор түгж бүх юм эрээнтэн мэлмэрч илхэн торойж байв. Хоньчин

– Амттайхан хоол байна даа хэмээн өгүүлээд буцаж хоньдоо бужигнатал элдээд хааны дэргэд хүрч очив. Чингэхэд хааны түшмэд түүнийг

– Юу гэж яваа вэ? гэж асуухад

Үгийн хариу өгнө гээд хааны өмнө шулуухан хүрч хаанд мөргөн

Манай эндээс дээр үед зүүдээ эрэхээр явсан тэр хүн, тусгай нэг газар эзлээд төмөр хайрцаг адил нэг хот барин сууж, лусын үлэмж сайхан нэг охиныг эхнэр болгон аваад сууж байна хэмээн айлтгасанд хаан

– Тэр гуйранчид би цалмаа өгч зүүдээ эртүгэй хэмээн илгээсэн юм. Маргааш бид очиж үзнэ хэмээн айлдаж хаан нь хоньчноор газарчлуулж таван зуун нөхөд дагуулан морилов.

Чингээд хаан түүний хотын ойролцоо хүрэв. Зүүд эрэгч, хаан ирж буйг байшин дээрээс хараад эхнэртээ

– Манай орны хаан тэр ирж явна. Урьж авчрах хэрэгтэй гэсэнд эхнэр

Тэр нохойн арьсыг эс түлсэн аваас хэрэг болох байсан. Түүнийг түлсэн билээ. Бас хоньчинд гэрлийг бүү үзүүлэгтүн гэснийг үзүүлсэн учир уршиг болов. Одоо энэ зүйлээс төвөг бэрхтэй их ажил гарч ирнэ. Хааныг уриваас сайн гэв. Хааныг урьж залахын тулд очоод хаанд мөргөл хүндлэл гүйцэтгэж, гэртээ урин авчраад алтан ширээн дээр суулгаж, түшмэд зарц нарыг бэлдсэн дэвсгэр дээр дэс дараагаар суулгав. Хаан тэргүүлэн хамаг түшмэд зарцад лусын идээ зэргийн өргөл хүндлэл, хотол чуулганыг бүрэн төгс үйлдэв. Хаан хоньчинд

Ман нэрт тэр эхнэр хаа байна? хэмээн айлдсанд, хоньчин хурднаа очиж хаалганы эгнэгийн тагийг нээв. Эгнэгийн гэрэл охинд тусаж, охины гэрэл харшид туссан учир харш дүүрэн гэрэл гялбалзав. Тэр хаан таалалдаа Энэ эхнэрийг булааж авбаас албат нөхөд нь цөм сэтгэл гансрах болно. Уран аргаар эхнэртэй нь хамт гартаа оруулж булаах хэрэгтэй хэмээн бодоод хаан

– Би хэрэгслээ өгч чамайг явуулсан бөлгөө. Харин чи миний дэргэд ч очихгүй, мэдээ ч хүргэхгүй байна. Маргааш чи бид хоёрын хэн нь их торготой байгаагаа үзэлцэн тэмцэнэ.

Миний торго их байваас чиний албат нөхөд зарц. эхнэр бүгдийг нь эзлэх болно. Чиний торго их байваас би орь ганц охинтой билээ Түүнийгээ чамд өгнө хэмээн айлтгав. Чингээд хаан түшмэд цөм буцаж одов. Охин Сацоман

– Хаан юу айлдаж байна? хэмээн асуув.

Хаанд торгоны тэжээмэл хүр хорхойтой учир торго ихтэй буй за. Бид нар торгоны утас ч үгүй шүү. Хэн торго ихтэйгээ тэмцэж үзэх тул торгоор хаан дийлвээс орон суурь, албат эхнэр сэлтийг хаан эзэлнэ гэж байна. Хэрхвээс сайн бэ? гэв.

Төлдөр нохойн арьс түлээгүй аваас болох байсан боловч түүнийг түлсэн, хоньчинд гэрлийг бүү үзүүл гэхэд үзүүлсэн учир уршиг тарив. Одоо энэ ажил бэрх төвөгтэй юмгүй хялбар хэрэг. Чи энэ хайрцгийг аваад эртний тэр далайн захад очиж

– Нагац лусын эрхт хаан аа хэмээн дуудаж хот барих ажлын хайрцгийг доош ав. Хив торгон нэхмэлийн хайрцгийг дээш гаргаж өгтүгэй хэмээн өгүүл. Түүнийг дээш нь аваад амыг нээлгүй авчрагтүн хэмээн хэлсэнд тэр эр хотын үйлийн хайрцгийг үүрээд далайн захад хүрэв.

– Нагац лусын эрхт хаан аа! Хотын үйлийн хайрцгийг доош авч, хив торго нэхмэлийн хайрцгийг дээш гаргаж өгнө үү? гэсэнд нэгэн хайрцгийг үүрч авчраад, хотын үйлийн хайрцгийг доош аваад одов. Тэр эр хайрцгийг үүрсээр даваан дээр гарч очоод ийн сэтгэрүүн: «Хаанд торго зөндөөн их бий. Үүний доторх хэдийхэн чинээ буй аж» хэмээн бодож хайрцгийн амыг нээсэн даруй таван өнгийн торго гарч тэр эрийг далдартал ороосныг эхнэр нь хараад хурдан гүйж ирээд «Хумигд, хумигд» хэмээн хэлэхэд таван өнгийн торго нь буцаж хайрцаг дотор орсон учир, тэр эр үхэлгүй, амьдын төдий гарав. Чингээд тэр хоёр ханилан харшдаа хүрэв.

Маргааш өглөө наран мандахад хаан, өмнө талд байдаг нэг уулыг торгоор битүү бүрсэн байв. Өглөө тэр эрийн байшингийн үүднээ хааны шадар түшмэл хүрч ирээд

– Чиний торго хаа байна? Бид уулыг торгоор битүү бүрхэж гүйцсэн гэв. Чингэхэд охин хайрцгаан авч байшин дээр гараад хайрцгийн амыг нээсэнд таван өнгийн торго гарч, тэр нутгийн уул тал бүхнийг торгоор хучив. Чингэтэл хаан түшмэд ирж

– Манай хүн мал бүгд торгонд боогдож үхэх гэж байна. Торгоо одоохон хумин авч тус болно уу? гэв. Чингэхэд охин

– Торго цөм хумигд хумигд гэхэд тэр торго хайрцаг дотор багтав. Чингэхэд хаан тэдний харшийн дэргэд ирж

Чиний торго их илүү ч үгүй, дутуу ч үгүй болов. Маргааш өдөр чи бид хоёрын хэний хайнаг чадалтай байгааг тэмцэлдүүлэн үзнэ. Чиний хайнаг дийлвээс урьд ярьсан мэт болох ба миний хайнаг дийлвээс урьдын адил мөрийцөх хэрэгтэй хэмээн хэлээд хаан ажрав. Охин Хаан юу гэж айлдаж байна? гэсэнд

– Хаанд тэнгэрийн хайнаг, уулын чинээ том хайнагууд маш олон бий. Бидэнд ганц ишиг ч байхгүй билээ. Маргааш хэний хайнаг дийлэхийг тэмцэлдүүлнэ хэмээн айлдаж байна гэв.

– Түүнээс илүү төвөгтэй үйл гарахгүй аваас энэ ажилд тийм бэрх төвөгтэй юм үгүй. Чи далайн захад очиж нагац лусын хаанд торго нэхмэлийн энэ хайрцгийг доош авч газрын хүрэн хайнагийг дээш гаргаж өгнө үү хэмээн хэл гэсэнд тэр эр очиж өгүүлсэнд лус гарч ирээд газрын хүрэн хайнагийг авчирч, хив торгоны хайрцгийг авч одов. Тэр эр хайнагтаа үмх гурил өгч, хооллосоор ирэх зуур «Хаанд уулаас том өдий төдий хайнаг бий» Манай энэ юухан байх вэ?» хэмээн бодсоор гэртээ хүрч ирээд

– Энэ юутай адил вэ? гэсэнд охин

Хааны хайнагийг чадагч буй амой гэв. Маргааш наран мандахад хаан хайнагуудаа хөөж хаалган дээр ирэв. Чингэхэд нөгөө эр айж

– Хааны хайнагууд хүрээд ирэв. Гаргаач! Манай энэ хайнаг гэдэг аль вэ? гэсэнд эхнэр Түүнд айхын хэрэггүй. Түүнээс аймшигтай гарьд нэрт бух гөрөөс бий хэмээн өгүүлэв.

Бас хааны нэг түшмэл хаалган дээр ирж

– Чи хайнагаа гаргагтун гэв. Чингэхэд охин газрын хүрэн хайнагийн дэргэд очиж үсийг самнаж үмх гурил өгөөд хүрэн хайнагийг гаргаж

– Тэдний зарим хайнагийг гишгэж ал. Заримыг сүлбэж алагтун. Цөмийг нэг доор овоолж орхигтун хэмээн өгүүлээд тавьсанд босго алхмагц хааны бүх хайнаг нэг доор нийлэвч охины тэр хайнагийн ганц толгойн чинээнд хүрэхгүй тийм том хайнаг, болсонд, түшмэл сүрэгчин нар охины тэр хайнагийг хараад эргэж харан харан дутаав. Чингэтэл тэр хайнаг өрөөсөн хамраа шуухитнуулахад их хүчтэй нь унаж ойчив. Унасныг туурайгаар гишгэлж унаагүй байгааг эврээр өлгөн авч алаад давхар давхар овоолов. Тийнхүү алж гүйцэхэд тэр хайнагийг охин татан авав.

Бас хаан түшмэд хаалганы дэргэд хүрч ирэв:

– Энэ өдөр чиний хайнаг дийлэхээр илүү дутуугүй болов. Маргааш хэний морь хурдан байхыг тэмцэлдэнэ. Чиний морь түрүүлвээс урьд ам алдсан ёсоор үйлдэнэ гэв. Эрийг дотогш ороход охин өгүүлрүүн

– Хаан юу айлдав гэхэд

– Хэний морь хурдан байхыг тэмцэлдэнэ гэж хаан айлдаж байна. Хаанд олон сайн морь бий. Бидэнд морь байхгүй тул хэрхвээс сайн бэ? гэсэнд

– Дахин далайн захад оч. Нагац лусын эрхт хаан аа, Газрын энэ хүрэн хайнагийг аваад газрын бяцхан хөх морь Сирайг дээш гаргана уу хэмээн хэлээд түүнийг богинохон хөтөлж ирэгтүн. Ийм үйл хялбар бөлгөө. Түүнээс илүү бэрх үйл одоо тохиолдоно гэв. Тэр эр бас далайн захад очоод

Нагац лусын эрхт хаан аа. Газрын энэ хүрэн хайнагийг аваад газрын бяцхан хөх морь Сирай нэртийг дээш гаргаж өгнө үү гэсэнд морины цулбууртай бяцхан хөх юм дагуулж авчирч өгөөд хүрэн хайнагийг хөтлөөд буцаж одов. Тэр эр цулбуурт морийг богинохон хөтөлж ирэв. Эр

«Үсийг нь охин самнах аваас ариухан сайхан морь болох буй за» хэмээн бодож баярласаар, гэртээ ирэв.

– Маргааш нь, наран ургахад хааны хүлэг Нарны гэрлийг тоосоороо халхлагч нэрт ажнай морийг хүлэглэн

– Морио уралдуулахаар ирэв хэмээн нэг түшмэл хүрч ирэв. Чингэхэд охин, өнөөх хөх морины үсийг самнаж сайхан болгов. Оюу тоногтой алтан эмээлийг мориндоо тохож, цээжин талаар нь сайн цагийн мянган бурхантай, адаг талаар нь алтан номын үсгийг алаглуулан бичсэн, дунд талаар дөрвөн Махаранзын зураг дурайсан, баруун зүүн хоёр мөрөн дээр нь наран сарны зурагтай үлэмж гоё дээлийг эрдээ өмсгөж, морио унуулан

– Морь уралдах газрын хэмжээг тэр даваа гэж зааж өгөх аваас давааны хормойд хааныг хүрэхийн хооронд сүүлдэж хоцор. Хааныг давааны хормойд хүрэх үед гурвантаа ташуурдаж бяцхан хөх морь Сирай минь одоохон харайлгаж урд нь гартугай хэмээн хэлээд эмээлийн урд бүүргэнээс барьж яв. Бүү бэрт. Бүү омогш хэмээн сургав.

– Тэр эр хааны дэргэд очив. Хаан түүний морийг дэл сүүпгүй ажиглахад хөх морь, дөрвөн хар туурайтай, төмөр дөрвөн хумстай байв. Сэрвээ нь өндөр, цээж бөгс нэлэнхийдээ цэвцийж гэрэлтэн цайж байв. Хаан түүнд

– Бид хоёрын уралдах хязгаар хэмжээ нь тэр даваа болно гээд хаан давхив. Тэр эр хааныг давааны дэргэд хүрэхийн өмнө амыг татан татсаар хоцров. Хаан даваанд хүрэх дөхөж явав. Хааныг даваанд хүрэхэд тэр эр морио гурав ташуурдаж

– Одоо харайгтун хэмээн хэлсэнд гуравхан харайгаад даваан дээр гарав. Чингээд гэдрэг харсанд хаан тэртээ хойноос ирж яваа харагдав. Тэр эр мориноос бууж «Хачин гайхам» хэмээн өгүүлж байхад хаан хүрч ирээд түүнд ийн айлдав.

– Чиний морь уралдаанд илүү гарсан юмгүй, дутуу ч үгүй байна. «Хачин гайхам» хэмээн юуг хэлж буй? Бид хот барьж буй бус, морь уралдуулахад хачин гайхам гэдэг учрыг хэл. Тэр юмаа маргааш авчрагтун гээд эргэж явахад шилний хонхор нь холоос бараантан харагдав. Тэрээр ч гэртээ харихад охин угтан ирж

– За хүрээд ирэв үү? Морь түрүүлсэн биз гэв.

– Морь хурдаа авсан. Би ч хүрэх газартаа хүрсэн. Би «хачин гайхам» гэж үг алдсанд хаан, бид энэ өдөр хотын ажилд цуглаад байгаа бус, хачин гайхам гэдэг учир шалтгаантай, түүнийг авчрагтун гэж байна. Юу гэж айлдавч эрх дураар тул алс хэтдээ би алдах ажгуу гэсэнд охин

– Хаан хачин гайхмыг хэрэгтэй гэж айлдаж байна гэж үү? гэв. Хачин гайхам гэдэг нь хэрэгтэй байна. Эс авчирваас мөрийгөө алдах болно гэсэнд

Хачин гайхмыг авчрахад хялбар боловч хаанд муу болно гэж айлтгал илгээх хэрэгтэй. Бас чи далайн захад очиж «нагац лусын хаан аа! Газрын бяцхан хөх морь Сирай үүнийг аваад хачин гайхмын тэр хайрцгийг авч ирнэ үү гэж хэл. Тагийг нээлгүй авчрагтун» хэмээн захив.

Энэ өдөр эртний дотно нөхөр хоньчин нь морио идээшлүүлэхээр хүрч ирэхэд түүнд охины хэлсэн нь

– Урьд болж өнгөрсөн уршигт хамаг ажлыг үүсгэгч эзэн нь чи мөн. Хаан одоо хачин гайхам гэдгийг авчир гэж айлдсан байна. Хачин гайхам тэр нь эзэн зарц хоёуланг нэн их гомтгоно гэж айлтгаж, хаан юу айлдах аваас чи хариу аваад ир хэмээн хэлсэнд хоньчин

«Хачин гайхам» тэр тийм чухаг ирэх буюу гэв.

«Хачин гайхам» тэр төвөг удах чухаг юм мөн гэсэнд

Би айлтгаж, хариуг мэдэгдье хэмээн хэлээд явав.

Охины эр нь далайн захад очиж

– Нагац лусын хаан аа. Газрын энэ бяцхан хөх Сирай нэрт морийг доош авч, хачин гайхмын

хайрцгийг дээш гаргаж ирнэ үү гэсэнд бяцхан хөх Сирай морийг авч яваад нэг дөрвөлжин хайрцгийг гаргаж ирэв. Түүнийг ардаа үүрсэнд хамраа газар хүргэх шахам бөгтийж явахаас өөр аргагүй хүнд юм байв. Тэр

Хачин гайхам гэдэг нь ямар юм бэ? Ийм их хүнд жинтэй байхыг үзвээс энэ хачин гайхмыг гэртээ авч очиж болох болов уу гэж бодсоор охины дэргэд очихын өмнөхөн түүний амыг нээж харсанд охин

– Тэнд сууж байх нь нэг учиртай хэмээн санаж гүйж очсонд хайрцаг дотроос гартаа твмөр алх барьсан тохойн чинээ төмөр хүн гарч ирээд «Хачин гайхам» хэмээн хэлсээр тэр эрийн овойсон яс бүхнийг нүдэж байв. Тэр охин

– Хумигд, хумигд хэмээн хэлэхэд хайрцаг дотор оров. Түүний амыг түгжиж, охин эрдээ

– Би чамд амыг нь бүү нээ гэж захисан атал нээж уршиг удсаар өөрөө өөртөө зовлон гаргаж байна гэв. Тэд зэрэгцсээр гэртээ очив.

Хаанд мэдээ хүргэсэн хоньчин морио хатируулан давхисаар ирж

– Хурдан явлаа шүү гэхэд

– Чи сууж бай. Би анхаарья гээд охин анхааран чагнав. Би эндээс хүргүүлсэн мэдээнээс илүү дэлгэрүүлэн айлтгав. Энэ мэдээг хайхрахгүй байна. «Хот орон хагачаад бас аминаасаа ч салах буй за» хэмээн өгүүлж байна. Одоохон гэр орон, газар нутгийг гэргийтэйгээ хамт өргөвөөс аминд чинь эс хүрэх болно хэмээн хэлэхэд охин хоньчинд

– Мөрийг бид авах ёстой байтал орон сууриныг хаан авна гэдэг нь хааны эрх хэтэрч байна. Хааны омог хэтэрвээс алсдаа ялагдахын муу зөн болно гэж айлтга. Хаан цэрэг татах аваас чи захиаг түргэн өгөх хэрэгтэй учир явтугай гэв. Тэр буцаж яваад хаанд

– Тэр хот орныг хамгаалах учир, өчүүхэн хүмүүсийг зэмлэх аваас зэмлэтүгэй хэмээн айлтгуулсан гэж өчив. Хаан хилэгнэж харьяат түшмэдэд зарлиг буулгаж, хааны түмэн цэргийг жагсааж явуулав. Хаан хатан гэртээ хоцров. Цэргээс урьдаар хоньчин хүрч ирээд гасалсаар хэлсэн үгийг уламжилсан нь

– Би хаанд эд таваар, эрдэнэ зэргийг өргөө. Цэрэг бүү тат гэж айлтгасанд

Надад хүрэлцэхүйц байна. Цэрэг татна гээд түмэн цэргийг ирүүлж буй. Энэ хотоо өгөвч үл буцах, учир аминдаа хүргэхгүйг гуйж айлтгаваас сайн гэсэнд

– Би эмээсээ асууна гэв.

– Гэргий минь хэрхэвч тусгүй. Хааны хатан болох байна гэхэд

– Хамаг гэмийн хаалгыг чи нээжээ гэхэд тэр эр гэргийдээ

– Цэрэг гадна дүүрэн болов гэсэнд

– Эрэг хэдий том ч газрын ангал мөн. Цэрэг хэдий түм хүрэвч хүний хүүр мөн. Анд нөхөр хоньчин тэр дэргэд байна уу? гэв. Анд нөхөр үүдэнд өдгөө хариу хүлээж байна гэсэнд

– За шийдэв. Тэр хэрэгтэй аваас үүдээ нээвээс зохино гээд чи харш дээрээс нүд алгасалгүй харж бай. Сонин юм үзтүгэй хэмээн өгүүлээд гэргий хайрцгийн амыг онгойлгож

Магад дайсан гэж танигдсан хоньчинг ал. Хамаг цэргийг хүүр болтол цохь. Хааны харшид ороод, хаан хатныг ч үхтэл нь балба хэмээн хэлж хайрцгийн амыг нээж эм амандаа «Дайсны толгойг цохь» хэмээн урьж байв.

Чингэтэл дөрвөн төмөр хүн гарч, урьдаар хоньчинг алж, дараа нь түмэн цэргийг хүүр болгов. Хааны харшид очиж, шатнаас эхлэн өөд «Хачин гайхам, хачин гайхам» гэлцэж авиран гарав. Хаан сэтгэлдээ

– Би эрх ихтэй. Лусын хатан охин рид хувилгаан ихтэй. Хачин гайхам тэр илт ирж байна хэмээн бодож, нүдээ бүлтэлзүүлэн харсанд алх барьсан дөрвөн жижиг төмөр хүн ирээд «Хачин гайхам» гэсээр хааныг ширээн дээрээс өнхрүүлж занчив. Чингэхэд лусын охин хааны

дэргэд очиж

Энэ хачин гайхмаарт ханав уу. Өдгөө хэрэгтэй юу? гэж өчсөнд хаан

– Лусын охин чи хувилгаан ихтэй ба зүүдээр хоол олж идэгч тэр ч буян ихтэй байна. Би цэргээр дайल्या гэвч та хоёрын хувилгаан мухардахгүй байна. Би ганц энэ тэнгэрийн охиноо түүнд өгье. Бид эмгэн өвгөн ном үйлдэнэ. Энэ хан төрөө та хоёрт өгье. Биднийг алавч хилэнц болохоос өөр юмгүй. Чи хувилгаануудаа хурааж ав. Биднийг бүү алуулагтун гэв. Чингэхэд эм хайрцгийн амыг нээж

Хумигд хумигд гэсэнд тэр дөрвөн төмөр хүн хайрцаг дотор оров. Эм хайрцгаа цоожилж үүрээд харшдаа буцав. Цэргүүд хөө хуягаа хол орхиж нэг нэг таяг тулж бие биедээ баярлаж ирэв. Тэд гэр гэртээ харьжээ.

Хаан охиноо бараа бологч түшмэдтэй хамт чимэг хэрэглэлтэй нь соёрхов. Тэр эр цаад наад хоёр хан төрийг хоёулыг барив. Лусын охин урьдаар ирсэн боловч хааны охин нь хүний охин мөн тул их хатан болов. Лусын охин бага хатан болов. Тэр хоёроос нэжгээд хөвгүүн төрөв. Хан төрийг номын ёсоор тэтгэж, албат харьяат нар өрнөн дэлгэрэв. Хүн ба лус хоёр нэг нь нэгэндээ их ач тустай болсон бөлгөө. Хүн ч найман лусын сангийн бумбыг бүтээсэн тул лус нь барагдашгүй санг эдлэх болов.

Бас нэгэн үе болоход тэр эр

– Миний ноднин зүүдэлсэн зүүд өдгөө бүтэж буй эсэхийг мэдье хэмээн сэтгэж баруун завжиндаа улаан будаг хийж, зүүн завжиндаа хөх будаг хийж хөх улаанаар бөөлжиж

– Би халуурч өвдлөө хэмээн өгүүлж байв. Есөн давхар байшингийн оройд наран тусаж бүлээцүүлэхэд доор нь магнаг зөөлөн дэвсгэр дэвсэж толгойг хааны охин өвөр дээрээ дэрлүүлж, хөлийг лусын охин өвөр дээрээ тавиад

– Хэрхэвч таны энэ өвчин эдгэх буй гэлцэн, хоёр хөвгүүн

Аав аа, аав аа хэмээн нааш цааш гүйлдэж байсанд, тэр инээд алдав.

– Одоо ингэж чилж байхдаа инээд алддагийн учир юу вэ гэсэнд

Дээр үед миний зүүдэнд орж зүүдлэгдсэн нь: Нарны эрт оройн байдал энэ хэртэй байхад би есөн давхар байшингийн орой дээр дэвсгэр дэвсэн сууж байв. Хааны охин ба лусын охин хоёр миний эхнэр болсон байна хэмээн зүүдэлсэн. Бас хааны охины өвөр дээр толгойгоо тавьж, лусын охины өвөр дээр хөлөө тавиад «Би хуурч өвдлөө» гэж байсан ба надад хааны охины хүүхэд лусын охины хүүхэд хоёул байна. Тэр хоёр «Аав аа, аав аа» гээд нааш цааш гүйцгээж байсныг зүүдэлсэн тул одоо инээд хүрсэн бөлгөө. Миний тэр зүүд яг таарч байна» гэсэнд Сайн амгалан явдалт хааны амнаас

– Тэр хүн зүүдээ шинжлээд их буянтан болжээ гэсэнд

Хүүрт үг хэлэв хэмээн төмөр торыг гал бадартал гурав дэлдээд харцага нисэх адил хүр хэмээн араас алдуурав.

Ламын зарлиг: Хүүрт үг бүү хэл гэсэн билээ. Энэ гурван үгээс зөрчсөн тул уршиг удав.

Ламын дэргэд очвоос зэмлэл хүлээнэ хэмээн сэтгэж дахин тэр хүүрийн газар очиж «Хала» гэснийг тогшуураар дэлдэж «Хүлү» гэснийг алхаж гишгэлсээр тэр модны дэргэд хүрэв.

Зүүдээр хоол олж идэгч нь зүүдэлснээ олж хан төрийг барьсны арван есдүгээр бүлэг болой.

# НАГАНЖУНАГИЙН ШАСТИРААС ОЧИРВААНЬ, ОДСЭРЖМАА ХОЁР УРЬД НЭГЭН ТӨРӨЛДӨӨ ЗАМБАТИВИЙНХНИЙГ АМГАЛАН БОЛГОСОН БҮЛЭГ ОРШВОЙ

Бас хан хөвгүүн хутгаа сугалж, тэр модыг нэгэнтээ цавчиж

– Лам минь Наганжуна Зүрхэн мөн. Би өөрөө Сайн амгалан явдалт хаан мөн. Тор минь есөн нүхт төмөр мөн. Тогшуур минь хүрэн сэндэн мөн. Тостой гурил минь барагдашгүй идээ мөн. Хүүр буухгүй буюу, модыг чинь унагалаа гээд тэр модны тэг дунд хүртэл цовхрон үсэрч харайсанд хүүр айн цочоод бууж ирэв. Түүнийг тогшуураар нүдэж, хутгаар нэг шааж, торны дотор хийж хүлгээр хүлээд үүрч зорьсон газар чиглэн одохоор зургаа долоон алхам өнгөрмөгц

– Хан хөвгүүн, хан хөвгүүн. Эсбөгөөс хан хөвгүүн нэг үлгэрийг ярь. Эсбөгөөс би нэг үлгэрийг ярина гэсэнд тэр хан хөвгүүн «Үг өдөж буй» хэмээн санаж эс дуугарав.

– Үйлээ барсан хаан чиний амнаас үг үл гарах буюу?

Би өчүүхэн нэг үлгэрийг ярья. Сонсогтун

Нэгэн их голд нэг их хаан байжээ. Тэр хааны хатан үлэмжийн гоё цэвэрхэн хүн байв. Тэр хатнаас үлэмж сайхан нэг хөвгүүн мэндлэв. Хөвгүүнийг мэндлэх цагт сайн бэлгэ, элдэв шинж үзэгдэв. Шинжигч бярманд үзүүлсэнд

– Энэ бурхны хувилгаан үлэмж хүн мэндэлсэн байна. Энэ лавтай чадагч мөн буй за.

Чадагчийн ёсоор бол эх нь урьд нярваан болно гэдэг билээ гэв. Тэр хөвгүүнийг мэндэлснээс хойш хан төр номын ёсоор дэлгэрч байв.

Чингээд хан хөвгүүн арван таван нас хүрэв. Хоёр гурван зарц дагуулж тэр голын эхэнд буй эр эм хоёр шулмас оршдог хилэнт эм мангас нэртэй уулын ойд очив. Түүнийг урьд тахиж байсан бөгөөд хан хөвгүүнийг мэндэлснээс хойш номын үйлдлийг дагаж явсан учир, тэр уулыг тайж тахиагүй тул шулмас хилэгнэж

– Хан хөвгүүнийг яаж хорловоос таарах буй хэмээн сэтгэж байх үед хан хөвгүүн, эзэн зарц нар ойн дотор хүрч очив.

– Энэ хан хөвгүүн төрснөөс хойш надад тахилгыг эс үйлдсэн тул үүнийг үгүй хийх хэрэгтэй гэж сэтгээд тэр эр эм хоёр шулмас том төмөр гахай болон хувилж, хан хөвгүүн зарц нарын дэргэд гүйж очсонд зарц нар доороо муужирч унав. Хан хөвгүүн айсангүй. Ийнхүү

– Миний гарт байгаа энэ хулсан нум төмөр нум болтугай. Энэ сум төмөр сум болтугай. Би хаан төрөө эзэлж үл чадах ба энэ л хан төр өрнөх ёсонгүй бол энэ хоёр гахайд идэгдэх болтугай хэмээн ерөөл тавьсанд хулсан нум нь төмөр нум болж, хулсан сум нь төмөр сум болоход түүнийг өөрөө эвхэртэл нь татаад

– Миний энэ сум тэр гахайн магнайн гол дунд оноод сүүлний үзүүрээр гарах болтугай.

Миний санаа асар ариухны хүчээр тэр үхэх болтугай. Үхээд тэнгэрт төрөх болтугай.

Шулмасын шашин баларч, бурхны шашин улмаар тодрох болтугай хэмээн харвасанд тэр гахай үхэж гучин гурван тэнгэрийн оронд төрөв.

Чингээд эм шулмас алаг гахай солонго завхарсан мэт хааш явсан чиггүй алга болжээ. Хан хөвгүүн нь муужирч унасан зарц нараа дал модны сэрүүн сүүдэрт тавьж, зандны салааны усаар сүрчиж сэргээгээд эзэн зарц нар ханилаад харшдаа буцав.

Нэгэн үе болоход тэр хааны хатны сэтгэлийг эм шулмас удирдсан учир хааны хатан

– Энэ өдөр тэртээ уулын энгэрт очиж уйтгараа сэргээе хэмээн айлдав. Явах төхөөрөмж хэрэглэлийг зарц нар хүргэж ирсэнд уулын энгэрт очоод

– Өнөөдөр энэ уулын хажуунаас энэ энгэр нь аятай байна хэмээн айлдаж суув. Тэр энгэрт байсаар халууцсан учир, эргийн сүүдэрт очиж сэрүүцэн суув. Төлдрийн алагдсан гахайн эхнэр эм шулмас тэр эргийг нураасан тул хатан халив. Зарц нар буцаж ирээд хаанд шууд айлтгаж эс чадан түшмэлээр дамжуулан айлтгасанд хаан сэтгэл зовниж, хаан түшмэд очиж үзэхээр явав. Хатны шарилыг үзээд хаан ч мууран унав. Хааныг зандны нунтагтай усаар сүрчиж, бурмын шүүстэй усыг аманд нь цутгаж чихэнд нь үг хэлсэн тул төдхөн сэргэв. Тэндээс хаан харшдаа очоод хатны шарилыг торгоор ороож оршуулав. Хатны хойдын буянд зориулж харьяат ардуудад түгээл түгээж, орон хийдийн хуврагуудад олон дахин хоол цав өргөв.

Тэр эм шулмас элдэв зүйлийн эрдэнээр чимсэн тунгалаг царайтай гоо охин болон хувилж хааны ордны дэргэд очив.

Олон хүн

– Чи хаанаас ирсэн бэ? хэмээн асуусанд «Би тэнгэрийн охин мөн. Тэнгэрийн орноос ирлээ гэв. Тэр хүмүүс түшмэдэд

– Манай хаан эцэг хөвгүүн хоёрт хатан хэрэгтэй бөлгөө. Өнөө маргаашдаа эрээд олохгүй, урьдын адил хатныг хаанаас ч олоогүй байна. Бусад орноос ававч урьдахтай адил болохыг үл мэднэ. Хаан эцэг хөвгүүн хоёрын аль нь ч авсан энэ хатан тохирно. Тэнгэрээс бууж ирсэн тул язгуур сайтай, үүнийг таалж хатан болговоос зохистой буй за хэмээн албат бүгд ам нийлж айлтгасныг хааны сонорт түшмэл уламжлав.

– Миний урьдын хатан шиг хатан үгүй. Одоо авгай авах хэрэггүй. Авч болохгүй. Энэ хан хөвгүүнээс асуугтун хэмээн айлдсанд түшмэд хан хөвгүүнд

– Манай энэ харшийн дэргэд тэнгэрээс бууж ирсэн үлэмж сайхан охин байна. Тэнгэрээс буусан хатан хаанаас ч үл олдох тул хан хөвгүүн гэргий болгон таалваас сайн биш үү? гэж өчсөнд түшмэлийн тэр үгийг сонсоод хан хөвгүүний махбод хямарч

– Би эхнэр авахгүй. Би хан төр барихгүй. Би ном үйлдэнэ хэмээн айлдсаныг тэр түшмэл эцэг хаанд

– Хан хөвгүүн хан төрийг барихгүй, хатныг ч авахгүй номыг үйлдэнэ хэмээн айлдаж байна хэмээн өчсөнд

Түүнийг дуудаж авчир гэв. Хан хөвгүүний дэргэд нэг түшмэл ирээд

– Хаан дуудуулж байна. Морилж очихыг айлтгая гэсэнд хан хөвгүүн эцгийн дэргэд очиж мөргөж хүндлээд суув. Хаан хан хөвгүүнд

– Манай хотын дэргэд тэнгэрээс буусан нэг охин буй гэнэ. Надад эхнэр болгоё гэсэнд би чиний эхийг үгүй болсноос хойш шунал хурьцлыг угаас тасалсан билээ. Чи номыг үйлдвээс хааны үндэс тасарна. Чи түүнийг яавч гэргий болгож авбаас зохистой хэмээн зарлиг болсонд, хан хөвгүүн хаанд

– Урьдах хаадын үндсэнд эцэг хааны зарлигийг зөрчих эрхгүй боловч би энэ охиныг харсан төдийд сэтгэл минь угаасаа үймж, түшмэдийн дамжуулсан сургамжлалыг сонсож махбод хямарч байна. Тэр охин тэнгэрийн охиноос илүү их дагина мөн боловч, би өдгөө хааны зарлигийг зөрчинө. Эцэг таны өөр ямар зарлиг хайрлавч үхэх хүртлээ шууд хүлээж авна хэмээн айлтгав.

Хааны сэтгэлд охин шулмас оршсон учир

– Чи түүнийг гэргий болгон авахгүй гэнэ. Одооноос хойш юу хэлснийг минь дагана гэв үү? гэж айлдаад

– Тэр охиныг чи эс авбаас би авна гэв. Чингэхэд хан хөвгүүн хаанд

– Үүнээс ангид ямар зарлиг хайрлавч шууд хүлээнэ хэмээн айлтгав. Хаан «Энэ охины бие гоо



үзэсгэлэнтэй гэнэ. Анхилам сайхан үнэртэй охиныг аль нэгэн цагт түүн лүгээ ханьцуулан нөхөрлүүлж болох буй за. Одоохондоо нас залуу ба хүмүүс юу хэлэвч үл мэдэх балчир аж хэмээн сэтгээд хаан тэр охиныг гэргий болгон таалав. Тэр охин хан хөвгүүний тааллыг элдвээр аргадавч хан хөвгүүн хүч ихтэй ба урьд насны буян их тул охин хуурч эс чадав. Эм шулмас Энэ хан хөвгүүнийг би үл чадах ажгуу. Энэ насанд үүнтэй нөхөрлөх учир үгүй болвоос хязгаар газарт цөлүүлэх аргыг хийе хэмээн бодов.

Чингээд охин нэгэн үе болоход баруун завжиндаа улаан будаг хийж, зүүн завжиндаа хөх будаг хийгээд хар хүрнээр нилийтэл бөөлжиж, би өвдөв гэж байхад, хаан урьдахь хатан өвдөж хальсны зовуурь сэтгэлд орж

– Одоо чиний өвчинд юу тустай вэ? хэмээн асуув.

– Миний өвчинд тус болох ганц юм бий. Баруун зүгийн мангасын оронд миний танил нөхөр мангасын хаан Есөн толгойт ягчисын охин Алтанзул цэцэг нэрт байдаг. Эм засалд тэр охиноос илүү мэргэд үгүй бөлгөө. Хүний эмч нар намайг эдгээж чадахгүй гэв. Хаан

– Тэр оронд зорчсон хүн буй буюу? Газар мэдэх хүн үгүй. Хэрхвээс сайн бэ? гэсэнд Бусдыг явуулахыг хүсэвч үл явна. Явж ч үл чадна. Манай энэ хан хөвгүүн буяны хүч ба арга мэх ихтэй учир өөртөө гэм зэм халдаалгүй, охин тэнгэртэй ханилаад ирэх буй за. Түүнээс өөр аргаар авчирч үл чадна гэв.

Хаан нэг түшмэлд

– Хан хөвгүүн Сайн номыг үзүүлэгчийг түргэн ирүүлсүгэй хэмээн айлдав. Түшмэд хан хөвгүүний өмнө очиж

– Эцэг хааны дэргэд морилж очно уу хэмээн өчив. Хан хөвгүүн урьд очихдоо үнэн зүрхнээсээ дургүй байдаг сан. «Өдгөө түшмэл үг хэлж гүйцмэгц сэтгэл нь маш баясан нэн их дурлаж, хааны дэргэд очоод мөргөж ёслон айлтгав. Хаан зарлиг буулгасан нь

– Сайн номыг үзүүлэгч чи буяны хүчин чадлаар өрнө зүгийн мангасын оронд очоод Алтанзул цэцэг нэрт авхайг авчирч энэ хатны өвчнийг арилгатугай. Эцэг хөвгүүн уулзахын ерөөлийг тавья гэсэнд Хан хөвгүүний сэтгэл догдолж маш баясаж

– Би Алтанзулыг авчирч хатны өвчнийг амарилуулж эцгийн зарлигийг гүйцээн бүтээгээд түргэн уулзахын ерөөлийг тавья. Сайн буяны цаг мөн тул маргааш явахыг айлтгая хэмээн өчив. Эцэг

– Албат нөхөр, зарц хэрэглэлүүдийг аваад эргэж ир гэж зарлиг болов.

– Хэрэглэл зарц надад хэрэггүй хэмээн айлтгав. Хааны таалалд

– Миний энэ хөвгүүн нас залуу ба юм үзэж хаширжаагүй тул аминдаа хор хийх ба хязгаар газар тэнэх гэж сэтгэсэн бус буюу хэмээн бодоод

– Үл бүтэх явдал хийх гэж байгаа бус биз? хэмээн айлдсанд хан хөвгүүн

– Үл бүтэх явдал хийвээс эцгийн зарлигийг зөрчсөн болно. Өдгөө амиа хорлох үйлийг үл чадна. Тэр охиныг авчирч түргэн таны дэргэд ирнэ хэмээн өчсөнд хаан баясав. Тэр охин шулмас сэтгэлдээ «Би амийг нь хорлуулж чадахаар болов» хэмээн бодов.

Хан хөвгүүн цаглашгүй баясаж өрнө зүгийн мангасын орон тийш одов. Чингээд эзгүй газар хүрэхэд түүний лагшин чилсэн тул түр хэвтэж амсхийв. Түүний сууж байсан газрын адагт хар далай байв. Эхэнд нь нэг их цагаан далай байв. Хар далай дотроос нэг хар могой гарч ирэв. Цагаан далай дотроос нэг цагаан могой гарч, тэр хоёр могой хоорондоо ноцолдож хар могойноос чийг дааж хөлс гарав. Цагаан могойноос хар хөлс хурын ус адил урсаж гарав. Хан хөвгүүн: «Ийм хоёр адгуус таарахгүй ажгуу. Энэ хоёр юундаа ингэж таарахгүй байна?»

хэмээн гайхаад сууж байтал хар могойн хэнхдэг дотор цагаан могой тэн хагас хүртлээ залгигдав. Хан хөвгүүн «Би энд харсаар суугаад залгиулж байгаа цагаан могойд туслах эрдэм

байхгүй буюу?» хэмээн бодож очоод хар могойн нуруун дээр гишгээд  
– Ууртны уур амарлих болтугай гэж хэлээд дэвхэцсэнд цагаан могойг бөөлжиж гаргав. Хар могой хар далайдаа, цагаан могой цагаан далайдаа үсрэн оров.  
Тэр шөнө тэндээ байтал цагаан далайн дундаас алтан үс сэгсийлгэсэн нэг хүүхэн гарч ирээд  
– Цэцэн ухаантан миний амийг аварсан тул харшид минь морилж очихыг айлтгая гэв.  
Чи хэн бэ? гэсэнд  
Би лусын хаан гэв. Тэр хар могой хэн бэ гэхэд  
Усны их эзэн Баруна мөн гэв.  
Би лусын оронд доошоо явж чадахгүй гэсэнд  
Лусын хаан элдэв хувилгаантай хэмээн хэлэлцдэг юм.  
Мэлмийгээ аниад миний рид хувилгаанаар очиж болно гэхэд тэр хан хөвгүүн мэлмийгээ аньсан төдийд таван зүйлийн эрдэнээр бүтсэн лусын их харшийн дунд очив. Харшид эрдэнийн ширээ засаж, түүний дээр хан хөвгүүнийг залж номын зарим үгийг хэлэлцэв. Их хаан та ямар хэргээр морилон ирсэн бэ? гэв.  
Би мангасын орноо буй есөн толгойт ягчисын охин Алтанзул цэцгийг авахаар ирлээ гэв. Та их номын хаан мөн тул түүнийг авах ерөөлийн хүч ихтэй байна. Тийм бус болбоос хэн ч авахад бэрх. Эсэрүн хурмаст тэргүүтэн хүсэн гуйж ирсэн олон боловч урьд хэнд нь ч өгсөнгүй. Их хаан чи тэр бурхан дагинатай урьд насны үйлийн барилдлагатай тул одоо авчирч болох буй за гэв.  
– Лусын хаан чамд зөн билэг байгаа буюу гэсэнд  
Хүнээс лусын төрөл дорой боловч зөн билэг морины сүүлийн хялгасны төдий үргэлжид тасралтгүй байдаг гэхэд  
– Одоо би тэр охиныг авчирч чадах болов уу? хэмээн асуусанд тэр лус хаанд  
Номч их хаан чи урьд насны буянаар эрдэнэт хүний биеийг олжээ. Урьд өглөг өгснөөр хааны хөвгүүн болон төрж, урьд насны үйлийн залгамж байгаа учир тэр хатантай уулзах больюу. Номч хаан чамд одоо хэрэггүй боловч хэрэг болох нэг цаг ирэх тул үүнийг өргөө гээд эрдэнийн шанагыг хив торгонд боож өгсөнд  
Үүнийг чи наанаа түр аваад хадгалж байтугай. Одоо би явья хэмээн айлдав.  
Чингээд бас хаан мэлмийгээ аньж лусын рид хувилгаанаар далайн мандал дээр гараад далайн эрэгт ирэв. Тэр лус хаанд  
Эндээс өгсөж явбаас үдийн газарт мангасын харш харагдах нэгэн хөвөө бий. Тэндээс харахад Номч хааны урьд насанд тавьсан ерөөлийн хүчээр тэр охин сэтгэлдээ таалаад хүрч ирэх болно. Тэр охин тэнгэрийн юу айлдсаныг чухалчлан сонсох маш хэрэгтэй. Түүний үгийг сонсон дагаваас охин тэнгэрийн хамт хааны харшид очиж болно. Номын их хаан чи хэрэг бүхнээ бүтээгээд түргэн морилж ирэх болно гээд уг замыг зааж өгөв. Чингээд лусын хааны ямар мэт хэлсэн ёсоор үдийн газарт хүрэхэд лавайн булаг, сайхан жимстэй нэгэн газар байсны тэнд очив. Урьд насны ерөөлийн хүчээр Алтанзул цэцэг нойроос сэрсэн мэт урьд насны цаглашгүй төрлийг дурдаад, хан хөвгүүний тэнд ирснийг мэдэж, хурдан сайн морио эмээллэж унаад гав ганцаар морилов. Тэр охин тэнгэр, хан хөвгүүний дэргэд ирээд өөрийн эрхгүй мөргөв. Хан хөвгүүн тэр охин тэнгэрт  
– Чамайг мангас хэмээн өөрийгөө хүн хэмээн ялгаж мэдэхээс өөр юм мэдэхгүй байна гэсэнд охин тэнгэр хан хөвгүүнд  
Миний урьдах төрөл тутамд ханилж явсан нөхөр мөн буй за гэсэнд хан хөвгүүн  
– Алтанзул цэцэг мөн буюу? гэхэд  
Мөн хэмээн айлтгав.

– Одоо эндээс тэнд очиход чинь мангасууд цөм дараахь өглөөний наран ургахыг хүртэл мацгийн санваар сахиж байна. Харшийн өмнө угаалгын их цөөрөм бий. Түүний хөвөөн дээр тэнгэр тулсан ридийн нэг их мод буй. Тэнд таван зүйлийн эрдэнээр бүтээсэн агуу их уудам ширээн дээр би сууж байна. Зургаан толгойтоос доош хоёр толгойтой мангасуудыг гадуур захаар суулгаж мангасуудад мацгийн санваар өгч байх болно. Чи өөрөө цөөрмийн хажууд очвоос болно. Айхын хэрэггүй морилж очоорой. Тэр цөөрмийн дэргэд Алтанзул буй буюу хэмээн асуутугай. Чингэхэд би зургаан толгойт нэгэн мангасыг таны дэргэд явуулна. Айж сандрахын хэрэггүй. Түүний дэргэд хүрээд ийн хэмээн айлтгаарай. «Зургаан толгойт мангас чи миний үгийг сонс. Би урьд насанд буян хурааснаар их эрдэнэт хүний биеийг олов. Алагчлалгүй өглөг өгснөөр эрдэнийн үндэс арвидав. Урьд насны төрөл тутамд ханилсан Алтанзул цэцэг их эрдэнийн ширээн дээр сууж буй тэр охин мөн байна. Намайг цээрлэлгүй түргэн хайхарч хэлсэн үгний хариуг өгөгтүн» гэж айлтга. Чингэхэд би «эцгээс асуухгүйгээр үл болно. Тэр урьд насны ханилсан хань мөн байна» гэж хэлнэ. Тэр мангас гадаад түшмэл мөн тул түүнийг эцэгт айлтгал хүргүүлэхээр илгээнэ. «Миний төрөл тутмын ханилсан хань тэр хүний дотроос хааны ариун үндсэнд мэндэлжээ. Намайг энэрч уулзахаар нааш явж ирсэн байна. Тэр номын хаантай уулзахаар явж болох уу?» хэмээн айлтгуулна. Тантай уулзахыг эс зөвшөөрнө. Би шөнө ирнэ. Эцэг хаан захисан бэрх үйлсийг би өөрөө чамд сургамжилна гээд тэр охин мангасын харшид буцав.

Чингээд хан хөвгүүн мангасын харшид очсонд тэр харш нь үзэж ханашгүй олон буман хотоор хүрээлэгдсэн байв. Тэр харшийн дэргэд таван зүйлийн эрдэнээр хүрээлсэн угаалгын нэг цөөрөм байв. Түүний хөвөөн дээр тэнгэр тулсан задийн мод байв. Түүний сүүдэрт байгаа агуу уудам эрдэнийн ширээн дээр охин Алтанзул өчигдрийн хэлсэн янзаар мангасуудад ном номлож байв. Цөөрмийн дэргэдээс

– Алтанзул цэцэг сууж байна уу? хэмээн асуусанд тэр охин

Миний төрөл тутмын ханилсан хань тэнд явж байна. Хурдан очигтун хэмээн айлдаад мангасын гадаад түшмэл зургаан толгойт нэг мангасыг илгээв. Тэр мангас хан хөвгүүний дэргэд очоод хан хөвгүүний сүрд тэсэлгүй мөргөж

– Номч хаан зарлиг юуг хайрлах вэ? гэсэнд

– Чи сэтгэлдээ сайтар тогтоож ав. Би урьд насанд буян хурааснаар эрдэнэт хүний биеийг олж, алагчлахгүй өглөг өгснөөр төгс эдлэл бүрдсэн хаан угсааны хөвгүүн болон төрөв.

Миний төрөл тутамд ханилсан Алтанзул, тэр өдгөө их эрдэнийн ширээн дээр сууж байна. Намайг цээрлэлгүй түргэн харгалзана уу хэмээн айлтга гэв. Тэрхүү түшмэл Алтанзулын дэргэд хүрээд гурав мөргөж

– Бие нь дөрвөн хуруу төдий боловч хязгааргүй сүр жавхлантай бөгөөд язгуур нь Номч их хааны хөвгүүн болон мэндэлсэн хэмээж буй ба охин тэнгэр таныг урьд насны төрөл тутамд ханилсан хань мөн гээд цээрлэлгүй түргэн уулзана уу? гэж байна хэмээн айлтгасанд Эцэгт айлтгая. Урьд насны ханилсан хань мөн боловч эцгийн зарлигтай харшваас хүссэн хэрэг үл бүтэх тул чи эцэг хааны дэргэд очиж, Их номч хааны айлдсан зарлиг ба надтай нас тутмын ханилсан хань мөн болох хийгээд төрлийн үндсийг түргэн айлтгаж ирэгтүн хэмээн айлдав.

Чингээд тэр мангас хааны дэргэд очиж, охин ба хан хөвгүүн хоёрын айлтгалыг өчсөнд

– Охины төрөл тутмын ханилсан хань мөн боловч миний хүүгээс үлэмж Алтанзул цэцэг чамайг Эсэрүн хурмаст тэргүүтэн гуйн хүсэгчин олон боловч миний хүүгээс үлэмж тул өдгөө хүртэл хэнд ч эс өгсөн бөлгөө. Энд суугаад зарц хийвээс учирч болно гэв. Тэр зарлиг захиануудыг хэлэхэд охин

– Одоо чи явж очоод, урьд насны ханилсан хань минь уулзахаар ирээд байгаа тул уулзуулахыг таалалдаа соёрхоно уу хэмээн айлтгаад ир гэж айлдсанд тэр мангас явж хаанд Алтанзул цэцэг авхайн нас тутамд ханилан учирч байсан нөхөр нь мөн учир уулзаж болох зарлиг бусдыг яавч хайрлан соёрх хэмээн айлтгуулав гэсэнд хаан

– Бэрх үйлийг бүтээх ба энд сууж зарц хийвээс уулзаж болно. Бусаар үл болно гэв. Түшмэл Алтанзул цэцэг охинд зарлигийг ёсоор дамжуулсанд

– Би гучин гурван тэнгэрээс цааш газарт таван зүйлийн эрдэнийн охиныг дагуулж солонго гэрлээр бүрхүүлж явна. Ямар бэрх үйл өгөхөө хаан мэдэх буй за хэмээн хэлээд, охин түшмэдэд зарлиг захиа өгөөд, мянган хигээс төгөлдөр лавай иштэй Алтанзул болов. Хигээс нь биндэрьяа, алт, мөнгө, шил таван зүйлийн эрдэнээр бүтсэн таван охин гарч тэр цэцгийг гартаан авч таван өнгийн торгоор зам тавьж гэнэт дээш өргөв. Чингэхэд мангас нь хааны дэргэд очоод

– Хан хөвгүүнд ямар бэрх үйл хайрлахыг эцэг хаан мэдтүгэй гээд охин чимэг хувцас өмсөж зүүгээд огторгуй өөд ажрав хэмээн айлтгасанд

– Охинтой тэр хүн уулзаагүй буюу? хэмээн айлдав.

– Эрхэм авхай тэр хүнтэй уулзаагүй хэмээн өчив.

– Чингэвэл чи миний урдуур долоон давхар хөшиг тат. Тэр хүн намайг үзвээс үхэх болно. Тэр охин ч дуурайгаад үхэх болно хэмээн айлдав.

– Долоон давхар хөшиг татах хэрэггүй бололтой. Дөрвөн хуруу бие нь цаглашгүй сүр жавхлантай байна. Би түүний дэргэд очиж мөргөхөд миний бие бүр жижигхэн болчихсон мэт санагдаж байсан шүү хэмээн өчсөнд

– Тийм боловч хөшиг тат. Тэр миний сүрд тэсэхгүй үхэх ёстой хэмээн айлдаад хөшиг татуулав. Чингээд хан хөвгүүнийг урин залсанд хааны өмнө ирэв. Зоог бүрэн төгс өгсний дараа хаан хөшигний цаанаас

– Миний охин Алтанзул, надад хүүгээс минь үлэмж бөгөөд мангасыг номхотгох хүчин чадал ихтэй юм. Ийм охиноо чамд өгч хэрхэн болох вэ? гэв. Хан хөвгүүн

– Би урьд насанд буян хураасан тул эрдэнэт хүний биеийг олсон. Алагчлахгүй өглөг өгснөөр эрдэнээр баялаг хааны үндсэнд төрөв. Төрөл тутамд ханилсан Алтанзул цэцэг надтай хагацахын аргагүй учрыг айлтгахаар ирсэн билээ хэмээн өчсөнд

Миний дууны сүрд тэсэж чадсан нь үлгэрлэшгүй гайхамшигтай байна хэмээн таалаад маш их баясаж байв.

Өнөө шөнө түүнийг нэг оронд хүргэгтүн. Маргааш дорнын сайхан цэцэрлэгт уйтгар сэргээхээр үдээс өмнө очоод үдэш болтол байх болно. Сайн хоол хэрэглэлийг өгөгтүн хэмээн айлдав.

Чингээд хан хөвгүүнийг залж аваад Алтанзул цэцгийн нойрсолгын таван зүйлийн эрдэнээр бүтээсэн бяцхан ордонд аваачив. Дорно зүгт нэгэн сайхан цэцэрлэг буй тул тэнд зугаалж, явах хэрэглэлийг бэлтгэж аваад

Зугаацаар морилохыг айлтгая гэв. Тэр өдөр ёслол хүндлэлийг бүрэн төгс дэвшүүлэв. Шөнө дунд Алтанзул цэцэг, сайн морийг унаад морилж ирэв.

Өнөөдөр юу айлдаж байна? хэмээн асуусанд

– Өнөөдөр шамдаж уулзуулахаар болсон билээ. Маргааш дорно зүгийн сайхан цэцэрлэгт хүнс хэрэглэл аваад тэр сонин үзмэрт оч гэж айлдсан бөлгөө хэмээн өчсөнд охин

– Тэр цэцэрлэг дотор гишгэмэгц дорно зүгийн үзэл урвуулагч цэцэрлэг гэгчид үзэл урваж зарим нь тариа тарьж, зарим нь шуудуу татаж, зарим нь тариагаа талхалж гүйцэд өвөл болсон байна. Түүнд сэтгэл урваад үүдээ түгжүүлчих болуузай. Нарны улаан гэгээ тасрахаас урьд

охин надад ингэнэ хэмээн хэлсэн шүү гэж сэтгээд таалалдаа хоногшуулан бодож түргэн морилж гартугай, алгасаж алмайрваас бид хоёр уулзахад бэрх болно хэмээн айлдаад охин буцав.

Маргааш өглөө болсонд тэр түшмэл хоол өгөөд нэг түлхүүр бариад

– Одоо үзмэр болгоохоор морилохыг айлтгая гэсэнд тэр хоёр ханилаад одов. Цэцэрлэгийн хашааны дэргэд хүрээд тэр түшмэл үүд нээн хоол хэрэглэлийг хан хөвгүүний мутарт өгч Хаан та цэцэрлэгийн хүрээлэнгийн дотор ирлээ гээд тэр буцахыг завдсанд

Түшмэл та энэ өдөр үзмэр үзэхгүй буюу? гэхэд

Би хааны дэргэд суух хэрэгтэй гээд буцаж одов. Түүний босгыг давж ортол хан хөвгүүний үзэл урвасан байв. Дорно зүгт тариа тарьж, өмнө зүгт шуудуу татаж, өрнө зүгт өвсөөр тариа талхалж байсан ба умард зүгт өвөл болж хөлдөж байтал улаан наран шингэж одов. Үүд хаах шахахад охин тэнгэр ирэв.

– Би урьд тэр мэтийг хэлсэн шүү. Одоо түргэн морилогтун гэхэд босго даван гарч ирэв

– Тэнд энэ өдөр их сонин байв. Маргааш зарлиг захиа юу хайрлах вэ? гэсэн айлтгалыг хүргүүлэгтүн. Чингэхэд

одоо өмнө зүгийн цэцэрлэгийн сонин юмыг үз хэмээн зарлиг буулгана. Өмнө зүгийн цэцэрлэгийн үүдээр ормогц өмнө зүгийн ороолонгийн цэцэрлэг гэдэг байв. Тэнд зарим хүүр нь заримыгаа унаад ташуурдаж байх ба зарим нь нэгийгээ идэж байх зэрэг цаглашгүй олон хүүр бий. Тэр цагт нь энэ толийг тэдний нүүр өөд чулуудаж орхи. Энэ толь нэг их том далай болно. Зарим хүүр захаар тойрох ба зарим нь хүргэж өгье гээд чиний хойноос дагаж ирнэ.

Наран шингэхийг хүртэл чиний дэргэд хүрч ирэхгүй. Дараа хаалга хаах гэж явцгаах тул умарталгүй гарч ирээрэй гээд тэр охин тэнгэр ажрав. Чингээд түшмэл

– Өнөө шөнө та хааны дэргэд очих уу? хэмээн айлтгав. Энэ шөнө эндээ сууна. Маргааш юу үйлдэх вэ? Зарлиг захиаг айлтгуулна уу гэсэнд, тэр түшмэл хаанд очиж

– Тэр тэндээ сууж байна. Ямар зарлиг захиа хайрлах вэ гэж байна, хэмээн айлтгав. Маргааш хоол хүнс өгөөд өмнө зүгийн цэцэрлэгт явуул хэмээн айлдав. Тэнд өргөл хүндлэл бүрэн төгс үйлдэв.

Маргааш өмнө зүгийн цэцэрлэгийг болгоохыг айлтгая гээд маргааш нь түшмэл удирдаж цэцэрлэгийн үүдийг нээж өгөөд буцаж одов.

Хан хөвгүүн дотогш морилсонд зарим хүүр заримыгаа унаад ташуурдаж байхыг үзэв. Зарим нь заримыгаа идэж байхыг үзэв. Хан хөвгүүний дэргэд хүүрүүд ирсэнд хан хөвгүүн тэр толийг чулуудсанд нэг их далай тогтов. Зарим хүүр далайн захаар тойрч яваа харагдаж зарим нь тулам унаад ирж байгаа харагдсан боловч наран шингэхийг хүртэл хааны дэргэд ирсэнгүй. «А ха ха, тэр үүдийг хаах шахаж байгаа буюу» хэмээн бодож хурдан морилсонд охин тэнгэр ирээд

– Одоо үүд хаахыг шахаж буй тул түргэн морилохыг айлтгая. Түүнээс урьд гарахгүй буюу.

Маргаашийн цэцэрлэг бол хутган хүрдний ой шугуй нэртэй буй. Хаалганы дотор орсон даруйд сэтгэл урвана. Хөхөрсөн зүлэг байна. Тэр зүлэгнээс салхи хөдлөөд зүлэг нь ой шугуй болно. Ой шугуй нь хутган хүрд болно. Мах цусыг хэсэг бусаг болгох тул миний энэ лавай иштэй алтан хутгыг сугалж гаргаад далайж

– Гарсан салхи намжтугай. Гарсан салхи амарилтугай. Салхин хутган хүрд хоёул амарлигтун хэмээн өгүүлвээс салхи ба хутган хүрд амарлиад сайхан зүлэг болно. Тэнд барс ирвэс, баавгай тэргүүтэн өөр өөрийн хүүхэдтэй наадан тоглоно.

Нарны гэгээ тасрахаас өмнө намайг дурдан санаж гарч ирэхийг айлтгая гээд охин одов. Бас тэр түшмэл

Та хааны дэргэд очих уу? гэсэнд

– Өнөө шөнө байгаа газраа очье. Маргааш юу үйлдэхийн зарлиг захиаг айлтгуулья гэв. Тэр түшмэл хааны дэргэд хүрч

– Зарлиг захиа юу хайрлах вэ? хэмээн айлтгасанд

Маргааш баруун зүгийн цэцэрлэгийн үзмэрт явуулагтун гэж айлдав.

– Бас түшмэл хан хөвгүүн хоёр, хоол аваад баруун зүгийн цэцэрлэгийн үүдийг нээж хан хөвгүүнийг дотогш оруулж түшмэл буцав. Түүний дотор хан хөвгүүн ороод оюу тэвш мэтийн зүлэг дээр очив. Санаанд оромгүй салхин хөдлөөд, зүлэг нь ойн цэцэрлэг болж, ой цэцэрлэг нь хутган хүрд болж салхины дуун «Ха ха, цохь цохь, ал ал» гэх дуун болж хувирав. Охиныг илт бясалгаж, тэр хутгыг далайсанд хутган хүрд, хан хөвгүүнийг нэг эргээд салхи ч намдав.

Тэнд урьдын зүлгэн дээр барс, ирвэс, баавгай, үхэр тэргүүтэн өөр өөрийн хүүхэдтэй хамт наадаж тоглосонд хан хөвгүүний сэтгэл алгасаж байтал наран шингэж одов. Чингэхэд «А ха, өдгөө үүд хаагаагүй болов уу?» хэмээн бодож түргэн очсонд тэр үүдний тэн хагас нь хаагдсанд охин тэнгэр

– Эртнээс би захисан шүү. Одоо багтахгүй хэмээн бодолгүй багтана хэмээн бодоод миний хойноос морилогтун гэсэнд тэр ёсоор бодсон учир арай ядан гэтлэв. Тэр охин хан хөвгүүнд

– Маргааш чамайг хаан дэргэдээ урьж аваачна. Мөргөөд таалалдаа асрахыг айлтгагтун. Би хан төрийг барих хэрэгтэй буй за. Маргааш умар зүгийн цэцэрлэгт ном лугаа зохилдсон үг ярина. Алжааж зүдрэхгүй буй за. Үүний дараа нь намайг өгөх болно гээд явж одов.

– Маргааш нь түшмэл ирж хан хөвгүүнийг урин залав. Их эрдэнийн харшийн дунд биндэрьяагийн ширээ сайтар засжээ. Түүний дээр мангасын хаан Есөн толгойт рагшас сууж байв. Түүний баруун талд жижигхэн алтан ширээ засаж, түүний зүүн баруун талд цувраад найман толгойт мангас ба мөн зургаа долоо, хоёр толгойт мангасууд хойноосоо дараалан сууж байв. Хан хөвгүүн мангасын хааны дэргэд хүрээд мөргөхийг завдсанд мангас ширээнээсээ унав. Бусад мангасууд, хан хөвгүүний сүрд тэсэлгүй мөргөцгөөв. Чингэтэл есөн толгойт мангас, тэр түшмэлд тушаалыг өгч тэр өөрийн ширээтэй адилхан биндэрьяа ширээг засуулав. Тэр ширээн дээр хан хөвгүүнийг суулгаж есөн толгойт хаан өөрөө ширээн дээр суув. Мангасын есөн толгойт бэлгэ чанар нь нэгд тасын толгой, хоёрт гардийн толгой, гуравт морины, дөрөвт барсын, тавд арслангийн, зургаад матрын, долоод эрлэгийн, наймд найман аймгийн чуулганы эзний толгой, есөд үхрийн толгойтой байна. Үг ярих цагт хоолой нь бүгдээрээ хүнгэнэж луугийн дуун ба Эсэрүгийн дуун адил байна. Ном лугаа зохилдох зарлиг үгийг ярилцав.

– Хаан чи маш буян ихтэй тул хүний дотроос манлай болсон сүр жавхлан хүчин төгөлдөр байна. Тэр дорно зүгийн цэцэрлэгт морилохын цагт чинь үүд хаасан буюу? хэмээн зарлиг болоход

– Би Дорнодын цэцэрлэгт очоод мөнх бусыг бясалгаж байгаад наран шингэх шахсан үед явж ирэхэд хаалга хаагдах шахаж түүний завсарт барс арслан чихэлдэж байв. Өмнийн цэцэрлэгт хүрэхийн цагт зарим ороолон заримыгаа унаж ташуурдан дагаж байв. Цаглашгүй арслангийн Самадийн бясалгалд суув. Нарны улаан гэгээ тасрах шахахад үүдний завсар есөн амтай Дигваранз байв. Намайг ирэхэд тэр гараад явав. Өрнө зүгийн цэцэрлэгт очихын цагт оюу тэвш адил зүлэг найлзуур хувиран зузаан ой цэцэрлэг болов. Чингээд салхин хөдлөхөд хутган хүрд болов. Тэнд мөнх бусыг нэгэн зуур бясалгаж байтал наран шингэсэн байв. Хаагдаж байгаа үүдний завсар нэг том чийрэг төмөр гахай байв. Намайг гарах үед босож одов.

Түүний мөрөөр би гэтэлж гарав хэмээн айлтгасанд хаан

– Хан хөвгүүн хүч чадалтай байна. Миний Алтанзул цэцэгтэй төрөл тутам ханилсан хань

байна. Урьд мэдсэнгүй нь миний махбод доройгоос болов. Одоо Алтанзулыг танд өргөө гэв ээ.

Умрын цэцэрлэгт ном лугаа зохиолдсон яриа ярилцаж, хоол зооглоцгоосны дараа умар зүгийн цэцэрлэгт хаан ба хан хөвгүүн нөхөр лүгээ сэлт морилж хүрээд биндэрьяа ширээн дээр хаан ба хан хөвгүүн хоёул заларч, гадуур нь мангасууд тойрон суув. Чингээд мангасын хаан

Дөрвөн зүгийн дагинас, өргөл хүндлэлийг бүрэн төгс үйлдэж буй тул бага багаар эс зоогловоос сүүл сүүлийнх нь нэмэрлэсээр багтаахгүй чилээрхэхийн гэм болох тул үдээс урьдын хоолыг тааруулан зооглох хэрэгтэй гэв. Тэнд түр байзнаж байтал дорно зүгээс гайхамшигт гоо сайхан тунгалаг царайтай лавайн охин, цул лавайгаар хийсэн таван зүйлийн эрдэнийн чимгээр чимсэн нэгэн саван дотор зуун амт төгөлдөр тэнгэрийн идээг хийж өргөн барив. Цадталаа зооглов. Өдөр дундад оюу охин эрдэнийн чимгээр чимсэн оюу савыг барьж зуун амт төгсгөсөн идээг өргөв. Наран шингэхийн үед баруун зүгээс шүрэн охин гартаа шүрэн саванд зуун амтат идээнүүдийг авчирч өгснийг зооглов. Үдэш болоход алтан охин, их эрдэнийн чимгээр чимсэн алтан саванд тэнгэрийн идээ авчирч барьсныг зооглов. Тэр мангасын хаан

– Та энэ өглөө дэвсгэр засаж өгснөөс хойш одоо хүртэл босохгүй сууж байгаагийн учир юу вэ? гэсэнд хан хөвгүүн

– Би анх тэнгэрийн орноо байх үед тэнгэрийн төгс эдлэл, хотол чуулган болоход дэвсгэр дэвссэнээс эхлээд төгс эдлэл гүйцэж, дуусахыг хүртэл суудаг байсны эрдэм мөн. Тэр цагт бас Алтанзул цэцэг миний нөхөр болж байсан хэмээн айлдав. Мангасын хаан

– Чи одоогийн энэ биеэс тэр цагт аймаар байсан буй за. Миний энэ охин гучин гурван тэнгэрийн орноос цааш газарт солонго гэрлийн хөндийд байсан бөлгөө. Одоогийн биеэс үлэмж сайхан байв гэхэд хан хөвгүүн

– Тэнгэрийн оронд бурхан болж болдоггүй. Урьдын бурхад хүний төрөлд шүтэж бурхан болсон. Би ч бурхны үрийг олохыг бодсон юм хэмээн өчив. Мангасын хаан тэргүүтэй мангасын цуглаан бүгд хан хөвгүүний тэр зарлигт их хүчтэй сүсэг төрж

– Хааны охины үг хүндтэй, хан хөвгүүн хүч чадалтай байна хэмээн магтаад оточ бурхны сүмийн мөргөл адил мөргөцгөөв. Мангасууд мах цусыг нэг жил тэвчих тангараг өргөв.

Чингэхэд мангасын хаан баясаад

– Охиноо өгье гэж ам алдав.

Хааны хүлэг нь хүн иддэг, арслан толгойтой, оюу зогдортой лавайн далавчтай хүлэг байв.

Түүнд алтан эмээл тохож, алтан хазаар хазаарлаж есөн толгойт мангас хүлгийн жолоог барьж байв. Маргааш нь үдээс өмнө хүлгийн дэргэд хаан ирээд, хан хөвгүүнд хэлрүүн

– Одоо эндээс хэдэн бээрийн газар өнгөрвөөс лавайн охин зургаан бум зургаан түм бий.

Зарим нь лавайн нэхмэл нэхэж, зарим нь лавайн унгас томж буй. Сайн байна. Сайн байна. Их төрөлхтөн сайн байна. Суугтун. Их төрөлхтөн өө гэлцэх болно.

Надад сайны хэрэг үгүй. Надад суух газар орон ч үгүй. Би Алтанзул байгаа газарт одно гээрэй. Түүнээс бас хэдэн бээрийн газар өнгөрөхөд оюу охин зургаан түм бий. Зарим нь оюу нэхмэл нэхэж, зарим нь оюу унгасыг томж,

Сайн байна. Сайн байна. Их төрөлхтөн сайн байна. Суугтун. Суугтун. Их төрөлхтөн өө гэлцэх болно.

Надад сайны хэрэг ч үгүй. Надад суухын хэрэг ч үгүй. Би Алтанзулын байгаа газарт одно гээрэй. Тэндээс хэдэн бээр өнгөрөхөд шүрэн охин зургаан бум зургаан түм бий. Зарим нь шүрэн нэхмэлийг нэхэж, зарим нь шүрэн унгас

ТОМЖ

Сайн байна. Сайн байна. Их төрөлхтөн. Сайн суугтун, суугтун. Их төрөлхтөн өө гэлцэх болно. Надад сайны хэрэг ч үгүй. Надад суухын хэрэг ч үгүй. Би Алтанзулын байгаа газарт одно хэмээн хэлэгтүн. Тэндээс хэдэн бээр өнгөрөхөд алтан охин зургаан бум зургаан түм бий.

Зарим нь алтан нэхмэл нэхэж, зарим нь алтан унгасыг томж

Сайн байна. Сайн байна. Их төрөлхтөн өө. Суугтун, суугтун. Их төрөлхтөн өө гэлцэнэ.

Надад сайны хэрэг ч үгүй. Надад суухын хэрэг ч үгүй. Би Алтанзулын байгаа тэнд одно гээрэй. Түүнээс хэдэн бээр өнгөрөхөд уудам том биндэрьяагийн ширээн дээр буй чадагч арсланд хүрнэ. Тэндээс нүдэнд харагдах газарт огторгуйн солонго гэрлийн хөндийд мянган хигээс төгөлдөр хүрд сэлттэй алтан цэцэг байх бөгөөд түүний сэрүүн сүүдэрт миний охин Алтанзул тэр морилон сууж байна. Сувд охин зургаан бум зургаан түмээр эргэн хүрээлсний гол дунд охин минь байна. Та хоёр төрөл тутмын ханилсан эр эм мөн тул тэр охин ширээн дээрээс бууж ирнэ. Одоо тэр Чадагчаас цааш явах газар байхгүй хэмээн айлдав.

Тэр зүгт хан хөвгүүн морилсонд мангасын хааны ямар мэт хэлсэн ёсоор байв. Хан хөвгүүн их эрдэнийн ширээн дээр хүрэхэд охин нөхөр лүгээ сэлттэй доош бууж мөргөв.

– Номч их хаан та бэрх үйлсэд алжаасангүй буюу? Намайг энэрч бодоод энэ зүгт ирэв үү? гэсэнд хан хөвгүүн

– Эцэг хааны зарлигийг сайтар бүтээж охин тэнгэр чамтай учрахаар ирсэн билээ. Одоо яаралтай буцах тул явахыг бэлтгэгтүн гэсэнд

– Өнөөдөр бидний дуу бүжиг тоглоом наадмыг болгоож суу. Маргааш буяны сайн цаг мөн учир маргааш явахыг айлтгая гэв. Тэр өдөр дуу бүжиг тоглоом наадам тэргүүтэн олныг үйлдэж, ном лугаа зохилдсон зарлиг захиаг үнэхээр зохиов.

Түүний маргааш эцгийн дэргэд тэр хоёр эр эм бараалхаж хааны харшид ирэв. Нэгэн сарыг хүртэл дуу бүжиг тоглоом наадам тэргүүтэн ном лугаа зохилдсон зарлиг залиаг үнэхээр зохиов. Тэр хан хөвгүүн хаанд

– Аяа, их хаан аа. Би хаан ширээнд суух ганц хүү мөн тул нутаг орондоо явбаас зохих учир явуулахыг айлтгая гэсэнд хаан

– Миний нүд лүгээ адил энэ Алтанзул цэцэг охинтой адил охин байхгүй. Байхын арга ч үгүй. Чандманиас ч үлэмж билээ. Урьд насны үйлийн барилдлагатай эр эм мөн тул охиныг номын хаан мөн тул чамд өргөсөн болой. Энэ хан төр ба тэр хан төр хоёрыг адилхан тэтгэж, сайн номыг үзүүлэх болно. Мангасын чуулган бүгдээр миний үгийг сонс. «Энэ номч хан хөвгүүн надаас үлэмж байна. Надтай тэнцүүхэн өргөн хүндлэгтүн. Мангасын чуулган аа. Миний зүрх лүгээ адил энэ Алтанзул цэцэг охин, миний хөвгүүнээс үлэмж тул төрөл тутмын хань энэ их номч хааныг оройгоороо хүндлэгтүн. Мангасын чуулган аа хэмээн айлтгасанд тэр мангасын шадар түшмэл мангасын хаан хатан хөвгүүн лүгээ сэлтэд

– Алтанзул цэцэг авхай мангаст ирсний учир нь тэнгэр лус найман аймгийн чуулганы эрхэм охин болон мэндэлсэн ба тухайлваас бүх мангасын чуулганд арван таван, битүүн, шинийн найманд мацгийн санваарыг хайрладаг сан. Номч хаан таны гэгээн баяны буянаар нас ахихад эгч дүү хоёр гарах буй за. Хүн хийгээд хамаг мангасын чуулган бүхнийг ба тэнцэшгүйг нэгтгэн тэтгэхийг их номын хаан мэдтүгэй хэмээн айлтгав. Эцэг хааны удирдсан мангасын чуулган, хан хөвгүүн ба хатан хийгээд таван охиныг хэдэн бээрийн газрыг өнгөртөл үдэв.

Хаан мангасын чуулганд

– Урьд насанд буян хураасан тул эрдэнэт хүний биеийг олов. Алагчлахгүй өглөг өгснөөр хаа ч очсон төгс эдлэл ихтэй болов. Төрөл тутам ханилсан энэ охин тэнгэрийг авчрав. Урьд насны тавьсан ерөөлөөр мангасыг боол болгов. Хаан чамтай дахин дахин учирч номтой зохилдсон



зарлиг захиаг дахин дахин үйлдэнэ хэмээн ном лугаа зохилдсон зарлиг захиа олонтаа ярилцав. Хан хөвгүүн, хатан дагинасын чуулган лугаа сэлттэй одож мангасын хаан чуулган гэдрэг буцав.

Чингээд хан хөвгүүн, хатан, дагинасын чуулган, улсын харшид хүрэх ойртмогц Алтанзул хийгээд дагинас

– Өөртөө ногдсон зарлигт үйл бүтээхэд лусын охин Гардийг дагуулж очвоос сайн гэсэнд хаан

– Энэ далайн дотор лусын хааны надад өгсөн эрдэнийн шанага бий хэмээн айлдсанд охин

– Гарди нь тэр эрдэнийн шанага мөн гэж тэр лусыг дуудсанд лусын хаан хан лугаа сэлттэй лусын харшид урин залав. Хэд хоног ном лугаа зохилдох зарлиг яриа зохиож, өргөл хүндлэлийг бүрэн төгс үйлдэв. Түүний дараа лусын хаанд

– Одоо явья хэмээн айлдав. Лусын хаан таван өнгийн торгоор боосон эрдэнийн шанага тэргүүтэй элдэв зүйлийн эрдэнийг өргөв.

Чингээд хаан хатан харшдаа хүрч очив. Тэр харшийн дэргэд хүрэхэд Алтанзул авхай таван зүйл эрдэнийн шигтгээтэй лавай иштэй Замбативийн цэцэг бүгд түүнд эргэдэг мянган хигээс төгөлдөр алтан цэцгийг гартаа барьж, тэр эрдэнийг хажуугаасаа зүүж ордны үүдэнд хүрсэнд түшмэл албат нөхөр зарц нар нэн ихэд баясаж уйлж мөргөв. Тэр ордны шат өөд дээшээ өгсөж, хаан хатан хоёрын дэргэд очсонд түшмэл албат нөхөр зарц нар баясав. Хатан урьд мөргөдөггүй байсан боловч гэнэт босож

– Номын хаан хүрч ирлээ гээд оточ бурхны ордон дахь мөргөлийн ёсоор мөргөв. Хаан зарлиг болруун

– Хан хөвгүүн сайн номыг үзүүлэгч чи мөргөлийн завсар цэцгээн барьсугай хэмээн айлдсанд Үүнийг барих хэрэггүй хэмээн өчиж цэцгийг хөөргөн тавихад тооноос дээш нэгэн бээр илүү газарт нөмрөн цацарч байв. Чингээд хаанд мөргөл ба хүндлэлийг үйлдэв. Хан хөвгүүн хаанд

– Мангасын орны Алтанзул цэцэг гэдэг энэ мөн гэв. Хан хөвгүүн эцэгт

– Таван зүйлийн эрдэнийн цэцэг өнгө өнгөөрөө үзэгдэж байна. Алтаар бүтээсэн үндэстэй, таван зүйлийн эрдэнийн өнгөөр солонголон дурайсан, лавай иштэй цэцэг үүнээс өөр байхгүй. Хааны цэцгийн хүрээнд үүний үнэр нь халдаад өнө удсан билээ. Одоо болоход үүний үнэр анхилуулаагүй цэцэг ойр хавь байхгүй болов гэв. Хаан

– Үнэхээр сайн байна. Эцэг хөвгүүн бидэнд эрдэнэ хэдий элбэг боловч ийм эрдэнэ байхгүй билээ. Бэрх явдлыг туулсаар явж авчирсан чинь сайн болов гэв. Тэр үдэш цэцгээн бариад таван зүйлийн эрдэнээр бүтсэн харшдаа морилов.

Тэр шөнө эм шулмас, хаанд

– Манай хан хөвгүүн Сайн номыг үзүүлэгч надад төдий сайнгүй муу байна. Энэ хөвгүүн одоохондоо нас залуу тул хааны зарлигийг дуулгавартай сонсож байна. Өдгөө хатантай боллоо. Бид хоёр хөгшнийг жаргаахгүй буй за. Хилэнт эм мангас нэртэй манай энэ ой шугуйт уулыг тэртээ өрнө талд зөөж түүний оронд эргэн тойрон хайсан хөвөөт есөн давхар хэрэм барьж, хотын дээвэртэй чацуу өндөр хоёр уулыг зэрэгцүүлж босгоод түүний хоорондуур усаар дүүргэж хэрэм өөд өгсүүлэн урт шат тавин уул ба харш хоёрын хооронд үүлэн гүүр тавьж энэ гүүрийг хурааж авч болдог тийм хотыг байгуулагтун. Бид тийм хотод эс сууваас хан хөвгүүн рид хувилгаан ихтэй ба Алтанзул цэцэг нь ерийн хүн мөн буй за. Одоо энэ цэцгийг охиноор хувилгасан байна. Бид хоёр тэр хотод хоргодвоос зохистой байна хэмээн айлтгасанд хаан

– Тийм юм бүтэх болов уу? гэсэнд

– Хаан соёрхвоос бүтэх нь лавтай хэмээн айлтгав. Тэр хаан

– Хан хөвгүүнийг иртүгэй хэмээн дуудаж ирүүлэв. Хан хөвгүүн мөргөсөнд

– Бидний энэ зүүн талд буй хилэнт эм мангас нэрт ой шугуйт энэ уулыг баруун тийш зөөж түүний орон дээр харш барь хэмээн барих харшийг шулмас охины урьд сургасны дагуу бэлтгүүлэхээр айлдав.

Эцэг хааны зарлигийг зөрчихийн аргагүй билээ хэмээн айлтгав. Чингээд Алтанзул цэцэг авхайн дэргэд хүрч ирэхэд охин

– Эцэг хаан ямар зарлиг захиаг хайрлав? хэмээн өчсөнд, эцэг хааны ямар мэт айлдсаныг хэлсэн учир

– Эцгийн зарлигийг зөрчихийн аргагүй тул бүтээх хэрэгтэй гээд эрдэнийн зургаан охинд зарлиг болсон нь

– Хааны ямар мэт хэлсэн ёсоор уулыг зөөж, харшийг бүтээж дуусгагтун гэсэнд тэр зүүн уулыг баруун талд зөөж хааны зарлиг мэтээр харш хэрэм асар лугаа сэлттэй бүтээв. Алтанзул цэцэг, хан хөвгүүнд

– Эцэг хааны дэргэд очиж энэ хатан их эм шулмас мөн, үүнийг эм шулмас мөн бусыг сорихын тул дээд цонхны дэргэд ороо застугай. Сарын шинэ мөн тул саран голлох үед орон дээрээ нойрссон янзтай болж худал унтахад чинь тэр эм дун цагаан араагаа гаргаж гэдсэн чинээ соёогоо ярзайлгасан төмөр гахай болж хааны гүрээг хага татах гэж ард чинь ирнэ хэмээн айлтгагтун. Маргааш буяны өдөр тул хатныг байхгүй цагт айлтгагтун хэмээн сургав. Чингээд хан хөвгүүн эцгийн дэргэд очиход тэр эм шулмас хан хөвгүүнд мөргөөд зоог авчрахаар явсан хооронд охин тэнгэрийн ямар мэт хэлсэн учир шалтгааныг өчсөнд

Тэр ч даан ч худал байгаа даа гэв.

Үнэн худлыг энэ шөнө дундын үед үзэгтүн хэмээн айлтгав. Тэр шулмас хүрч ирээд хан хөвгүүнд зоог өргөсөнд түүнийг эс таалав. Хан хөвгүүн

– Маргааш буяны сайн өдөр мөн тул эцэг хаан морилж очно уу хэмээн айлтгав. Тэр шулмас Тэр хотод хоргодох учир тэд нар чөлөө харж хорлох нөхцөлгүй болно хэмээн бодов. Чингээд хаан нойрссон мэт байсанд хан хөвгүүний хэлсэн нь үнэн болсонд хаан айж

– Өглөө түргэн болоосой. Босох юм сан хэмээн бодож байв. Маргааш наран ургахад хааны морилох зам бүгдэд таван зүйлийн эрдэнээр бүтсэн шүхэр дүз ба газар бүхэнд хөгжимт тахил үйлдэж, огторгуйд хив торгон тахил үйлдсэн байв. Урдахь цэцгээс ч нэн илүү сайхан цэцэг төмөр хотын оройд сагсайж багшран байв. Тэд

– Хаан хатныг морилж ирэхийг айлтгая гээд хан хөвгүүн морилж очив. Хааныг урьд шөнө айлгасандаа баярлаж, мөн хоргодох газар буй хэмээн сэтгэл баясаж байсан эм шулмас

– Тэнд хоол унд хэрэглэл хэрэгтэй гэж айлдаж байсан шүү гэхэд хан хөвгүүн

– Тэр харш дотор хоол унд хэрэгсэл барагдашгүй их бий гэв. Чингээд тэр шулмас хэрмийн үүдэнд эргэлдэж байгаад шат өөд өгсье хэмээн сэтгэж очтол эрдэнийн цэцэг Алтанзул шатан дээр тэгнээд сууж байв. Тэнд хаан эцэг хөвгүүнийг ирмэгц Алтанзул эм шулмаст

– Чи хэн бэ? гэсэнд эм шулмас

– Би тэнгэрийн охин мөн гэсэнд тэнгэрийн зургаан бум зургаан түмэн охиныг дуудаж авчраад

– Энэ нь тэнгэрийн охин мөн үү? Харягтун гэсэнд манай тэнгэрийн оронд зарцын зарцад ч ийм охин байхгүй гэсэнд эм чичрээд

– Би лусын охин мөн гэв. Лусын охин Гарди, усны эзэн Барунагийн охиныг дуудаж ирүүлээд Танай лусын оронд ийм охин бий юу? гэсэнд лусын зургаан бум зургаан түмэн охин

– Манай лусын оронд зарцын зарцад ч ийм охин байхгүй хэмээн айлтгасанд бас охин чичирч мөргөөд

– Би Асурийн охин мөн гэв. Асурийн зургаан бум зургаан түмэн охиныг дуудаж ирүүлээд

- Танай Асурийн оронд ийм охин бий юу? гэсэнд
- Манай Асурийн оронд зарцын зарцад ч ийм охин байхгүй гэв. Бас «Би найман аймгийн охин мөн гэв. Чуулганы эзэн заан хошуутын охиныг ирүүлээд
- Энэ найман аймгийн охин мөн үү? харагтун гэсэнд чуулганы эзний хурсан хоёр түм нэг мянган охин хүрч
- Манай найман аймгийн зарцын зарцад ч ийм охин байхгүй гэсэнд
- Чи хэний ч хань байж үл зохицох байна. Одоо чи үнэн дүрсээ үзүүлэх үү? үгүй юу? гэсэнд охин бөөн хар юм болж араа нь дун цагаан араа соёогоо ярзайлгасан цагаан эм гахай болов. Чингэхэд
- Эм шулмас аа, эм мангас чамайг одоо номхтгох цаг боллоо хэмээн айлдсанд хэрмийн уст суваг дотроос орой дээрээ ганц эвэртэй нэг улаан үхэр гарч ирээд шулмасын бөгснөөс мөргөж оройгоор нь ганц эврээ цухуйлгаж усан дотор аваад одов. Чингэхэд эцэг хаан хөвгүүний хамт баясан
- Эцэг хаан номыг зохиож цагаан төмөр хотын дотор суув. Хан хөвгүүн Сайн номыг үзүүлэгч ба охин Алтанзул хоёр хан төрийг барив. Таван аймгийн дагинас бээр дөрвөн зүгийг захирч, бурхны шашныг сахихаар андгайлав. Тэнгэр, ягчис, найман аймгууд ч шажныг сахихаар андгайлав. Чингээд хан төр нь дэлгэрч замбативийг эрхэндээн оруулав. Мангасын орныхон хааны албат нэгэн зүгт хамтарсан болой. Мангасууд мах идэж цус уухыг тэвчиж, номын ёсоор амьдрахыг олонтаа тангараглав.
- Тэр хаан Сайн номыг үзүүлэгч нь цогт Очирваань мөн. Тэр цагийн охин Алтанзул нь охин тэнгэр Одсэржмаа мөн гэсэнд хан хөвгүүн Сайн амгалан явдалтын амнаас
- Номч хаан хатан урьд насанд ерөөл тавьснаар төрөл тутамд эр эм бололцсон нь маш гайхамшигтай хэмээн үг алдсанд
- Хүүрт үг хэлэв хэмээн хүүр нь төмөр торыг гал бадартал гурав дэлдээд араас харцага хүр хэмээн нисэх адил болж алдуурав.
- Хан хөвгүүн сэтгэрүүн: «Лам захиж айлдсан нь: «Тэр хүүр юу яривч үгний хариу бүү гаргагтун» гэсэн боловч миний сэтгэл алгасаж амнаас гурван үг алдсан тул тэр хүүр алдууран одов. Хүүргүй очвоос ламын зэм ирэх болно» хэмээн бодож, бас тэр хүүрийн газарт очиж «Хала» гэсэн хүүрийг тогшуураар нүдэж «Хүлү» гэснийг өшиглөж гишгэлсээр урьдын тэр модны дэргэд хүрэв.
- Очирваань хийгээд Одсэржмаагийн мэндэлсний үед тэнгэр ягчис найман аймгийг боол болгон зарцалж, Замбативийг амгалан болгосон хорьдугаар бүлэг болой.

# НАГАНЖУНАГИЙН ШАСТИРААС ХАН ХӨВГҮҮН ДОНДОВЫГ СУРГАСАН ТҮҮХ, САЙН АМГАЛАН ЯВДАЛТ ХАТУУЖИЛ ҮЙЛДСЭН БҮЛЭГ ОРШВОЙ

Бас хан хөвгүүн модны дэргэд хүрч

Лам минь Наганжуна Зүрхэн мөн. Би хан хөвгүүн Сайн амгалан явдалт мөн. Тор минь есөн нүхт төмөр мөн. Тогшуур минь хүрэн сэндэн мөн. Хүлэг минь мэхт гинж мөн. Хутга минь чулууг огтлогч ирт мөн. Тостой гурил идэвч барагдашгүй идээ мөн. Хүүр чи буухгүй буюу? Модыг огтолно гээд тэр модыг шууд тастахаар цавчсанд тэр хүүр бууж ирэв. Түүнийг тогшуураар нүдэж амыг зааж, нүд рүү нь хутгаар хатгаж, мөч мөчөөр нь мөлтөлтөл торондоо чихээд хүлгээр чанга хүлж үүрээд арван алхам хэр явахын цагт Хан хөвгүүн, хан хөвгүүн хэмээн дуудав. Дуугарахгүй байсанд Үйлээ барсан хан хөвгүүн чиний мэтийн амнаас үг гарахгүй байна. Би нэг үлгэрийг хэлнэ. Сонсогтун.

Нэгэн их голд Сайн туст нэрт нэг номч хаан байжээ. Түүний хатан нь Энэтхэгийн өрнө зүгийн нэгэн хааны авхай бөлгөө. Хэдэн жил болсонд хатнаас хөвгүүн төрсөнгүй. Шоочноор шодуулж, төлгөчнөөр төлгөдүүлсэнд

Гадаад их далайд очиж, тэнгэр лусыг тайж тахиваас хөвгүүнтэй болно гэсэнд тэр хаан хатан, албат нөхөр бүгдээр охин тэнгэрийг тахих хэрэглэлийг олон их заанд ачиж ачаа хэрэглэл сэлтийг авч хувцас чимгийг өмсөж зүүсэн

ардуудын хамт их далай тийш одов. Завь онгоцоор явж тэнгэр, лус газрын эзэн оршсон ариухан тэр газарт очиж долоо хоног хүртэл чухаг дээдэд залбиран ном сахиулсанд чуулганы бэлгийг өргөж, найман аймагт бэлэг өгөв. Долоо хоногийн дараа хөвгүүн төрөхийн сайн бэлгэ үзэгдсэнд нутагтаа буцаж ирэв.

Нутагтаа ирээд арван сарын нүүр болоход үлэмж сайхан нэгэн хөвгүүн мэндлэв. Шинжигч бярманд үзүүлвээс

Хөвгүүн нь бэлгэ чанар лугаа төгсгөсөн бөгөөд бурхны хувилгаан мөн байна. Тал бүрдээ нэг алд дүүрэн гэрэл цацарсан байгаа тул чадагч бурхан мөн болов уу? гэхэд тэр хаан хатан хоёр баясаж, албат нөхөр зарц бүгдээрээ баярлан хиур хийсгэж, лавай үлээж хан хөвгүүнд «Дондов» хэмээн нэр өгөв. Чингээд хан төр нь номчлон дэлгэрэн мандаж байсаар хан хөвгүүн Дондов дөрвөн нас хүрч гайхамшгийн гуа тунгалаг сайхан царайтай хөвгүүн болов.

Түүний эх нь хүчир өвчин тусаж халив. Чингэхэд албат нар ч их гаслалдаж – Түүнийг хальснаас хойш орон нутаг дахь газрын шим ч доройтож муудав хэмээн ярилцах болов.

– Одоо тийм хатныг эрэхэд олдохгүй боловч нэг хатан хэрэгтэй байгаа хэмээн бүгдээрээ ярилцаж, хаан ширээнд зохицох хатан олоогүй учир зохисгүй нэг хатныг олж авав. Чингээд нэг үе болоход түүнээс гайхамшиг гоо сайхан царайтай нэг хөвгүүн мэндлэв. Тэр хөвгүүний алдрыг «Донид» хэмээн нэрийдэв. Ах дүү хоорондоо цаглашгүй их амраглан байв. Зоогийг нэг аяганаас идэж уудаг, нэг ор дэрэн дээр өвөртөө орж нойрсоцгоодог байв.

Нэгэн үе болоход хатан нь харшийн орой дээрээс үгмэрийг болгоогоод явж тэртээх дорно зүгийн зүлэгний дунд хүрч сонирхон чагнаж байсанд тэр дорно зүгт тоглоом наадагчид найман түм дөрвөн мянга орчим хүмүүс дуулан цоордож байв. Тоглоом наадамд холхин тойрогч бүхэн бэр эрэх зэрэг дэмий яриа ярьцгааж тэдний дундаас зөвлөгөөнийг удирдагч голлон ярьж буй зарим нь

– Манай энэ хаанд хоёр хөвгүүн мэндэлсэн билээ. Хаан ширээнд их хөвгүүн нь сууваас зохистой. Эхийн талаас энэ бага хөвгүүнд хаан ширээг эзлүүлэх гэх биз хэмээн тэнд байгаа бүгдээр ам нийлж

– Энэ хан хөвгүүн Дондовын эх нь хаан язгууртайгаар үл барам, Дондовыг өөрийг нь тэнгэр нарт залбирч олсон тул бурхны сайхан бэлгэ тэмдэгтэй хөвгүүн буй. Хаан ширээнд тэр л суухаас өөр хүн суух зохисгүй. Энэ хан хөвгүүн Донид бол дүү болохоос гадна, эх нь ч зохисгүй хүн тул хаан ширээг эзлэх учиргүй хэмээн ярилцаж байв. Тийм үгийг сонссон тэр хатны сэтгэл гунигт автагдав.

Чингээд өмнө зүг тийш харах цагт өмнөдөд буй нэгэн том хөндий талд эрчүүд цөм сум харвагчид, харайгчид, дүүгүүрдэгчид тэргүүтэн цугларч байв. Тэд наадмын завсарлагаагаар мөрийн архийг ууцгааж бүгд нийлэлдэн яриандаа ид орж дэмий балай юм хүүрнэж байгаа хүмүүсийн дунд очсонд хан хөвгүүн ах дүү хоёрын тухай урьд мэт яриаг ярьж байв.

Хаан ширээнд хан хөвгүүн Дондов сууваас зохистой. Хан хөвгүүн Донид дүү бөгөөд ээж нь зохисгүй хүн тул хан ширээг үл эзэлнэ хэмээн урьд мэт ярилцаж байв. Чингэхэд хатан Миний энэ хүүгээр хаан ширээг эзлүүлэхгүй ажгуу хэмээн сэтгэн гунив.

Бас баруун зүгт доошоо болгох цагт охид унгас ээрэн, нэхмэл нэхэж, угас томох зэрэг ажлыг хийж тэнд цугларсан байв. Үдээс өмнө нэхмэлээ нэхэж оройхон болоход бүгдээр хошуу холбож янз бүрийн үг ярилцаж байв. Үдэш болоход хаа ч адил хан хөвгүүн Дондовын эх нь хан төр сайтай учир тэр яавч хан болох буй заа. Хан хөвгүүн Донид нь дүү бөгөөд эх нь ч зохисгүйн учир хан төрийг үл олно хэмээн учир түүхийг ярьцгааж байв. Чингэхэд хатны сэтгэл агшин төдий ч амрахгүй болов.

Бас харшийн хойд зүг өөд харсанд хүүхдүүд тоглож наадаж, найман түм дөрвөн мянгаад хүүхэд цугларсан байв. Зарим нь ширээ засаад нэгийгээ хан хөвгүүн Дондов байна хэмээн хаан ширээн дээр гаргаж байв. Зарим нь

– Хан хөвгүүн Дондовын бараа бологч бид байна хэмээн мөргөлийн харамж авч явахдаа булаалдсаар байв. Нэг нь

– Би хан хөвгүүн Донид мөн. Хан ширээнд би суух учиртай гэхэд бүгдээрээ хэлсэн нь Хан хөвгүүн Дондов ахмад бөгөөд ээж нь сайн учир хаан ширээг эзэлвээс болно гээд хан хөвгүүн Дондовыг хаан ширээнд суулгахаар шийдэж бүгдээрээ ханилаад явцгаав. Чингэхэд хатан «Хаан ширээг хан хөвгүүн Дондов эзлэх бололтой. Миний хөвгүүн хаан ширээнд сууж чадахгүй бололтой. Хөвгүүн минь хаан ширээг эс эзлэвээс эхийг ч үл тоомсорлох больюу» хэмээн сэтгэж муу санаа төрөв. Хан хөвгүүн Дондовыг үгүй болгох нэг арга үйлдье» хэмээн сэтгэж баруун завжиндаа улаан будаг хийж, зүүн завжиндаа хөх будаг хийгээд хар хүрэнгээр бөөлжиж, тэр шатаар бууж яваад хотын саравчинд байгаа бие зарлиг тааллын шүтээнийг эргэж явсан Сайн туст номч хааны мөр дээр очиж хялайн харж, өнхөрч унан хар хүрэнгээр бөөлжиж, нүүр амандаа цус улайртал нялаад

– Би өвдлөө хэмээн унан тусан хэвтэж байхад хаан

– Чиний энэ ямар өвчин бэ? Юу өвдсөн бэ? Хэмээн айлдаад

– Юу туслах вэ? хэмээн бодож хааны сэтгэлд урьдын хатан хальсан нь гэнэт бодогдож

Одоо хэрхвээс сайн бэ? Юу туслах бол? хэмээн сэтгэл нь тэвдэж бачимдав. Чингээд шоочингоор шоо тавиулж, төлгөчнөөр төлгө тавиулавч тус огт болсонгүй. Гүрэм дором хийж чухаг дээдийг тахиж тэргүүтэй хэчнээн их юм

үйлдэвч эс туслав. Хаан сэтгэл гансарч өвчтэй болоход хүрчээ.

Чингээд хэд хоног болсонд хатан

– Надад туслах ганцхан арга бий. Тийм юмыг үйлдэх нь үл зохих тул би өөрөө үхэхээс өөр

арга байхгүй гэв.

– Чамайг туслахын арга байваас заавал үйлдэнэ. Тус болох юу байна? гэсэнд хатан

– Манай хан хөвгүүн Дондов бол хүн бус шулмасын хувилгаан байна. Үүнийг нярайлсан даруйд эх нь ч хальсан. Одоо надад ч үхлийн хорлол тусаад байна. Тэр бид хоёр ч яамай. Хаан таны амь биед гэм хор ирэх муу ёрын төлгө хийгээд эш гарч байна. Үүнийг алаад надад зүрхийг нь өгвөөс тус болно гэж байна. Хааны бие аминд түүнээс илүү гэм болох юм байхгүй. Тэр мэтийг хийж эс болох тул гадаад далайн өөр нэг тивд түүнийг анх гуйж авсан газар хүргэх ахул бүгдэд хорлолгүй болно. Чингэж үйлдвээс гаднын хүмүүс хочлох болно.

Тиймийн тулд намайг зоргонд нь орхивоос зохино хэмээн өчив. Хаан түр бодол бодов.

– Миний үлэмж сайхан тэр эхнэр байх цагтаа чухаг дээдэд залбирсан учир энэ хөвгүүн төрсөн бөлгөө. Үүний эх нь үхэв. Шинжээчин бярман ч намайг үхээгүй байхад хан төр барих хүн ирнэ гэсэн. Өөр хүн ирж хан төрийг эзлэхгүй буй за. Амины ганц цуврал минь энэ байна. Төлгөнд гарсан эш ба зүүд цөм үнэн тохирч буй ажгуу хэмээн бодоод хаан хатандаа

– Чамд тус болно гээд алах болбоос эрхэм хатанд бузар болно. Манай энэ хан төрийн ёсонд амьтныг хөнөөн хорлохыг тэвчсэн тул хөвгүүнийг алваас тамд төрөх буй за. Тийм хилэнцэт үйлийг юунд тулавч үл хийнэ. Чиний хэлсэн мэтээр хязгаарт цөлөх нь хэрэгтэй болох буй за хэмээн үг алдав. Чингэхэд хатан ч хааны үг алдсанаас хойш өвчин гайгүй гэдэг болов. Хаан нь албат нарыг цуглуулж

– Манай хан хөвгүүн Дондов шулмасын хувилгаан мөн байна. Түүнийг анх тэнгэрээс гуйж авсан учир одоо нутаг газарт нь цөлөх болно. Түүний бэлэг хэрэгсэл, хоол, эд таваарыг төхөөрөгтүн хэмээн хаан зарлиг болов. Хааны хэлэх нь ганцхан тул няцаан айлтгах аргагүй болж, хааныг далдуур цаглашгүй хочлов.

Хан хөвгүүн Дондовт сайн хүмүүс өөрт нь

– Манай энэ хатан хан хөвгүүнд хар буруу санаж хаанд сонсгол мэдээ хүргэж, хан хөвгүүнийг хөөлгөх болсон байна хэмээн айлтгав. Чингэхэд хан хөвгүүн «Алуулснаас яавч дээр дутаан одьё хэмээн бодоод дүүтэйгээ хоёул унтдаг нэг хөндий өрөө байсан тэндээ хоёул идээний үлдэц бүхнийг хураадаг байжээ. Чингээд хаан хатан хоёр хан хөвгүүн Донидыг дуудуулж

– Хөөрхөн бяцхан дээл гутал, бяцхан нум сум хийсэн бөлгөө. Хэр таарахыг үзэгтүн хэмээн урамшуулав. Ах дүү тэр хоёр дэндүү амраг тул хаан хатан хоёрын дэргэд ч салсангүй. Тэр хан хөвгүүн Донидод хүмүүс

– Энэ ахыг чинь хязгаар газар цөлөх гэж байна. Чи энэ ахаа бараадаж байх нь сайн бус гэв.

Чингэхэд дүү

– Ах аа, Та хязгаарт цөлөгдөх гэж байна. Ахдаа хань болно. Намайг дагуулж яваарай гээд ахынхаа хүзүүгээр тэврэв. Түүнд ах нь

– Хязгаарт цөлвөөс идэж уух юм огоот үгүй. Гадаад их далайд орхигдох болно. Чи чингэснээс хоол хувцасны эзэн болж хааны энэ үндсийг бариваас зохино. Эхээс төрсөн бусад хөвгүүн үгүй. Бид хоёул усанд орхигдвоос эцэг хааны үндэс ч тасарч одно. Чингэснээс харшийн дотор гүйж байтугай. Намайг тэр эцэг эх гарзанд үл бодсон тул өр төлөөсөөр алагдавч үл хайхарна гэсэнд дүү нь

– Ахад ийм зовлонтой үйл ирсэн тул хааны үндэс тасравч тасартугай. Үхэвч амьдравч ах дүүтэйгээ заавал ханилж явна хэмээн ахын дэргэдээс нэг ч алхам холдох дургүй болов. Хаан хатан хоёр

– Маргааш ахыг нь гадагш цөлөхийн үеэр түшмэлүүд тэр дүүг барьж хоцрогтун хэмээн айлдав.

Чингээд өдөр хоног тооцож хан хөвгүүнийг хязгаарт цөлөхийг бэлтгэв. Тэр хан хөвгүүн

Дондов: «Энэ дүүгээсээ би хагацахын арга байхгүй. Бид хоёр ханилаад явавч дүүг байхгүй болбоос эцэг хааны таалал гансарч зовох болно. Бид хоёул хамт явбаас хааны үндэс ч тасрах болно хэмээн бодоод шөнө дунд гэнэт боссонд дүү мэдээд ахын хүзүүнээс тэврээд унтав.

– Ах явбаас би ч явна гэж хэлээд дүү нь ахыгаа явах зав гаргасангүй.

– Өдгөө одод ч түгж байна. Шөнө тахил бэлтгэж байгаад явах хэрэгтэй хэмээн бодож дэрний дэргэд цуглуулсан идээний үлдцийг бугын арьсан тулам дотор чихэж тавив. Шөнө хэдэн удаа дугаах гэвч дүү нь мэдэж гаргасангүй.

– Би энд юу үйлдвэрч энэ дүү хоцрохгүй байнам хэмээн сэтгэж, хүн нохой хэвтсэн хойгуур туламтай хүнсээ мөрөн дээрээ тохоод гарч явсанд ахыгаа явахаас сэжигдэж гутлаа тайлалгүй хэвтэж байсан дүү нь мэдэж босоод

– Ах хааш явсан ч мөрөөр би ч явна гэсээр хүрч ирсэнд

– Хүү жаргалаа зовлонгоос арилжина гэдэг чамд иржээ. Ахыгаа зовохын ташрамд дүү минь ч зовох байна гэж хэлээд дагуулан явав. Аль өөд явна гэхийн байр чиггүй, зам мөр гараагүй нэг их элстэй тал газарт цаашлан явав.

Хан хөвгүүнийг хязгаарт цөлөх бэлтгэлийг гүйцэтгээд хан хөвгүүнийг урин авчрахаар хүн явуулсанд

– Хан хөвгүүн ах дүү хоёул ойр хавьд байхгүй болжээ хэмээн хаанд айлтгав.

– Тийнхүү байхгүй болбоос манай албат ардууд нуусан буй за, эрэгтүн гэв. Албат нарын дотор эрээд эс олов. Морьтой элчийг дөрвөн зүгт гаргавч хан хөвгүүн ах дүү хоёрыг олж эс чадав. Чингэхэд тэр хаан хатан хоёр таалал алжааж тэр хатан ч хуурмаг бус үнэн өвчтэй янз гаргаж байснаа болив. Албатууд

– Тэр хааны алжаан зүдэрсэн нь хатанд тус болов хэмээн ярилцав,

Түүнээс хан хөвгүүн ах дүү хоёр жаргал үзэлгүй, эзгүй тал газар явахад буг чөтгөр, хортон араатан хорлолгүй мөргөн угтаж өчүүхэн төдий ч хөнөөл хүргэсэнгүй. Хэдэн сарын турш эзгүй цөл талд тэнэж ах нь хатсан бөөн гурилыг идээд дүүдээ бөөн гурил өгдөг байв. Замын хоног олон тул идэх юм барагдаад тулмаа урж идэв. Тэр туламд давстай хоол байсны учраас ам цангах нь улам нэмэгдэв. Хээр талд өнө удаан болсон ба хоол ч өчүүхэн тул биеийн чадал доройтов. Чингэж явсаар усгүй хөндийд хүрэв. Дүү нь балчирдаад цангаж үхэх шахаж гишгэж явж чадахгүй болсонд түүнийг үүрч явдаг болов. Ус эрэхэд ус олдсонгүй. «Уулын нэг хошууны ард ус бий» хэмээн сэтгээд

– Чи эндээ сууж байгтун. Ах нь хурдан яваад ус эрээд ирье. Ах чинь хурдан явна. Чи орхино гэж бүү сэжиглэ. Ус эс олдвоос бид хоёул үхэх болно шүү гээд ах нь явав. Ах нь ус эрэвч олсонгүй. Бас нэг уулын хошууны ард ус бий болов уу хэмээн сэтгээд цааш явав. Тэр дүү нь ахыгаа харсаар бүлтийгээд сууж байснаа ахыгаа холдож цааш явахаар дүү нь «Ах аа» хэмээн дуун алдаж түрүүлгээ хараад унав. Ах нь эргэж харсанд дүүгээ унахыг үзээд буцаж гүйж ирэв. Дүүгийн дэргэд ирсэнд дүү нь нэгэнт үхсэн байв. Түүнийг өвөр дээрээ аваад бүсээ тайлж элгэндээ авч аманд нь шүлсээ хийж, чихэнд нь дуудсан болой. Дуудавч тэр сэргэсэнгүй. Ах нь «Би дүүгээ оршуулдаг болжээ» хэмээн гайхаад хоцров. Тэр дүүгийнхээ хүүрт ерөөл тавьж

– Бид хоёр нэг ч хагацдаггүй байсан. Одоо би гав ганцаараа явах хэрэгтэй болов. Эцэг эх хан төрийн дотроос тосны дундаас гарсан өд мэт гав ганцаараа эзгүй талд хоцров. Таньж мэдэх нь тэнгэр газар хоёроос өөр юмгүй. Би урьд насандаа ямар үйл үйлдсэн бол доо. Би өөрөө үхээд дүү минь үлдсэн бол сайн сан. Гэвч тусгүй. Үхэх, мөнх бус гэгч үүнийг хэлдэг. Бөглүү хол ч байдаггүй. Надад урьд насны Ядам бурхан байдаг бол энэ насанд бид хоёрыг уулзуулаад улмаар эх эцэгтэй ч уулзуулах болтугай. Хилэнцэт үйлсийг тэвчих болтугай. Энэ үлгэрийг

бодоод хоол унд өөрт аль байснаа өглөгт өгөн чадах болтугай. Үхэх, мөнх бус энэ бөглүү холгүй бөгөөд бүхэнд ирдгийг дахин дахин дурдах болтугай. Алс сүүлд бодийн үрийг олох болтугай хэмээн ерөөл тавьж түр нэгэн Самадид оршив. Даяаныг тайлж үүгээр ч үл туслах байна! Чингээд тэр дүүгийн хүүрийг эвлүүлэн үүрээд арван найман хөтөл голыг давж өнгөрөв. Тэнд байгаа нэг их нөмөртэй хадны хавьд том бут мод байв. Тэнд оршуулж болох гэвч «доор газар төрнө» хэмээн сэтгэж тэр том бут модны дээр авирч гараад түүн дээрээс харваас Алхат уул ба цаст уулаас бууж ирсэн урсгал устай нэг газар байв. Тэнд модны сэрүүн сүүдэрт сайхан хавтгай чулуун хайрцаг засаж амьтны хорлол хөнөөл хүргэхгүй болгож оршуулав. Хайрцаг далдрахыг хүртэл хагацаж ядан буцаж харан харсаар одов. «Түүнд хоргодовч амьбрахын аргагүй байна» хэмээн сэтгэж олон гол хөтөл давж одов.

– Тэнд хүн нохойн чимээ анир огоот үгүй байтал чихэнд Диншагийн дуун жингэнэж дуулдсанд «Энэ голд нэг хийд байгаа бололтой хэмээн бодож сайтар ажиглан харсанд замаар явсан нэг хүний мөр байв. Түүнийг дагаад явсанд нэг булгийн дэргэд бясалгагч тойн балин өргөх уншлага уншиж байв. Түүний дэргэд очвоос балингийн гурил ба мөхлөг балин нэн элбэг овоолоотой байв. Өлссөн учир түүнээс идсэнд тэр лам түр нэгэн удаа ширтэж хан хөвгүүнийг ажиглав. Хан хөвгүүн эзгүй талд өнө удаж дотроо хоолгүй тул мариа нь барагдаж ясан хэлхээ болсон ба талын их дэрсэнд дээл нь навсартал элэгджээ. Үлэмж сайхан дүүгээ үхүүлснээс болж толгойн үс нь өөдөө өрвийн, дүрс царай алдсан түүнийг лам ажиглан гайхаж суув.

– Би бүтээлийг шүд цагаан залуу цагаас хөгширч үсээ цайтал үйлдэж балинг жил сараар бүтээж бясалгал үргэлжлүүлэн хийв. Зорилгогүй юм байхгүй билээ. Үүнээс урьд бирдийг илт үзсэн удаа огт үгүй гээд эрихээрээ нэг шавхарч хатуу тарни ч тоолов. Хан хөвгүүн сэтгэрүүн: «Өдгөө дотор гэдсэндээ хоолгүй, гадна орогнох орон байргүй байна. Хүний насны эхэн адаг бүхэнд жаргах зовох дэлгэрэх буурах жам ёс нь минийхтэй адил байна. Өөрт юм байгаа цагт юу байгааг хоолоос тусгайлж өглөгийг алагчлахгүй үл өгсөн минь гансралтай. Нойр хоолоо орхиж зургаан зүйлийн амьтныг буянд дуртгая» хэмээн сэтгэж, бат тангаргийг тэр үед тавив. Тэр ламын өмнө гурав мөргөөд

– Би бирд бус, хоосон хүн. Дэлгэрэх буурахыг үзсэн хүн хэмээн айлтгасанд

– Хаа очихоор яваа буй? хэмээн айлдав. Хан хөвгүүн

– Ламын яруу алдарт шүтэж, ус авах ба хоол бэлтгэх зарц болохоор ирсэн хэмээн айлдав. Тэр хан хөвгүүний үсийг хусаж дээлийг нь сольж амьдарлагыг үнэхээр өөд татав.

Лам нарийн ажигласанд хөвгүүн нь бэлгэ чанар төгөлдөр бөгөөд эргэн тойрондоо гэрлийн хүрээ цацруулсан байв. Лам баясаж

– Хааны тахилын лам өвгөрөхөд миний ор болох хөвгүүнийг номын сахиус өгсөн буй за хэмээн бодоод ламын хоол хийх ба ус авахыг захиж таалав. Маргааш нь тэр голын эхэнд дэрс хадахаар явуулж түүнээс хойш өдөр дэрс хадахаар явуулдаг болов. Дэрс маш элбэг тул хоёр үүргийг нэгэн бөөн болгон авч ирж нэг үүргийг ламын орон дээр дэвсэж, нөгөө үүргийг өөрөө дэвсэж өдөр бүр сольдог байв. Чингээд голын эхэнд очоод тэр уулын орой дээрээс харахад тэр голын адагт хааны харш тэнгэр тулсан мэт сүндэрлэж, бас нэг их далай, тэнгэртэй зах нийлэм харагдана. Хааны албатын хязгаар нь үнэхээр үл мэдэгдэнэ. Тэндээс уруудаж буцахдаа их багаар түрүү түрүүчийн авч байсны хэр дэрсийг хадаж аваад ламын нойрсох дэвсгэрт өвсийг тавихад урьд дэвссэн өвс нь бүлээн бөгөөд даршиж тогтсон байв. Түүний өөрийн доор дэвссэн өвс огт тогтдоггүй байв. Чингэхэд лам

– Чиний ор дэвсгэр чинь огт тогтдоггүй, шөнө нойр муу хүрдгийн учир юу вэ? Чамд сэтгэлийн зовлон их байна. Надад хэлэгтүн гэхэд



Ламд эс айлтгаваас бус хэнд айлтгах вэ? Миний санааширч явдаг нь нэг их төр улсын эзэн эцэг хаан Сайн туст гэгчийн хөвгүүн мөн. Хойд эх ирж намайг хязгаарт цөлүүлэв гэх зэргээр урьдын шалтгааныг дэлгэрэнгүй өчиж бас

– Миний зүрх лүгээ адил дүү минь үхсэн учир толгой дэрэн дээр тавивч нойр огт хүрдэггүй. Ламын ачийг санаж явсаар ийм болов гэсэнд Лам

– Чи эгэл хүн бус байна. Овог яс ч хаан мөн байна.

– Эцэг эх хоёр чинь ийм хөвгүүнээ цөлж орхих гэж дээ! Одоо дүүгийн чинь ясыг авахаар маргааш явъя. Хөвгүүн Дондов чи замыг удирдагтун хэмээн айлдав. Хэд хоногийн хоол хүнс аваад яс байгаа газар тийш явсаар хоёул тэнд хүрэв. Сэрүүн халхавчтай бутны дэргэд очиход хавтгай чулуун хайрцгийг онгойлгож гараад алга болжээ. Зүг бүхэнд харавч бутарсан яс үс ч үл үзэгдэнэ.

– Хөвгүүн Донид нь ахын ерөөл тавьсан ба зуны дунд сар болоход хур бутан дээр бууж, бутнаас унасан дуслын ус хан хөвгүүний аманд орсон учир өнөд удаан цангасан тэр сэргэж, хан хөвгүүний бие сэтгэл салаагүй байсан учраас босож гараад эзгүй талд тэнээд явчихсан тул тэр хоёртой эс тааралдав. Лам шавь хоёр ч хийддээ буцаж ирэв.

– Хот мандлын хумхын зан үйл тэргүүтнийг хан хөвгүүний хойдын тусын тулд үйлдэв.

– Хан хөвгүүн өдөр бүр голын зхэнд түлээ түүхээр очдог байв. Зарим хүүхэд «ах Дондов» гэнэ. Зарим хүүхэд «Бяцхан дүү Дондов» гэнэ. Бяцхан хөвгүүнийг үнэхээр хайрлаж сайн хэлэлцдэг болов. Чингээд хүүхдүүдтэй үерхэж наадалцах ба ноцолдох болов. Тэр хөвгүүн луу жилтэй учир өөрөөсөө том ахмадуудыг ч доороо захирч чаддаг болов.

– Энд луу жилтэй хэн ч байхгүй. Би луу жилтэй учир алдар минь луунаас их болов. Би дээд талыг эзэлдэг нь түүний учраас болжээ хэмээн нэг удаа ам барджээ. Чингээд ламын дэргэд буцаж харив.

– Тэр голын хаанд гайхамшигт гоо тунгалаг царайтай нэг охин буй. Өөр хөвгүүн байхгүй бөлгөө. Буяны сайн цагт тэндхийн далайд оюу хөх луу дуугарсаар огторгуйгаас тэр далайн гол дунд бууж ордог байжээ. Хаан түшмэд ч үзмэр, наадам хурим тэргүүтнийг тэр өдөр хийдэг байжээ. Наадам хурим үйлдэхэд хаан гүрэнд хур бороо цаг үесдээ бууж, жилийн тариа сайжирч, хүн малын өвчин арилдаг байжээ. Гадаад их далайд юу санасныг сэтгэлчлэн бүтээдэг чандмань эрдэнэ байх тул ерөөл тавьж бүх юмаа бүтээж гардаг байжээ. Сүүлийн үед хувь заяа хомстсон учраас тэр амьд луу далайд буухгүй болсон тул луутай арван хоёр нас хүрсэн хүнийг амьдаар нь далайд хийдэг заншилтай болсон бөгөөд хаан түшмэд ч чимэг хувцас өмсөж залбирлыг тавиваас урьд мэт санасан бүгдийг бүтээдэг байв. Чингээд тэр голоос жил нас таарах нэг хүнийг эрж явсанд

– Эр бөгөөд арван хоёр настай нь энэ хөвгүүн Дондов байна хэмээн сонсоод түүнийг авчрах элч даяанч ламын дэргэд очив. Чингээд

Манай хаан зарлиг болсон нь ламын энд арван хоёр нас хүрсэн нэг хүүхэд байна гэнэ. Сайн бэлгэтэнд хэрэгтэй болсон тул түргэн өгөгтүн хэмээн хэлээд хаалгыг дэлдэв. Ламын таалалд «урьд далайд хийдэг нэг учир бий тул сайнгүй болов» хэмээн бодоод хөвгүүний дээрээс тогоо хөмрөн нуугдуулж

– Ямар яриа гаравч надад муу үл болно. Чамайг далайд хийх гэж байна. Бүү дуугараарай хэмээн захив. Лам

– Би жил сараар бүтээл хийдэг хүн тул хөвгүүн ач хаанаас байх вэ. Намайг алах аваас зүрхийг минь сугалж алтугай гэв. Лам аргаа бартал тэдэнд шахагдан, шаардуулж байв. Тэд бүгдээр агуйд чихэлдсээр ороод агуйг нэгжиж ламд хутга гарган алах гэж бачимдуулж шаардсанд хан хөвгүүн тогооны нүхнээс гараад ламыг алчих байх гэж сэтгээд

– Би энд байна. Миний ачит ламыг чингэж болохгүй хэмээн тогоогоо өргөж хаяад босов.

Нөгөө хөвгүүн чинь тэр байна хэмээн баясаж

– Гайхамшигийн сайхан хөвгүүн байна гэлцээд гараас нь шүүрэн авч хөтлөхөд лам бас шүүрэн баривч дийлсэнгүй. Ламыг гэдрэг түлхэж унагаад алдуулав. Тэр лам гасланд дарагдаж зоогоо ч зооглолгүй бүр нярваан болоход шахав.

Тэр хан хөвгүүн хааны дэргэд очсонд хан хөвгүүнийг үзээд

– Гайхамшигт хөвгүүн байна гэж хаан ч баясав. Хоёр гурван хоног хааны нойрсолгын байшинд байв. Хааны арван хоёр настай гайхамшигт сайхан тунгалаг царайтай охин нь хан хөвгүүнд сэтгэл татагдав. Тэр хоёр бие биеэсээ салж чадахгүй хамт байх болов. Гадаад их далайг тахих цаг тулж ирэв.

Энэ хоёр салж чадахгүй болжээ. Хэрхвээс сайн? гэлцэхэд хан хөвгүүн

– Охин намайг зуураад тавихгүй байна. Эрдэнэ авдаг онгоц дотор чадалтай түшмэлийг бид хоёртой хамт суулгаж явуулагтун. Чингээд охиныг унтаж байхад нь баригтун. Би та бүхний тус ба зургаан зүйлийн амьтны тусын тулд сэтгэл татгалзахгүй шийдвэрлэн явна хэмээн айлдсанд түшмэд хаанд тэр ёсоор айлтгав. Хаан баясаж

– Хөвгүүний тэр хэлдэг үг зөв хэмээн айлдав. Нөхөд түшмэд хамтаар тэр хоёртой ханилж яваад хөлөг онгоцонд сууж цаашлан одов. Охин хан хөвгүүнээс олон хоног зуурсан тул гар нь суларсан байв. Хан хөвгүүн түшмэдэд

– Баригтун хэмээн нүдээр дохио өгөөд хан хөвгүүн өрөвдөх сэтгэлээр далайд харайн оров.

Огторгуйд солонгын гэрэл шүхэрлэж, газар дэлхийд луугийн дуун дуурсаж цахилгаан цахилав. Тэр түшмэл охиныг барьж хааны харшид буцаж ирэв. Тэр их далайн гол дунд, лус гавуу зогбуу хоёроор удирдуулсан лусын охид маш олон байв. Хан хөвгүүн бөөгнөн цугларсан тэд бүгдийн дэргэд хүрсэнд лусууд хан хөвгүүнийг угтаж өргөл хүндлэлийг бүрэн төгс өргөж

– Урьд бол бидэнд нэг хүнийг өгдөг байсан. Далайд хүргэсэн хэдэн нөхөд уйлан цурхирах ба хөгжмийн яруу дуун сэртгэшгүй болдог байсан. Өдгөө номч их хаан та энд ирснээр манай лусын орныхон шим төгөлдөр болоод нас уртсаж амьтан бүгдийг сэрүүн хур амирлав. Үхвээс ч тэнгэрийн оронд төрөх болно гэлцээд маш их баясав.

– Одоо та дээшээ морилохгүй буюу? Манай лусын оронд амьтны тусын тулд суутугай хэмээн өчсөнд хан хөвгүүн

– Би хаа суусан ч ялгаагүй. Миний нэг сайн лам бий. Таалал гансран чилж хоцорсон. Нэг дүү байсан нь дэвэн дэлхийгээр тэнэж байгаа буй за гэв. Чингэхэд лусууд

Чингэвээс өөдөө морилохыг айлтгая гэв.

– Таны ачаар одооноос хойш далайд хүн хаяулахгүй болгоё. Чандмань эрдэнэ ба газрын хамаг шимийг урьд урьдаасаа илүү үлэмж болгоё хэмээн тангаргийг өргөв. Хан хөвгүүний хормойд өдий төдий үлэмжийн эрдэнийг дүүрэн хийж өргөөд мөргөж ерөөл тавьцгаав.

Хан хөвгүүн нүдээ аньж «Тэр ламын дэргэд хүрье» хэмээн бодсон даруй ламын дэргэд хан хөвгүүн хүрсэн байв. Тэр лам хан хөвгүүний хойноос гасланд дарагдаж хоол ундаа ч эс зооглодог тул нярваан болох шахсан байв. Нүдийг нь зовхины нь арьс халхалж, хүн танихгүй болжээ. Ламын хүзүүнээс тэвэрч

– Миний лам аа. Ийм болчих гэж дээ. Би ирээд байна шүү. Лам тааллаан бүү чилээтүгэй хэмээн айлтгасанд

– Миний хан хөвгүүн, их далайд хийгдсэн тул үхсэн буй за. Үхээд буцаж ирэхийн ёс хэрхэвч байхгүй гэдэг. Чи намайг тавлаж байна уу? гээд лам муужран унав. Чингэхэд нь борцны зутан өгч биеийг тосоор илж сэргээв. Ламын нуухыг арилгаж зовхийг өөд сөхөж хүзүүнээс нь тэвэрч

- Би хан хөвгүүн байна шүү гэсэнд лам хан хөвгүүнийг ажиглаад баясаж хан хөвгүүний хүзүүнээс тэвэрч чанд тэврэлдэв.
- Үхсэн амьд хоёр ингэж учрах байдаг аж. Чи яагаад буцаж ирж чадав? гэсэнд хан хөвгүүн урьдын учир шалтгааныг ярьж эрдэнүүдийг ламд өргөв. Лам баясаж
- Чиний мэтийн хан хөвгүүн ертөнцөд чухаг буй. Би хийгээд амьтан бүхэнд өлзий болох ба энэ насанд хагацалгүй хойд төрөлд чононуудын тэргүүтэнд төрөх болтугай хэмээн ерөөл тавив.
- Чингээд лам ба хан хөвгүүн хоёул нойрсохдоо нэг дэртэй, зооглохдоо нэг хоолтой, явбаас гар гараас хөтлөлцөж явахаар барахгүй агшин зуур ч хагацаж чадахгүй болов. Нэгэн үе болоход тэр голын хаан
- Бид ламыг урин залж өргөн хүндэлж их өргөлийг өгөх хэрэгтэй. Бяцхан хөвгүүнийг усанд хийсэн тул урьд урьдынхаас цаг илүү сайжирч, чандмань эрдэнэ арвижиж, хүн малын өвчин тасарч, хурын ус цагтаа бууж амгалан жаргалан хотол төгс болов гээд ламыг урин залахаар хүн илгээв. Ламын үүдний дэргэд хүрээд ламд түшмэл
- Хаан таны ачийг хариулахын тулд урин залахыг айлтгуулав гэв. Лам очьё гэж ам алдав. Чингэхдээ хан хөвгүүн бид хоёр холдож чадахгүй учир хоёул хамт явна. Гэвч хаан чамайг булаах магадгүй. Явахад арга хэрэглэвээс болно хэмээн айлдаад, нэг том бүдүүн дээлийн хормойг уртасгаж шинэ хормой хийж дээлээ өмсөөд, хан хөвгүүнийг лам ардаа дээлийн дотуур аваад морилов. Түшмэд хүлэг авч ирэхэд
- Би унаа унахыг тэвчсэн тул унахгүй хэмээн айлдаад
- Та нар түрүүлж яв. Би хойноос чинь явья гэв. Түшмэд урд нь явж лам явган морилж хүрэхэд хаан охин хоёр угтаж ламд өргөл хүндлэлийг бүрэн төгс үйлдэв. Тэр хааны охин үхсэн хан хөвгүүний хойноос гаслан шаналж турсан байв. Өндөр ширээн дээр ламыг залрахыг айлтгасанд лам суухгүй хэмээн айлдавч суухаас өөр аргагүй болж лам ширээн дээр авиран гартал ламын хормойноос хан хөвгүүн мултарч ширээний өнцөгт сугаран хоцров. Чингэхэд хаан ба хааны охин нөхөд хан хөвгүүнийг хараад хааны охин хан, хөвгүүнээс зуурч тэр хоёр бие биеэ тэврэлдэв. Тэр хаан түшмэд маш их гайхаж
- Яагаад ингэж хүрч ирсэн бэ? хэмээн ламд өчсөнд лам урьдын учир шалтгааныг хаан түшмэл охин сэлтэд айлтгасан ба бус бас хааны угсаа мөн хэмээн дэлгэрэнгүй айлдав. Түүний эрдэнийг авч хаанд бодитой өргөсөн тул хаан баясаад
- Чамайг их номч хаан мөн байсныг эс танив хэмээн айлдаж хан хөвгүүнд алтан ширээ засаж хаан түшмэд өөр өөрийн сууринд сууцгаав. Охинд оюу ширээг засав. Өөр өөрийн суудал дээр хэлэлцэн морилцгооход өргөл хүндлэлийг бүрэн төгс дэвшүүлсэн ба номын зарлиг үгийг ярилцав. Тэр хаан
- Энэ хан хөвгүүн Дондов урьд эртний хааны угсаа мөн ажгуу. Ялангуяа тэр бодит дүрээрээ номч хаан мөн тул түүний зохиол үйлс бүгд рид хувилгаан мэт байна. Бусдаас эрээд явсан ч ийм хаан үл олно. Надад хөвгүүн байхгүй бөлгөө. Миний хаан суурийг энэ хөвгүүн орлон барих учиртай. Энэ охин ч үйлийн барилдлагатай мэт хагацаж чадахгүй байна. Одоо энэ өдөр гариг одон сайнтай өдөр тул хан хөвгүүн Дондовыг хаан ширээнд суулгая. Би тойн болж лам бид хоёр өвс ус түлээ гурав бүрдсэн нэг ууланд хийд байгуулж тэнд сууна хэмээн айлдаад албат ардуудыг цуглуулж тэр өөрийн мутарт байдаг чандмань эрдэнэ ба гайхамшгийн сайн шүтээн хийгээд алтан судруудыг залж, огторгуйд хив торгон тахилыг үйлдэж, газар бүхэнд дуу бүжиг, тоглоом наадмыг түгээмэл дэлгэрүүлж, сайн морь ба заан хийгээд хан хөвгүүнд амины оршлыг соёрхож охин хан хөвгүүн хоёрыг хаан хатан болгон төрийг бариулав. Их хаан голын эхэнд нэг хийдийг байгуулж, ном буян үйлдэж ламтай хамт аяга тахимлаг бурхан

хувраг лугаа сэлттэй номын ёсыг дэлгэрүүлж байв. Тэр албат цөм баяр баясгалантай хотол төгс энх амгалан урьдаас нэн их өрнөн мандав.

Нэгэн үед хан хөвгүүн Дондов

Би хан төрийг номчлон дэлгэрүүлсэн боловч нөгөө дүү минь хаана төрсөн ба хаа байгааг нэг ч удаа эрж сурагласангүй. Над мэт муу хүн юунд үлдэв хэмээн сэтгэж өөрөө өөртөө их гансрал төрүүлэв. Албат ардуудаа дагуулаад хагас сарын хүнс авч

– Бид ноён зарц бүгдээр дэлгэрэн хөгжиж байгаа үестээ уйтгараа сэргээхээр явах ба эзгүй хээр тал газар бүхэнд бид энх жаргаж эрхээ эдэлнэ хэмээн айлдахад ноён зарц нар урамтай одов. Хаан өөрийн урьдын аялан явж байсан газруудаар цаашлан одов. Хоосон эзгүй талд оронгүй хүмүүс түр орон бэлтгэж, тариагүй газар тариа засаж, усгүй газарт ус гаргаж, үгээгүй ядуу албатуудад тариа өгсөөр одов. Тэр хан хөвгүүний хальсан газарт хүрэхэд бутны дунд бүрд тогтсон байв. Тэнд хийд байгуулж, буяныг үргэлжлүүлэн цагийн тахил лугаа сэлттэй байгуулав. Чингээд дүүг цаадах уул хавиар эрэвч сураг эс гарав. Нааш явах замд цагийн тахилыг өргөхөөр ирсэн үед хийдийн модчин

– Манай энэ хийд байгаа газрын эхэнд урьд үзэгдээгүй үс нь ургасан хүн дүрстэй аймаар амьтан, чанга чанга дуугарсаар ил явдаг. Тэр олон голын цаад талд буй хэмээн айлтгасанд хан хөвгүүний сэтгэлд дүүтэйгээ уулзаж буй мэт өрөвдөх сэтгэл төрөв. Хаан

– Нөхөд та нар тэр дээр газарт аль зохистой хотыг баригтун. Нэг нь нэгэндээ хорлолгүйгээр ажлаа хийгтүн хэмээн айлдаад тэр ноён зарц арван тавуул, тэр амьтан буй гэдэг давааны ар өөд одов. Хан хөвгүүний хальсан тэр газарт хүрээд тэр өдөр дүүтэйгээ уулзсан мэт маш их баясгалантай болов. Гэвч тэр газарт урьд зовлон үзэж байсан учир нулимсыг ч асгаруулав. Нэг уулын оройд очихын цагт тэр голын завсарт юм сэржигнэж байв. Сэмээрхэн гэтэж очсонд хүний биетэй үс нь ургасан мангас мэт нэг амьтан байв. Зүр алаад махыг нь үүрч ахаа нэрээр нь дуудаад

– Ах Дондов хаана байгаа боловч хувь мах нь энэ байна гэж хэлээд шөнө болохоор хэвтэж, өдөр болохоор босоод явдаг байв. Түүний мөрөөр мөшгөж очсонд овоолон тавьсан шинэ хуучин ба хатсан мах том байшингийн чинээтэй байв. Тэнд асар их нулимс асгаруулан «Тэр үхэж байсан дүү минь надад ийм юм бэлдэж байх болбоос, надаас арчаагүй дорой хүнгүй байна» хэмээн санаж маш их гашуудав. Чингээд бараа бологсдыг буцаав. Тэднийг явсны дараа дүү нь махны хувийг авч

– Ах Дондов хаана байгаа боловч хувины мах энэ байна хэмээн хэлсээр ирж явав. Нөгөө ах нь

– Донидоо. Би энд байна хэмээн дуудсан нь дүүгийн чихэнд сонстов. Бас

– Ах чинь энд байна хэмээн хэлсээр дэргэд нь очихоор явав. Чингэхэд хөвгүүн Донид «Миний ахын дуутай адилхан байна» хэмээн сэтгээд гүйж ирээд мөргөв. Тэнд ах, дүү хоёр уулзав. Ах нь дүүгээ «ийм болчих гэж дээ» хэмээн сэтгэж ихэд уйлав. Дүү нь

– Ахтайгаа уулздаг учир байжээ хэмээн өгүүлж маш их баясав. Тэр хоёр түр зуур муужирч унаад сэргэж босов. Ах нь хутгаа гаргаж үсийг нь хусав. Уйтгар сэргээхээр явж байсан урьдын тэр газарт очив. Хан хөвгүүн ах дүү амьд үхсэн хоёрын уулзаж уйтгараа сэргээсэн хэмээн хэлэлцдэгийн шалтгаан нь үүнээс гарсан ажгуу.

Дүүгийн биеийн үсийг хусаж таван рашааныг уулгасанд сүр жавхлангаар ах лугаа адил болов. Чингээд урьдын хальсан газрын хийдэд одож буяныг үргэлж тасралтгүйгээр үйлдэв. Нааш ирэх зам бүгдэд их хийдийг байгуулж харшдаа хүрч ирэв.

Хан хөвгүүний сэтгэлд «Өдгөө би дүүтэйгээ учрав. Миний тавьсан ерөөл бүхэн бүтэж буй тул эцэг хаантайгаа уулзахаар явах хэрэгтэй» хэмээн таалаад харшаасаа чандмань эрдэнэ тэргүүтэй долоон зүйлийн эрдэнэ ба юу дуртай бүхнийг авч хаан хатан дүү гурвуул албатаа

дагуулаад эцгийн дэргэд хүрэхээр одов. Эцгийн газар нутгийн цаад ард хот барьж буй хүмүүс дээр хүрч ирэв. Тэндээс хаан эцэг эхэд хүргүүлэх айлтгалыг нэг шадар түшмэлээр удирдуулж олон харцсыг илгээв. Урьд өөрийн албат байсан тэр хүмүүс хотын үйл хийлцэж байв. Тэр хүн – Хязгаар нутгийн нэг номч хааны тэнд хаан Дондов ах дүү хамт байна гэж сураг сонсов. Тэр сургаар эцэг эх хоёр нь хан хөвгүүн ах дүүгийн хойноос гасланд дарагдаж байв. Айлтгалыг хүргэхээр яваа морьтон хүмүүсийг хараад «Одоо цэрэг ирэв» гэлцэн харшдаа дутаав.

Чингэхэд нь

– Хаан Дондов ах дүү нь эцэг эхтэйгээ уулзахын тулд айлтгал мэдээ хүргэж ирж явна хэмээн өчсөнд

– Яагаад тийм байх вэ. Одоо хаан ширээг булаах буй за хэмээн айж байв. Гэтэл

– Хаан аа, энд морилж ирээд байна гэсэн айлтгалыг өргөсөнд хаан түшмэд маш баясаж, огторгуй дүүрэн хив торгон тахил, дэлхий дүүрэн дуу бүжиг, хөгжмийн тахилаар хан хөвгүүн ах дүүг угтаж айлтгалыг явуулав.

Хан эцэг урьд харшийн босго алхаж гараагүй боловч

– Одоо хөвгүүн ба хатан бэрийг угтахаар явья хэмээн айлдаад нүднийхээ зовхийг шилээр тэвхдэж мутартаа оюу таягийг тулаад хаан хатан хоёр угтаж морилов. Тэр хотоос нааш угтаж морилохдоо өлзий хутгийн найман эд тахилтай ирэв. Хаан эцэг эх ба хан хөвгүүн ах дүү бэр лүгээ сэлт тэнд уулзав. Баясах нь хэтэрхий тул нэг нэгэндээ зууралдав. Ээж нь

– Номч хаан Дондов чамайг бурхны хувилгаан мөн гэдгийг би эс мэдсэн тул чалчаа үг хэлсэн ба муу сэтгэл үүсгэснийг илчлэн наманчилья. Хүлцэн өршөө. Одоо өвгөн эмгэн бид хоёрын жаргах зовохыг ах дүү та хоёр мэд гээд унасан мэт олон мянгантаа мөргөв. Хан хөвгүүн Дондов

– Би зургаан зүйлийн амьтныг эх эцэгтэй адил сэтгэсэн тул өшөө барих муу санаа огоот үгүй. Ээж юу үйлдсэн нь над тусламж нөхөр болсон хэмээн айлдаж номын зарлиг яриаг яруу тодорхой зохиов. Хан хөвгүүн Донид эцэг хааны ширээнд суув. Хатан, ах дүү хоёрыг нэгэнд зохицуулан байлгав. Цаад наад хоёр хан төрийг ялгаваргүй тэтгэв. Аугаа хүчээр Замбативийг эрхшээсэн хааны албат нар энх тайван, өдөр шөнө үргэлжид номыг эдэлж байв гэсэнд Сайн амгалан явдалт хан хөвгүүн: «Би урьд модны дэргэд очоод намайг бүү ав» гэж байсан энэ хүүрийг анх үүрснээс хойш номын учир түүх олон домгийг надад яривч би мэдэл онолыг эс олов. Ардаа хүүр үүрэвч дургүйцэх ба хашрах явдал надад байсангүй. Өнөөдрийн ярьсан түүхээс дээш хорин нэгэн үлгэр болов. Зовлонг эдэлж үүрсээр яваа тул би алсдаа хан төрийг номын ёсоор тэтгэгч болох буй за. Бүхний хан хөвгүүн Дондов ирэх явах суух алиныг үйлдэвч түүнд ламаас бусад юм санагдсангүй. Аминд үхэл ирэвч далайн ёроолоос ламыг дурдаж байжээ. Ламыг дурдсаар алсдаа ламтай уулзсан байна. Чингээд хан хөвгүүн Дондов хязгаараар тэнэвч эцэг эхтэйгээ уулзаж Замбативийг эрхэндээ багтаасан тийм номч хаан болжээ. Энэ хүүр намайг зовлонд шаналгаж заяагаа барсан хан хөвгүүн хэмээн өгүүлэвч заяа барагдаагүй байгаа буюу. Чиний мэтийн гуйранчин Даваадагва ийм байна хэмээн сэтгэж нулимсаа

хамар дээгүүрээ урсгаж, ламаа дурдан маш их сүсэг бишрэл төрсний хүчээр ламын лавринд хүүрийг үүрсээр хүрч ирэв.

Тэр лам чанд бясалгалд орсон байвч мөргөж эргэн эргэсээр адистидыг айлтган

– Өнөөх Даваадагва чинь ирэв. Эндээс гарсны даруйд хүчтэй сүсэг үүсэж үнэн чин зориг төрж ламын айлдсан зарлигийг бүтээж байна хэмээн өчсөнд лам

– Чи урьд насанд өглөг их өгөөгүйгээс энэ насанд хоосон болсон байна. Урьд насандаа лам ба шашинд сэтгэл асар ариухан байсан тул энэ насанд ном лугаа уулзсан байна хэмээн

айлдаад, надад судар дандар шастирт мэргэжсэн дөрвөн шавь бий. Түүний дотор дамжиглалтай нэг байсан нь чи мөн буй за хэмээн айлдав.

Тэрсүүдийн багшийн энэ цогцын толгойноос бусад нь алт болоогүй тул энэ үлдсэн биеийг өмнө зүгийн Цогт уулын сүмийн босгонд булж дарагтун. Тэрсүүдийн энэ шажин өндөр болох шалтгааныг үгүйсгэнэ. Бурхны нигүүлсэхүй бээр Замбативд дээдийн ном дэлгэрч болно хэмээн номлов. Хан хөвгүүн

– Алт болсон энэ толгойгоор суварга буюу бурхны бие, юуг босговоос зохих вэ? хэмээн айлтгасанд Наганжуна

– Ганц үмхээс илүү идээ юм байхгүй боловч түүнээс тусгайлан авч өглөг өгөх хэрэгтэй. Энэ насанд санаа асар ариухныг баривч өмнө зүгийн Цогт ууланд алтыг бүтээж чадаагүй нь түүний учраас ажгуу. Сайн амгалан явдалт аа! Дотор бурхны биеийг босгонд агуулавч тусгүй. Сайн амгалан явдалт минь Очирт суурь тэргүүтэй хийдэд алтыг түгээж болохоор байгаа буюу хэмээн айлдаж алт болсон энэ толгойг бутаргаж Энэтхэгийн хийдийн энгийн хүмүүст нэжгээд цэнг түгээв. Хуучин Увадини ба өвгөн даяанч нарт алтыг лангаар өргөв. Очирт суурийн Наландарийн хийдэд алтан цөгцийг тавиуртай хамт өргөх нөхцөлтэй болов. Толгойн дундаас алтангол зэс, зүү мэт юм гарсан бөгөөд үүнийг бид хоёр залбирлыг тавихын шүтээн болгоно. Шунал хурьцал нэн дэндвээс орчлонд хүлэгдэхийн уг болохоос өөр юмгүй хэмээн айлдав.

Тэр алтны голыг бурхан шүтээний дэргэд тавьж нэг сар болтол багш шавь хоёр бүтээлийг зохиож залбирал тавьсанд нэг тохой Майдарын бие бүтэв. Энэ нь сайн буяны цаг болох бүр Наганжунад зарлиг зөвлөгөөн өгдөг болов. Тэрсүүдийн багшийн цогцонд бясалгал хийсний эрдмээр Наганжуна оршин байх үедээ номын дуазыг сайтар байгуулж тэрсүүд буруу үзэлтнийг гэсгээж зургаан зуун сүүдэр дээрээ нярваан болохын дүрийг үзүүлж цөвийн цагт ирнэ гэж ам авав.

Шажныг баригч дээд төрөлхтөн таны хойноос би ч дагах болтугай. Ачит лам дээдэс та нар ухааныг баригч насны шидийг хайрлаж намайг номын номхтгуун болгон боловсруулах болтугай гэсэн ерөөлийг Сайн амгалан явдалт хан хөвгүүн Майдар ба Наганжуна зүрхэн хоёрын өмнө тавив.

– Сайн амгалан явдалт хан хөвгүүн хүүрийг алт болгосны энэ хорин нэгэн үлгэрийг уншваас барагдашгүй шидийг олох болно хэмээн багш Наганжуна айлдсан байна. Лам Наганжунагийн зүрхний ерөөл эцэс туйлд хүрч Сайн амгалан явдалт хан хөвгүүн, бэрх хатуужлыг эдлэсний хорин нэгдүгээр бүлэг болой.

Энэ шашинд хоёрдугаар багш хэмээн алдаршсан амьтны итгэл Наганжуна эцэг хөвгүүн бээр үйлийн уг үрд итгэж, авах гээхийг ёсчлон үйлдэх хүний ертөнцийн алсын гол шижмийг уртасгасны учир сайн үр гарч, санасан хэрэг нь бүтсэн болой. Гайхамшигт буян гарах шастирын эрихийг зохиов. Үүнийг үзэж уншсанаар ерөнхий шид бүтээл гарна хэмээн Наганжуна айлдсан буй.

Сайн бэлгийн их баясгалангийн хуримаар тврөлхтөн бүгд чингэж энэ өргөн уудам улс гүрэнд маш баясгалан бөгөөд Сайн амгалан гарах болтугай.

Өлзий хутаг орштугай. Өлзий хутгийн цог дэлгэрч Замбативийн чимэг болтугай.

Мангалам